



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 12-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-22
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	23-145
<hr/>	
1. “Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	25-30
2. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	30-45
3. “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	45-66
4. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/	66-72
5. “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	72-73
6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	73-78
7. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	78-90
8. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	90-116
9. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	117-135
10. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	135-138
11. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	138-140
12. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	140-145

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы
2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 53.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Ганхуяг, Ж.Эрдэнэбат;

Чөлөөтэй: Г.Дамдинням, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Ц.Сэргэлэн;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, Ч.Ундрэм;

Тасалсан: Б.Баярсайхан, Б.Жавхлан;

Хоцорсон: Н.Алтанхуяг -12 минут, С.Амарсайхан -17 минут, Э.Батиугар -2 цаг 56 минут, С.Ганбаатар -07 минут, Д.Ганбат -11 минут, Н.Ганибал -10 минут, Т.Доржханд -14 минут, Ц.Мөнх-Оргил -23 минут, Н.Наранбаатар -1 цаг 55 минут, Х.Нямбаатар -10 минут, М.Оюунчимэг -20 минут, Д.Өнөрболор -55 минут, Ш.Раднаасэд -21 минут, Ц.Туваан -08 минут, Г.Тэмүүлэн -1 цаг 23 минут, Д.Цогтбаатар -43 минут, Н.Энхболд -39 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг. “Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбатын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 47

Татгалзсан: 8

Бүгд: 55

85.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоол батлагдсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:36/

Хууль зүйн байнгын хорооны даргыг сонгосонтой холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван, мөн банкны Хууль, эрх зүйн газрын захирал Д.Аюуш, Эрх зүйн бодлогын хэлтсийн захирал Б.Эрдэнэхуяг, Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, С.Бямбацогт, Б.Дэлгэрсайхан, Д.Ганбат нарын тавьсан асуултад Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг, Монголбанкны Дэд ерөнхийлөгч Г.Энхтайван нар хариулж, тайлбар хийв.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гаргаж болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Энэ хуулийн 14.3-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, бүртгэл, хэмжээ, хэлцэл хийхэд баримтлах журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 25

Бүгд: 53

52.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл шинээр нэмэх:

“25 дугаар зүйл.Хяналт шалгалт

25.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, актив, пассив, өөрийн хөрөнгөд тавих шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан хяналт шалгалт хийж болно.

25.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Амарсайхан, С.Бямбацогт нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 26

Бүгд: 54
51.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Бямбацогт, Б.Бат-Эрдэнэ, Ш.Раднаасэд, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Т.Доржханд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, С.Амарсайхан, Н.Ганибал, Т.Доржханд, Т.Аюурсайхан нар үг хэлэв.

“Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 04 минутад хэлэлцэж дуусав.

Үдийн завсарлагааны цаг болсон тул хуралдаан 13 цаг 04 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 09 минутад эхлэв.

Дөрөв. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын дарга Б.Дөлгөөн, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын даргын албан үүргийг хавсран гүйцэтгэгч Г.Адьяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хариулж, тайлбар хийв.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: Тогтоолын төслийн 1 дүгээр заалтын 4, 5 дахь дэд заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Тав. “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Одбаатар, Нийслэлийн Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮ-ийн ерөнхий инженер Т.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооноос гаргасан “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Хууль, эрх зүйн газрын ахлах референт Д.Саруул, Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Ц.Батболд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн Ё.Отгонжаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ш.Адъяаа, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, С.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрэм, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61 дэх заалт нэмсүгэй:

6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.аялал жуулчлалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5 дахь хэсэг 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.39.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйл, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.40.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1,3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.47.соёлын өвийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.усан замын тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.50.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.51.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг,

10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.55.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.57.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг заасан зөрчил;

6.58.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.19 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 6.12 дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.60.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.61.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 21

Бүгд: 42

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 20

Бүгд: 42

52.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Ш.Адьяаа, Ц.Анандбазар, Х.Баделхан, Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Баттөмөр, Э.Батшугар, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, С.Ганбаатар, Н.Ганибал, Х.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, Ж.Мөнхбат, Г.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн, Ц.Туваан, Ч.Ундрам, Д.Цогтбаатар, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг, С.Чинзориг, Ж.Чинбүрэн, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61 дэх заалт нэмсүгэй:

6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.аялал жуулчлалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр

зүйлийн 1, 4, 5 дахь хэсэг 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.39.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйл, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.40.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1,3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.47.соёлын өвийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.усан замын тээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.50.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.51.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10.16, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.55.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.57.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.58.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.19 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, 6.7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.9 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, 6.12 дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.60.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.61.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 27” гэсний дараа “, 28” гэж, 6.12 дахь заалтын “7.5 дугаар зүйл,” гэсний дараа “7.10, 7.11, 7.12, 7.13,” гэж, “6.5 дугаар зүйлийн 10, 12,” гэсний дараа “13,” гэж, “6.17 дугаар зүйлийн” гэсний дараа “5,” гэж, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.14. дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр зүйл,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 21
Бүгд: 42
50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр зүйл,” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх.

“4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 19
Бүгд: 42
54.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Дамбий, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Б.Алтантулга,

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газрын дарга З.Буянбадрах нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 15 цаг 08 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Ш.Адъяаа, Н.Ганибал, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 19

Бүгд: 41

53.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Найм.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, С.Орхон, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Б.Пүрэвдорж, О.Цогтгэрэл, Ц.Туваан, М.Оюунчимэг, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Ц.Мөнхцэцэг, Н.Учрал нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	19
Бүгд:	41

53.7 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Ес.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, С.Орхон, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Н.Наранбаатар, Б.Энхбаяр, Ж.Батжаргал, Х.Булгантуяа нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 18 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа, М.Оюунчимэг, Ц.Туваан, С.Чинзориг нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 17

Бүгд: 44

61.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 18 цаг 48 минутад хэлэлцэж дуусав.

Арав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, С.Орхон, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Баяртуяа, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын

хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 18

Бүгд: 42

57.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, С.Орхон, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай

хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 17

Бүгд: 41

58.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, мөн хорооны Даатгалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч З.Батболд, Үнэт цаасны газрын ахлах мэргэжилтэн А.Нинжин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга А.Хишигбаяр, мөн газрын ахлах шинжээч Б.Гэрэлсайхан, С.Орхон, Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Бодлогын хэрэгжилт, судалгааны газрын дарга Ц.Ганцэцэг, мөн газрын Санхүү бүртгэлийн газрын дарга Б.Даваахүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аюурсайхан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Туваан нарын тавьсан асуултад Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 16

Бүгд: 40

60.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 19 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 8 цаг 18 минут үргэлжилж, 76 гишүүнээс 64 гишүүн хүрэлцэн ирж, 84.2 хувийн ирцтэйгээр 19 цаг 31 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 14 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт Байнгын хорооны даргыг сонгох чөлөөлөх тухай асуудал. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг. Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хуулийн төсөл, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, 14.Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, чанар, аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих асуудлаар холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, санал боловсруулах, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг Түр хорооны тайланг сонсох. Хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т зааснаар Улсын Их Хурлын даргад 17 цагаас өмнө үг хэлье гэж бичгээ ирүүлсэн 3 гишүүн ирүүлсэн байна. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар 01 дүгээр сарын 12-ны өдөр чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлэх хүсэлтийг хүргүүлж байна гэсэн байна. Үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Өнөөдрийн хэлэлцэх асуулгатай холбогдуулж 2 асуудлыг хэлэлцэх асуудалд оруулах ийм саналыг энэ чуулганы хуралдаанд хэлэх ийм шаардлага гарлаа. Монгол Улсын сайд бөгөөд ЗГХЭГ-ын дарга Амарбаясгалан Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Мянгад сумын Халзан бүргэдэйн ордын талаар 11 сарын 03-ны өдөр Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд асуулга тавьсан. Энэ асуулгын хариу уг энэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зааснаар Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд ирүүлэх хуулийн хугацаатай. Гэтэл өнөөдрийг хүртэл Үйлдвэр, Хүнд үйлдвэрийн сайдаас ЗГХЭГ-т хүргүүлсэн албан тоотын хариу ирүүлчхээд, энэ асуудлаар өнөөдөр Улсын Их Хурлын гишүүн миний асуулгад Халзан бүргэдэйн ордын талаар иргэдээс ирүүлж байгаа санал хүсэлт, тэнд болж байгаа нөхцөл

байдлын энэ талаар Улсын Их Хуралд Засгийн газраас танилцуулга ирүүлэх энэ хуулийн үүргээ Засгийн газар Улсын Их Хуралд танилцуулах, ямар шалтгааны улмаас энийг ирүүлэхгүй байгаа нь тодорхой бус байгаа учраас Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ бүрэн эрхийн хүрээнд энэ Улсын Их Хурлын тухай хуульд заасан энэ асуудлыг хуулийн хугацаанд нь ирүүлж, асуудлыг шийдэж өгөх шаардлагатай байна гэсэн нэг ийм асуудлыг тавья.

Нөгөө талаараа Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцыг бид өнөөдөр Монгол Улсын Засгийн газраас баруун бүсийн эрчим хүчийг хангах маш том мега төсөл гэдгээ бид дэмжиж энийг Улсын Их Хурал Засгийн газартай хамтарч энэ төслийг яаралтай эхлүүлэхийн төлөө байгаа. Энэ төслийг эхлүүлэх ажлын хүрээнд нөлөөллийн бүсэд байгаа 3 аймгийн 300 өрхийн 1500 иргэнд нэг удаагийн нөхөн олговор олгох тухай хуулийн төслийг 2022 оны 11 сарын 08-ны өдөр өргөн барьсан Улсын Их Хуралд. Гэтэл он дамжлаа. Энэ асуудлыг яагаад хэлэлцэхгүй байна вэ? Яагаад хэлэлцэхгүй байна, ямар шалтгаан байна вэ? Өнөөдөр Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж заасан хүрээнд иргэдийнхээ амьдрах орчныг хангах энэ үүрэг нь төрд байгаа. Энэ үүргийнхээ хүрээнд энэ асуудлыг яаралтай шийдэж өгөх нь өнөөдөр Монгол төрийн үүрэг.

Үнэхээр энэ цахилгаан станцыг цаашид явуулах тэр нөлөөллийн бүсэд байгаа 1500 иргэний асуудлыг Засгийн газар, Монголын төр шийдэх ийм үүргээ биелүүлэх ийм шаардлагатай байна. Энэ нөхцөл байдалтай холбогдуулж энэ 2 асуудлыг энэ долоо хоногийн Улсын Их Хурлын чуулганаар оруулах ийм саналыг би оруулж байна. Миний саналыг бас хүлээж авч хуулийн хүрээнд энэ асуудлыг шийдэж өгөхийг Улсын Их Хурлын удирдлагаас хүсэж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Бөхчулууны
Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Эрхэм гишүүдийн энэ өглөөний амгаланг айлтгая. Тэгэхээр 2017 онд Монгол Улс ОУВС-д хамрагдаж, тэтгэврийг 7 жилээр бодох одоо энэ асуудлыг оруулж ирсэн. Тэгээд энэ өнгөрсөн хугацаанд 2017, 2018, 2019, 2020, 2021, 2022, 2023 ингээд 7 жилийн туршид энэ одоо тэтгэврийг 5 жилээр бодох тухай одоо асуудлыг ярьж жагсаал зохион байгуулж, Улсын Их Хурлын индэр дээрээс жар гаруй удаа үг хэлж, энэ хуулиа одоо таниулах зорилгоор 21 аймгийн 2-оос бусад одоо томоохон сумууд аймгийн томоохон сумууд дээр одоо уулзалт хийж, зөвлөгөөн зохион байгуулж ингэж ажилласан. 2021 онд Засгийн газраас нийгмийн даатгалын багц хуулийг оруулж ирсэн боловч энэ дээр нь бүр 7 биш бүр 10 руу явуулах ийм багц хууль оруулж ирсэн. Энийг нь одоо эсэргүүцэний үр дүнд Засгийн газар буцааж авч явсан. Харин өнөөдрийн Засгийн газар энэ одоо тэмцлийн минь үр дүнд 7 биш 5 жилээр одоо бодох энэ нийгмийн даатгалын багц хуульд тусгаж оруулж ирсэнд Засгийн газарт бас талархаж байна.

Мөн түүнчлэн энэ хуулийг одоо дэмжиж байсан Улсын Их Хурлын гишүүддээ бас талархаж байна. Тэгэхээр бидэнд бас нэг асуудал үлдсэн. Ямар асуудал үлдсэн бэ гэхээр Боловсролын хууль багц хууль мөн Улсын Их Хурал дээр орж ирээд бараг 2 жил гаруй болж байна. Улсын Их Хурлаар хэлэлцдэггүй уддаг ийм одоо асуудал байгаа. Тэрэнтэй адилхан нийгмийн даатгалын багц хуулийг олон жилээр одоо барих ийм асуудал үүсэж магадгүй. Тийм учраас хаврын чуулганаар Улсын Их Хурлын гишүүд та бүхэн одоо энэ хуулийг яаралтай хэлэлцэж ахмадуудын асуудлыг шийдвэрлэхийг хүсэж байна. Тэгэхээр өнөөдрөөс эхлээд одоо энэ нэгэнт Засгийн газар багц хуулиа оруулж ирсэн учраас энэ тэмцлээ зогсоож байна.

Дараагийн тэмцэл эхэлж байна. Тэгэхээр өнгөрсөн 2018 оны 1 сарын 1-нээс хойш өнөөдрийг хүртэл энэ 7 жилээр, 6 жилээр бодуулсан иргэд энэ зурвасхан

хугацаанд Монгол төрийн буруу одоо бодлогоос болж хохирч үлдэх ёсгүй. Тийм учраас энэ одоо хүмүүсийг хохироохгүй байх, энэ хүмүүсийн одоо нийгмийн татварыг нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэр тэтгэврийг 7 жил 7 жилээр бодсон байсныг нь буцааж, 5 жилээр нөхөн бодож, нөхөн олговор олгох тухай энэ хуулийг өргөн барьсан хуулийг одоо хэлэлцэхийг шаардаж эхэлнэ. Бид энэ Монгол Улсынхаа хөгжил дэвшлийн төлөө өдөр шөнөгүй ажилласан амьд бурхад болсон ахмадуудыгаа энэ зурвасхан хугацаанд хохироож үлдээж болохгүй юм. Тийм учраас манай ахмадууд хөдөө орон нутагт одоо энэ тун удахгүй Улсын Их Хурлын чуулган завсарлах гэж байна. Хөдөө орон нутагт ажиллаж байгаа ахмадууд энэ Улсын Их Хурлын гишүүдээсээ энэ нөхөн олговроо нөхөн бодох энэ хуулийг одоо хэлэлцэж өгөхийг шаардахыг нийт ахмадуудаасаа хүсэж байна. Ингээд та бүхэндээ энэ хаврын чуулганаар нийгмийн даатгалын багц хуулийг бүрэн хэлэлцэж, эдгээр бүхий л асуудлыг шийдвэрлэхийг уриалж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн. Төмөр замын тээврийн тухай хууль Сандагийн Бямбацогт гишүүн нэрээ татлаа. Ширнэнбаньдын Адьшаа, Адьшаа гишүүнээ таны хэлсэн Нөхөн олговор олгох тухай хуулийн төслийг бол чуулган дээр та ярихгүй, хэлэлцэх асуудал дээр Төсвийн байнгын хороо хэлэлцэж байж Байнгын хороогоор хэлэлцсэн асуудал Байнгын хорооноос чуулганд орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ долоо хоногийн нэгдсэн хуралдаанд хэлэлцэхийн тулд Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх шаардлагатай. Төсвөөр Нөхөн олговор олгох тухай асуудал чинь Төсвийн байнгын хороогоороо Тэмүүлэн гишүүнтэй яриад, Төсвийн байнгын хороогоороо хэлэлцсэний хэлэлцүүлэх асуудлаа яриад, тэгээд Төсвийн байнгын хороон дээр хэлэлцсэний үндсэн дээр чуулганы нэгдсэн хуралдаан дээр орж байна. Төсвийн байнгын хороогоор хэлэлцээгүй учраас энэ долоо хоногийн чуулганы нэгдсэн хуралдаанд оролцох бололцоогүй байна. Пүрэвдорж

гишүүний асуудал бол өнөөдөр Нийгмийн даатгалын тухай хууль хэлэлцэх үеэр яригдах сэдэв байна. Хэлэлцэх асуудалтай холбоогүй юм байна. Бямбацогт гишүүн нэрээ татлаа. Ингээд өнөөдөр Ховдын 3 гишүүн үг хэлэх саналаа ирүүлж, холбогдох саналуудыг хэлсэн байна. Ингээд гишүүд хэлж дууслаа. Одоо хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг. “Байнгын хорооны даргыг сонгох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Нэгдүгээрт Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудал хэлэлцэнэ. Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай асуудлаар ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Лхагвын Мөнхбаатар танилцуулна. Индэрт орж байна.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг ХЗБХ 2023 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн нэр дэвшигч Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршилага, төрийн ажлын мэдлэг чадварыг харгалзан ХЗБХ-ны даргад нэр дэвшүүлэн хэлэлцүүлээ. Баттөмөрийн Энхбаяр 1994 онд Дорнод аймгийн Чойбалсан хотын ЕБС-ийн нэгдүгээр дунд сургууль, 1998 онд МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийг төгссөн. Хуульч мэргэжилтэй. Хууль зүйн

ухааны магистр. 1998-2004 онд Улаанбаатар эрдэм дээд сургуульд багш, 2000-2001 онд Улсын Их Хурлын гишүүний туслах, 2001-2002 онд Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн ажлын албанд референт, хуулийн зөвлөх, 2003-2006 онд Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Тамгын газрын дарга, 2006-2007 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, 2009-2011 онд НДЕГ-ын Тамгын газрын дарга, 2011-2013 онд МАН-ын бүлгийн даргын зөвлөх, 2014-өөс 16 онд УИХ дахь МАН-ын бүлгийн зөвлөх, 2016-2018 онд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, 2020 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар уг асуудлыг хэлэлцэх үед Монгол Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа өргөн битүүлсэн хуулийн төслүүдийн уялдаа холбоог ханган ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат Хянан шалгах түр хорооны даргын хувьд эрхэлсэн ажлаа дуусгах эсэх талаар асуулт асууж хариулт авсан бол Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улаанбаатар хотын утаатай холбоотой хүний суурь эрх зөрчигдөж байгаа эсэх асуудлаар албан тушаалтнуудын мэдээллийг Хүний эрхийн дэд хорооны хуралдаанаар сонсох ажлыг зохион байгуулах талаар Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нэр дэвшигчийг дэмжиж байгаа талаар тус тус үг хэлсэн болно. ХЗБХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 92.9 хувь нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Дашдондогийн Ганбат

гишүүнээр тасаллаа. Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Та бүхнийхээ өглөөний амар амгаланг айлтгая. Ингээд Баттөмөрийн Энхбаяр гишүүнийг ХЗБХ-ны даргаар нэр дэвшүүлж сонгож байгаад бол нийг бол дэмжиж байгаа юм. Гэхдээ бас Хяналт шалгалтын түр хороо гэж байгаа. Энэ одоо анх удаагаа байгуулагдсан ийм түр хороо. Энэ Хяналт шалгалтын түр хороо хяналт шалгалтынхаа чиг үүргийг хэрэгжүүлнэ. Улсын Их Хурал хууль тогтоохоос гадна хуулийн хяналтад хэрэгжилтэд хяналт тавьж ажилладаг. Энэ манай улс оронд одоо нүүрлээд байгаа энэ бузар булай одоо Монгол Улсын энэ бузар булай бол одоо дэлхий нийтээрээ бол шившиг болоод ингээд гараад явчихсан. Одоо ждү, нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хэргүүд гэх мэтчилэнгийн. Энэ Хөгжлийн банкин дээр байгуулагдсан түр хорооны даргыг бол байн байн солих юм. Тэгээд дарга болгоод дэвшүүлээд явчих юм. Энэ одоо сайн ажиллаад дэвшүүлээд ингээд яваад байна уу? Эсвэл тэр түр хороог ажиллуулахгүйн тулд зориуд бодлогоор ийм юм хийгээд байна уу? Энийг одоо бас юу гэж бодож байна вэ? Энэ түр хорооны даргыг солимооргүй байх юм. Тэгээд одоо нэг удаа сунгаж ажилладаг. Одоо 4 сард хугацаа нь дуусна.

Тэгээд нөгөө л ард түмний шүүмжлээд байгаа гэмт хэргийг завшдаг, замхруулдаг, маш хөнгөлөлттэй зээлүүдийг урт хугацаанд авчихсан. Нөгөө үйлдвэр завод нь баригдаагүй байдаг. Маш өндөр хүүтэйгээр Монгол Улсын нэрийг бариад зээл тусламж, бонд гаргаад авчихсан ийм зүйлүүд олон байгаа. Энийг одоо анх удаагаа шалгах гэж оролдож байгаа зүйл бол энэ Хөгжлийн банкны түр хороо байгаа юм. Энэ мөрдөн шалгах анхны сонсголыг энэ ирэх долоо хоногоос хэрэгжүүлээд явах юм. Энэ хууль хяналтын байгууллагууд бол сүүлийн үед бол ажиллахаа больчихсон байна шүү дээ. Эсвэл ажиллуулахгүй байгаа юм уу? Тэр нь яах вэ олон жил одоо энэ бугшсан хууль хяналт хяналтын байгууллагыг

атгачихсан, тэрүүгээрээ одоо шантаажилж маш их мөнгө олсон, тэрийгээ угаадаг хэсэг бүлэг этгээдүүдийн гарт бол олон жил байсан. Яах вэ сүүлийн үед би энэ Нямбаатар Хууль зүйн сайдыг бас нэлээн зөв чиг зүгт ажиллаад байгаа юм уу гэж ойлгоод байгаа. Тэгээд энийг одоо бас Улсын Их Хурал хянан шалгаад, дэмжээд ингээд явах ёстой. Тэрний үр дүн бол гараагүй байгаа. Үр дүн гарахад ойрхон байгаа л гэж амлаад байгаа. Тэр нь амьдрал дээр яаж хэрэгжих юм, яах юм мэдэгдэхгүй байгаа юм.

Улсын Их Хурал, Засгийн газар бол одоо хөл толгой нь олдохоо байсан шүү дээ. Улсын Их Хурал одоо хаана хуралдаад байдаг юм энэ танхимд хуралддаг юм уу, эсвэл тэр 2 давхар, 2 давхар тэр Засгийн газрын танхимд хурлаа хийдэг юм уу, мэдэгдэхгүй. Овоо гайгүй хэл ам нь ороод, энэ улс орны бузар булхайг уудлаад яриад явж байсан гишүүдийг сайд болгоод тавьчих юм. Тэгээд тэр хүн маань чимээгүй болчих юм. Ийм юмнууд их олон давтагдаж байна.

5 гишүүнийг одоо нүүрсний хулгайд олон бүлгээс зарласан. Энэ 5 гишүүн маань энэ муу муухай зүйлийг ил гаргана. Бид нар, бид нарт бол хамаагүй гэсэн. Гэтэл энэ ажил маань сүүлийн үед чимээгүй болчихлоо. Энэ талаар одоо юу бодож байна вэ? Маш их олон хүн бол Хөгжлийн банканд ингээд шалгуулж байгаа. Сүүлийн үед нэг хэдэн төгрөгийг нь төлсөн болоод ханиш нь уначихсан хэдэн төгрөг төлөөд ард нь бол одоо гэмт хэргийн ялыг завиших ийм одоо зүйл үргэлжилж байна байна. Энэ талаар та одоо юу бодож байна вэ гэсэн ийм энэ асуултуудыг бол тодруулах нь зөв байх. Энийг одоо бас энэ хүмүүс энэ улсыг.../минут дуусав/

Г.Занданшатар: Нэр дэвшигч Баттөмөрийн Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Гишүүддээ өглөөний амгаланг айлтгая. Ганбат гишүүний асуултад хариулъя. Хөгжлийн банкныг шалгах Улсын Их Хурлын түр хороог

өнгөрсөн оны 4 дүгээр сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын тогтоолоор байгуулсан. Энэ бол 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт хийгдэж, ард түмний дээд хяналтыг сайжруулах хэрэгтэй. Улсын Их Хурал буюу энэ хууль тогтоох төлөөллийн дээд байгууллага бол ганцхан хууль батлахаас гадна баталсан хуулийн хэрэгжилт ер нь юу болж байна гэдэг дээр ерөөсөө ажлын тал хувь нь байх ёстой. Энэ ажлын тал хувийг сайжруулахгүйгээр манай улс одоо энэ хулгай юманд нүүрлэлээ гэдэг дээр дүгнэлт хийж өнгөрсөн Улсын Их Хурал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үүний хамгийн эхний үр дүн болж өнгөрсөн оны эхээр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг манай одоо Бямбацогт нарын гишүүд өргөн барьж, Улсын Их Хурлын дарга бас Занданшатар энэ дээр манлайлж, парламентын ардчилал, хяналтыг сайжруулах хүрээнд бол Улсын Их Хурлын хяналтын хуулийг бол гаргасан. Энэ хуулийн дагуу анхны байгуулагдсан түр хороо өнгөрсөн хугацаанд бол нийтдээ 8 удаагийн ерөнхий хяналтын сонсголууд бол хийгдсэн. Ирэх долоо хоногт бол Хөгжлийн банкны хянан шалгах, мөрдөн шалгах гэж хэлж болохоор нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол зохион байгуулагдах гэж байгаа. 1 сарын 16-наас 20, 2 сарын 6-наас 10, 3 сарын 12-17 оны өдрүүдэд зохион байгуулагдахаар тов гарсан. Одоо урьдчилсан байдлаар бол энэ хугацаанууд бол сунгагдаж явагдахаар байгаа. Хамгийн багадаа 1 сарын хугацаанд энэ сонсгол зохион байгуулагдаж, Үндэсний олон нийтийн телевизээр зохион байгуулагдана. Олон асуудал бол нотлох баримттайгаар ил болно. Иргэд бол пүү наа болох нь бол ойлгомжтой.

Тэгэхдээ бид буюу ард түмний төлөөллийн дээд байгууллага энэ хулгайн юмыг одоо ярих, нотлох илчлэх, энэтэй эвлэрэхгүй байх энэ дээр манлайлж ажиллах хамтын одоо үүрэг хүлээсэн гэж ойлгож байгаа. Ганбат гишүүн бол энэ түр хорооны бас гишүүн. Түр хороог

Сүхбаатар дарга бас нэг байгуулж, ахалж ажиллаж хянан шалгагчдыг томилж, ажилд нь оруулж нэлээн олон асуудлыг бол хийсэн. Миний хувьд бас үргэлжлүүлээд энэ хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр ажиллаад одоо нэг дэх өдрөөс эхний үр дүнгүүд ил болно. Энэ доторх асуудлыг бол би нарийн ширийн яриад яах вэ. Угаасаа шууд явах учраас. Тийм учраас энэ Хяналт шалгалтын түр хорооны даргаа бол дуусгана гэсэн бодолтой байгаа. Хийвэл бүү ай, айвал бүү хий гэсэн үг байдаг. Айхгүй байгаа. Тийм учраас бол хийж дуусгана гэсэн бодолтой байгаа.

Нэгэнт Түр хороо учраас Улсын Их Хуралд энэ оны 4 дүгээр сард сонсголууд дуусаад, ажлынхаа тайланг тавиад, угаасаа энэ Түр хороо хуулийнхаа дагуу 1 жилийн хугацаанд ажиллаж байгаа учраас татан буугдана. Тийм учраас бол одоо Байнгын хороон даргад болсноор Түр хорооноосоо чөлөөлөгдөх ёстой гэсэн ийм учир шалтгааныг бол миний хувьд олж харахгүй байгаа. Тийм. Би бол одоо бүр чөлөөлөгдөхдөө тулбал би бас Байнгын хорооны дарга болох албагүй гэж бодож байгаа.

Г.Занданшатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулж асууна, 1 минут.

Д.Ганбат: Яг ингээд тулаад ирэх юм бол та сонголтоо хийгээд түр хороогоо бас ингээд гүйцээж ажиллуулах юм гэж сонслоо. Энэ бас чихэнд чимэгтэй байна. Зүйтэй байна. Үр дүнг нь бид нар харах ёстой. Нөгөө талаар одоо 2014, 5 онд би ХЗБХ-ны даргаар ажиллаж байсан. АН-ын гишүүдийн тухайн үеийн Улсын Их Хурал дахь дэмжлэгтэйгээр бол бид бүхэн бол авлигыг индексээр бол Монгол дэлхийн дэлхийн улс орнуудын түвшинд бол 75, 6-д авчирсан. Тэгтэл одоо сүүлийн үед та хэд чинь 62-уулаа, 65-уулаа болчихсон мөртөө нөгөө авлигынхаа индексээр бүр 110-т ороод ирсэн байна. Энэ одоо улам л авлигажаад л ингээд л яваад байх юм. Энэ үүрэг энэ үед бол ХЗБХ-ны даргын үүрэг роль маш чухал. Энийг манлайлж, чиглүүлж ингэж ажиллахад. Энэ Авлигын

индексийг одоо одоо 110-аас нь хөдөлгөөд, ядаж тэр 2 оронтой тоонд оруулж болохгүй юу? Хэрэв тухайн үедээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулаад хариулъя.

Б.Энхбаяр: Улиран одсон 2022 он бол бүхэлдээ хулгай ярьсан жил байсан. 23 он эхлээд ингээд сонсгол яваад бас хулгай ярина. Иргэдээ бухимдуулахыг бол ойлгож байгаа. Тэгэхдээ бид одоо энийг өчигдөр бас Ерөнхий сайд Үндэсний зөвшилцлийн чуулган дээр хэлж байсан. Тэгээд дугуй байх юм уу гэж. Тэгээд мэдсэн ч мэдээгүй царайлаад байж байх юм уу гэдэг асуудлыг ярьсан. Энэ бол өөрөө улс төрийн манлайлал гэж ойлгож байгаа юм. Эрх баригч намын дарга ард түмэндээ хандаж хэлсэн үг. Тийм учраас энэ манлайллыг бол тууштай дэмжиж ажиллах нь Улсын Их Хурлын ард түмний төлөөллийн дээд байгууллагын бас хамтын үүрэг гэж ойлгож байгаа. Энэ сонсгол дээр хууль таны хөндөж байгаа хуулийн байгууллагуудтай холбоотой асуудал нотлох баримтаар хөндөгдөнө. Та түр хорооны гишүүн. Бид хамтдаа энэ асуудлыг ярих бололцоо үүсэх байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа. Асуулт үг нөгөө тогтоол учраас. ХЗБХ-ны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалтад бэлэн байна уу? Санал хураалт. Эхний санал хураалт учраас бүртгэлийн санал хураалт. Энэ бүртгэлд ороогүй гишүүдийг дуудъя. Одоо ХЗБХ-ны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг сонгохыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 85.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Байнгын хорооны даргаар сонгох саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын

тогтоол баталсанд тооцлоо. Тогтоолыг уншиж танилцуулъя.

Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай, Монгол Улсын Их Хурлы тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2 дахь хэсэг, санал хураалтын нэг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаярыг Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны даргаар сонгосугай.

2. Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатарыг Монгол Улсын Их Хурлын ХЗБХ-ны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Энэ, 3. Энэ тогтоолыг 2023 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Тогтоолын эцсийн найруулгатай саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг баталсанд тооцлоо. Ингээд ХЗБХ-ны даргаар сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн Баттөмөрийн Энхбаяртаа бас ажлын амжилт хүсье. Тэгээд энэ бол их бас хариуцлага юм. Энэ аливаа энэ томилгоот ажлууд бол хариуцлагууд. Тэгэхээр ер нь Улсын Их Хурал 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр төсвийн томилгооны эрх мэдлүүдээс татгалзаж Засгийн газарт бүрэн эрхийг шилжүүлсэн. Тэр хэрээрээ хууль батлаад орхидог, хэрэгжилтэд нь хяналт шалгалт байдаг ажил өнгөрсөн 30 жил хаягдаж ирсэн, хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаад дүгнэлт хийж хяналт, нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн аливаа асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн саналаар 19 гишүүний саналаар дээш гишүүний саналаар бол Хяналт шалгалтын түр хороо байгуулж мөрдөн шалгах үндсэндээ эрхтэй ийм хяналт шалгалтын ажиллах ажил явуулах эрхийг Үндсэн хуулиар бий болгосон.

Энэний үр дүнд 2022 оноос энэ хууль хэрэгжиж эхэлснээр энэ Хөгжлийн банкны

асуудлаар хяналт шалгалтын түр хороо байгуулагдаж, ер нь энэ Хөгжлийн банк, оффтейк гэрээ, нүүрсний хулгай гэх мэт олон асуудлаар энэ ажлын хэсгүүд шүгэл хүлээж Улсын Их Хурлаас эхэлж л энэ шүгэл үлээж энэ асуудлуудыг ил тод болгож, мэдээлэл ил тод байдал хангагдаж, Улсын Их Хурал, Засгийн газар одоо энэ тэмцлийг эхлүүлсэн гэж хэлж болно. Засгийн газар энэ чиглэлээр ажиллаж байгаа. Тэгээд энэ ажлыг нь түр хорооны ажлыг бол одоо эхний хяналт шалгалтын түр хорооны хурлууд хэд хэд болсон боловч одоо Хөгжлийн банк дээр байгуулагдан ажиллаж байгаа энэ анхны мөрдөн шалгах үр дүнтэй ирэх долоо хоногт хэлэлцэх гэж байгаа. Энэ түр хороонд олон гэрчийг давхардсан тоогоор дуудаж, нотлох баримтуудыг шинжлэн судалж, энэ сонсголыг Монголын олон нийтийн радио телевизээр шууд дамжуулна. Тэгээд энэ сонсголыг хариуцлагатай зохион байгуулах хэрэгтэй. Одоо ХЗБХ-ны даргын хувьд, Түр хорооны даргын хувьд ч гэсэн тэр.

Ер нь бол цаашидаа энэ газрын багц хууль, том реформын хууль, Улс төрийн нам, Улс төрийн намын санхүүжилтийн хууль, том реформын хуулиуд, энэ бүхэнтэй ч Үндэсний баялгийн сангийн хууль том реформын хууль. Тэгээд энэ бүхэнтэй ч гэсэн энэ хэлэлцүүлгүүд уялдах ёстой. Ер нь бол бас нөгөө талаас энэ Улсын Их Хурал, нүүрсний хулгай, Хөгжлийн банк гээд ингээд олон шүгэл үлээж нүүрсний гэх мэт Таван толгой, төмөр замын бүтээн байгуулалт нүүрсний оффтейк гэрээний асуудлыг Улсын Их Хурал, Засгийн газар одоо ярьж хэлж, шүгэл үлээж ингээд жагсагчид иргэдийн зүгээс ил болгож харах шаардлагатай гэж хуулийн байгууллагад шилжүүлээд сар ч хүрэхгүй хугацаа болж байна.

Тэгэхээр энэ бол хүний эрх талаасаа ч гэсэн, Эрүүгийн хэргийн хянан шийдэх процесс талаасаа ч гэсэн ингээд гэнэт одоо шүүхээр тогтоогдоогүй байхад яаруу сандруу хүнийг шийддэг, шийтгүүлдэг юм бол зарладаг юмнууд байж болохгүй. Ийм

учраас энэ дээр анхаарал тавьж, тэгээд олон эрүүгийн хэрэг үүсгэгдээд шалга, үргэлжлэн явагдаж байгаа гэж бид ойлгож байгаа. Тэгээд энэ мөрдөгдөж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар нотлох баримтыг цуглуулах, шинжлэн дүгнэх, шинжээч томилох, дүгнэлт гаргах, үйл баримтыг сэргээх ажлууд бүгд цаасан суурин дээр явагддаг. Маш их цаг хугацаа ордог ажил гэдгийг иргэд олон нийт, гишүүд ойлгож, сая Ганбат гишүүний хэлээд байгаа энэ саналуудтай ч уялдуулж хэлэхэд ер нь бол мөрдөх байгууллагууд болон прокурор, шүүхийн байгууллагын ажилд эрх зүйн болон төсөв орон тооны талаас нь л дэмжлэг үзүүлнэ үү гэхээс биш хөндлөнгөөс нөлөөлөх, чиглүүлэх, тэгээд одоо нэр ус шаардах, зарлуулах ч гэдэг юм уу энэ ажил бол бас хуулиар хориотой гэдгийг бас бид анхаарч ажилламаар байгаа юм. Энэ процесс чинь маш их процесс шаарддаг ажил учраас Эрдэнэтийн хэрэг гэхэд чинь одоо 2 жил гаруй шалгагдаад шүүхэд шилжиж байгаа гэж сая сонслоо.

Хөгжлийн банкны хэрэг 11 сар шалгагдаад шүүхэд шилжиж байгаа, наян хэдэн хүн шилжиж байгаа гэж сонслоо. Тэгээд энэ бүхэн чинь бол одоо энэ цаасан суурин дээр маш нотлох баримттай, үнэн зөв явагдах асуудал дээр бол анхаарч дэмжлэг үзүүлж, харин ч энэ орчин үеийн дэвшилт технологи ашиглан мөрдөх ажиллагааг илүү шуурхай явагдах эрх зүйн орчныг бий болгох талаас нь ХЗБХ дэмжиж ажиллах хэрэгтэй. Энэ дээрээ бол одоо ХЗБХ-ны дарга бас нягт хамтран ажиллах хэрэгтэй гэдгийг бас энд онцлон хэлж байна. Энэ маш их хугацаа шаарддаг энэ ажлууд дээр бас тийм энэ шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг гэдэг ийм хэргүүдийг бол ... болохгүй, нөлөөлж болохгүй гэдэг ийм зарчим баримтлах нь зүйтэй байх. Ингээд ХЗБХ-ны даргын ажилд амжилт хүсье.

10.40 цаг

Хоёр.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүн 2016.12.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалдаа орно. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан нарын 18 гишүүнээс 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2022 оны 10 дугаар сарын 30-ны өдөр, 2023 оны 01 дүгээр сарын 5, 6-ны өдрүүдийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Тус Байнгын хороо нь 2023 оны 01 дүгээр сарын 14-ний хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44, 42 дугаар зүйлд заасныг баримтлан дээрх хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаа. Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас санал хураалт явуулахгүйгээр төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулахаар Байнгын хороонд шилжүүлсний дагуу ажлын хэсэг төслийн 10, 25 дугаар зүйлүүдэд заасан Монголбанк, СЗХ-ноос хамтран батлах журмуудын ерөнхий зохицуулалтыг дэлгэрэнгүй тусгасан зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг бэлтгэснийг Монгол Улсын

Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д заасныг үндэслэн санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Хуралдааны нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан зарчмын зөрүүтэй саналуудыг төсөлд нэмж тусган төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүй, алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, хууль зүйн техникийн шинжтэй засваруудыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны хуралдаанаар дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналууд саналын томьёоллуудыг Байнгын хорооны танилцуулгын хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын Банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Банк банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэж шийдвэрлэж, хуулийн төслүүдийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Сандагийн, Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Та бүхэнд энэ өглөөний амрыг эрье. Тэр энэ хуулийн асуудал бас өмнө нь нэг хөндөгдсөн юм. Тэгээд өмнө нь нэг хөндөгдөөд буцахдаа яаж буцсан гээд гэхээр гадаадын улс орнуудын төрийн өмчийн компани хөрөнгө оруулалт хийж болохгүй гэдэг л нэг ийм асуудал яригдаж байсан. Тэгээд сая одоо

ингээд эцсийн хэлэлцүүлэгт бид л юу хэлэлцээд орж ирж байна шүү дээ. Тэгэхээр одоо бол хуульд ямар нэг гадаадын улс орнуудын төрийн өмчит хуулийн этгээд бол энд бол хөрөнгө оруулалт хийх ямар ч бололцоогүй гэж би ойлгож байгаа. Энийгээ би одоо бататгаад сонсчихъё гэж бодож байна.

Хоёрт ер нь энэ бид нар гадаадын ямар нэг томоохон улс оронд дамжсан банкны салбар байхгүйгийн шалтгаан юу юм бэ гэж Монголд. Ерөөсөө гадаадын том хөрөнгө оруулалтыг дагаж банкнууд орж ирдэг. Риотинто Оюу толгойг дагаж 2 том банк орж ирэх гэж байсан 2 том банк өрсөлдөөд явж байсан. Гэтэл бид нар гэрээ байгуулахдаа Оюу толгойн мөнгийг оруулж ирэхгүй байж болно гээд л зөвшөөрчихсөн байхгүй юу. Гадаадад хадгалж зарцуулж болно гээд л ингэчихсэн. Тэрнээс болоод гаднын тийм том банк орж ирэх хаалга нь хаагдчихсан. Ер нь бол гаднын том хөрөнгө оруулалтыг дагаж л Монголд орж ирнэ. Тэгэхэд Монголд өнөөдөр одоо улс орнууд дамжсан тийм банкны том гаднын юу байхгүй байна шүү дээ, хямд эх үүсвэр байхгүй шүү дээ. Тэр бол бид нараас болсон байхгүй юу. Бид нар өөрсдөө гаднын том хөрөнгө оруулагчаа гадаадад мөнгөө байршуулахыг зөвшөөрөөд байгаа явдал байхгүй юу.

Тэгээд энэ цаашидаа бол бас нэг анхаарах ёстой юм бол би гуравт юу үнэт цаас гаргана гээд байгаа шүү дээ. Тийм ээ. Үнэт цаас гаргана гээд байгаа юм. Ингээд гадаадын зах зээл дээр үнэт цаас гаргаж, босгоод ингээд нөгөө өр чинь өөрөө Монгол Улсын өрд л тооцогддог юм. Одоо тэр битгий хэл Оюу толгойн өр Монгол Улсын өр дээр тооцогдоод л 30 хэд болчихсон явж байгаа шүү дээ. Тэр 12 тэрбум доллар чинь. Тэгэхээр энэ тал дээр бас ер нь цаашидаа нэлээн анхааралтай байхгүй бол Хөгжлийн банк шиг асуудал үүсэх юм бол энэ дээр нэг осолтой юм байгаа шүү гэж би хэлээд байгаа юм. Яагаад гэвэл эх үүсвэр татахдаа одоо үнэт цаас гаргана гээд ингээд заачихсан. Тэгэхээр энэ мэтийн зүйлүүд дээр бол анхаарах ийм шаардлага

байх ёстой. Эхнээсээ зөв явахгүй бол болохгүй гэдгийг бол хэлье.

Тэгээд цаашидаа энэ хууль гарсны дараа одоо хэрэгжүүлэхэд бас нэг манай СЗХ холбогдох байгууллагууд, Монголбанк энэ тэр бас хяналт тавьж ажиллах ёстой шүү. Монголбанк хяналт сайн тавиагүйгээс л өнөөдөр Хөгжлийн банкны асуудал үүссэн шүү дээ. Хяналтаа сайн тавиагүй. Тэгээд нэг Хөгжлийн банк гээд нэг Төв банкны хуулиараа хамаарах ч юм шиг, хамаарахгүй ч юм шиг банк байгуулж хаяж байгаад л тэгээд л байхгүй болчихсон. Тэгээд л тэр хөрөнгүүд угаагдчихсан. Тийм учраас ер нь яах вэ төр төрийн нэрийн өмнөөс мөнгөний бодлогыг явуулаад, өр зээлийн асуудал дээр хяналт тавьж байгаа байгууллага нь өөрөө Төв банк юм чинь ер нь бас энэ одоо банкнууд дээр бол тавих хяналтаа эхнээсээ СЗХ банк маш сайн ажиллах ёстой шүү гэдгийг би эцэст нь хэлье.

Г.Занданшатар: Үг хэллээ. Сандагийн, нэг асуулт. Байнгын хороо хариулъя. Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг. Ажлын хэсэг байгаа юм уу, хариулах юм уу?

Ц.Цэрэнпунцаг: Даваасүрэн гишүүний асуултад хариулъя. Саяын Даваасүрэн гишүүний эхний асуулт төрийн өмчтэй гадаадын төрийн өмчтэй банк бол банк хөрөнгө оруулалт хийвэл яах юм бэ, энэ хуулиар зохицуулж байгаа юу гэж байна. Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар бол нэг улсын хөрөнгө оруулалт бол одоо гуравны нэгээс нийт гадаадын хөрөнгө оруулалтын одоо манай улс руу орж ирж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын гуравны нэгээс илүүгүй байх ёстой гэсэн энэ Гадаадын хөрөнгө оруулалтын хуульд одоо байгаа энэ заалтын дагуу бол энэ гадаадын хөрөнгө оруулалтын хуулиар явна.

Хэрэв энэ дээр одоо гаднын гадаадын төрийн өмчтэй одоо банк зөвшөөрөл хүсээд энэ лимит хэтэрчихсэн байх юм бол энэ одоо Үндэсний аюулгүй

байдлын зөвлөл дээр бас давхар санал авахаар, авч байж энэ бол одоо зөвшөөрлийг нь одоо Монголбанк, СЗХ гаргана. Өөр Энхтайван нэмж хариулах уу.

Г.Занданшатар: 81.

Г.Энхтайван: Даваасүрэн гишүүний асуултад тодруулъя. Энэ хуулийн Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 15.2 дээр гадаад улсын төрийн өмчит хуулийн этгээд, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тусгай зөвшөөрөл хүссэн тохиолдолд ямар зохицуулалттай байх тухай нарийвчлан зохицуулсан байгаад байгаа юм. Хэрэв төрийн өмчит хуулийн этгээд тусгай зөвшөөрөл хүссэн бол Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 21.1 дээр заасны дагуу одоо Монгол Улсын Засгийн газраас буюу одоогоор гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эдийн засгийн хөгжлийн яамнаас урьдчилсан зөвшөөрөл авч байгаа. Урьдчилсан зөвшөөрөл авч байгаа.

Гадаадын хөрөнгө оруулалт, Хөрөнгө оруулалтын тухай хуулиар тухайлсан 3 салбар буюу банк санхүү, харилцаа холбоо, уул уурхайн салбарт гадаад улсын ТӨК орж ирж байгаа бол урьдчилж зөвшөөрөл авах ийм зохицуулалттай байгаад байгаа. Тэгэхээр яг энэ дагуугаа явна. Энийг бол хуулийн 15.2 дээр нарийвчлан зохицуулаад өгсөн байгаад байгаа. Мөн Даваасүрэн гишүүний түрүүний хэлдэг тэр гадаад эх үүсвэрээс үнэт цаас гаргаад, хөрөнгө татаад явж байгаа нь цаашидаа манай улсын гадаад өрд тооцогдоод явна гэсэн. Энэ бол яг гишүүний хэлж байгаа бас яг зөв. Бид бүхэн тэгэхдээ энэ гадаад хөрөнгө оруулалт буюу гадаад зах зээл дээр үнэт цаас гаргаж байгаа энэ тоо хэмжээ болон хэлбэр одоо хэмжээ максимум хэмжээн дээр бол ямар нэгэн хязгаарлалт, энэ хуулийн төслөөр бол тавихгүй байгаад байгаа.

Гэхдээ энэ нь бол нэг талаасаа гадаад өр гэж эдийн засгийн харьяатаас

харьяат бусаас орж ирж байгаа гадаад өр гэж бүртгэгдэж байгаа ч, нөгөө талдаа төлбөрийн тэнцэл дээр бол гадаадын хөрөнгө оруулалт гэж бүртгэгдээд явна. Тэгэхээр бол энийг төлбөрийн тэнцлийн санхүүгийн дансан дээр хөрөнгө оруулалт гээд бүртгэгдээд явах учраас энэ дээр бол одоо бусад одоо гадаадын хөрөнгө оруулалттай ижил статустай явагдана. Тэгэхээр энэ дээр бол Төв банкны зүгээс тухай бүрд нь зохицуулсан хяналтаа тавиад явна. Гишүүний тавьж байгаа саналтай бол бүрэн санал нэгдэж байна.

Г.Занданишатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ хөрөнгө оруулалтын банк байгуулах, Банкны тухай хууль батлах гээд их олон жил ярьсан, яригдсан их эрсдэлтэй гээд байсан. Ер нь бол энэ цагийн үед бас батлах нь зөв байх. Гэхдээ сая орж ирж байгаа нь зарчмын зөрүүтэй саналын томъёолол дээр нэг 2 заалт байна л даа. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааны хувьцааг тав хүртэл жилийн хугацаанд эзэмшиж болно 10.5. 10.6 хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны хорь хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаанд саналын эрхгүй байна гээд. Хөрөнгө оруулалтын банкнууд Монголд орж ирнэ. Монголд орж ирээд томоохон төслүүдийг санхүүжүүлнэ. Томоохон компаниудад юу төслийн одоо зээлүүд авна. Төсөл нь одоо амжилтгүй хэрэгжиж байвал төслийнх нь одоо эрсдэлтэй учирвал үндсэндээ тэр компани, тэр төсөл, тэр хөрөнгө хөрөнгө оруулалтын банкны нэг талаасаа бол одоо мэдэлд бүрэн шилжих ёстой. Яагаад гэвэл зээлээ өгсөн учраас. Ингэх юм бол одоо урьд нь болгоомжилсон шалтгаан бол ингээд үндсэндээ бол Хөрөнгө оруулалтын банк оруулж ирээд Монголчуудыг хөрөнгийн зах зээлийн мэдлэгтэй мэдлэггүй санхүү, хувьцаа, лиценз энэ одоо олон улсын одоо санхүүгийн хэлцлүүдийн талаар ойлголттой, ойлголтгүйгээс нь болоод одоо үндсэндээ лицензүүдийг хамаад

авчихна. Монголын томоохон компаниудыг бүгдийг нь одоо тийм худалдаад авчихна гэдэг л урьд нь болгоомжлол байгаад үүнээс болоод ерөөсөө баталдаггүй байсан, ярьдаггүй байсан. Гарцаа байхгүй одоо юу гэдэг юм зах зээлийн харилцаанд оролцоо, Монголчуудын бизнесийн харилцаа, эдийн засгийн мэдлэг мэдээлэл бас нэлээн сайн боллоо. Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл хөгжиж байна. Одоо бол харьцангуй тэр эрсдэлүүд бас багасаж л байгаа байх.

Гэхдээ тэгээд энэ заалтаар харах юм бол зориуд зорилготойгоор одоо юу гэдэг юм зээл авчхаад бүх одоо хувьцаагаа бүх одоо хөрөнгөө бүх төслөө барьцаалж зээл авчхаад тэр зээлээ төлж чадахгүй тохиолдолд тавхан тав хүртэл жилийн хугацаанд хорь хүртэл хувийн хувьцааг нь хөрөнгө оруулалтын банк саналын эрхгүйгээр эзэмших нь. Ийм эрсдэлтэй тохиолдолд одоо хөрөнгө оруулалтын банк хөрөнгө оруулах уу? Ийм тохиолдолд одоо тэр хөрөнгө оруулалтын банкны эрх ашиг яаж хангагдах вэ? Энэ тал дээр бас ямархуу одоо үндэслэлээр энийг оруулсан юм бэ гэдгийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт нь дахиад нөгөө асуудал тийм үү. Ерөөсөө одоо хөрөнгө оруулалтын банкнууд маань орж ирээд энэ бол Монгол Улсын нөгөө томоохон одоо төрийн өмчит компаниуд, хувийн хэвшлийн томоохон компаниуд энэ том том төслүүд, дээрээс нь одоо уул уурхайн томоохон ордууд, лицензүүд эдгээрийг чинь тэгээд зээл өгч байгаад л яаж ийж байгаад л одоо наагуур цаагуур хуйвалдаад нэг мэдсэн одоо юу гэдэг юм Хөрөнгө оруулалтын банкны өмч болчихсон байх энэ эрсдэлээсээ хамгаалсан заалтууд бас нөгөө талд нь байж чадаж байгаа юу? Энэ 2 дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Г.Занданишатар: Байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуултад хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Дараа нь Энхтайван, ажлын хэсгийнхэн нэмж

хариулаарай. Нэгд, түрүүчийн тэр Бямбацогт гишүүний өмнө нь энэ хууль хэлэлцэгдэж байх үед өмнө нь орж ирж байхад одоо бас анхаарч авч үзэх ёстой байсан асуудал бол энэ барьцааны асуудал байсан гээд байна, тийм ээ. Барьцааг одоо ингээд лицензээ барьцаалчих вий, лицензээ барьцаалаад алдчих вий гээд ингээд ийм асуудал байсан гэхээр. Тэгэхээр энэ бол энэ хууль үйлчилснээр бол хөрөнгө оруулалтын гадаадын хөрөнгө оруулалтын банк гадаад гадаадын биш хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкнаас зээл авч байгаа зээлдэгч бол одоо удаан хугацаатай төсөл хөтөлбөр энэ рүүгээ бол зээл авна. Мэдээж энд одоо зээл авахдаа бол энэ зээлийн барьцаа бол одоо Банкны тухай хуулиар зохицуулагдана.

Тийм учраас бол өнөөдрийн арилжааны банкнууд бол өнөөдөр зээлдэгчтэй зээл олгохдоо бол өнөөдөр хэрэв уул уурхайн компани байх юм бол одоо энэ уул уурхайн компанийнх нь тэр лицензийг бол одоо барьцаанд авч байгаа. Тэгээд энэ барьцаанд аваад, тэгээд энэ зээлд нь эрсдэл гараад ингээд хэрэв тэр банк одоо энэ зээлдэгчээсээ энэ лицензийн барьцаанд авсан лицензийг нь авах тохиолдол гарах юм бол энэ банк өөрөө бол эзэмшихгүй. Банк бол дараагийн одоо энэ зээлийн төлөх одоо энэ тэр бизнест энэ лицензийг нь одоо эзэмшүүлэх ийм процесс болно. Тийм учраас бол одоо шууд банк лицензийг нь авахгүй банкны барьцаанд байна. Тэгэхдээ дараагийн тэр одоо лицензийг эзэмшиж тэр банкны өрийг барагдуулж, тэр гэрээний гүйцэтгэлийг хангах тэр бизнесийнхэн бол Ашигт малтмалын хуулийн дагуу лицензээ шилжүүлж авна. Тэр хуулиар бол одоо лицензийн одоо дуудлага худалдаагаар мөн одоо хэлэлцээрт орж хэлэлцэх энэ хэлэлцээрээр явж, өнөөдрийн л явдаг энэ Ашигт малтмалын хуулиар явж байгаа учраас бол энэ банкин дээр бол ямар нэгэн лиценз бөөгнөрч банкны эзэмшилд баахан лиценз очно гэсэн ийм эрсдэл бол гарахгүй юм байгаа юм. Энхтайван тэгээд 2 дахь асуултад нь хариул даа.

Г.Занданиатар: 81. Энхтайван Монголбанкны.

Г.Энхтайван: Бямбацогт гишүүний асуултад нэмж хариулъя. Бямбацогт гишүүн энэ хуулийн төслийн 10.6 дээр байгаа хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч холбогдох этгээдийн гаргасан хувьцааны хорь хүртэлх хувийг эзэмшиж болох уу гээд эзэмших хувьцаа нь саналын эрхгүй, тэгээд 5 жилийн хугацаатай байна гэдэг зохицуулалт дээр саналаа хэллээ. Бид бүхэн анх одоо өргөн мэдүүлсэн хууль дээр бол энэ 20 хувь гэдгийг бол 49 хувь гэж оруулж ирсэн байсан.

Хөрөнгө оруулалтын банкны өөрийнх нь үндсэн, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны өөрийнх нь үндсэн үйл ажиллагаа бол төсөл санхүүжүүлэх байгаад байгаа, төсөл санхүүжүүлэх. Бусад холбогдох үйл ажиллагаа нь бол зөвхөн төсөл санхүүжүүлэх үндсэн үүргийнхээ дагалдах хэрэгсэл болж явна. Тэгэхээр хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк тухайн төслийг санхүүжүүлж явж байхдаа тухайн төслийн одоо үйл ажиллагаа болон холбогдох бусад зүйлстэй танилцах, мэдээлэл авах төслөө амжилттай явуулах үүднээс бол компанийн хувьцааг нь төслийнхөө тэр тухайн зээл олгож байгаа хуулийн этгээдийнхээ хувьцааг хорь хүртэл хувийг эзэмшдэг байя гэж байгаа юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулиар арилжааны банк нь хуулийн этгээдийн хувьцааны 10 хүртэл хувийг л эзэмшиж байгаа. Тэгэхээр хөрөнгө оруулалтын банкин дээр энэ нь илүү уян хатан байгаад хорь хүртэл хувиар эзэмшээд явъя энэ гэж байгаа юм.

Тэгэхээр энэ нь болохоор хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь зөвхөн өөрийнхөө хуулиар олгогдсон бизнесээ хийе. Бусад төрлийн бизнес буюу одоо одоо бид бүгдийн болон олон нийтийн шүүмжлээд байгаа банк бус өөр янз янзын төрлийн бизнес хийгээд яваад байна гэдэг энэ агуулгыг болиулаад, зөвхөн банк өөрийнхөө

төслөө санхүүжүүлэе, өөрийнхөө хуулиар олгогдсон бизнесээ хийдэг болъё л гэж байгаа юм. Олон улсын жишигээр бол бид бүхэн бол нэлээн олон судалгаа харсан. Тав хүртэл жил гэдгийг бол маш олон орны хууль дээр бол байдаг юм байна лээ. Ер нь бол олон улсын жишиг дундаж нь бол төслийнхөө хэмжээнээс хамаараад бол нэг 5-9 жилийн хугацаанд эзэмшдэг юм байна лээ. Одоо бид бүхний сүүлд бол авсан яг манайхтай яг ижил төрлийн ийм хууль гаргасан бас яг ийм төрөлжсөн банкны тухай хууль бол оруулж ирсэн. Ирланд дээр бол яг энэ хугацаа бол 7 жил байгаад байгаа юм. Төслийнхөө хэмжээнээс шалтгаалаад.

Тэгэхээр тухайн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь өөрийнхөө хөрөнгө босгож санхүүжүүлж байгаа төсөл хөтөлбөр, төсөл дээрээ тухайн хуулийн этгээдийнхээ хувьцааг 5 жил эзэмшээд, 5 жил дотроо тухайн бизнес төслийн үйл ажиллагааг явуулна. Явуулна л гэсэн үг санхүүжүүлнэ гэсэн үг. Хэрэв тэгээд 5 жил нь өнгөрөх юм бол тухайн хувьцаагаа бол буцаагаад хуулийн этгээддээ зарна гэсэн үг. Тэгэхдээ энэ бүх үйл ажиллагаанд бол тухайн төсөл хэрэгжүүлэгч ААН-ийн бодлого үйл ажиллагаанд нь оролцохгүй, зөвхөн мэдээлэл авах зорилгоор хувьцаа эзэмшээд явна гэж байгаа. Энэ нь бол саналын эрхгүй байдал байна гэдэг 16-гийн заалтаар зохицуулж өгсөн байгаад байгаа.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан асуулт асууна.

Б.Дэлгэрсайхан: Энэ нэгэнт 3 дугаар хэлэлцүүлэг орж ирж байх үед нь таарчихлаа л даа. Тэгээд нэгэнт гаднын хөрөнгө оруулалтын банк оруулах гэж байгаа бол жоохон гайгүй хууль хийж, гайгүй томхон юм оруулж ирмээр байгаа юм. Ингээд баахан юмаар хязгаарлачихаар банк бусархуу л юм орж ирнэ дээ. Та нар хараарай. Энэ ялангуяа одоо тэгээд л нэг хэмжээг нь дэндүү хязгаарлагдмал зааж өгвөл тэгээд л нэг жижиг мөнгөтэй гарууд орж ирээд л тэгээд нэг ийм банк гэхэд

хэцүү, банк бус гэхэд хэцүү ийм юм болох вий. Зүгээр манай Монголбанкныхан мэдэж байгаа юм байгаа биз дээ. Нэгэнт одоо бид нар чинь эдийн засгаа тэлье, гаднын банк оруулъя гэж байгаа бол жоохон томхон эрх, үүргийг нь ч гэсэн тавиад л ер нь нэг томхон тийм банк орж ирэх боломжийг нь хангаж өгөх талаас нь анхаарах ёстой байх гэж бодож байгаа юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт бол энэ банк орж ирэхийг бол дэмжиж байна. Яагаад вэ гэхээр манай ашигт малтмал эрхэлж байгаа улсууд бол ихэвчлэн гаднын банкнаас зээл авдаг. Лицензээ барьцаалаад. Тэгээд ингээд харж байхад бол мөнгө нь гаднаас орж ирдэггүй. Энэний хамгийн том жишээ та нар бол Саусгоби дээр харсан байх. Мөнгийг нь бол шараад аваад явчихсан. Тэгээд лиценз эксим дээр очсон. Хятадын эксим банк дээр тийм биз. Тэгээд өнөөдөр Эксим банкны төлөөлөгч нэртэй хэдэн улсууд тэгээд өнөөдөр нүүрс гаргаад ингээд энэ уурхайг эзэмшиж байгаа. Ийм юм бол Монголын ашигт малтмал дээр дүүрэн бий. Бүр одоо л зарим нь бол одоо Монгол талтайгаа хуйвалдаж байгаа ч гэсэн лицензээ банканд тавиад, мөнгийг нь хуваагаад зориулалтын дагуу ашиглахгүй оруулж ирээд хуваагаад ингээд алга болгочихсон. Тэгээд ийм баахан лицензүүд барьцаанд байгаа. Банк энийг Монголбанк энийг ямар ч хянах юм байхгүй. Мөнгө орж ирсэн үгүйг нь хэн ч мэддэггүй.

Гэтэл Ашигт малтмалын хуульд тодорхой заалт байхгүй. Ерөнхийдөө нэг хяналт тавина л гэсэн нэг ийм юм байгаа юм. Тийм учраас энэ Банкны хуульдаа ч тэр одоо энэ орж ирэх Ашигт малтмалын хууль дээр ч тэр яг энэ ашигт малтмалыг зориулж зээл авсан бол зориулалтын дагуу ашиглаж, энэ мөнгө нь орж ирж үү, үгүй юу гэдгийг 2 талаасаа хянахгүй юм бол энэ Монгол Улсад энэ лицензүүд шиг ийм арга замаар гаднынхны гарт орчихоод байгаа юм шүү. Тэгээд гаднын банкандаа ч эрсдэлтэй болчихсон, гаднынхан ч хөрөнгө оруулж байгаа нэртэй одоо Монголын нэг цаасыг аваачиж барьцаанд тавиад мөнгөтэй болоод бултчихдаг. Манайханд нэг жоохон

хувь хүртээд үлддэг нэг ийм л жишиг тогтсон шүү дээ. Тэгээд энэ хууль чинь ийм заалт нэг ч алга байна шүү дээ. Тэгээд энийгээ та нар юу гэж хариулах юм бэ? Энэндээ бодитой хариулт өгөөч.

Тэгээд дараа нь Ашигт малтмалын хууль орж ирэхэд энийг бүр томоохон бүлэг заалт болгож оруулахгүй бол ийм бүлэглэл бий болсон. Гаднынхантай хуйвалдаад Монголын лицензийг тавиад, тэгээд мөнгийг нь хувааж идээд, зориулалтын дагуу ашигладаггүй ийм юм бий болчихсон. Тэгээд сүүлд нь шүүхээр яваад, тэгээд тэр нь нэг арбитраар орсон болоод Монголын Засгийн газар ингээд олон улсад өрөнд ордог. Хождог улсууд нь нэг хөрөнгө оруулагч нэртэй, тэгээд энэ нэг зуучилсан Монгол хоёр л хожиж байгаа юм шүү дээ. Ийм жишээ бол олон мянгаар нь хэлж болно. Би ганцхан жишээ хэлсэн. Ашиг энэ Саусгоби дээр ийм юм болсон шүү. Тийм учраас бол Монголд банк орж ирж байгаа нь сайн. Тэгэхдээ оруулах гэж байгаа бол олигтойхон шиг оруулсан нь дээр шүү дээ. Тэгэхгүй өнөөдрийн одоо энэ манай Монголын банкнуудын өгч байгаа шиг ингээд жижигхэн зээл өгөх юм бол ямар ч хэрэггүй шүү дээ.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн ажлын хэсэг юу Байнгын хороо хариулна.

Ц.Цэрэнпунцаг: Дэлгэрсайхан гишүүний эхний асуулт. Энэ хязгаарлалт их байна гээд энэ хууль дээр гаднын одоо банкнууд хөрөнгө оруулалтын банк орж ирвэл гээд байна. Энэ бол нэг талаасаа харин бүр их нээлттэй байгаа. Бид нар бол бас хязгаарлалтууд байсныг нь ажлын хэсэг дээр ярилцаад нэлээнийг нь авсан. Тийм ээ. Нэг жоохон хязгаарлалт гэж хэлж болох юм бол бид нар тэр хөрөнгө оруулалтынх нь өөрийн хөрөнгийн хэмжээ байгаа юм. Тэр нь одоо нэг 500 байсныг нь энд бас чуулган дээр бас л нааш цаашаа ярьж байж, өнөөдөр бол энийг нь Монголбанк өөрөө тогтооё гэсэн юм. Эдийн засгийнхаа тухайн цаг үеийн нөхцөл байдал ямар байх юм. Хэрэв эдийн засаг

том өсөлт сайтай томроод байвал мэдээж өндөрсөнө. Бага юм гарч болж хумигдаад байвал энийг бол одоо тод цаг, нөхцөл байдалдаа бас одоо зохицуулж Монголбанкнаас зохицуулсан нь зүгээр юм байна гээд.

Тэгээд энэ банкнууд орж ирэхэд гаднын банкнууд орж ирэхэд бол ердөө 3 жилийг хязгаарлах гэх юм бол 3 жилээс дээш жил ажилласан, тэр өөрийнхөө тэр толгой компани байгаа тэр хөрөнгө оруулалт байгаа банк байгаа тэр улс орныхоо одоо тэр зохицуулах байгууллагаас нь бол ерөнхийдөө мэдээлэл шугамаар мэдээлэл авна. Энэ бол танай улсад энэ ийм үйл ажиллагаа явуулдаг банк мөн үү, биш үү гэдэг дээр. Тэр 3 жилээс дээш ажилласан, дээ ажилласан байх ёстой. Энэ дээр бол бүр өндөр шаардлагууд байсныг нь энэ төсөл дээр байснуудыг нь авсан. Мөн гарахдаа одоо 10 жил хүртэл энэ буцааж хөрөнгө оруулалтаа одоо гаргахгүй ийм хатуу түгжсэн байсныг нь бол авсан. Энэ бол чөлөөтэй байгаа. Гэхдээ энэ бол гаднын банкны хууль биш. Ерөнхийдөө бол хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хууль байгаа юм шүү Дэлгэрсайхан гишүүнээ. Гэхдээ гадаад, дотоодын аль алинд нь нээлттэй. Тийм учраас дотооддоо ч гэсэн дотоодынхоо хөрөнгө оруулагчид бас боломж нээсэн, гадаадын хөрөнгө оруулалт хийх гадаадын хөрөнгө оруулалт, оруулалтын банкнуудад бас боломжийг нь нээсэн. Ийм хязгаарлалт бол харин маш бага. Эрх чөлөөтэй тийм хууль болсон. Та бас сайн харвал энэ унивал байгаа. Тэгээд дараа нь танд сайхан тайлбарлаж өгч болно.

Тэр лиценз барьцаалаад байгаа барьцаалаад одоо энд ийм гаднынхан лиценз барьцаалчхаад ийм мөнгө босгодог ийм юм болоод яваад байна гэдэг бол яг энэ хууль гарахгүй байснаар ийм болсон. Ерөөсөө л гаднын хөрөнгө оруулалтын гадаадын банкнууд орж ирээд энэ хууль байхгүй, лиценз байхгүй, нэг төлөөлөгчийнхөө газрыг нээхдээд байгаад байсан. Тэгээд төлөөлөгчийнхөө газраар дамжуулж зээлийн хүсэлт аваад,

тэрнийгээ л одоо гадагш гадна талаасаа гадаадад очиж тэр зээлийнх нь одоо зээлээ гадна гаргадаг энэ процесс явчихсан учраас одоо бол учраас энэ таны яг сая гараад байгаа асуудлууд гараад байсан юм. Энэ хууль гарснаар бол энэ асуудлыг шийдэж байгаа юм. Энэ хууль гарснаар яаж шийдэж байгаа юм гэхээр зэрэг энэ хөрөнгө оруулалтын гадаадын энэ хөрөнгө оруулалтын банк гадаадаас орж ирээд оруулсан, гаднаас хөрөнгө оруулалт хийх юм бол энэ Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын татвар төлөгчид л одоо үйл өөрийнхөө үйлчилгээг үзүүлнэ. Тийм учраас бол энэ Монгол Улсад татвар төлж байгаа Монголын компаниудын одоо тэр лицензийг Ашигт малтмалын хуулийн дагуу, Банкны хуулийн дагуу одоо барьцаалаад тэгээд нэг Ашигт малтмалын газар бүртгэлтэй тэр лиценз бол энэ Монгол Улс дотроо одоо банканд тавигдах, тэгээд барьцаанд одоо банканд хадгалагдах энэ ерөөсөө Монгол Улсынхаа хил дотор, Монгол улсынхаа энэ хуулийн орчинд явагдах учраас бол энэ хууль гарахгүй байснаас болоод ингээд энэ бүдэг бадаг ийм байснаас болоод ийм одоо сөрөг үзэгдэл гараад байсныг бол одоо энэ хууль гарснаар шийдэх ийм давуу талтай хууль болж байгаа юм.

Г.Занданшатар: 81 Энхтайван Дэд ерөнхийлөгч хариулъя.

Г.Энхтайван: Дэлгэрсайхан гишүүний асуултад нэмж хариулъя. Хуулийн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь зөвхөн гадаад улсын санхүүгийн санхүүгийн байгууллага Монгол Улсад энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаа эрхлэхээр бол зөвхөн охин компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулна. Салбар одоо нээж үйл ажиллагаа явуулахгүй. Тэгэхээр охин компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулна гэдэг маань тухайн хуулийн этгээд Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байна. Монгол Улсад бүртгэлтэй Төв банкнаас тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд байхаар манай үндэсний төлбөрийн системд бүртгэгдэнэ. Үндэсний төлбөрийн

системийн оролцогч болоод явахаар тухайн санхүүгийн институтийн аливаа төрлийн бүх гүйлгээ манай Төв банкин дээр бүртгэгдээд явна. Тэгэхээр мөнгөн хөрөнгийн урсгал дээр бол Төв банк бол энэ дээр хяналтаа тавиад явна.

Гэхдээ бид бүхэн бол Валютын зохицуулалтын хууль болон бусад одоо холбогдох олон улсын нэгдсэн гэрээ конвенцынхоо хүрээнд валютын буюу одоо капитал контрол буюу хөрөнгийн урсгал дээр хяналт тавьдаггүй, хяналт тавихгүй байх үүрэг хүлээдэг. Тэгэхээр бид бүхэн бол гарах урсгал дээр болон одоо бусад урсгал дээр хяналтыг бол капитал контролыг бол тавьдаггүй. Тэгэхээр энэ дээр бол бид бүхэн охин компани хэлбэрээр байгуулагдаж байгаа учраас Төв банк бүх төрлийн хяналтаа бол тавиад явна. Хяналт шалгалтын хүрээнд ч тэр, бусад одоо хуулийн этгээдийнх нь хүрээнд ч тэр. Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкиг бол аливаа уян хатан хэлбэрээр оруулж ирж том санхүүгийн институтүүдийг оруулж ирэх талаар гишүүн ийм зарчмын асуудал хөндлөө. Энэ дээр бол Төв банк ч гэсэн санал нэг байгаа. Бид бүхэн энэ дүрмийн сангийн хэмжээ хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Төв банкин дээрээ тогтооно гэдэг заалтаар авч байгаагаараа илүү уян хатан болгож байгаа юм. Тэгэхээр хуульд одоо энэ Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль дээр өөрийн хөрөнгийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр нэг зээлдэгчид зээл гаргана гэж байгаа.

Тэгэхээр энэ тухайн хөрөнгө оруулагч жишээлбэл гурван зуун тэрбум төгрөгийн дүрмийн сантай оруулж ирлээ гэхэд нэг зээлдэгчийн хэмжээ есөн зуун тэрбум төгрөг байна. Хэрэв 3 их наядын зээл хийхгүй дүрмийн сангийн одоо хөрөнгө оруулаад ирвэл энэ чинь 9 их наядын хэмжээнд очно гэсэн үг. Тэгэхээр олон улсын байгууллагуудын гаргасан судалгаагаар энэ төрөлжсөн банк болон ердийн арилжааны commercial банк хоёрын одоо дүрийн сангийн ялгааг бол бас хэд хэдэн байдлаар бол судалж гаргасан

байсан. Сүүлд гаргасан судалгаагаар бол ер нь бол төрөлжсөн банк ойролцоогоор бол 3-4 дахин их хэмжээгээр дүрмийн сангийн хэмжээ бол тодорхойлогддог юм байна лээ. Тэгэхээр өнөөгийн нөхцөл байдалд манай арилжааны банкны дүрмийн сангийн хэмжээ бол нэг зуун тэрбум төгрөг байгаад байгаа. Мөн Банкны тухай хуулиар тавьж байгаа хязгаарлалтаар өөрийн хөрөнгийн 20 хувь дээр нэг зээлдэгчийн хязгаар тавигддаг. Тэгэхээр нэг зээлдэгчийн бол авч чадаж байгаа дээд хэмжээ одоогийн байдлаар бол нэг 300 орчим тэрбум төгрөг л байгаа. Хаан банкны хамгийн өндөр өөрийн хөрөнгөтэй банкны 20 хувь гэхээр.

Тэгэхээр энэ хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк үйл ажиллагаа явуулаад эхлэхээр мэдээж нэг зээлдэгчийн хэмжээ бол энэнээс бол дээшлээд явна. Тэгэхээр бол энэ нь эргээд санхүүгийн зах зээл дээр илүү либералчлагдаж, нэг зээлдэгчийн хэмжээ нь нэмэгдээд ирэхээр том төсөл хөтөлбөрүүд хэрэгжээд явна. Энэ дээр бол илүү уян хатан байх боломжтой гэж үзэж байгаа. Тэгээд Төв банк бол энэ дээр аливаа төрлийн бүх юм хязгаарлалтуудыг бол энэ дээр аваад өгчихсөн байгаа. Түүрүүн Цэрэнпунцаг гишүүн бас хэллээ. Энэ дээр бол үндсэнээр төсөл санхүүжүүлнэ, төсөл санхүүжүүлэхтэй холбоотой үндсэндээ бүх төрлийн үйл ажиллагааг нь бол зөвшөөрч байгаа. Томоохон хэмжээний хязгаарлалтуудыг бол ерөөсөө тавихгүй байгаа.

Г.Занданшатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууна нэг минут.

Б.Дэлгэрсайхан: Үгүй ээ үгүй, би ийм л юм асуугаад байгаа юм л даа. Энийг энэ Банкны хуульд яаж оруулах юм. Энэ Ашигт малтмалын хууль удахгүй орж ирнэ. Тэгээд энэ Ашигт малтмалын хууль дээр чинь бол зөвхөн хяналт тавина л гэсэн юм байгаа юм, ерөнхий заалт байгаа юм. Тэгтэл нөгөө ашигт малтмалын лицензийг барьцаалчхаад, зориулалтын дагуу ашиглахгүй өөр юманд ашиглаад байгаа

юм. Тэрэнд банк яаж хяналт тавих юм бэ гэдгийг энэ хуульд яаж заасан юм. Ер нь Ашигт малтмалын хууль орж ирэхэд энийг давхар анхаарахгүй бол манай Ашигт малтмалын хууль бол зүгээр л лицензээ тавиад туучихсан хууль байна лээ шүү дээ. Мөнгө нь орж ирдэггүй, тэгээд гадуур угаагдаад, тэгээд нэг барьцаанд нэртэй тэгээд зориулалтын дагуу ашиглагддаггүй, тэгээд тэнд нэг уурхай байгаа гэдэг нэг гоё нэртэй. Гэтэл бид нар чинь том уурхай нээгээд энэ одоо улсад хөрөнгө.../минут дуусав/

Г.Занданшатар: 81 Энхтайван Дэд ерөнхийлөгч Монголбанк.

Г.Энхтайван: Энэ Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль батлагдсанаар Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хамтраад хэд хэдэн журам батлахаар энэ хууль дээр бол оруулж ирж байгаа. Энэ журмуудын нэг дээр бол зээлийн үйл ажиллагааг зохицуулсан журам байгаад байгаа юм. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа одоо энэ Банкны тухай хууль болон одоо энэ салбарын бусад одоо бид бүгд ярьдаг Урт нэртэй хууль гэдгээр бол зээлийн үйл ажиллагаа зөвхөн зориулалтынхаа дагуу зээлийн мөнгөн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, ашиглах тухай зохицуулалт байгаа. Хэрэв энийг зөрчсөн бол Төв банкин дээр албадлагын арга хэмжээ авч байгаа, торгуулийн болон албадлагын бусад хуулиар заагдсан арга хэмжээнүүдийг авч байгаа. Тэгэхээр яг энэ Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хууль батлагдаад бид бүхэн зээлийн үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан журмыг бол батална. Энэ журмаар бол мэдээж зээлийн үйл ажиллагаа тухайн зээлийнхээ зориулалтын дагуу ашиглагдаж байгаа эсэх дээр бол Төв банк бүрэн хяналтаа тавиад явна. Хэрэв зээлийн үйл ажиллагаанд зээл одоо зээлийг зориулалтын бусаар ашигласан тохиолдолд бол мэдээж энэ дээр Төв банк.../минут дуусав/

Г.Занданшатар: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна.

Д.Ганбат: Аливаа хууль, бодлого аливаа хууль тогтоомж, шийдвэрийн ард талд бодлого байдаг. Энэ хуулийн ард талд одоо ямар бодлого байна вэ нэгдүгээрт? Хоёрдугаарт энэ хөрөнгө оруулалтын гадаадын хөрөнгө оруулалтын энэ банкны энэ хууль батлагдсанаар гуравдагч орны банкны хөрөнгө оруулалт салбар банк нь орж ирэх юм уу? Миний ойлгож байгаагаар бол иймэрхүү хууль батлаад бусад улс орнууд орж ирж байгаа нь бол манай 2 хөршийн төрийн өмчтэй банкны салбарууд байгуулагдах байх. Эхний ээлжид бол ер нь бараг л тэд нараас өөр хүмүүс орж ирэхгүй байх. Хэрэв орж ирнэ гэж бодвол. Аль 2016 онд Монгол Улсын эдийн засаг гайгүй ч юм уу боломжтой байх энэ үед нь энэ хуулийг батлаад зөв зүйтэй оруулж ирээд ингээд явах байсан бас. Энэ хэтэрхий олонх байгаа нөхцөлд энэ хуулийг оруулж ирээд өнөөдөр батлуулаад ингээд явах нь бол энэ Монгол Улсын газрын нутаг дэвсгэр, байгалийн баялгийг бусад улс орнуудын мэдэлд оруулах ийм юм цаана нь харагдаад байна. Энэ чиглэл рүү явчихсан. Ийм хууль болчих вий.

Нөгөө улс орнуудын барьдаг бодлого бол өөрийнхөө хөрөнгө оруулалт, өөрийнхөө иргэдийг хамгаалах ийм бодлоготой байдаг. Дэлхийн хаана ч гэсэн нутаг дэвсгэр дээр. Манай Монгол Улс шиг биш л байхгүй юу даа. Хэдэн хулгайч нараа баахан хэдэн хулгайч нар чинь энэ Монгол Улсын газар дэвсгэрийн нутаг дэвсгэрийг лиценз нэрээр авчхаад, тэрийгээ энэ хөрөнгө оруулалтынхаа гаднын хөрөнгө оруулалтын банканд тавьчхаад ингээд гараад явчихна. Эргэлзэхгүй байна. Тэгээд тэрийг дуртай хүн дуртай хүндээ шилжүүлдэг. Тэрний цаана нь нэг гадаадын иргэн байж байдаг. Тэгээд энэ улс орон чинь энэ маягаар одоо цаашаа явчихна. Нөгөө талаар одоо энэ гаднын хөрөнгө оруулалт орж ирдэггүй нэг шалтгаан нь бол хууль шүүхийн систем. Энэ одоо манайх шударга, тэр олон улсын стандартад нийцсэн ийм үйл ажиллагаа

явуулж чаддаггүй. Дандаа одоо захиалгатай, хувийн шүүгчтэй, хувийн прокурортой, хувийн мөрдөн байцаагчтай, хувийн цагдаагийн газартай ингэж л ажиллаж байгаа шүү дээ. Хэн одоо эрх мэдэлд байгаа тэр хүмүүсийн хүсэлд нийцүүлж шийдвэрээ гаргадаг болохоос хуулийг баримталж хуулийг дээдэлж ажилладаг юм бол энэ улс оронд бол байхгүй болсон шүү дээ сүүлийн хэдэн жил бол. Өмнө нь ч тааруу байсан.

Тэгээд янз бүрийн одоо хуулийг гаргадаг. Тухайлбал, одоо энэ банкнуудыг олон нийтийн хяналтад оруулна гээд хувьцааг нь гаргаж байгаа нэртэй нэг 5, 10-хан хувийг гаргаж байгаа шүү дээ. Тийм зэрэмдэг хууль гаргасан. Тэрний л нэг жишиг явж байна уу даа. Энэ хоёрын хооронд юм хийснээс бараг хийхгүй нь дээр байдаг. Энэ тал дээр анхаарч ажиллах ёстой. Үүнээс гадна тэр ломбардын хүүг буулгана, банкны үүг буулгана, дан оронтой тоонд оруулж ирнэ гэсэн байхгүй. Эсрэгээрээ 3 даруй тэр нь өсчихсөн. Өнөөдөр энэ банкнуудын хүү чинь хамгийн наад тал нь 2, 3 хувь дээр оччихсон. Үгүй ээ ийм юманд хяналт тавьдаг, ийм одоо хууль гаргадаг, ийм Монголбанк энэ тэр чинь одоо ингэж ажиллаж чадах уу? Энэний ар талд баахан газар, нутаг дэвсгэрээ гаднын банкны салбар тэр тусмаа төрийн өмчтэй энэ хойд, урдах хөршийн банкны салбарт тавьчхаад, тэд нарын одоо үйлчлэл дунд ийм одоо явдал гарч магадгүй. Тэрний жишээ нь бол одоо би Тажикстан гэж хэлмээр байна. Тэрний жишээ бол одоо би Шри-ланка гэж хэлмээр байна. Энэ мэтчилний Пакистан гэж хэлмээр байна.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга, гишүүн эрхэм гишүүн хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Ганбат гишүүний асуултад хариулъя. Ганбат гишүүн энэ хууль гараад гуравдагч орноос ба орж ирэх үү, яадаг бол гэж санаа зовж байгаа бас зүйтэй. Ингээд энэ яг таны одоо бас тавьж байгаа одоо санаа зовж байгаа

асуудлыг бол шийдэхийн тулд энэ хууль гарч байгаа юм. Ер нь бол яг одоо нэг талдаа ярих юм бол бид нар одоо тэр энэ гаднаас ингээд энэ компаниуд маань одоо энд дотооддоо байгаа банкнаас авч чадахгүй бол гадагшаа яваад эндээс одоо гаднаас банкнаас мөнгө авахдаа одоо энэ лицензээ ингэж барьцаалаад байна гээд энэ Дэлгэрсайхан гишүүн сая асуудал яриад байна шүү дээ. Энэ асуудал бол одоо өнөөдөр байгаа байхгүй юу. Энэ хууль байхгүй, энэ хууль гараагүй байхад л ингээд л энэ лицензээ барьцаалж гаднаас зээл авах энэ процесс чинь яваад байна шүү дээ.

Тэгэхээр бид нар энэ хуульгүй, одоо энэ хууль эрх зүй нь тодорхой бус байгаа учраас бол ийм асуудал байна. Бодит байгаа асуудал байж л таараа. Дээрээс нь бол дахиад энэ хардалт сэрдэлтүүд их байгаа учраас бид нар энэ хуулиа гаргаж байж, энэ асуудлыг бол одоо ард нь гарна. Тийм учраас энэ хууль бол гарах нь одоо сайн үр дүн авчирна. Өнөөгийн энэ нөхцөл байдлыг бол сайжруулна гэж үзэж байгаа юм. Дээрээс нь одоо таны бас саяын асуултад байгаа тэр төрийн гаднын гадаадын төрийн өмчтэй банкнууд орж ирэхэд одоо энэ бас 2 хөршөөс орж ирээд энэ гадаадын хөрөнгө оруулалтын тэнцвэртэй байдал алдагдах ийм нөхцөл байдал үүсэх байх гэж санаа зовж асууж байгаа юм байна гэж ойлгож байна. Тэгэхээр энэ бол түрүүн хэлсэн Дэлгэрсайхан гишүүн дээр хүртэл асуултад хариулахдаа хэлж байсан. Энэ бол Монголбанк зөвшөөрөл олгохдоо Засгийн газраасаа зөвшөөрлөө авна. Чиг үүргийн дагуу бол Эдийн засгийн хөгжлийн яамнаас ийм учраас Засгийн газрын хуралдаанаар орно. Хэрэв нэг улсын одоо гадаадын хөрөнгө оруулалтын одоо хэм хэмжээ ямар байгаа юм, тэр нь үнэхээр тэр одоо үндэсний аюулгүй байдлын одоо тэр зөвлөмжид тусгагдсан тэр хэм хэмжээг давж байгаа бол энэ бол УАБЗ дээр яригдах, яригдаж ингэж ил одоо нээлттэй явж байж энэ зөвшөөрөл гарах юм байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол одоо цаг алдахгүй бид нар мэдээллээ авч, энэ дээр санал бодлоо илэрхийлж, энэ Их Хурал дээр хүртэл одоо энэ зөвшөөрлийн асуудал яригдаж байхад бид нар аваад энэ асуудлуудаа кэйс кэйсээр хийсээр нь одоо ярилцаад явах ийм боломжтой ийм л болж байгаа юм байгаа юм. Тэгэхээр бид нар таныг яг ярьж байгаа энэ асуудлуудад бид нар одоо асуудлууд гарч байгаа яг бодит өнөөдрийн амьдрал дээр байгаа энэ асуудлуудыг шийдэхийн тулд энэ хуулийг гаргаж байгаа учраас бол энэ хууль бол гарцаагүй одоо гарах нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Мөн өдийд одоо бид нар гадаадын хөрөнгө оруулалт их чухал байна гэж яриад байгаа. Тийм ээ. Тэгээд энэ гадаадын хөрөнгө оруулалт дотор чинь бол одоо мэдээж энэ банкны салбар руу орж ирэх хөрөнгө оруулалт, энэ нь банк санхүүгийн салбарт оруулж ирэх хөрөнгө оруулалтыг бас дэмжсэн чиглэлд бол бид нар Гадаадын хөрөнгө оруулалтын хуулиа сайжруул гээд л та бүхэн ч хэлдэг, санал бодлоо хэлдэг. Энэ Засгийн газраас ч гэлээ гадаадын хөрөнгө оруулалтыг татна, эрх зүйн орчныг сайжруулна гэж ярьж байгаа.

Энэ гадаадын хөрөнгө оруулалтыг татах, энэ гадаадын хөрөнгө оруулалтын одоо таатай орчныг бүрдүүлэх, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх энэ чиглэлд одоо гарах ёстой, сайжрах ёстой нэмэлт, өөрчлөлт, өөрчлөлт оруулах ёстой хуулиудын нэг бол энэ Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны хууль юм. Баярлалаа.

Г.Занданишатар: Дашидондогийн Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тодруулъя. Энэ хууль батлагдаад гарсны дараа та бүхэн судалгаа бас байгаа байлгүй дээ. Өнөөгийн нөхцөл байдалд бас тааруулж ажиллаж байгаа гэж ойлгож байна. Уул нь бол цаг нь биш л гэж үзэж байгаа юм би бол. Хамгийн эхний ээлжид одоо ямар банкны салбар байгуулагдах гээд байна вэ? Ямар хөрөнгө оруулалт орж ирэх гээд байна вэ? Энэ гуравдагч орнууд гэж заагаад байдаг нь тэднийх арай шилэн тунгалаг байдаг.

Арай хяналттай байдаг. Хувийн өмч бол бас арай өөр байдаг гэдэг талаасаа. Төрийн өмчтэй банкнууд тийм банкнууд ороод ирэхээрээ нөгөө ар тал нь цаад талд нь нөгөө улсын төр байж байдаг. Тэгээд энэ лиценз энэ лицензийг чинь шүүхийн шийдвэргүйгээр та нар хоорондоо шилжүүлэх юм байна. Гэтэл одоо энэ бол одоо Монгол Улсын нутаг дэвсгэрийг бараг л бие биедээ гаднын тэр улсууд шилжүүлэх нь бол хэний ч хяналтгүйгээр явах юм байна шүү дээ. Өнөөдөр уул нь бол хууль тогтоох, гүйцэтгэх энэ шүүх засаглал.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэрэнпунцаг Цэдэндамбын Цэрэнпунцаг Эдийн засгийн байнгын хорооны дарга. Одоо санал хураалттай гишүүд.

Ц.Цэрэнпунцаг: Энэ, Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ угаасаа бид нар хууль гаргахдаа бол мэдээж та бид нар бүгдээрээ л энэ Их Хуралд сууж байна. Хууль санаачлах эрхтэй. Тэгэхдээ хууль санаачлахдаа бол одоо энэ нэг хүнд юм уу, нэг компанид ч юм уу, нэг хэсэг бүлэг эсвэл нэг улсад ч юм уу зориулж хууль гаргаж болохгүй байх. Энэ бол одоо өнөө хууль дээдлэх зарчимд бол нийцэхгүй байх гэж санаж байна. Би чухам одоо нарийн тэр хуульч биш учраас одоо сайн мэдэхгүй байна. Би тэгэхдээ бол миний барьж байгаа зарчим бол бид нар энэ хуулийг гаргаснаар энд ашигтай юу, тэнд хортой юу гэдгийг одоо бодож энийг урьдчилж тооцоолж энэ хуулийг гаргаагүй. Энэ хууль дээр ажиллаагүй. Бид бүхэн бол Монгол Улсад орж ирэх хөрөнгө оруулалт, дээрээс нь Монгол Улсын дотоодын хөрөнгө оруулагчдад энэ банк санхүү.../минут дуусав/

Г.Занданшатар: Энхтайван 81, энэ эцсийн хэлэлцүүлэг.

Г.Энхтайван: Ганбат гишүүний асуултад нэмж хариулъя. Яг одоогийн байдлаар манай улсад 3 гадаадын банкны төлөөлөгчийн газар ажиллаж байгаа. 3 төлөөлөгчийн газар ажиллаж байгаа.

Эдгээрээс яг манай зах зээл дээр манай дотоодын ААН-үүдэд өгсөн зээлээрээ Япон улсын хөрөнгө оруулалттай банкны банк хамгийн өндөр зээл буюу нэг 240 орчим сая долларын зээлийг өгсөн байгаад байгаа юм. БНХАУ-ын банк бол энэ дээр хамгийн сүүлд бол 2017 оноос хойш бол их зээл гаргаагүй байгаад байгаа юм. Тэгэхээр манай улсын зах зээлийг сонирхож байгаа банкнуудын тоо бол бас хязгаарлагдмал байгаад байгаа юм. Тэгэхээр хамгийн одоо юу гэдэг юм томоохон сонирхогч нь бол Япон улсын хөрөнгө оруулалттай банк байх магадлалтай л гэж Төв банкны зүгээс үзэж байгаа юм. Тэгэхдээ Төв банк зүгээр гадаадын банк, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 2 санал байгаа. Эдийн засгийн байнгын хорооны гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 8 дугаар зүйлийг 10 дугаар зүйл болгон, доор дурдсанаар бүхэлд нь өөрчлөн найруулах:

“10 дугаар зүйл.Үнэт цаас, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах

10.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хязгаарлалтын хүрээнд гадаад улс, дотоодын үнэт цаасны зах зээлд үнэт цаас гаргаж болно.

10.2.Энэ хуулийн 10.1-д зааснаар дотоодын үнэт цаасны зах зээлд гаргах үнэт цаас нь зөвхөн хаалттай хүрээнд байна.

10.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, мөнгөн хөрөнгийн нөөцийг удирдах

зорилгоор мөнгөний зах дээр богино хугацааны үнэт цаас гаргаж болно.

10.4.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк төсөл санхүүжүүлэх зорилгоор харилцагчийн үнэт цаасны зах зээл, мөнгөний зах дээр арилжаалагдах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийг худалдаж, худалдан авч болно.

10.5.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк компанийн хувьцааг тав хүртэлх жилийн хугацаанд эзэмшиж болно.

10.6.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк нь харилцагч, түүний холбогдох этгээдийн гаргасан хувьцааны 20 хүртэл хувийг эзэмшиж болох бөгөөд эзэмшиж байгаа хувьцаа нь саналын эрхгүй байна.

10.7.Энэ хуулийн 14.3-т заасан хязгаарлалтын хүрээнд хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, бүртгэл, хэмжээ, хэлцэл хийхэд баримтлах журмыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран батална.” Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Санал хураалт. 52.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 25 дугаар зүйл шинээр нэмэх:

“25 дугаар зүйл.Хяналт шалгалт

25.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц, зохион байгуулалт, актив, пассив, өөрийн хөрөнгөд тавих шаардлага болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан журмаар зохицуулна.

25.2.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагч

гадаад улсын хуулийн этгээд бол тус этгээдийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагатай Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтарсан хяналт шалгалт хийж болно.

25.3.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үүсгэн байгуулагчийн оршин байгаа улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллага энэ хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгэгдсэн хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд Монголбанкны зөвшөөрлөөр хяналт шалгалт хийж болно. Санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. Пүрэвдорж, Амарсайхан Сайнбуянгийн Амарсайхан гишүүн, Сандагийн Бямбацогт гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Хяналт шалгалт дээр бас анхаарах хэрэгтэй. Тэгэхээр би нэг зүйлийг ялангуяа одоо гишүүдийн иргэдийн бас нэг бас санаа зовоод байгаа нэг зүйл бол энэ ашигт малтмалын лицензтэй холбоотой шийдлүүд бас яг ингээд нарийн зохицуулагдаагүй байна л гэж үзээд байгаа юм. Би нэг Сингапурын банк орж ирлээ гэж үзье. Сингапурын банк нэг ашигт малтмалын лиценз барьцаалаад нэг компанид нэг тэрбум төгрөгийн зээл өглөө. Тэрнийхээ одоо нэг 80 хувьд нь одоо эрсдэл эрсдэлээ тооцоод 80 хувьд нь өглөө гэхэд 800 үнэтэй лицензийг 80 хувьд нь буюу 800 саяд нь өглөө л дөө. Тэгээд 800 саяын өгчихсөн явж байсан чинь банк нөгөө компани нь эрсдэлд орлоо. Эрсдэлд ороод нөгөө компани нь лицензийг нь хураагаад авна. Тэгээд дуудлага худалдаа энэ хуулийн дагуу дуудлага худалдаа явуулах юм байгаа юм. Тэгээд банкны нийт эрсдэл нь бол нийт одоо зардал нь болох доор 850 сая болчихсон. Тэгэнгүүт тэрнийгээ одоо дуудлага худалдаанд оруулангуут Сингапурынхаа нэг компанид энэ их зүгээр лиценз байгаа юмаа очоод авчих нэг тэрбум хүртэл дуудаад авчих. Манайхтай 800 саяараа тооцоо хийчих. Бид нар тавь нөгөө 50 саяыг нь 50 саяыгаа бид нар

банкныхаа эрсдэлийн санд тооцоод ингээд арилгая. Ингээд л явчих байхгүй юу даа.

Тэгээд одоо лиценз болгон дээр ингээд л сонирхлоо оруулаад ингээд явчих юм бол наадах Монголын энэ одоо ашигтай, ашигтай энэ ашигт малтмал энэ Монголын иргэдийн одоо газрын доорх баялаг Монголын ард түмний өмч байна гэдэг энэ юм чинь тэгээд л ер нь бүгдээрээ гадагшаа л яваад урсаад дуусах ийм нөхцөл байдлыг гаргаад байна л даа. Дуудлага худалдаагаар худалдана, нийтэд борлуулна гэдэг чинь ийм байдлаар л явчих байхгүй юу даа. Тийм учраас энэ дээрээ бас нарийн зохицуулалт одоо энэ хуулиараа бол яах вэ дуудлага худалдаагаар бол оруулна гэж байгаа. Тэгэхдээ нөгөө Монголбанк дээрээ яаж харилцан хамааралгүй ААН-д өгөх үү гэдэг юман дээрээ сайн бодохгүй бол энэ ч нэг тийм сайн сайн лицензүүд, тэгээд нэлээн том талбайтай тэр одоо лицензүүд нэг орны гарт төвлөрөх ийм нөхцөл байдал руу л орж байна шүү гэж та нарт анхааруулж байгаа.

Г.Занданшатар: Энэ заалттай холбоотой санал хэлнэ. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Ер нь энэ заалтыг дэмжиж байгаа. Зарчмын зөрүүтэй саналыг. Тэгэхдээ би бас хэд хэдэн зүйлийг тодруулж хэлье гэж бодсон юм. 20 онд энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийн ажлын хэсгийг би бас Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоод ахалж байсан. Тэгээд өнөөдрийн хууль бас батлагдаж байгаад баяртай байна. Яагаад гэвэл өнгөрсөн одоо 20, 30 жилийн хугацаанд энэ ард иргэд, бизнес, ААН-үүд арилжааны хэдэн банкнаас амь амьдрал нь шууд хамааралтай. Дээрээс нь гадаад, дотоодын өрсөлдөх энэ одоо боломж нөхцөлийг бий болгох замаар ААН банкнууд өрсөлдөх замаар иргэдэд хямд өртөгтэй, баталгаатай найдвартай санхүүгийн хэрэгсэл зээлийг олгох боломж нөхцөл хязгаарлагдмал явж ирсэн. Тийм учраас улсын эдийн засаг ч бас одоо тэлэх боломжгүй явж ирсэн. Тэгэхээр энэ

хуулийн хэрэгжилт дээр бас одоо батлагдсаных нь дараа Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо онцгой анхаарах ёстой гэж үзэж байгаа.

Хөрөнгө оруулалтын банк дотроо 3 төрөл байдгийг бүгдээрээ мэдэж байгаа. Тэгэхдээ манайх одоо төрөлжсөн хөрөнгө оруулалтын банк гэдэг ийм тодотголтойгоор энэ Банкны тухай хуулийг баталж байна. Энэ хуулийн 6.3 дээр энэ хуулийн 6.6, 7-г буюу андеррайтер кастодиан үйл ажиллагаа явуулахад СЗХ, Монголбанкнаас зөвшөөрөл авч урьдчилан одоо санал авна гэсэн ийм заалт орж байна. Энэ байж болохгүй зүйл шүү. Энийг хэрэгжилтийн явцад одоо энэ жишигээрээ батлагдах гэж байгаа бол зохицуулалт дээр анхаарах ёстой. СЗХ бие даасан үйл ажиллагаа явуулдаг ийм байгууллага. Монголбанкнаас шууд хамааралтай байж болохгүй. Энэ асуудал дээр.

Хоёрдугаарт, энэ 7.2 дээр төсөл, зээл олгох хэмжээ, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг банкны системд нөлөө бүхий банкнаас хуулийн этгээдэд олгосон зээлийн хэмжээ, бусад хүчин зүйлийг харгалзан Монголбанк, СЗХ тогтооно гэж заасан байгаа. Энэ заалтаар энэ хөрөнгө оруулалтын банк үйл ажиллагаа явуулах боломж бас хязгаарлагдахаар байгаа шүү. Өөрөөр хэлбэл энэ зах зээлд давамгайлдаг нөгөө системийн нөлөө бүхий гэдэг нөлөө бүхий банкнуудын хуйвалдаанд орж, энэ шинээр байгуулагдах банк чинь үйл ажиллагаа явуулах зээлээ олгох боломж нөхцөл үзэмжийн хэмжээнд шилжих ийм эрсдэлтэй заалт энд орсон байгаа шүү. Энийг бас хэрхэх талаар манай Эдийн засгийн байнгын хороо холбогдох албан байгууллагынхан анхаарахгүй бол наанаа нэг хууль баталдаг, цаанаа энэ банк үйл ажиллагаа явуулах боломж байхгүй. Нөгөө л явж ирсэн эдийн засаг, улс төрийн хуйвалдааны нэг золиос болдог, хэрэгсэл болдог эрсдэлтэй заалт энд зориуд оруулсан байна. Энийгээ бас анхаарах хэрэгтэй.

Энэ хууль бол батлагдахаас өөр гарцаагүй хууль батлах ёстой. Бид хөгжье, урагшилъя, өөрчлөлт шинэчлэгдье гэж байгаа бол дэлхий нийттэйгээ хөл нийлүүлж алхах хэрэгтэй. Бүх зүйл бүх зүйлийг одоо гаднынхан авчихна. Дотнынхонд хүрэлц дотоодод өөрсдөө хийж чадна гэж явсаар байгаад бүгдээрээ ямар байдалд ажиллаж амьдарч байгааг мэдэж байгаа. Хамгийн гол нь баталсан хууль, хийж байгаа ажлынхаа эзэн нь байж чадах хэрэгтэй өөриймсөг сэтгэлээр. Өөрсдөө эзэн шиг байж чадахгүй байж өрөөлөөс айдаг, айлгадаг ийм явуургүй арга одоо явахгүй. Тэгэхээр үнэхээр одоо зах зээлээ хөгжүүлэе, ААН, иргэдээ дэмжье, амьдралд ойрхон, бодитой санхүүгийн зах зээлийг бий болгоё гэвэл энэ Хөрөнгө оруулалтын банкны хуулиа бодитой хэрэгжүүлж, богино хугацаанд ажил хэрэг болгох хэрэгтэй шүү. Энэ дээр манай Монголбанк, СЗХ анхаарч ажиллана биз. Энэ хуулийг одоо бас түргэн шуурхай хэлэлцэж баталж байгаа Улсын Их Хурлын дарга, Эдийн засгийн байнгын хороо, ажлын хэсгийнхэнд бас талархлаа илэрхийлэе. Баярлалаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ санал хураах гэж байгаа заалтын 25 дугаар зүйлийн 20.1.Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банк, түүний толгой компани, нэгдлийн бүтэц зохион байгуулалт актив пассив өөрийн хөрөнгөд тавигдах шаардлага болон бусад зохистой шалгуур үзүүлэлт, тэдгээрт хийх хяналт шалгалттай холбогдох харилцааг Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ны хамтарсан хамтран баталсан журмаар зохицуулаад хаячхаж байгаа юм. Тэр хамтран баталсан журам гэдгийн цаад талд чинь л тэгээд л нөгөө хуулийн хулгай. Асуудлыг үзэмжээрээ шийддэг. Хууль дээр бид нар өчнөөн олон зүйл тийм үү, хэлэлцэж хэлэлцэж бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн ус орон хэрэг үү гээд Их Хурал дээр хэн нэгэн давуу тал бий болгочихгүй юм шиг юм шүү. Хуулийн

цоорхой гаргачихгүй юм шүү, хийдэл гаргачихгүй юм шүү гээд ингээд хууль батлаад өгчихдөг. Тэгэнгүүт нь Монголбанк, СЗХ журам батлаад нөгөө бидний зорилго нэг мэдсэн чинь тийм үү, тэмээ ямаа, тэнгэр газар шиг хол өөр ойр болчихсон, өөр болчихсон ийм болчих вий дээ. Тэгээд өөрсдөдөө давуу эрх бий болгодог.

Төр тавьж байгаа зорилго маань өөр бодлого, зорилго нь өөр, хуулийн үзэл баримтлал нь өөр. Журам нь түүний эсрэг. Одоо нөгөө нүүрсний хулгай гэдэгтэй адилхан. Нэг мэдсэн нөгөө хөрөнгө оруулалтын банк чинь лицензүүдийг, ордуудыг бүгдийг нь одоо тийм үү Монголын эдийн засгийг дэмжих төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх бага хүүтэй зээл орж ирээд Монголын эдийн засагт томроосой, ажлын байр бий болоосой, үйлдвэрлэл хөгжөөсэй гэсэн бодлого биш, явал энэ ордуудыг нь ордоор нь авчих уу, явал лицензийг нь тэр лицензээр нь авчих уу уурхайнуудыг нь гэдэг юм болчихсон явж байх вий. Энэ рүү тэр чиглэсэн журам батлаад өгчихсөн байх вий. Урьд нь одоо нүүрсийг чинь тэгээд тороор нь тэгээд хөөрхий амьтад хүрээр нь хулгай хийдэг байсан. Авто машинаар нь одоо вагоноор нь хулгай хийдэг нь одоо ил тод боллоо шүү дээ, харагдлаа шүү дээ. Одоо сүүлдээ бүр тийм уурхайгаар нь бүтэн ордоор нь хулгайлчихсан явж байх вий дээ нэг мэдсэн чинь. Энийг сайн Монголбанк, СЗХ журмаараа онгорхой цоорхой үлдээчихсэн байх вий дээ. Энийгээ анхаарах ёстой шүү. Ийм зорилгоор бид энэ хуулийг батлаагүй шүү.

Нөгөө талдаа тийм үү, төрийн нэр бариад энэ СЗХ, Монголбанкныхан эргүүлээд Хөрөнгө оруулалтын банкиг чин шударгаар одоо юу гэдэг юм Монгол Улсын эдийн засагт Монгол Улсдаа тийм үү эдийн засагт ард иргэдийн амьдрал өгөөжтэй, ингээд төсөл хөтөлбөрийг санхүүжүүлээд хамтраад ажиллая гэж байхад нь дундаас нь гох дэгээ тавиад хүнд суртал гаргаад ингээд байдаг байх вий. Бас энийгээ сайн бодолцоорой. Тийм болохоор

одоо хэллээ шүү. Хуулийг бид нар бидний баталсан бидний бодож байсан үзэл баримтлалаас өөр болгочоод, дараад нь хуулийн хулгай хийчихсэн, сүүлд нь Их Хурлын баталсан хууль нь асуудалтай хууль байж, Их Хурлын гишүүд ийм хачин юм хийчихжээ гэдэг нэрийг одоо юу гэдэг юм муу л бол хойд зүгийн хар овоохой гэж Их Хурал руу чихэхгүй шүү. Тийм болохоор одоо энэ хүрээндээ та бүхэн бас энд өөрсдөө олж авсан, хуулиас давсан журам гаргахгүй байх ёстой шүү гэдгийг л анхааралдаа аваарай, энийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Ингээд уншиж танилцуулсан байгаа. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя. Гишүүд санал хураалтад бэлдэнэ үү. Санал хураалт. 28 гишүүн дэмжиж, 51.9 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор. Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

11.39 цаг

Гурав. “Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эдийн засгийн байнгын хороо боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Дараагийн асуудалд орно. Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Содномын Чинзориг танилцуулна.

С.Чинзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ш.Адьяа, Ж.Батсуурь, Д.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Д.Ганбат, Н.Ганибал, С.Одонтуяа, О.Цогтгэрэл, Ж.Батжаргал, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Д.Ганболд, М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, Б.Энхбаяр, Т.Энхтүвшин нарын гишүүдээс 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр, Нүүрсний олборлолт, тээвэрлэлт, экспортын асуудлаар ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулах хүсэлт ирүүлсний дагуу нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх эрх бүхий байгууллагуудын тайлан мэдээлэлтэй танилцах ерөнхий хяналтын сонсголыг 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаа сонсголын тайланг сонсгосон билээ.

Сонсголын тайланг сонссонтой холбогдуулан нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбогдуулан холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлан, тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг үндэслэн Байнгын хорооноос санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан.

Тогтоолын төсөлд нэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой эрх, эрх бүхий байгууллагуудын удирдлага, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны үйл ажиллагаатай Засгийн газрын хяналт

шалгалтын ажлыг уялдуулах, үндэсний баялгийн баялгийн сангийн тухай, Эрдэс баялгийн бүтээгдэхүүний ил тод байдлын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд яаралтай өргөн мэдүүлэх, 1991 онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болгох асуудлыг судалж, судлан үзэж саналаа танилцуулах, төрийн өмчийн ААН-ийн үйл ажиллагаа, үр ашиг нэмэгдүүлэх, байгалийн баялгийн үр өгөөжийг ард түмэн тэгш, шуударгаар хүртээх зорилгоор Эрдэнэс таван толгой ХК хувь ХК-ийн хувьцааг 2012 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс хойш төрсөн Монгол Улсын иргэн бүр шинээр хувьцаа эзэмшүүлэх асуудлыг судалж танилцуулах, иргэний мэдээлэл авах эрхийг хангах хүрээнд Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжид үндэслэн ААН болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж хэлэлцүүлэх, Эрдэнэс таван толгой ХК-аас санхүүжүүлсэн оффтейк гэрээний хүрээнд хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төмөр замын бүтээн байгуулалтад хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлтэд үндэслэн санхүүжилтийг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэх зэрэг тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгахаар тусгасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэр нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч учир буй хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий хянаж шалгах түр хороо үйл ажиллагааг эрчимжүүлэх, цуглуулсан нотлох баримтуудыг шинжлэх судлах сонсголыг 2000 Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан зохион байгуулах, нийтийн эрх ашгийг хөндсөн ерөнхий хяналтын сонсголын зохион байгуулалт, үр нөлөөг сайжруулах зорилгоор оролцогчдын хамрах хүрээ, эрх, үүргийг тодорхой болгох, сонсголын үр дүнг мэдээлэх, холбогдох

байгууллагад үүрэг чиглэл өгөх, биелэлтэд хяналт тавих шаардлагатай гэж үзвэл холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт, өөрчлөлт оруулах талаар саналаа Улсын Их Хуралд танилцуулахыг холбогдох байнгын хороодод даалгасан болно.

Нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нүүрсний экспорт тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

Г.Занданиатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Доржханд, Батлут гишүүнээр тасаллаа. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Бид нар Улсын Их Хурлын бас их чухал тогтоолыг одоо өнөөдөр хэлэлцэж байна. Эдийн засгийн байнгын хороон дээр энэ асуудал хэлэлцэж байх үед бол бид нар бас саналаа хэлж байсан. Хамгийн гол нь Улсын Их Хурлын тогтоол амьдрал дээр гараад хэрэгждэг байх ёстой. Тэгэхгүй бол одоо энэ нүүрс тойрсон асуудал, хэдэн их наяд тэрбум оффтейк гэрээ гээд л янз янзын тоо яриад байдаг. Тэгээд бодит амьдрал дээр яг энэ нь хэдэн хэдий хэмжээний хохирол учруулаад байгаа юм. Энэ оффтейк гэрээг яаж байгуулсан юм. Энэ гэрээний заалтууд нь ямар байгаа нь цаашдаа бид ер нь оффтейк гэрээ гэдгийг байгуулах уу, байгуулахгүй юу гээд олон асуудлууд байгаа. Бид бас энэ тогтоол дээр ер нь

цаашидаа оффтейк гэрээг байгуулахгүй байя. Олон улсын хэмжээний ийм гэрээ хэлэлцээр хийх бол заавал Улсын Их Хурлаараа орж байж энэ нь хэлэлцдэг байя гэсэн энэ саналуудыг бол бас тусгаж байгаа.

Нөгөө талаасаа өнөөдөр би бас нэг зүйлийг ярих гэж байгаа нь Эрдэнэс таван толгой компани маань одоо жишээлбэл 19 оны ноогдол ашгаа бол өгсөн. Энэ одоо бүх тооцоо судалгаанууд нь байгаа. 22 оны 12 дугаар сарын 15-ны өдөр өгсөн байгаа. Энэ тэр 2 сая 171 мянган иргэнд 154 тэрбум төгрөгийг ингээж олгосон. Харин 20, 21, 22 оны энэ ногдол ашгийн хувьцаагаа олгоогүй. Тийм учраас энийг бол олгох ёстой гэсэн байр суурийг энд тогтоол дээр тусгах саналаа бол илэрхийлж байсан. Тэгээд би бас энэ нөгөө бүрэн эрхт төлөөлөгч нарын нэг тайланг одоо Их Хуралдаа ч юм уу тавиасай гэж хүсэж байгаа. Энэ юу юм гэхээр одоо жишээлбэл 20 оны ногдол ашиг 150 тэрбум төгрөг гээд бодвол 21, 22 оны ноогдол ишиг 300 орчим тэрбум төгрөг ингээд өгөх бололцоо байгаа. Одоо ингээд яригдаж байгаа энэ их хэмжээний мөнгүүдийг тооцоод үзвэл нэг иргэндээ өгөх ёстой ногдол ашгаа өгчих бүрэн бололцоо байгаа нь бол эндээс харагдаад байгаа юм.

Үүнээс гадна Эрдэнэс таван толгой өрөө жишээлбэл 2021 оны 4 сард 336.6 тэрбум төгрөг, 119.7 сая ам.доллар, 21 оны 8 сард 2 дахь удаагаа 519.4 тэрбум төгрөг 53 сая ам.долларын ингээд 2 бонд гаргасан байгаа. Тэгэхээр энэ бондын зарцуулалтыг бид нар бас тайлагнаж мэдэх одоо эрх байгаа. Энийг одоо тайлагнах нь чухал байгаа. Үг нь энэ бонд гаргасан гол зориулалт нь юу юм гэхээр нөгөө Таван толгой-Зүүнбаян, Таван толгой-Гашиун сухайтын төмөр зам, дулааны станц барина гэсэн. Өнөөдөр бол дулааны станц жишээлбэл баригдаагүй. Энэ төмөр зам нь ямархуу байдалтай байгааг бид нар бүгдээрээ бас мэдэж байгаа. Тэгэхээр ийм мөнгө босгочхоод дахиад төмөр замын оффтейк гэрээ дээр Эрдэнэс таван толгой маань мөнгө гаргасан уу, үгүй юу гэдэг нь

манш тодорхойгүй асуултын хариулт нь нэхэгдсэн ийм зүйлүүд байгаа учраас бид нар энэ тогтоолоор бас энэ зүйлүүдэд тодорхой заалтууд оруулаад, энэ нь нийтэд ил тод байх ёстой гэсэн байр суурийг илэрхийлж байгаа юм.

Тэгэхээр ийм олон удаа бонд гаргаад, ингээд явж байгаа юм чинь энэ 21, 22 оны буюу сүүлийн 2 жилийн энэ 1072 хувьцааны ноогдол ашгийг иргэддээ олгох бололцоо тооцоо судалгаанаас аваад үзэхэд харагдаж байгаа. Тэгэхээр энэ зүйлүүдийг бид бас Улсын Их Хурлын тогтоолоор чиглэл болгоод өгөх нь чухал байгаа юм. Энэ дээр жишээлбэл одоо манай Байнгын хороон дээр бид нар бас ярьсан. Ийм бололцоо байгаа гэж бол үзэж байгаа. Тэгэхээр миний одоо хэлж байгаа нь бол асуулт биш санал байгаа. Энийг бас Эдийн засгийн байнгын хороон дээр миний бие Доржханд гишүүн, Батлут гишүүн бид нар бас гаргасан. Тэгэхээр энэ заалтыг тусгаад, энэ сүүлийн 2 жилийн иргэдийн 1072 хувьцааны ногдол ашгийг өгөх тал дээр одоогийн Эрдэнэс таван толгой компанийн ТУЗ-д нь бас чиглэл болгож өгөх нь бол зүйтэй гэсэн байр сууриа илэрхийлж байна. Баярлалаа.

Г.Занданиатар: Үг хэлчихлээ. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн.

С.Амарсайхан: Би энэ ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан ганц 2 санал хэллээ гэсэн юм. Нэгдүгээрт энэ төрийн өмчит аж ахуй нэгж байгууллагуудын орлого, зарлага, зарлагын төлөвлөгөөг зөвхөн ТУЗ-ийн хэмжээнд сонсдог, мэдээлдэг, баталдаг, улсын төсөвтэй уялдуулдаг. Гэхдээ тэр одоо орлогын төлөвлөгөө, борлуулалтын төлөвлөгөө, зардал чирэгдэл дээр Улсын Их Хурал, Засгийн газар бас одоо сонсож, хяналт тавьдаг, мэдээлэл авдаг төлөвлөгөөг нь батлах тал дээр цаашид онцгой анхаарах зайлшгүй шаардлага бий гэж үзэж байгаа юм. Ер нь ийм хяналт байхгүй учраас дур зоргоороо төлөвлөдөг, зарцуулдаг, тэр дундуур авлигал хээл хахууль явдаг, алсын хараагүй, авлигажсан,

засаглал муутай ийм төрийн өмчийн компаниуд улам нэмэгдэж ирсэн нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ тогтоол дээр төрийн өмчит ААН Эрдэнэс таван толгой компанийн ногдол ашгийг хуваарилах гэсэн ийм заалт орсон байгаа юм. Ашгийг нөхөж олгох. Ер нь цаашидаа энэ ногдол ашгийг олгохдоо бэлнээр гэхээсээ илүүтэй иргэдэд хадгаламжийн дансыг нь нээж өгөөд, орон сууцны урьдчилгаа төлбөр, орон сууцны одоо сарын төлбөр гэдэг юм уу, ипотекийн зээлийн төлбөртэй нь уялдуулж хариуцлагажуулж, харилцан уялдаа холбоотой ногдол ашгийн үр шимийг, өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр шинэ зохион байгуулалтыг хийх ёстой гэж үзэж байгаа. Ингэж байж тодорхой үүрэг хариуцлага хүлээж байж энэ ТӨК-ууд ашиг орлоготой ажиллана. Тэгэхгүй зүгээр төсвийн одоо зарлагыг нөхөх, алдагдлыг нөхөх зориулалттай мэтээр зарлага гаргаж явдаг ийм төрийн өмчтэй ААН-үүд байгаа учраас хувийн хэвшилтэйгээ ч өрсөлддөг, төрийн өмчит нэрээр төрдөө ч үр ашиггүй, ард иргэддээ ч өгөөжгүй ийм одоо зарчмаар ажил явж ирсэн.

Тэгэхээр ялангуяа энэ цаашидаа хэчнээн ч төрийн өмчит ААН-ийн хувьцааг иргэдэд олон нийтэд өгөөж хэлбэрээр ноогдол ашиг хэлбэрээр өгөх өгнө гэж зохион байгуулна, тэр хэрээрээ энэ ажил амьдрал, амьжиргаатай нь уяж өгөх хэрэгтэй байна. Өнөөдөр иргэд 30 хувийн ипотекийн урьдчилгаагаа төлөх гэж хамаг байдгаа зарцуулж байна. Бүр хэдэн үеэ барьцаалж байна. Дээрээс нь дахиад банкны баахан өндөр хүү төлж байна. Тэр хүү нь зориулалт бусаар зарцуулагдаж байна. Тэгэхээр энэ утаанаас салах, амьдрал амьжиргааг нь сайжруулах, ахуйг нь сайжруулахын тулд ногдол ашгийг амьдралд нь бодитой хэлбэрээр нь зохион байгуулъя гэдэг ийм ажил дээр одоо холбогдох байгууллагууд ТӨК-ууд энэ баялгийн сантайгаа уялдуулж зохион байгуулах зайлшгүй шаардлага байна шүү гэдгийг хэлж байгаа юм.

Эцэст нь хэлэхэд одоо энэ нүүрсний хулгайтай холбоотой жинхэнэ хулгайчид чинь ил болж байна шүү дээ. Нөгөө бидний яриад байдаг дунд, доод шатны албан тушаалтнууд. Нэр нь Их Хурал, Засгийн газар дээр байгаад байдаг. Нидэр дээрээ жинхэнэ дунд шатны албан тушаалтнууд, тэр төрийн өмчит ААН-үүдийн чинь нөхдүүд хэдэн одоо ой тоонд буухааргүй хэмжээний ийм одоо мөнгийг гэртээ хадгалаад байж байдаг. Би өөрөө бизнес, аж ахуй 10, 20 жил эрхэлсэн хүн. 1000 гаруй ажлын байр бий болгосон хүн, олон салбарт үйл ажиллагаа явуулсан хүн. Гэртээ битгий хэл компанийнхаа кассад ийм мөнгө хадгалж үзээгүй 7, 8 тэрбумаар нь. Ийм байхад ард иргэд цөхрөлгүй яах вэ. Ийм байхад ард иргэдийн итгэл тасралгүй яах вэ. Ийм байхад авлигал хээл хахуул яаж одоо зогсох уу. Тэгээд ичих ч үгүй одоо үл хөдлөх хөрөнгийн бизнес ч гэх шиг. Тийм бизнес байхгүй шүү дээ. Тэр тусмаа энэ ковидын үед ийм хямарсан үед. Зүгээр нэг одоо дундаж албан тушаалтан хэдэн арван тэрбумаар нь цаас шиг гэртээ хадгалж байдаг тийм.../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ тийм ээ. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Сонсголд эхлэхээс нь дуустал нь одоо суусан. Тэгээд ер нь иргэдийн маань тэр хэлэх гэсэн санаанууд бол 3 юман дээр фокусласан. Нэгд нь мэдээж Эрдэнэс таван толгойн оффтейк гэрээ, хоёрт нь энэ богинын тээврийн асуудлууд. Энэ богинын тээвэр маань буцаад бас нэмэгдээд төмөр замын тээвэр бас орж эхэлж байгаа юм байна. Гурав дахь асуудал мэдээж Эрдэнэс таван толгойг тойрсон худалдан авалт, 7.1 их наядын худалдан авалт. Сүүлд нь ер нь бас нэг ийм 4 дэх асуудал Үндсэн хуулийг ноцтой зөрчсөн асуудлаараа олон иргэд бас үгээ хэлсэн. Тэгээд 1991 оны БНМАУ-ын Засгийн газрын тогтоолоор орон нутгийн Таван толгой дээр БЭТ томилж үйл ажиллагааг нь зогсоосон. Ийм асуудлыг бол ярьсан.

Энэ одоо ер нь тэгээд 92 онд Үндсэн хууль батлагдахын өмнө буюу БНМАУ-ын коммунизмын үеийн Засгийн газрын тогтоолоор БЭТ томилоод үйл ажиллагаа явуулж байгаа нь өнөөгийн манай засаг чинь арай тэр 91 оны одоо коммунист коммунизмаас илүү ухарсан үйлдэл хийгээд эхэлчэв үү дээ. Ер нь 91 онд чинь Үндсэн хууль 92 оны одоо ардчилсан Үндсэн хууль батлагдахаас өмнө зах дээр наймаа хийж байгаа хүнийг панзчин, дамын наймаачин гээд барьж хорьдог, нийтээрээ нийлж шоглодог, хувийн өмчийг үл зөвшөөрсөн бүх юм төрийн өмчтэй байсан энэ үеийн хууль тогтоомжийг ашиглана гэдэг чинь өнөөдөр энэ Үндсэн хуулиа зөрчсөн. Энэ асуудлыг бас олон иргэд сөхөж ярьсан. Тэгэхээр бид бүхэн бас энэ иргэдийнхээ хэлсэн үгийг өнөөдөр бас авч хэлэлцээж Засгийн газар үнэхээр Их Хурлын тогтоолын дагуу ажиллах уу, үгүй юу гэдэг бас асуудал байна шүү.

Ер нь 19 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө ер нь бид бүхэн дагаж байгаа юу, үгүй юу гэдгээ бас та бүхэн сайн судлаарай. Одоо удахгүй бас Үндсэн хуульд гар дүрэх гээд маш олон зөвлөлдөх зөвлөл олон ард иргэдийн одоо бодол санааг үймүүлээд ингээд яваад байдаг. Өөрчилчхөөд өөрчлөлтөө биелүүлдэггүй. Үндсэн хуулиа баталчхаад Үндсэн хуулиа биелүүлдэггүй ийм байдалтай байх юм бол энэ засаг төр цаашаа явахад хэцүү шүү. Ер нь Эрдэнэс таван толгойн тэр оффтейк гэрээ гэхэд 19 их наяд. Өнөөдөр Улсын Их Хурлын төсвөө жилдээ нэг 20 их наядаар баталж байгаа. Тэгээд энэ асуудлыг өнөөдөр та Улсын Их Хурлын бүрэн эрхт халдсан энэ үйлдлүүдийг таслан зогсоох ёстой. Одоо жишээ болгоод хэлэх юм бол энэ Дубайн гэрээ, Эрдэнэт Эрдэнэтийн 49 хувь гээд тухайн үеийн Засгийн газар нь Улсын Их Хурлаараа оруулахгүйгээр хэлэлцүүлэн баталсантай холбогдуулаад Засгийн газрын одоо холбогдох хүмүүст эрүүгийн хэрэг үүсгээд ял өгч байсан нь саяхан. Одоо тэр үеийн одоо Ерөнхий сайд нь эх орондоо ирж чадахгүй гадаадын улс оронд яваад байгаа ийм үйлдэл байгаа шүү.

Тэгэхээр яг энэ цаг хугацаанд энэ оффтейк гэрээнүүдийг хийсэн Засгийн газар ч гэсэн ирээдүйд хариуцлага хүлээнэ гэдгээ бас ойлгож байх ёстой гэж бодож байна. Ер нь богинын тээврийн асуудал дээр бас хэлэх хэд хэдэн асуудал байгаа. Сая тэр нүүрс амнаас нь зараад, тэгээд тээврийн маш их марж үүсгэснээс болоод энэ богинын тээвэр гэдэг бизнес гарч ирсэн. Сая төмөр замынхан яг энэ бизнесийг цаашир нь үргэлжлүүлээд тэр холбогдох албан тушаалтнууд нь гэртээ хэдэн арван тэрбумаар нь мөнгийг ингээд хадгалж байна. Энэ асуудал дээр ЗТЯ нэн ялангуяа маш хурдтай шийдэмгий шийдвэр гаргаж ажиллахгүй бол өнөөдрийн байдал улам даамжирна, улам цаашир нь үргэлжлэх нь. Тэгэхээр энэ асуудлуудаа хурдан шийдээрэй гэдгийг бас хэлье. Тэр дарга нар холбогдох хүмүүсээ Эрдэнэс таван толгой дээр томилоод түүгээрээ дамжуулж авлига авдаг энэ асуудлыг бас цэгцэл.../минут дуусав/

Г.Занданиатар: Хариулт хэн хариулах уу? Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Санал хэлсэн юм биш үү.

Г.Занданиатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаарх Ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулж Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсрогдож орж ирж байгаа юм. Мэдээж энэ хүрээнд яригдсан асуудлуудыг 3 үндсэн чиглэлд эрэмбэлж, тодорхой чиглэлүүдийг Монгол Улсын Засгийн газарт өгч холбогдох арга хэмжээ авхуулахаар тогтоолын төсөл боловсрогдсон байна. Гэхдээ энэ бол зөвхөн нүүрс экспорт, тээврийн асуудал биш юм билээ. Ерөөсөө энэ нүүрсний чинь уурхайнуудтай холбоотой асуудал өөрөө гарч ирээд байгаа зүйл. Тийм учраас энэ нүүрсний олборлолт, экспортлолд, тээвэрлэлтийн ил тод байдал, түүнд тавих хяналт, үр ашгийг

дээшлүүлэх чиглэлээр тов тодорхой үүрэг чиглэлийг Засгийн газарт өгөх ёстой гэж ингэж ойлгож байна. Мэдээж эрх зүйн шинэтгэлүүд хийгдэнэ. Энэ саяын хяналтын ерөнхий сонсгол явсантай холбогдуулаад үүссэн нөхцөл байдлуудыг дүн шинжилгээ хийгээд арилгах тодорхой арга хэмжээнүүд авагдаж хуулиудад тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд орно. Тэр болтол энэ бүхий л үйл ажиллагаанууд ил тод, нээлттэй, хяналттай, тэр хэмжээгээрээ Монгол Улсад хүртэх ёстой иргэдэд нь үр өгөөж нь нэмэгдэх нөхцөлийг хангасан байх энэ үүрэг чиглэлийг бол би Засгийн газарт өгөх ёстой гэж ингэж ойлгож байна.

Дараагийн нэг хэлмээр байгаа зүйл хэрвээ үр ашгийг дээшлүүлнэ, үр өгөөжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байгаа бол энэ өөрийн өртгийг хямдруулах тухай асуудал өөрөө босож ирж байгаа юм. Нэг тонн нүүрсийг ямар өртөг зардлаар гаргаж ирээд байгаа юм бэ? Энүүнийгээ цаашид яаж бууруулж, илүү өөрийн өртгийг бууруулах замаар үр ашгийг дээшлүүлэх бололцоо байгаа юм бэ гэж. Энүүнтэй чинь уялдаад тэр дотоод худалдан авалтууд гэдэг юм уу, бараа материалын нийлүүлэлт, хангалт, удирдлагын зардал гээд олон зүйлүүд яригдах ёстой. Тийм учраас тэрүүнийг тэгж задлалгүйгээр, ер нь энэ нүүрсний салбарын үр өгөөжийг дээшлүүлэх асуудал дотор ерөөсөө өөрийн өртгийг хямдруулах чиглэлээр маш том судалгаа хийж, холбогдох зөв зохистой арга хэмжээнүүдийг нь цаг алдалгүй авч хэрэгжүүлж байж бид сая энд нэлээн гайгүй үр дүн бий болох юм байна гэж ингэж харж байгаа. Энүүнийг одоо бас энэ тогтоолын төсөлд тусгах бололцоо боломж байгаа юу гэдгийг одоо асууж тодруулмаар байна.

Дараагийн нэг одоо тодруулмаар байгаа зүйл бол ерөөсөө энэ 1072 хувьцааны үр өгөөжийг дээшлүүлэхтэй холбоотой асуудал. Тэгээд энэ өнгөрсөн он жилүүдийн ногдол ашиг хуваарилалтын асуудлыг нэлээн нарийсгаж судалж, түүнийхээ дагуу бас тодорхой арга хэмжээнүүдийг ер нь

болж өгвөл болдог юм бол одоо энэ сар шинээс өмнө л хийх хэрэгтэй байгаа. Нөхцөл байдал тийм амаргүй байна. Тийм учраас энэ Монголын ард түмэн хүртэх ёстой баялгийнхаа үр өгөөжийг хүртэх ёстой. Тийм учраас энэ 2021, 22 оныхоо хувьцааныхаа ногдол ашгийг энэ 1 дүгээр сард юм уу 2 дугаар сарын эхэн дээр багтаж хүртэх ийм бололцоо боломжийг Монголын төр бүрдүүлж өгөх ёстой, энэ талаарх судалгаа юмнуудыг.../минут дуусав/

Г.Занданиатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар ерөнхий хяналтын сонсгол бол явуулсан. Ерөнхий хяналтын сонсголыг чинь гол одоо ач холбогдол сонсгол явуулдаг хүрээгээ бол манай иргэд гишүүд бол маш сайн мэдэж байгаа байх гэж бол бодож байна. Ерөнхий хяналтын сонсголын чинь энэ хэлэлцэж байгаа асуудлаар сонсгол явуулж байгаа асуудлаар холбогдох албан тушаалтнуудын мэдээлэл, тайлбарыг сонсоод сонсдог, тэгээд Их Хурлын гишүүд асуулт асуудаг, саналаа хэлдэг, оролцогчид бол санал одоо л илэрхийлдэг ийм л одоо зохицуулалтаар энэ ерөнхий хяналтын сонсгол явуулдаг.

Тэгээд хуульдаа ерөнхий хяналтын сонсгол явуулаад тухайн асуудлаар асуудлыг цаашидаа боловсронгуй болгох шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооны болоод Их Хурлын шийдвэрийн төсөл одоо боловсруулж, Их Хуралд оруулж хэлэлцүүлэх ийм хууль, эрх зүйн зохицуулалт бол байгаа юм. Тийм учраас бид Эдийн засгийн байнгын хорооноос зохион байгуулсан энэ ерөнхий хяналтын сонсгол явуулсантай холбоотойгоор энэ үүссэн нөхцөл байдалд бодитой үнэлэлт дүгнэлт өгч цаашидаа энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой гарч байгаа асуудлыг дахин гаргахгүй байх, нөгөө талаасаа таны яриад байгаа тэр үр өгөөжийг дээшлүүлэх, ялангуяа нүүрс

олборлолт, тээвэрлэлтийн өөрийн өртгийг нь одоо бас бууруулах үр ашгийг нь нэмэгдүүлэх ийм одоо зайлшгүй шаардлагатай гэж бол үзэж байгаа. Энэ хүрээндээ холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлтөд оруулах саналаа Их Хуралд одоо бас яаралтай өргөн барьж хэлэлцүүл гэдэг ийм чиглэлийг Засгийн газарт бол өгч байгаа. Тийм учраас бол энэ талаар бас хууль, эрх зүйн орчин одоо бүрдэж, бас тодорхой ахиц гарах болов уу гэж бол бодож байна.

Хоёр дахь асуудал энэ Эрдэнэс таван толгойн хувьцааг иргэдэд эзэмшүүлсэн, үүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, дээшлүүлэх асуудал үнэхээр одоо их чухал бол байгаа юм. Тийм учраас бол энэ Эрдэнэс таван толгойн компанийн хөрөнгөд дахин үнэлгээ хийх иргэдэд эзэмшүүлж байгаа 1072 хувьцааны нэгж хувьцааны үнийг бас дахин шинээр одоо тогтоох, мөн одоо энэ хувьцааны ногдол ашгийг иргэдэд олгох асуудал бол үнэхээр чухал байгаа юм. Тийм учраас энэ тогтоолд бол 2 одоо заалт бол оруулж байгаа. Нэг дэх асуудал нь 12 оны 4 дүгээр сарын 1-нээс хойш одоо төрсөн Монгол Улсын иргэддээ энэ Эрдэнэс таван толгойн хувьцааг шинээр одоо эзэмшүүлэх асуудлыг судалж, одоо бас шийдвэрлэх тодорхой саналаа 2023 нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд оруулж ирж танилцуулж шийдвэрлэх гэсэн нэг ийм бас чиглэл Засгийн газарт өгч байгаа юм.

Хоёр дахь асуудал нь сүүлийн жилүүдэд энэ 1072 хувьцааны ногдол ашгийг иргэдэд бол өгөөгүй. Тийм учраас бол энэ ногдол ашиг аваагүй байгаа иргэдэд Эрдэнэс таван толгой 1072 хувьцааны одоо ногдох ногдол ашгийг нь нөхөн одоо олгох ийм чиглэлээр бас заалт бол оруулж байгаа. Ингэж бас бид нар энэ 1072 хувьцааны үр өгөөжийг иргэддээ тэгш шударгаар хүртээх хүргэх ийм ажлыг бодитой бас ажил болгоно гэсэн ийм чиглэлийн заалтууд их тогтоолд бол орж байгаа. Тийм учраас бол энэ ногдол ашиг авах асуудал, иргэдэд ногдол ашиг хүргэх одоо асуудал бас нэлээн бодитой бас ахиц

бол өөрчлөлт бол орох байх гэж бол найдаж байгаа.

Г.Занданишатар: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тийм ээ, тэр ногдол ашгийг хүртэх бололцоо боломжийг бүрдүүлэх асуудал дээр биднүүсийн энэ төрийн өмчтэй гэдэг юм уу, ерөөсөө энэ заяагдмал баялаг дээр тулгуурласан компаниудын схем өөрөө их зөв байж байж явах болоод байгаа юм. Тийм учраас тэр шинээр хийгдэх гээд байгаа хөрөнгө оруулалт юмнуудаа шууд компани өөрийнхөө зардлаар хийгээд байдаг тэр үйл явц юмнуудыг нь зөв хязгаарлах замаар үр ашгийг дээшлүүлдэг нөхцөлөө бий болгох, зайлшгүй шаардлагатай үр өгөөж дээшлүүлэх хөрөнгө оруулалтынхаа асуудлыг нэмэлт үнэт цаас гэдэг юм уу, хөрөнгө босгох замаараа хийгддэг энэ харилцааг нь эрх зүйн хувьд нь зөв зохицуулж байж сая наад хувьцаа эзэмшиж байгаа улсуудын чинь эрх ашиг бүрэн хангагдах ийм бололцоо боломж нь бүрдээд байгаа байхгүй юу.

Г.Занданишатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой хяналтын сонсгол хийгдсэн. Тэгээд хяналтын сонсголыг удирдсан Чинзориг гишүүнээс нэг 2 асуулт байгаа юм. Нэгдүгээрт нь Нүүрсний экспорттой холбоотой. Нүүрсний экспорт чинь одоо хилийн хэдэн боомтой л гарч байгаа шүү дээ тодорхой нэртэй. Тэгээд аль, аль боомтууд дээр ямар, ямар экспорт дээр одоо нүүрсний хулгай байсан бэ? Юу гэж яригдсан бэ? Энэ талаар хариулж өгөөч.

Хоёрдугаарт тээвэрлэлттэй холбоотой. Тээврийн жолооч нар нүүрсний тийм үү хулгайч байсан уу, хулгайч байгаагүй юу нүүрсний? Одоо үндсэндээ бол нөгөө нүүрс тээвэрлэсэн, нүүрс олборлосон нүүрстэй холбогдсон бүгдээрээ л ерөөсөө хулгайч юм шиг л ийм нэг

хавтгайд нь харлуулаад л яваад байна л даа. Миний ойлгож байгаагаар бол тэр нүүрстэй холбоотой хулгайн асуудал дээр бол ТӨК, ТӨК тойрсон төрийн албан тушаалтнууд энэ төртэй холбоотой л үндсэндээ бол асуулт хулгай л байгаа байх гэж бодож байгаа. Хувийн компанийнхан, хувийн компанийнхан өөрсдөөсөө өөрөө өөрсдөөсөө хулгай хийнэ гэж байхгүй байх. Хувийн компани, хувийн компаниас хулгай хийнэ гэж байхгүй л байх. Энэ дээр та тэр нүүрсний хулгай яг хаана байна вэ? Энэ дээр тодорхой хариулт өгөөч. Юу гэж яригдсан бэ гэж. Тэгэхгүй бол одоо хүн болгоныг ерөөсөө тэр Их Хурлын гишүүдээс авхуулаад л зүгээр одоо тэнд явж байгаа нэг тээвэрчин болгоныг л хадны мангаа, нүүрсний хулгайч болгоод л ингээд цоллодог, харлуулдаг хавтгайд нь. Ийм байж таарахгүй байх.

Урьд нь бас Хөгжлийн банк гээд л одоо юу гэдэг юм, сайн төсөл, сайн зээлийг нь одоо тийм үү хулгайч болгоод л явж байсан. Зээлээ зориулалтын бусаар авсан, хууль зөрчиж авсан, хууль зөрчиж зарцуулсан, хууль бусаар зар төслөө хэрэгжүүлээгүй гэдгээр нь ялгаж ялгалгүй бүгдийг нь харлуулсан. Түүнтэй адилхан одоо нүүрсэн дээр бүгдийг нь харлуулж болохгүй байх. Миний бодож байгаагаар төмөр замчин тийм үү, нэг төмөр замчин тэр өртөөний дохиочин нүүрсний хулгайч биш. Тэр хэдэн мянган одоо нүүрс тээвэрлэж байгаа жолооч нар нүүрсний хулгайч биш. Тээврийн хөлсөө аваад л амьдрах гээд л, ажлаа хийгээд л явж байгаа улсууд. Ард талд нь тэр зохион байгуулж байгаа тэр вагоныг нь тавьж байгаа тэр юу нүүрсийг нь ачиж өгч байгаа, нүүрсийг нь худалдаж байгаа, тэнд л хулгай байгаа шүү дээ. Тийм болохоор энэ бүгдийг одоо бас нэг ялгаж салгаж, ингээж өгөхгүй бол тэгээд л энэ хэдэн мянган жолооч нарыг бол нүүрсний хулгайч юм шиг харддаг, сэрддэг хамааруулдаг ийм байж таарахгүй байх.

Тэгээд энэ дээр одоо бас хэдэн, хэдэн мянган одоо төмөр замчдыг бас хулгайч гэж харж болохгүй байх.

Тээвэртэй холбоотой С зөвшөөрөл хулгай байсан уу байсан. Энэ цэгцэрсэн. Одоо бөмбөлөг, ган бөмбөлөг гээд зарим эрх мэдэлтнүүдийн мөн машин бол өдөр болгон явдаг байсан. Энэ байхгүй болсон. Ил тод нээлттэй болсон. Одоо вагоны асуудал сая үүссэн. Вагоны асуудал бид нар ил тод нээлттэй болгоно. Ямар ч байсан одоо тээвэртэй холбоотойгоор одоо юу гэдэг юм С зөвшөөрлийг нь тэр ган бөмбөлгөөр одоо юу гэдэг юм, зарим нь одоо хөөсөн бөмбөлөг гээд ядарсан хэдэн жолоочийн бөмбөлөг нь хагарч л байдаг. Эрх мэдэлтэй дарга нарын бөмбөлөг хагардаггүй ган бөмбөлөгт явдаг. Энэ асуудал байхгүй болж байгаа. С-гийн асуудал байхгүй болж байгаа. Одоо энэ вагоныг дагасан нүүрсний одоо хулгай гэдэг юм энэ асуудал байхгүй болно. Ийм байдлаар үндсэндээ бол тээвэртэй холбоотой юу гэдэг юм нүүрсний хулгайн асуудал бусад одоо тийм үү, энэ авлигал, ашиг сонирхлын асуудал алга болно. Алга болгоно энийг тийм. Үүний төлөө ажиллаж байгаа, үр дүн гарч байгаа. Бусад асуудал дээр одоо бас хэрхэн явагдах вэ, ямархуу шийдэл байсан бэ? Яавал энэ төрийн өмч дагасан, ТӨК дагасан энэ нүүрсний худалдаа, экспорт дагасан хулгайнуудаа хэрхэн одоо яаж алга болгох талаар бас юу яригдсан бэ? Энийг бас хариулж өгөөч гэсэн 2 асуулт байна.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр би түрүүн хэлсэн дахиад л хэлье. Ерөнхий хяналтын сонсгол бол яг тухайн асуудлаарх албан тушаалтнуудын мэдээлэл, тайлбарыг одоо сонсдог. Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, саналаа хэлдэг, оролцогчид, иргэдийн төлөөлөл, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөлөл саналаа одоо хэлдэг ийм л одоо сонсгол. Тийм учраас бол тэрэн дээр яг одоо хаана нь хулгай байна уу, хэн хулгай хийгээд байна вэ гэдгийг бол энэ ерөнхий хяналтын сонсгол дээр бол тогтоох тийм бол бололцоо бол байхгүй. Бидний ярьж байгаа зүйл бол яг тэр сонсголд оролцсон, оролцсон иргэд, төрийн

бус байгууллагуудын төлөөллийн одоо ярьж байгаа тэр одоо түвшинд л бид нар энэ асуудлыг бол ярьж байгаа гэж.

Зүгээр энэ асуудлаар Хянан шалгах түр хороо бол байгуулагдаад ажиллаж байгаа. Бид нар оны өмнө хугацааг нь дахин 6 сараар сунгасан. Хяналтын түр хороон дээр бол яг гэрч одоо дуудах, нотлох баримт гаргуулах, холбогдогчдыг дуудаж оролцуулах, нотлох баримттай мэргэжлийн шинжээч томилж, томилж дүгнэлт одоо гаргуулах тэгээд ийм одоо төлөөллүүдийг оролцуулсан Хяналтын түр хороо хуралдаж, шаардлагатай бол одоо нээлттэй сонсгол явуулах ийм боломж нь хуулиараа байгаа. Тэнд тэр түр хорооны хурал дээр тэндээс зохион байгуулах хяналт сонсгол дээр бол яг одоо нарийн тэр хулгайтай холбоотой асуудал хаанаа байна вэ, хэн илүү оролцсон байна вэ гэдгийг нэлээн одоо нотлох баримт дээр тулгуурлаж гэрч холбогдогчдыг оролцуулан хийх одоо хийх учраас илүү нарийн бол асуудал яригдах байх.

Зүгээр нээлттэй сонсгол явуулсан хүрэнээс үзэхэд бол ер нь бол энэ нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудал дээр чинь бол одоо бас хулгай байна гэдгийг бол оролцогчид бол нэлээн сая ярьсан. Гэхдээ таны хэлж байгаатай би бол санал бол нэг байна. Төмөр замын одоо ажилчид тэр нүүрс тээврийн компанийн жолооч нар бол энэ бол хулгай бол хийгээгүй. Харин тэр төрийн өмчийн болоод төрийн өмчийн оролцоотой томоохон энэ компани дээр чинь бол хулгай болбол байна. Тэнд ажиллаж байгаа тэр удирдлагууд нь оролцдог байна. Төмөр замын болоод тэр нүүрс тээврийн компаниудын одоо удирдлагууд нь оролцдог ийм асуудлууд байна гэж яригдсан. Тийм учраас бол ийм түвшинд бол бас ярих ёстой болов уу гэж.

Би бол тэр ерөнхий сонсгол дээр иргэдийн ярьж байгааг сонсоход бол тэр нүүрс тээврийн 9000 гаруй жолооч нар шалгаж байна та нар. Тэд нар бол хулгай хийгээгүй шүү гэж эздийг нь одоо шалгах

ёстой гэдэг асуудал яриад байгаа юм. Би бол санал бол нэг байх. Тэр хууль хяналтын байгууллагаас явуулсан мэдээлэл сонсгол, нүүрс тээврийн 9000 орчим тээвэрчдийг бол мэдээлэл тайлбар авсан юм байна лээ. Авахдаа би бол ойлгохдоо тэр нүүрс тээврийн жолооч нар хулгай хийсэн гэж шалгаагүй юм байна. Тэр нүүрс тээврийн жолооч нарын тэр тээсэн нүүрсийг хэн одоо тээлгүүлж байна вэ, хэний эзэмшлийн одоо компани байна вэ гэдгийг нь тогтоохын тулд энэ одоо нүүрс тээврийн жолооч нараас мэдээлэл, тайлбарууд авсан юм байна гэж бол цаад эздийг нь тогтоохын тулд ийм тайлбар одоо бас мэдээлэл авсан юм байна гэж бол ойлгож байгаа.

Ер нь бол энэ төрийн өмчийн томоохон компаниуд дээр хулгай луйвар байгаа нь бол тодорхой байна. Тийм учраас энэ тогтоолын хүрээнд сонсголын хүрээнд одоо энэ Их Хурлын хүрээнд бас тодорхой бас арга хэмжээ авъя. Тодорхой хууль тогтоомж, өөрчлөлт шаардлагатай бол хуулиудыг нэн яаралтай одоо горимоор Их Хуралд одоо оруулж ир гэсэн ийм чиглэл Засгийн газарт бол өгч байгаа. Их Хурал дээр одоо хэлэлцэгдэж байгаа Энхбаяр гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа. Энэ Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль эдгээр хуулиудынхаа хүрээнд энэ төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын засаглалыг сайжруулахтай холбоотойгоор бид бас эрс тийм шинэчлэл хийх зайлигүй шаардлагатай байна гэдгийг сонсгол.../минут дуусав/

Г.Занданшатар: Баярлалаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр энэ оруулж ирж байгаа Их Хурлын тогтоолын төслийг бол дэмжиж байгаа. Энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар Их Хурал Ерөнхий сонсгол зохион байгуулсан. Чинзориг гишүүн энэ нээлтийн сонсголыг ахлаад ингээд зохион байгуулсан. Энэ дээр одоо яригдсан асуудлыг нэг

ишийдэл болгож энэ Их Хурлын тогтоолд одоо оруулж байгаа. Ялангуяа одоо ногдол ашгийг иргэд хуваарилах, цаашилах юм бол Засгийн газраас тавьж байгаа энэ оффтейк гэрээнүүдийг ҮАБЗ-өөр чиглэл гаргаж байж хийдэг энэ байдлыг зогсооё, Улсын Их Хурлаар одоо нээлттэй үнэхээр шаардлагатай ийм гэрээ хийх шаардлагатай бол энэ гэрээний асуудлыг Их Хурлаар ярьж. Цаашилах юм бол одоо олон жил яригдаж байгаа энэ Баялгийн сангийн хууль, тэгээд тэр нордик загвар энэ Скандинавын орнуудын баялгийн менежмент, баялгийн сангийн менежментийг сайжруулж байгаа ийм сайн жишиг туршилагаар ингээд явуулъя. Энэ хуулийнхаа асуудлыг түргэвчилж энэ тэр гээд нэлээн чухал, чухал санаанууд орж ирж байна гэж ингэж ойлгож байгаа юм.

Энэ дээр би асуух гээд байгаа юм бол энэ ногдол ашиг иргэдэд олгохтой, 1072 хувьцаа эзэмшиж байгаа иргэдэд олгохтой холбоотой асуудлаар гээд тэгэхэд энэний цаад талд төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой компаниудын одоо хариуцаж байгаа энэ хүний асуудалтай л холбоотой. Тэр хүмүүсийн одоо сэтгэл, тэр хүмүүсийн хариуцлага, үнэнч шударга байдалтай холбоотой асуудал л гараад байна шүү дээ. Энэ чинь одоо Таван толгой, Эрдэнэс таван толгой компани ашиглалтад орсноосоо хойш 12.5 их наяд төгрөгийн борлуулалтын орлого олоод тэрнээсээ 7.5 их наяд төгрөгийн худалдан авалт хийчихсэн. Тэрэн дотор нь бол одоо өчнөөн үнийг нь хэд дахин нугалаад ийм худалдан авалт хийчихсэн тухай асуудал яригдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийг хариуцаж байгаа тэр компанийн одоо ил тод нээлттэй засаглалыг сайжруулахтай холбоотой асуудал энэний цаад талд байж байна.

Бид бол бас олон жил ярьж байгаа. Энэ төрд ажиллаж байгаа төрийн өндөр дээд ажил албан тушаал хашиж байгаа улсууд төрийн албыг төрлийн алба болгодог. Өөрийн хувийн компани нүүсээрээ одоо төрийн худалдан авалтад оролцдог. Түүнчлэн одоо төрийн баталгаа гаргасан

зээл бондоос авдаг ийм асуудлуудыг зогсоо гэж олон бүрэн эрхийн хугацаанд ярьж, шаардаж шахаж ирсэн. Энэ маань бол одоо ажил болгож улс Засгийн газраас одоо энэ төрийн өндөр албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийг төрийн удирдах албанд ажиллах, худалдан авалт, энэ төрийн баталгаа гаргасан зээл, элдвийн хөнгөлөлт нөхцөлтэй ийм зүйлүүдийг авдаг энэ байдлыг одоо зогсоох хууль гараад ингээд нэг юм нэлээн олон жил 10 гаруй жил ярьж байж энэ бас нэг хэрэгжих ийм юундаа орж байна.

Би Чинзориг гишүүнээс асуух гэж байгаа юм энэ сонсгол дээр тэр эрх бүхий албан тушаалтнууд энэ хууль хяналтын байгууллагуудынхан ирээд ямар одоо тодорхой зүйлийг хэлсэн бэ? Тухайлбал энэ тээвэр туургатай холбоотой компаниудын ар тал дээр эрх мэдэлтнүүдийн машин тээврийн компаниуд явдаг гэж байгаа. Энэний одоо асуудлууд нь тодорхой болов уу? Түүнчлэн энэ төрийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой компаниудын тэр нүүрсний гэрээнүүдийг хийсэн энэ гэрээнүүдийг хийхэд нөлөөлсөн төрийн өндөр албан тушаалтнуудын нэр бас тодорхой болов уу? Энэ талаар одоо ажил явц байдал. Энийг л иргэд, олон түмэн шаардаад байна шүү дээ. Энэ дээр тодорхой зүйл хэлэх үү? Тэгэхгүй одоо ингээд асуудлыг Засгийн газар гаргаад тавьдаг. Тэгээд хууль хяналтын байгууллагаар очоод жаал нааш цааш нь эргүүлж тойруулж байгаад, тэгээд сүүлдээ замхраад алга болдог. Энэ хариуцлага тооцож чаддаггүй энэ байдал чинь л одоо.../минут дуусав/

Г.Занданишатар: Үг хэллээ. Содномын Чинзориг гишүүн хариулъя.

С.Чинзориг: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр нээлттэй ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсан. Энэ дээр эрх бүхий албан тушаалтнууд, сайд нар тэгээд дээр нь энэ Ерөнхий прокурорын газраас, Гаалийн ерөнхий газрын удирдлага энэ тэр гээд

нийтдээ албан тушаалтнууд мэдээлэл тайлбар бол хийсэн. Нийтдээ 6 мэдээлэл, тайлбар сонссон. Тэгэхээр энэ мэдээллүүдээс харахлаар Бат-Эрдэнэ гишүүний асуугаад байгаа яг тэр гэрээ хийхэд хэн нөлөөлсөн байна гэдэг асуудал бол тэр мэдээлэл дээр бол тэр тодорхой асуудал бол гарч ирээгүй.

Хоёр дахь асуудал нь энэ нүүрс тээврийн компаниудын чинь ард хэн байгаа байдаг юм бэ гэдэг асуудал бол тэр бас мэдээ дээр бол нэг их тийм тодорхой бас болоогүй гэж хэлж чадна. Ойлгож болно. Миний түрүүний яриад байгаа тэр яг энэ асуудлаарх байгуулагдсан Хянан шалгах түр хороо ажиллаж байгаа. Тэр Хянан шалгах түр хороон дээр чинь яг одоо нотлох баримт цуглуулж байгаа, нотлох баримт, баримттаа мэргэжлийн шинжээчид ажиллуулж дүгнэлт одоо гаргуулж байгаа. Дээр нь түр хороо эрхийнхээ дагуу гэрч бас дуудаж асуух, холбогдогчийг оролцуулж асуух ийм бас үйл ажиллагаа явуулах эрх нь бол тэр Хянан шалгах түр хороон дээр бол байгаа юм.

Тийм учраас бол таны одоо яриад байгаа энэ гэрээний ард хэн байна вэ, хэн нөлөөлсөн байна вэ, ямар албан тушаалтан байна уу, энэ нүүрс тээврийн компаниудын ард хэн байна, хэний компани энэ нүүрс тээвэр дээр оролцоод байна уу гэдэг нь бол тэр Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанаас нэлээн одоо тодорхой болох юм. Тэр гэрчүүд гэрчүүдийн өгсөн тайлбараас, тэр холбогдогчдын өгч байгаа тайлбараас, мөн төр хянан шалгах хороо өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд цуглуулсан нотлох баримт энэ нотлох баримтдаа мэргэжлийн шинжээчдийг оролцуулан хийлгэсэн дүгнэлтүүдээс одоо тодорхой болох юм гэж бол бас та бүхэн бас ойлгож байгаа байх гэж. Тийм учраас бол бид энд Хянан шалгах хорооны ажиллах хугацааг 6 сараар сунгаж өгсөн. Хаврын чуулганы эхээр энэ Хянан шалгах түр хороо энэ гэрчүүдийг, холбогдогчдыг оролцуулсан нотлох баримт цуглуулсан нотлох баримтдаа тэр шинжээчдийн дүгнэлт тусгасан тусгаж, тэгээд Хянан шалгах

түр хорооныхоо хурлаар хэлэлцэх, шаардлагатай бол Хянан шалгах түр хороо эдгээр төлөөллүүдийг оролцуулсан нээлттэй сонсгол явуулах явуул гэсэн ийм одоо чиглэлийг түр хороонд бол өгч байгаа.

Тийм учраас энэ түр хорооны хийх одоо энэ хуралдаан, сонсголоос бол энэ хэн нөлөөлсөн байна, ард нь хэн байна вэ гэдэг нь одоо илүү тодорхой болох ийм бас боломжтой. Дахин хэлэхэд бол энэ хяналтын ерөнхий сонсгол бол холбогдох төрийн албан тушаалтнуудын мэдээлэл сонсож тайлбар бол тайлбар авдаг ийм л хууль, эрх зүйн зохицуулалттай учраас бол нарийн хэн одоо нөлөөлсөн байна, хэн одоо ард нь байна вэ гэдгийг бол бид тогтоох тийм үүрэг бол тийм боломж ч энэ сонсголын сонсголд бол байхгүй. Харин одоо энэ удаагийн хяналтын сонсгол хийснээрээ бид нар нэг давуу тал нь бол өмнө нь 4, 3 удаа агаарын бохирдлын асуудлаар Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар, Хөгжлийн банкны асуудлаар хяналтын ерөнхий сонсгол явуулж байсан. Эдгээр сонсголыг хэлэлцээд Их Хурал ингэж 2 дахь удаагаа хэлэлцэж, бүр энэ сонсгол явуулсны мөрөөр авах арга хэмжээний тогтоол одоо баталж байсан ийм асуудал байхгүй юм байна лээ. Тэгээд сонсгол явуулаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Ерөнхий хяналтын сонсгол явуулаад ингээд Их Хурлын тогтоол оруулж ирж байгаа нь энэ бол сайшаалтай. Би бас түрүүнд тэмдэглэж хэлсэн. Тэгэхээр та сая яриад байгаа одоо тэр Хянан шалгах түр хорооны ажлыг эрчимжүүлж, энэний чинь цаад талд одоо эзэн байгаа шүү дээ. Тэр эздийг нь тодорхой болго. Сая одоо бас гишүүд яриад байгаа. Ингээд ерөөсөө бүгдэд нь хамааруулдаг. Бүх одоо 9000 тээврийн компаниуд, тээвэрлэгчид тээврийн компаниуд руу нялзаагаад байдаг. Энд байж байгаа бүх хүмүүст одоо хар будаг

түрхээд ингэж байгаад одоо аль ч үгүй замхруулаад, тэгээд жинхэнэ хулгайч луйварчид нь одоо ард талд нь сугараад үлддэг ийм байж таарахгүй. Тийм учраас энийг одоо сайн шаардаж шахаж, хурдан гаргах хэрэгтэй.

Нөгөө талынх нь юм бол яг үүнтэй уялдуулаад ингээд ерөөсөө төр бол муу менежер гэдэг тэр хүний асуудлаас болоод ингээд энэ чинь төрийн өөрөө баялгийн менежментээ хийх энэ асуудлыг чинь бүр аль ч үгүй болгоод ингээд хаях гээд байна шүү дээ. Ингэх юм бол энэ улс орон чинь.../минут дуусав/

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Ерөнхий хяналтын сонсгол Их танхимд мэдээлэлтэй албан тушаалтан, мэдээлэлгүй ард иргэд ороод тэр бол юм ярих боломж олдоогүй л дээ. Одоо энийг Мөрдөн шалгах сонсголыг энэ хаврын чуулганы хугацаанд биш хаврын чуулганаас наана хийвэл яадаг юм. Энэ чуулганы завсарлагааны хугацаанд нэгдүгээрт? Энүүгээр бид нар энэ хулгай зэлгийгээ цэгцэлж авахгүй бол энэ зүгээр нэг өнөөдрийн нэг Таван толгойн асуудал биш шүү. Ер нь Монголын бүх газар баялаг баялагтай холбоотой мөнгө төгрөг явж байгаа бүх газар хулгай нүүрлэсэн байна. Удахгүй энэ Монгол Улс азийн Зимбаби гэдэг нэр авахаар хэмжээнд очсон байна шүү. Энэ Эрдэнэс Монголыг тойрсон нийтдээ 25 компани байна. Багануур, Эрдэнэт, Эрдэнэс таван толгойгоос эхлүүлээд. Эрдэнэс силвер гээд одоо. Энэ бүх компаниудын чинь үр ашгийг тооцоход энэ ард түмэн энэ гурван сая ард түмний чинь бол өлхөн хэний ч гар харахааргүй амьдрах боломж бий шүү дээ бид нарт.

Энэ ашигт малтмалтай холбоотой юмыг сүүлийн үед нэлээн судалж үзлээ. Нийтдээ Монгол Улсын хэмжээнд 1148 ашиглалтын лиценз байна. 3400000 хүнд хуваахад наадах чинь 2800 хүн тутам нэг лиценз ашиглаж уул уурхай ашиглаж байгаа байхгүй юу. Энэ бол багагүй

хэмжээний ашиг олж байгаа, бүр багагүй хэмжээний. Энэ алт зэс, жонш, төмөр одоо юу байдаг юм. Энэ бүгдийн татвар болоод бусад хэлбэрээр орж ирж байгаа энэ ашиг орлогууд яг хаагуур яваад байна вэ? Энэ 1072 хувьцаа гэж өнөөдөр зөвхөн Эрдэнэс таван толгой тойрч бид нар энийг хиймээргүй байна. Энэ хувьцааны ашгийг яаралтай өгөх хэрэгтэй. Өгөхдөө энийг бүр том зургаар нь тооцож хийх ийм боломж бид нарт байгаа биз дээ. Тэгээд энэ тогтоол дээр Чинзориг гишүүнээ ийм утгагүй юм хүртэл бас хийгээд оруулаад ирэх юм. Энэ оффтейк гэрээг цааш нь үргэлжлүүлэх эсэхийг судалж шийд гээд аудит оруулсны үндсэн дээр. 119 доллараар өртөгтэй юмыг 60 доллароор зарсныг цааш нь яах гэж үргэлжлүүлэх гээд байгаа юм бэ? Энэ хэнд хэрэгтэй юм. Дахиад энд дахиад оффтейк гэрээг үргэлжлүүлж, ингэж дахиад хулгайг нь үргэлжлүүлэх гээд дэмжих гээд байгаа юм уу? Энийгээ зогсоо л доо.

119 доллароор зарагдаж байгаа нүүрсийг 60 доллароор гэрээ байгуулаад ингэж дундаас нь зувчуулж байгаа юмыг одоо яах юм бэ? Тэгээд одоо наана чинь аудитын дүгнэлт гарч ирэх юм байна. Энийг бол цааш нь үргэлжлүүлэх нь зөв юм байна гэдэг. Тэгээд энэ нүүрсний хулгай тойрсон энэ бүлэглэлүүд чинь энэ дээр чинь ажиллаж байгаа шүү дээ. Энэ өгүүлбэр хаанаас орж ирсэн юм, энийг чинь ерөнхий сонсголыг би бол бүтнээр нь үзсэн, цуг байсан дотор нь суусан. Энэ дотор энэ аудитын дүгнэлт гаргаад цааш нь үргэлжлүүлье гэж ерөөсөө нэг ч хүн тийм юм ярьж байгаагүй. Энийгээ больё.

Энэ 1072 хувьцаатай холбоотой ард иргэдэд дөч хүртэлх хувийг нь мөнгөжүүлэх, нэг өрхөд ойролцоогоор нэг хүнд ойролцоогоор хоёр сая орчим төгрөгийн ногдол ашиг өгөх боломж бид нарын өнөөдөр зөвхөн өнөөдөр байгаа Эрдэнэс таван толгой дээр бол байгаа юм байна лээ. Зөвхөн орлого дээр нь тооцоход. Энийг нь бүр том хэмжээнд нь өгье л дөө. Одоо энэ Эрдэнэс Монгол, Эрдэнэс Монголыг тойрсон энэ 16, 24, 25 том

компани дээр байгаа энэ бүх ногдол ашиг юмнуудыг нь тооцож, энэ баялгийн хуваарилалтыг нь ард түмэнд нь яг өгье гэж байгаа бол яг чин сэтгэл бид нарт байгаа бол энийг нь яг тэр хэлбэрээр нь хийе л дээ. Энэ тооцоо судалгаа хийгээд яах хийхэд бол удаад байх юм байхгүй санагдах юм.

Мэдээж зарим ААН-үүд нь ашигтай байгаа. Зарим нь алдагдалтай байгаа байх. Алдагдалтай байгаа юм. Одоо тэгээд бид нар ингээд хууль руу юм чихдэгээ боль. Компанийн хууль болохгүй. Төрийн болон орон нутгийн өмч.../минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсгийн дарга Содномын Чинзориг гишүүн хариулъя.

С.Чинзориг: Тэгэхээр би түрүүн хэлсэн. Өмнө нь Улсын Их Хурал тодорхой асуудлаар 3 удаа утааны асуудлаар, агаарын бохирдлын асуудлаар Жагсаал цуглаан хийх хуулийн хэрэгжилтийн талаар, Хөгжлийн банкны асуудлаар 3 удаа ийм ерөнхий хяналтын сонсгол явуулсан байдаг. 4 дэх ерөнхий хяналтын сонсгол нь нүүрсний экспорт, тээвэрлэлттэй холбоотой асуудлаар хяналтын сонсгол явуулсан. Өмнө нь 3 удаа хяналтын сонсгол явуулаад Их Хурал дээр тайланг нь одоо хэлэлцэж, түүний мөрөөр Их Хурлаас тодорхой бас тийм шийдвэр одоо гаргаж байсан тохиолдол бол байхгүй юм байна лээ. Харин одоо энэ удаагийн хяналт ерөнхий хяналтын сонсгол явуулсны давуу тал нь бол зайлиггүй энэ одоо асуудлаар Их Хурал дээр танилцуулж, Их Хурлын одоо тодорхой шийдвэрүүдээ гаргах нь зүйтэй гэж бол бид бол үзсэн.

Тийм учраас бол ерөнхий хяналтын сонсгол явуулаад, анхны тохиолдол нь энэ сонсголын мөрөөр авах Их Хурлын одоо шийдвэрийн төсөл боловсруулж, оруулж ирж байгаа гэдгийг бас зориуд бол хэлье. Ипотекийн гэрээ, оффтейк гэрээтэй холбоотой 2 асуудал оруулж ирж байгаа Раднаасэд гишүүнээ. Нэг дэх асуудал нь цаашидаа ерөөсөө энэ Үндэсний аюулгүй

байдлын зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ бас байгуулахгүй байх гэсэн. 2 дахь асуудал нь бол улсын нууцад хамруулахгүй байх. Энэ асуудлыг хэрэв гэрээ зайлиггүй байгуулах шаардлагатай бол Их Хуралд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлж байх гэсэн ийм одоо бас нэг заалт бол оруулж байгаа. нэ бол нэлээн бас чангаруулсан ийм одоо заалтаа гэж бол ойлгож байгаа.

Таны яриад байгаа санал бол Их Хурал Байнгын хороон дээр тодорхой нэр бүхий гишүүдийн саналаар Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүдийн одоо саналаар ийм одоо томъёолол орж ирсэн. Доржханд гишүүн дараагаар нь бас өөрөө санал гаргасан гишүүн нь өнөөдөр тайлбар бас хийж болох байх. Эрдэнэс таван толгой ХК-иас компаниас санхүүжүүлсэн оффтейк гэрээний хүрээнд хэрэгжиж байгаа төмөр замын бүтээн байгуулалтад хөндлөнгийн аудит оруулах, аудитын дүгнэлтдээ үндэслэн санхүүжилтийн үргэлжлүүлэх эсэх асуудлыг одоо шийдвэрлэе гэсэн ийм одоо тодорхой заалт бол орж ирж байгаа. Энэ бол тодорхой гишүүдийн саналаар бол орж ирж байгаа юм. Би бол бодохдоо аудит оруулах нь зайлиггүй шаардлагатай юм байна гэж.

2 дахь асуудал энэ ажлыг чинь үнэхээр одоо хэрэгтэй, хэрэгцээтэй хэрэгтэй үр дүнтэй хэрэгжиж байна гэж үзвэл аудитын дүгнэлтийг үндэслээд санхүүжилтийн асуудлыг нь бас шийдвэрлэх тэр боломж нөхцөлийг нь одоо бас үлдээх нь бол зөв, буруугүй ч болов уу гэж бол бодсон. Хэрэв аудитын дүгнэлтээр энэ үр дүнгүй болсон байна, үр ашиггүй болсон юм байна, зогсоох нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргавал тэгээд л одоо зогсоох тэр эрх нь бол нээлттэй байгаа юм Раднаасэд гишүүнээ гэж бол хэлье. Тийм учраас бол оффтейк гэрээтэй холбоотой ерөөсөө оффтейк гэрээ байгуулахгүй байх улсын нууцад авахгүй байх, цаашидаа ийм оффтейк гэрээ байгуулахаар бол зайлиггүй Их Хуралд оруулж ирж байж Их Хурлаар хэлэлцүүлж байж одоо шийдвэрлэж бай

гэдэг бол энэ бол маш одоо том зарчмын томоохон одоо бас өөрчлөлт болж байгаа шүү гэдгийг би бас хэлэхийг бол хүсэж байна. Тэгээд тэр яг тэр аудитын дүгнэлттэй холбоотой, санхүүжилтийг үргэлжлүүлнэ эсэх асуудал гэдгийг бас яг өөрөө санал гаргасан энэ Оюунчимэг гишүүн, Доржханд гишүүд бас тайлбар бас хэлж бол болох байх гэж бол бодож байна.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн нэмж хариулъя.

Т.Доржханд: Зөв, зөв, баярлалаа. Тэгэхлээр яалт ч үгүй энэ 2 асуудлыг бол нэмсэн, санаачилсан нь бол үнэн. Тэгээд цаашид бол оффтейк гэрээ бол байж болохгүй. Байж болохгүй гэдэг нь юу вэ гэхээр нууцалж болохгүй. Оффтейк бол өөрөө олон улсад хэрэглэгддэг. Энийг бол ашиглаж болно. Гэхдээ оффтейк гэрээг нууцлаад Үндэсний аюулгүй байдлын зөвлөмж гаргадаг юм уу, аль эсвэл нэг байгууллага нь нууцлаад цаашаагаа ингээд шууд худалдан авалт хийдэг, тэр нь бол зах зээлийн үнээс хэд дахин илүү өндөр үнэтэй байдаг зүйлийг бол зогсоо гэж байгаа юм. Тэгээд ҮАБЗ-өөс тухайлбал ямар нэгэн зөвлөмж цаашид гаргахдаа энэ аж ахуйн ажил болон хөрөнгө оруулалтын ийм төрлийн асуудлуудаар бол битгий зөвлөмж гарга гэж байгаа юм.

Харин Үндэсний аюулгүй байдалтай холбоотой хил, гааль, гадаад асуудалтай холбоотой зүйл дээр бол болно гэж ийм байдлаар. Харин дараагийнх нь ийм байгаа шүү Раднаасэд гишүүнээ. Одоо ингээд Эрдэнэс таван толгойн бүрэн эрх төлөөлөгчийн мэдээллээс сонсох юм бол нөгөө Бодь Интернэйшнл гэдэг компани руу хүсэлт явуулсан гэж байгаа юм. Хүсэлт нь юу вэ гэхээр энэ оффтейк гэрээнийхээ нөхцөлийг эргэж ярья гэж байгаа юм. Үгүй ээ, энэ юу гэж тийм байж болох юм бэ. Тов тодорхой хулгай ойлгомжтой болчихсон байхад. Дээрээс нь төмөр замын бүтээн байгуулалт нь олон улсынхаа зах зээлийн үнээс 3-4 дахин илүү үнэтэй байна гээд. Өөрөө бол маш хямдхан барьчихсан гээд байгаа шүү дээ. Нэг аравны бараг нэг

дөрвөн сая доллароор нэг километрийг нь барьчихсан гээд. Гэхдээ энийгээ болохоороо суурь бүтцээрээ нийтэд нь биш ингээд таслаад л тэндээ сайхан тайлбарлаж байгаа байхгүй юу.

Гэтэл олон улсын түвшинтэй харьцуулах юм бол маш их өндөр зардлаар барьчихсан. Тэрийг нь больё гэхэд хажуу талд нь нүүрсээ авахдаа цаана нь 190 доллар нэг тонн нь байх ийм зах зээлийн үнэтэй байхад жар болон түүнээс нэг жоохон дээгүүр л авчихсан юм байна лээ шүү дээ. 2-3 дахин өндөр үнэтэй бага үнээр ингээд авчихсан. Энийгээ нууцалчихсан. Энэ зүйл чинь хулгай байна. Зарим гишүүд бүр дээрэм гээд байгаа шүү дээ. Би бас санал нийлж байгаа. Үгүй ээ, ийм тохиолдолд юун тэр санхүүжилтийг нь цаашаа үргэлжлүүлж өгөх вэ? Юун Эрдэнэс таван толгойн бүрэн эрхт төлөөлөгч учраа олчихёе гээд явах вэ. Уучлаарай. Тийм болохоор хэрэв Улсын Их Хурлын энэ байр суурийг хүлээж авахгүй бол тэгвэл хөндлөнгийн аудитыг оруул гэж байгаа юм. Оруулах хүртэл наад санхүүжилтээ зогсоо гэж байгаа юм. Тэгээд харин цаашаагаа үнэхээр дүгнэлт нь хөндлөнгийн бөгөөд зөв байна гээд үзээд, үнэхээр тодорхой төвшинд санхүүжилт өгөх хэрэгтэй гэх юм бол тэрийг нь бол шийдээд явах нь зүйтэй гэдэг ийм байдлаар энэ тогтоолын агуулга нь явж байгаа шүү. Ийм байдлаар.

Тэгэхгүй бол цаана чинь дахиад л нэг хөшигний цаана ярилцаад л, за за санхүүжилтийг нь өгчихье гэдэг юм явах гээд байна шүү. Энийгээ хулгай гэдгийг бүгдээрээ иргэд мэдэж байгаа, бид мэдэж байгаа бол Улсын Их Хурал нь энэ дээрээ тогтоолоороо энийг тодорхой зааж өгье гэж байгаа юм шүү. Харин би нэг зүйлийг ингээд гайхаад байгаа юм. Бас шууд хэлчихмээр байна. Эдийн засагч хүний хувьд бол хэлмээр байна шүү. Бид нар ингээд хулгай ярьж байхад чинь попордог байж болохгүй. Өнөөдөр 5 хүн АТГ-аас ингээд зарлачихлаа. Үгүй ээ, та өөрөө ингээд би бол хулгайч биш, жинхэнэ хулгайч нь өөр хүмүүс байна. Тухайлбал Аюурсайхан бол жинхэнэ хулгайч л гэж та ярьсан шүү дээ.

Үгүй ээ, тийм биз дээ жишээ нь. Гэтэл тэрийгээ ингээд нотлоод ярихын оронд тийм юм ярихгүйгээр Эрдэнэс таван толгойн 40 хувийг нь бид нар ард түмэндээ өгнө гээд. Нөгөө л нэг халамж хавтгайруулсан гэсэн ийм байдлаар ингээд яриад байхаар итгэл үнэмшил байхгүй байна. Иргэддээ өгөх тэр асуудал байж болно.

Гэтэл оффтейк гэрээгээр 18, 19 их наяд төгрөгийг нь урьдчилаад орлогыг нь идчихсэн, дахиад бөөн алдагдалтай компанийг та нар ингээд хувьцаа болгож өгнө гэж хуурч болохгүй. Оюу толгойн 34 хувийг аваад бид нар 22 тэрбум долларын өрөнд орох ийм нөхцөлийг үүсгэсэнтэй адилхан юмыг ингээд хийх гээд байгаа байхгүй юу. Дараа нь жинхэнэ хулгайч нь гарч ирээд зуун хувийг ард түмэндээ өгнө гээд алга ташуулах юм уу. Үгүй ээ, энэнийхээ оронд та нар шударга бай л даа. Тэгээд зарлах гэж байгаа бол зарлаад яв л даа. Нотлох баримтаа гарга л даа. Тэгэхгүй ингээд өөр байдлаар улс төр хийгээд, хамгаалалтад орно гэх юм бол наадахтай.../минут дуусав/

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн тодруулж асууя 1 минут.

Ш.Раднаасэд: Доржханд чинь одоо баавгайн талд байна уу, хэний талд байна мэдэхгүй энэ ард түмний талд байгаа юм уу. Яриад байгааг нь сонсохоор энэ оффтейк гэрээ буруу баба гэх юм. Тэгсэн мөртөө төгсгөлд нь болохоор хамгийн сайн болчихсон шүү дээ гэсэн агуулгатай юм яриад байгаа юм. Ямар учиртай юм бэ энэ. Дүгнэлт гаргаад үргэлжлүүлэх юм уу тэгээд. Одоо таван сая доллароор барьчихсан байгаа төмөр замыг тэгээд үргэлжлүүлэх юм уу? Нэг километрийг нь. Дүгнэлт гаргасныг үндэслээд үргэлжлүүлэх эсэхээ шийд гэж байна шүү дээ. Тэгээд энийг чинь үргэлжлүүлэе л гэж гарч ирнэ биз дээ. Санхүүжилтээ аваад явж байгаа шүү дээ энэ төслүүд чинь бүгдээрээ. Ерөөсөө зогсоогүй байгаа шүү дээ. Энэ Богд хаан төмөр зам гээд гэрээ

байгуулаагүй ч гэсэн санхүүжилтээ аваад л явж байна гэж өөрсдөө хэлж байгаа шүү дээ. Тэгээд энэ зөв юм уу. Одоо тэгээд энийг ярихаар өөр юм яриад байх юм урдаас. Ийм байдлаар цаашаа яваад байвал наадах нь яваад л байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Раднаасэд гишүүнээ таны яриад байгааг бол ойлгож байгаа. Тэр аудит оруулаад санхүүжилтийг үргэлжлүүлэн эсэх, эсэхийг шийдвэрлэх гэдэг асуудлыг хэдүүлээ Эдийн засгийн байнгын хороон дээр одоо энэ чинь бол Эдийн засгийн байнгын хороон дээр нэг хэлэлцүүлэгт шилжүүлэхээр байнгын хороонд шилжүүлнэ шүү дээ. Тэрэн дээр нь одоо шаардлагатай гэвэл одоо та саналаа хэл. Бид ч гэсэн одоо дахиж авч үзье. Энийг бол одоо энд маргалдаад яахгүйгээр тэр эцсийн хэлэлцүүлэгт бэлдэхдээ шаардлагатай бол одоо өөрчлөөд боловсронгуй болгоод оруулаад ирэхээр боломж нь бол байгаа. Тэгээд тэр одоо Байнгын хороон дээр үргэлжлүүлээд дахиад одоо таны саналыг бас судалж үзээд, Байнгын хороон дээр ярья гэсэн ийм бодолтой бол байна. Тийм боломж бол байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр би бас нөгөө надад байгаа мэдээлэл Раднаасэд гишүүнд байгаа мэдээлэл зөрөөд байх шиг байна. Ямар ч байсан санхүүжилтийг нь бол Бодь Интернэйшнл гэдэг компани бүх санхүүжилтийг бол зогсоочихсон гэж байгаа юм, зогсоочихсон. Одоог хүртэл. Нөгөө хэд нь авъя гэнгүүт нөгөө бүрэн эрхт төлөөлөгчийнх нь өгсөн мэдээллээр болохоор одоо ингээд хүсэлтээ тавиад гэрээгээ өөрчлөөд цаашаа санхүүжилтийг өгөх ийм процесс яригдаад байгаа байхгүй юу. Харин энийг нь одоо зогсоо, энийг нь өгч болохгүй гэж байгаа юм. Хэрэв үнэхээр бид нарт судалгаа байхгүй. Тэр нөгөө бизнес эрхэлж байгаа

компани үндэслэлтэй гэх юм бол тэгвэл хөндлөнгийн аудит оруулъя. Шаардлагатай бол олон улсын хөндлөнгийн аудит оруулъя. Жишээ нь энэ төмөр зам гэдэг юм чинь жишээ нь Монголын энэ төмөр зам урагшаагаа гоё тал газар ингээд тавьчихсан юм байна лээ л дээ. Би мэргэжлийн хүн биш. Тэгэхдээ мэргэжлийн хүмүүсээс авч байгаа юм. Та нар ингээд төсөөл дөө. Шинжин Уйгараас урагшаагаа нөгөө Төвд рүү явсан нэг зам байдаг шүү дээ. Маши өндөр ингээд уулын дээгүүр ингээд явчихсан. Өндөр, өндөр баганатай. Тэр зам чинь бол ингээд бид нарын төсөөллөөр бол ингээд уулан дундуур, уулан дээгүүр төмөр зам тавина гэдэг чинь асар их өндөр зардал байх даа. Яг ижилхэн ийм стандартын зам нь тэнд чинь 3.4 сая доллароор нэг километр нь тавигдсан байна.

Гэтэл манай энэ урагшаа явдаг зам чинь бол уулын нөхцөл эд нар нь бол маш тааламжтай юм байна лээ шүү дээ. Барихад их нөгөө алслал энэ тэр нь бол налуу эд нар нь бол маш тааламжтай, маш бага зардлаар явах боломжтой. Үгүй ээ, тэгээд хажуу талд нь нөгөө концесс хийсэн компаниуд чинь 1.2, 3 сая доллароо л хийчихсэн юм байна лээ шүү дээ. Яг ижилхэн нөхцөлтэй байхад. Гэтэл манайх болохоор энэ 3.5 саяар хийсэн гээд. Тэр Баясгалан гэдэг хүн танилцуулгадаа болохоороо үгүй ээ энэ суурь дэд бүтэц гэдэг юм чинь болохоороо зөвхөн одоо суурь дэд бүтцээр тооцдоггүй юм. Зөвхөн ингээд тавьсан замынх нь өртгөөр нь тооцох ёстой. Тэрүүгээр бол 1.4 гээд. Гэтэл олон улсад нэг километр замын өртгийг тооцохдоо суурь дэд суурь бүтцээр нь тооцдог. Энэ дээр болохоор тэр доод бүтэц, дээд бүтэц, тэгээд салаа зам өртөө зөрлөг, байшин барилга, дохио холбоо бүгд орж байж энэ чинь өртөг нь гарч ирж байгаа байхгүй юу. Зүгээр л хулгай шүү дээ. Тийм болохоор Улсын Их Хурал дээр энэ асуудлыг одоо шийдтэл зогсоо гэж байгаа юм. Зогсоосноо үргэлжлүүлж болохгүй гэж байгаа. Үнэхээр шаардлагатай бол олон улсын хөндлөнгийн аудитыг оруулж ирж байгаад наад асуудлаа явуулах

асуудлаа шийд ээ л гэдэг ийм л тогтоол байхгүй юу. Ийм л байдлаар байж байгаа шүү. Энэ дээр бол хатуу байна.

Цаашид бол УАБЗ-өөс ч гэдэг юм уу, ямар нэгэн аж ахуйн шинж чанартай, дэд бүтцийн шинж чанартай асуудлыг тэнд шийддэг байж болохгүй. Ямар нэгэн чиглэл өгдөг байж болохгүй. Энийг парламент дээрээ ярьдаг байх ёстой. Парламент чинь Эрдэнэс таван толгой гэдэг компанийн орлогоос нь татвар аваад, тэр татварын хэмжээг нь өнөөдөр энд яриад төмөр зам барих юм уу, газар доорх дэд бүтэц барих юм уу, цахилгаан станц барих юм уу гэдэг асуудлыг шийддэг байх ёстой байхад, парламент өнөөдөр юу юм 2023 оны хөрөнгө оруулалтын төсөл гээд 1.4 их наядыг л ингээд ярьж байна шүү дээ. Мөнгө байхгүй гэхэд. Гэтэл тэнд чинь 18, 19 их наядын зөвхөн оффтейк гэрээгээр нэг захирал нэг чиглэл аваад шийдчихсэн байгаа юм чинь парламентын засаглал биш байна. Энэ олигархын засаглал байна. Захиалгатай юм байна. Тэгээд тэрэнд нь УАБЗ биш тэрийг ингээд шахаж шийдвэр гаргуулсан хүн нь гадагшаа зугтаачихсан байна. Ийм бол энэ нөхдүүдтэйгээ хариуцлага тооцох асуудлыг ярья. Тэгэхийн тулд энэ хулгай дээрмийн гэрээг бол одоо санхүүжилтийг нь зогсоо л гэсэн ийм агуулгаар явж байгаа шүү. Энэ дээр бол огтхон ч бид нар буцаж байгаа юм бол байхгүй.

Харин энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудал бол жаахан намжчихаад байна. Тийм болохоор Раднаасэд гишүүн ярьсандаа байгаад, тэр өгнө гэсэн мэдээллээ өгөөрэй. Тэрэн дээр чинь харин дэмжиж явна шүү.

Г.Занданшатар: Энд бас нэг зүйл яригдаад байдаг нэг юманд би тодорхой хариу өгчихмөөр байна. УАБЗ-өөс лав л би тэр ямар нэгэн оффтейк гэрээг нууцад авах нь битгий хэл танилцаагүй, хараа ч үгүй, үзээ ч үгүй. Сүүлийн үед бас зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр тийм яриад байгаа, оффтейкийн гэрээ нууцад авсан ч гэх ииш. Тэгээд энийг бол

хариуцлагатайгаар мэдэгдье. Ер нь бол үеийн үед энэ стратегийн том орд газруудыг ашиглая, дэд бүтцийг нь барьж байгуулья гэж ҮАБЗ-өөс хэрэгжсэн, хэрэгжээгүй зөвлөмжүүд бол гарч байсан юм байна лээ. Ер нь бол тийм оффтейк гэрээтэй ямар ч нэг оффтейк гэрээ бол нэг ширхэг ч оффтейк гэрээтэй танилцахыг нь бол битгий хэл үзэж хараагүй шүү. Сая сүүлийн үед зарим нэг сайт энэ тэр тийм яриа гараад байгаа юм. Тэрнийг бол одоо гишүүд танилцаж үзэж харж болох юм байна лээ. Нууцын журмаар нь. Дамбын Батлут гишүүн алга байна. Баагаагийн Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ нүүрсний хулгайн асуудал бол Монголын түүхэнд бичигдэх хамгийн том хулгайнуудын нэг шүү. Ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн энэ 30 жилийн хугацаанд Монголд энэ өмч хувьчлал гэж Монголын ард түмний эсрэг хийсэн энэ маш том гэмт хэрэг байсан. Дараагийнх нь энэ ашигт малтмалын лиценз тойрсон хулгай. Одоо энэ Таван толгой, Эрдэнэс таван толгой тойрсон хулгай байх. Тэгээд энэ чинь одоо нэг 86000000 тонн нүүрс борлуулаад нэг 12.6 их наяд төгрөг олоод, 7.5 их наяд төгрөгөөрөө худалдан авалт хийчихсэн ийм л байгаа юм л даа. Нүүрс аман дээрээс нь жаран доллар худалддаг, Ганц модон дээр очихоороо 240 доллар болдог. Дунд нь хулгайч нарын халаасанд 180 доллар тонн тутмаас ордог. Ийм л юм байгаа шүү дээ. Энийг хэн хийх юм гэхээр эрх мэдэлтэй хүмүүс л энэ шүү дээ.

Оффтейк гэрээ гээд л ингээд нэг тооцохоор зэрэг 19 их наяд төгрөг. Энэ жилийн чинь Монгол Улсын төсвийн орлого чинь 19 их наяд төгрөг шүү дээ. Гэтэл Монгол Улсын төсвийн орлоготой тэнцэх хэмжээний тийм гэрээ очоод хийчихсэн байна шүү дээ. Тэгээд одоо энд яриад байгаа юмнуудыг ингээд харахаар зэрэг л тэнд нэг Эрдэнэс таван толгой компанийн захирал, Эрдэнэс таван толгой трансйн захирал одоо хийчихсэн юм шиг л сүүлийн үед л яриад байгаа байхгүй юу. Үгүй ээ энийг чинь хянадаг шалгадаг, үздэг хардаг

Монгол Улсын бүтэн жилийн төсөвтэй тэнцэх хэмжээний зардал гэрээ хийчихсэн байхад одоо энэ үздэггүй юм уу, хардаггүй юм уу? Тэгээд коксжих нүүрс нь эрчим хүчний нүүрс болдог. Жин тонн дээр нь ажилладаг, бөмбөлөг тээвэр гээд одоо удирддаг. Худалдан авалттай холбоотой асуудал, нүүрс худалдах гээд ингээд энэ чинь 10 хэдэн төрлийн хулгайны асуудал явж байгаа шүү дээ.

Хувьцааны ашиг өгөөгүй, 20 онд өгөөгүй, 21 онд өгөөгүй, 22 онд өгөөгүй. Энийг Монголын ард түмэнд өгөх ёстой. Тэгээд одоо энэ төрийн өмчтэй компаниуд хулгай нүүрлэхсэн. Улс төрд нь хов нүүрлэхсэн, улс эх оронд нь хог нүүрлэхсэн. Төрийн өмчтэй компаниудад нь хулгай нүүрлэхсэн байна шүү дээ. Тэгээд энийг хэлэхээр одоо ингээд энэ хулгайчийн троллууд одоо янз бүрийн юмаар дайрч байна л даа. Бид нарыг одоо энэ шударга юм ярьж байгаа улсуудыг Монголын ард түмэн дэмжиж байгаа. Энэнээс айж ичиж, одоо янз бүр болно гэж ерөөсөө байхгүй. Хулгайч нартай бол хатуу тэмцэнэ. Эрх мэдэлд одоо улс төрд эрх мэдэлтэй улсууд л хийж байгаа шүү дээ. Түүнээс тэнд байж байгаа нэг муу тээврийн жолооч, нэг ачиж байгаа нүүрс ачиж байгаа хүн, жижиг үйлчилгээ үзүүлж байгаа хүмүүсийг тэнд бол ямар хулгай байхгүй шүү дээ. Тэрийг очиж байцаагаад шалгаад байх шаардлага ч байхгүй шүү дээ. Тэгээд эрх мэдэлтэй улсуудаа шалгах хэрэгтэй шүү дээ.

Энэ оффтейк гэрээнүүдийг цуцлах хэрэгтэй. Монголд одоо Монгол Улсад ашиггүй юм хийчихсэн байна шүү дээ. Богд хааны төмөр зам гэдэг чинь одоо магадгүй эрх ашигийн эрэмбээрээ тооцох юм бол бараг 10 дахь ч асуудал байж магадгүй. Хүн амын 42.5 хувь нь ядуурчихсан байна шүү дээ. Ажил алга байна. Ажлын байр алга байна. Тэгтэл тэнд хаа холуур нэг төмөр зам барина гээд л. Эцэст нь бол буруутай хүн нь олддоггүй. Энэ тодорхой хувийг одоо эзэмшүүлэх, энэ янз бүрийн улсуудаас л буруу зөрүү гээд байх шиг байна. Бид ерөөсөө буцахгүй. Энэ тодорхой

хувийг нь эзэмшүүлэх ёстой нэгдүгээрт. Энэ дээр одоо ямар хариулт өгөх вэ? 40 хувийг эзэмшүүл гээд л бид нар хуулийн төсөл өргөн барьчихсан байгаа.

Хоёрдугаарт нь тэр 20 оноос хойших 3 жилийн ноогдол ашгаа Монголын ард түмэнд өгөх ёстой. Энэ попорч байгаа юм биш. Баялгийн эзэд өнөөдөр авах ёстой юмаа авахгүй шүү дээ. Энэ Хөгжлийн банкиг тойрсон нэг дөчөөд чанаргүй зээлийн асуудлыг л одоо үндсэндээ нэг 8 сар хиртээ шалгаж байна л даа. Яг энэ хулгайг, яг энэ эрчээр шалгах юм бол 3-4 жил шалгана. Ийм учраас энэ хууль хяналтын байгууллагууд маш сайн эдийн засагч нар, маш сайн санхүүгийн ажилтнууд, энэ уул уурхайн одоо энэ мэргэжлийн улсуудын туслалцааг Монголын төрөөс үзүүлж, энийг богино хугацаанд шалгаж дуусгах ёстой. Энэ чиглэлээр юу.../минут дуусав/

Г.Занданиатар: Чинзориг.

С.Чинзориг: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Ер нь бол энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудлыг богино хугацаанд шалгаж хариуцлага тооцох ёстой гэдэгтэй бол санал бол нэг байна. Яг одоо энэ хууль хяналтын байгууллагуудтай холбоотой шалгах ёстой, богино хугацаанд дуусгах ёстой гэдэгтэй бол би бол энд ямар хариулт өгөх ямар ч одоо боломжгүй. Ямар ч байсан ерөнхий хяналтын сонсгол дээр Ерөнхий прокурор өөрийн биеэр одоо оролцож бас мэдээлэл бол өгсөн. АТГ-ын дарга бас өөрийн биеэр одоо оролцож оролцогчдын асуултад хариулт бол өгсөн. ЦЕГ-ын одоо бас удирдлагууд оролцож бас хариулт бол өгсөн. Тэгэхээр бол иргэд бол оролцогчид бас энэ талаар тодорхой мэдээлэлтэй болсон болов уу гэж бол бодож байна.

Хоёр дахь асуудал нь тэр ногдол ашиг өгөхтэй холбоотой асуудлууд бол орж ирж байгаа Баттөмөр гишүүнээ. 21, 22 онуудад ногдол ашиг өгөөгүй энэ ашгийг ногдол ашгийг иргэдэд нөхөн одоо олгох чиглэлээр заалт тодорхой чиглэл Засгийн газар руу өгөгдөж байгаа. Хоёр дахь

асуудал 2012 оны 4 дүгээр сарын 1-нээс хойш төрсөн Монгол Улсын иргэдэд энэ Эрдэнэс таван толгойн 1072 хувьцаатай хувьцаа эзэмшүүлэх асуудлыг нэгдүгээр энэ оны нэгдүгээр улиралд багтаан Их Хуралд одоо бас судалж танилцуул гэдэг ийм чиглэл бол өгч байгаа юм. Тийм учраас бол ногдол ашигтай холбоотой асуудал ингээд жаахан цэгцрэх болов уу гэж би бодож байна.

Эдийн засгийн байнгын хороон дээр бид бол нэлээн юм ярьсан. Энэ иргэдийн 1072 хувьцааны ногдол ашиг өгөхгүйгээр энэ боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ гээд 2 одоо төмөр зам бол барьчихсан байгаа. Эсвэл одоо энэ иргэдэд энэ 1072 хувьцааг нь бол олго. Эсвэл одоо тэр иргэдийн 1072 хувьцааны ногдол ашгаар барьсан энэ гашиун, Таван толгой-Гашиун сухайт, Таван толгой-Зүүн баян гэсэн энэ төмөр замуудад энэ иргэдийн ногдол ашгийн ашгаар одоо барьсан учраас энэ компани төмөр замуудын хувьцааг эзэмшүүлэх нь ч зүйтэй гэдэг асуудал бол нэлээн Байнгын хороон дээр нэлээн яригдсан. Тэгэхээр тодорхой бас ийм чиглэлүүд бол өгөгдөж байгаа.

Их Хурлын гишүүд бас тодорхой хэмжээгээр Их Хурлын тогтоолын төсөл өргөн барьсан юм байна лээ. Энэ асуудлыг Их Хуралд бол өргөн барьсан Их Хурал хэлэлцэж бол эхлээгүй байна. Хэрэв энэ Их Хурлын гишүүдийн энэ ногдол ашгийг Эрдэнэс таван толгойн эзэмшиж буй ногдол ашгийн хувьцааны хэмжээг одоо нэмэгдүүлэхтэй холбоотой асуудлыг Их Хурал хэлэлцэх эсэхийг нь одоо шийдчих юм бол энэ тогтоолтой бас эцсийн хэлэлцүүлгийг Байнгын хороон дээр хийхдээ хамтатгаад хэлэлцээд одоо явах тийм боломж нь бол бүрдэх тийм бас боломж бас бүрдэх болов уу гэж бол бодож байгаа. Ийм одоо хариултыг Баттөмөр гишүүний асуултад хариу хариулт хэлье.

Г.Занданиатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Тогтоолын төсөлтэй бол Эдийн засгийн байнгын хорооны гишүүний хувьд бол зөвшөөрч байгаа. Бид ч бас нэлээн хэдэн талаас нь ингээд харж байгаад явсан, гаргасан. Энэ ерөнхий сонсголын хяналтын сонсгол дээр энэ хажууд байгаа Раднаасэд гишүүн, Доржханд, Тогтохсүрэн гишүүн, Амарсайхан гээд бид хэд бас нэлээн байж байгаад дуусан дуустал нь сууж бас иргэдийнхээ үгийг нэг сонсьё гээд сууцгаасан л даа. Тэгээд эцэст нь одоо хулгайчаараа дуудагдаад л тэгээд л дууссан.

Ер нь бол одоо энэ сонсгол дээр энэ гадаа жагсаж байгаа иргэд маань бол бөөнөөрөө шахуу орж ирсэн шүү дээ. Мааш бухимдалтай байгаа. Өнөөдөр гээд тэгэхэд энэ амьдралын түвшин бол энэ ядуурал нь бол одоо туйлдаа хүрч байна шүү дээ. 30 хувьтай ядуурлын түвшин 30 хувьтай байсан сүүлд 5 функтээр нэмэгдлээ гэсэн. Энэ 35 хувь болчихоод явж байх шиг байна. Сая эндээс 40 хувьтай л гэж ярьж байна. Энэ чинь үнэхээр одоо бас бүр туйлдаа хүрч байна шүү дээ. Тэгэхээр би юу хэлэх гээд байна вэ гэхээр энэ тогтоолын төсөл дээр өөр нэмэгдээд ч байдаг юм уу, энэ Улсын Их Хурал ер нь энэ асуудлуудаа нэг ингэж эргэж харахгүй юм уу? Энэ сонсгол хийлээ гээд тэгдэг. Бид яах вэ хэлсэн асуудлуудыг нь ярьдаг, сонсдог. Тэгээд л ингээд тогтоолын төсөл болоод яах вэ анх удаа орж ирж байна л даа сайшаалтай.

Гэхдээ энийгээ цаашаагаа нэг үзэж хармаар байна шүү дээ. Миний тавих гээд байгаа асуудал бол ерөөсөө энэ орж ирж байгаа, гадаа жагсаж байгаа хүмүүс сая энэ сонсгол дээр орж ирж байгаа хүмүүсийг нэг болгоод түр хороо гэдэг юм уу юу байдаг юм ямар нэгэн байдлаар энэ хүмүүстэй ширээний ард ер нь суувал яасан юм бэ? Болохгүй байгаа зүйлүүдээ яривал яасан юм. Магадгүй зарим нэгэн одоо бүрэн эрх байдаг юм уу, дархан эрх энээ тэрээ юмнуудаасаа хэдүүлээ татгалзъя л даа. Дээрээс нь өөр ямар нэгэн хууль дүрэм юу байдаг юм, Үндсэн хуулиасаа авхуулаад, Сонгуулийн тухай хуулиуд байж байна, Улс

төрийн намуудын тухай хуулиуд байж байна. Сонгууль бүрэн эрхийг нь одоо баталгаажуулаад орох боломж бололцоо байж байна. Энэ бүх зүйлүүдээ магадгүй бид нар өөрсдөө харж чадахгүй байгаа зүйлүүд байвал харсан ч гэсэн одоо хүсэхгүй байгаа зүйлүүд байгаа бол энийгээ өөд өөдөөсөө харж байгаад засъя л даа.

Нэг хэсэг нь болохоор Ордон дотор суугаад, нөгөө хэсэг нь болохоор хүйтэн цемент дээр сууж байгаад л ингээд нэг нь нэг бичиг өгдөг, нөгөөдөх нь нэг бичгийг нь аваад ингээд тогтоол болгоод ингээд явдаг. Энэ чинь одоо 30 жил л үргэлжиллээ шүү дээ. Энэ нийгмийн байдал энэ одоо амьдралын түвшин энэ бүх зүйлүүд чинь болохгүй болоод л энэ жагсагчид чинь тэр сонсгол дээр бол хэлж байгаа зүйлийг чинь ярьж байна шүү дээ. Одоо энэ Раднаасэдийн хэлж байгаагаар бол энэ чинь азийн бүр хамгийн одоо тэг авлигадаа автагдсан ийм улс орон болж хувирлаа шүү дээ. Төмөр замтай холбоотой асуудлууд ч гарч ирж байна. Бүр арай дэндэж байгаа байхгүй юу даа.

Тэгэхээр би юу санал болгоод байна гэхээр ерөөсөө 2 талаасаа л гарч ирье. Энэ дотор тэр амьдралын түвшин бүх зүйлүүдээ ярья. Болохгүй байгаа зүйлүүдээ ярья. Одоо энэ гишүүдийн тавьж байгаа зүйлүүдийг нэг бүрчлэн, тэгээд хэдэн асуудал хэдэн одоо зүйл болох юм, тэр хуульд ямар өөрчлөлтүүд оруулах вэ, Үндсэн хуулиас авхуулаад бүх хуулиуддаа ямар өөрчлөлт орох гарах юм. Энэ хяналтын сонсгол дээр хамгийн гол тавьж байсан юм ер нь бол энэ парламентаа тараа гэсэн зүйл тавигдсан шүү дээ. Одоо өнөөдөр энийгээ хэдүүлээ ярья л даа. Парламентынхаа энэ зүйлийг одоо энэ функцийг бид бол аваад үлдэх ёстой. Энд бол хүрч болохгүй. Гэхдээ нэгэнт парламент дээр одоо хууль батлах ийм эрх одоо үндэс нь байж байгаа бол одоо өнөөдөр бүх хуулиудаа бид нар гаргаж ирж байгаад үндсээр нь хараад, юу болохгүй байна, иргэд дээр ямар зүйл бухимдалтай байгаад байна гэдгийг нь үндсээр нь авч

үзвэл яасан юм бэ гэсэн нэг ийм саналыг тавих гээд байгаа юм.

Сонсгол гэхээсээ илүү энэ дотор бид нар тойроод магадгүй Улсын Их Хурал энийгээ нэг авч хэлэлцэх хэрэгтэй байна шүү дээ. Ярих хэрэгтэй байна. Хамгийн гол нь тэр төлөөлөлтэй нүүр тулж байгаад уулзах хэрэгтэй байна шүү дээ. Асуудлаа шийдэх хэрэгтэй. Гучаад жилийн хугацаанд хуримтлагдсан маш олон асуудлууд байгаад байна шүү дээ. Нүүр тулж тодорхой асуудлуудаа ярихгүйгээр нэг тал нь нэг нь одоо дулаан байранд байж байгаад нөгөөдөх нь одоо хүйтэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, одоо санал хураалт явуулах учраас 2 зарчмын, 1 зарчмын зөрүүтэй санал байгаа. Санал хураалтад бэлтгэж гишүүд чуулганы танхимд цугларна уу. Асуулт хариултын цаг дуусаж байна. Асуултад Содномын Чинзориг гишүүн хариулна.

С.Чинзориг: Сонсгол явуулах цаг үе нь талбай дээр иргэдийн жагсаал цуглаантай байгаа үетэй давхцсан учраас бол тэр журмынхаа дагуу хуулийнхаа дагуу 14 хоногийн хугацаатай сонсголд нээлттэй хяналтын сонсгол оролцох иргэд бол хүсэлтээ илэрхийлдэг. Энэнийхээ хуулийнхаа дагуу тэр жагсаалд оролцож байсан иргэд бас нэрээ өгөөд, жагсаалд оролцогчид бол энэ сонсголд нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй бол орж ирсэн. Нөгөө талаас АН-ын төлөөлөл бас нэлээн зохион байгуулалттай орсон юм уу гэж бол бодсон. Гэхдээ бас энийг бас буруутгах арга байх. Хуулийнхаа хүрээнд л одоо 14 хоногийн хугацаатай бүртгэл явагдаад л саналаа нэрээ өгсөн иргэд бол оролцоод саналаа өгсөн.

Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа би бол санал бол нэг байна. Тэр иргэдийн саналыг иргэдтэйгээ нүүр тулж яриад л юм ярья гээд байгаа юм. Гэхдээ энэ ерөнхий хяналтынхаа сонсголд чинь Улсын Их Хурлын 6-хан гишүүн л одоо үг хэлсэн.

Бусад нь дандаа тэр сонсголд оролцож байгаа иргэд ная гаруй иргэд асуулт асууж, саналаа бол хэлсэн. Өнөөдөр энэ ерөнхий хяналтын сонсгол явуулсантай холбогдуулаад авах гэж байгаа мөрөөр нь одоо авах энэ Их Хурлын тогтоолын шийдвэрийн төсөл бол тэр сонсголд оролцсон иргэдийн санал бодлыг л одоо бас тусгал гэж бол хэлж бол болно. Тийм учраас бол тэр жагсаал цуглаанд оролцсон болон мөн одоо энэ сонсголд оролцсон иргэдийн төлөөлөл санал энэ Их Хурлын тогтоолын төсөл хэлбэрээр орж ирж байгаа гэж бол, гэж бол хэлж болно.

Ер нь цаашидаа бид нар энэ ерөнхий хяналтын сонсгол явуулдаг энэ хууль, эрх зүйн орчноо бас боловсронгуй болгох нь зүйтэй юм байна гэсэн ийм бодолтой бол байгаа. Ийм одоо чиглэлээр ч гэсэн энэ Их Хурлын тогтоолын төсөлд бол бас заалт бол орж ирж байгаа юм. Одоогийн мөрдөж байгаа хуулийн чинь дагуу ерөнхий хяналтын сонсгол явуулахаар холбогдох Байнгын хороо нь зохион байгуулдаг. Холбогдох Байнгын хорооны гишүүдийн 1/3-ээс доошгүй нь одоо хүрэлцэн ирсэн бол сонсгол хүчинтэйд тооцдог. Одоогийнхоо хуулийн зохицуулалтаар бол Байнгын хорооны гишүүд асуулт асууж үг хэлдэг. Оролцож байгаа иргэдийн төлөөлөл бол асуулт асуух эрхгүй, санал одоо хэлэх ийм л одоо эрхтэй хууль, эрх зүйн зохицуулалт бол байгаа юм байна лээ.

Гэхдээ энэ ерөнхий хяналтын сонсголыг явуулахдаа иргэдийн санал гаргасны дагуу иргэдийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллагуудын төлөөллийг ч гэсэн оролцогчдоос холбогдох мэдээлэл хийсэн албан тушаалтнуудаас санал асуух, үг, асуулт асуух эрхийг нь одоо бас бас одоо хангаж өгсөн гэдгийг бас та бүхэнд бол хэлье. Тийм учраас ер нь цаашидаа бид нар энэ ерөнхий хяналтын сонсгол явуулах энэ хууль, эрх зүйн орчноо боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай юм байна лээ гэж.

Хоёр дахь асуудал нь Бат-Эрдэнэ гишүүний яриад байгаа тэр ер нь нийгэмд

одоо болохгүй байгаа асуудлаа ярья гэдэгтэй бол санал бол нэг байгаа. Их Хурал ч гэсэн энэний дагуу бас тодорхой шийдвэр гаргаад, зөвлөлдөх санал асуулга явуулах иргэдтэйгээ иргэдийнхээ оролцоотойгоор нийгэм, эдийн засгийнхаа тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлж, гарц шийдлийг нь иргэдийнхээ оролцоотойгоор тодорхойлж гэсэн ийм одоо шийдвэр гаргаад, эхнээс нь эхнээсээ энэ зөвлөлдөх хэлэлцүүлгүүд бол эхлээд яваад бол эхэлж байгаа гэж бол бодож байгаа юм. Тийм учраас бол энэ дээрээ бид нар энэ тулгамдаж байгаа нийгэм, эдийн засгийн аливаа асуудлыг иргэдийнхээ оролцоотойгоор тодорхойлж, гарц шийдлээ иргэдийнхээ оролцоотойгоор тодорхойлох ийм бас процесс бол явагдаж байгаа. Энэ дээр нэлээн бас тодорхой асуудлууд яригдаж, тодорхой шийдвэрийн төслүүд бас Их Хурал дээр яригдах байх гэж бол бодож байна.

Г.Занданиатар: Авах ёстой гэж та сүүлд нэмэгдээд та хоёр авахгүй гээд л. Одоо санал хураалт явуулна. Аюурсайхан гишүүн. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Санал хураалт явуулна.

Т.Аюурсайхан: Баярлалаа. Энэ тогтоолын төслийг бол дэмжиж байна. Ажлын хэсэг бол бас боломж боломжоороо л ажиллаж байгаа гэж үзэж байгаа. Энэ түр хороо байгуулагдаад бас боломжоороо ажиллаж байх шиг байна. Улсын Их Хурал дээр одоо хэдий хамааралтай ажил хийх нөхцөл боломж нь хэр байдаг юм тэр хэмжээндээ л ажиллаж байгаа гэж ойлгож байна. Хууль хяналтын байгууллага бол маш их өргөн хүрээнд ажиллаж байна гэдгийг бас хэвлэл мэдээллээр харж байна. Маш олон нууц асуудлууд ил болж байна. Маш олон гэрээ хэлэлцээр ил болж байна. Энэ бүгдийг нь одоо тойрсон шалгасан, өргөн хүрээний хяналт шалгалтын ажил явж байна. Энэ бол зөвхөн Таван толгойтой холбоотой биш. Энэ бол Монгол Улсын хэмжээнд одоо энэ уул уурхайг дагасан бохир улс төр,

бизнесийн энэ одоо том бугшсан асуудлууд бол ил болж байна.

Бид нар олон жил энэ байгалийн баялгийг ард түмэндээ өгөх ёстой гэдэг дээр ярьж байгаа шүү дээ. Тэмцэж байгаа, Үндсэн хуульд тодорхой өөрчлөлтүүдийг оруулсан. Тэгээд энэний хажуугаар маш их улс төр явж байна. Маш их бохир улс төр хийж байна. Янз бүрээр бие биеийгээ ярьж байна, цоллож байна. Хэрэв энэ дээрээ бид нар анхаарахгүй ингэх юм бол жинхэнэ одоо асуудлууд нь энэний цаагуур саармагжина шүү. Хүмүүс нь зугтааж байна, ул мөрөө баллаж байна. Хэн нэгэн хамааралгүй хүмүүст нэр хоч өгч байна. Энэнийхээ төлөө маш их мөнгө төгрөг цацаж, төөрөгдүүлсэн энэ асуудлуудыг гаргаж байна. Ингээд явах юм бол энэ асуудал чинь үр дүнд хүрэхгүй шүү дээ. Тийм учраас энэ дээр яах вэ Раднаасэд гишүүн бол тэр захирлаар ажиллаж байсан хүнийг нь би танихгүй, энэ бол Аюурсайхан гишүүнтэй холбоотой хүн шүү дээ л гэж хэлсэн. Найз нөхдийн харилцаатай. Үгүй ээ, тэр бол үнэн л дээ. Тэрийг нь найз нөхдийн харилцаатай байлаа гээд заавал ч үгүй тийшээгээ эрх ашгаа чихсэн байх албагүй шүү дээ. Энийг чихсэн тэр хүмүүс нь тэгж өөрсөд шигээ бодоод байдаг юм уу. Энэ асуудал дээр бол тэгж одоо хулгай зэлгийгээр нь бас хэлсэн асуудал бол байхгүй шүү Доржханд гишүүнээ.

Хэрэв тийм юм байдаг бол Раднаасэд гишүүн хариуцлагатайгаар хандаад, нотлох баримт юмнуудаа хэлэх байлгүй дээ. Тэгээд энэ Эрдэнэс таван толгой дээр миний ямар ч хуулиар хүлээсэн удирдах тийм чиг үүрэг бол байгаагүй шүү. Хувийн харилцаагаараа би ерөөсөө ороогүй. Тэр нүүрс тээврийг хариуцдаг, баздаг байсан гээд. Нэг машин нэг жолооч хэлж байна уу? Үгүй ээ, тийм нууц байна гэж хаана байх юм. 140 машин, 540 машин явуулдаг бол тэр чинь том компани биз дээ. Тэр 573 компани тендер авсан гээд ганц нөлөөлсөн юм байна уу? Хамаарал бүхий хэн нэгнээр. 633 гэрээ байгуулсан компани дээр ганц юм байна уу? Оффтейк

гэрээтэй холбогдуулаад туслан гүйцэтгэгч маш олон компаниуд гарч ирж байна шүү дээ. Үгүй ээ, энэ дээр нэг юм байна уу? Өнгөрсөн хугацаанд би одоо янз бүрийн одоо энэ эрх ашгаа янз бүрийн юм руу огт хийж байгаагүй. Энэ асуудлаас маш их болгоомжтой байсан. Одоо би найз нөхдийн тоо хүртэл маш бага болсон. Янз бүрийн юм ярих гэдэг, санал болгодог хүмүүсээс зайгаа авсаар байгаад ер нь бол ийм л болж байгаа шүү дээ. Ийм ч байх ёстой гэж бодож байна.

Тэгээд энэ асуудал дээр бол нэг мөр, олон нийтийн эргэлзээг тайлах ёстой. Хөрөнгө, орлогоо би шалгуулна, шалгуулна. Бизнесийн салбараас би улс төрд орсон хүн шүү. Миний хөрөнгө оруулалт бүгд нотлогдох эх үүсвэртэйгээ жил болгон мэдүүлдэг шүү дээ. Олон юм яриад байгаа та бүхэн ч гэсэн адилхан бас хөрөнгө оруулгаа шалгуулчхаарай. Бүгдээрээ хамт ил тод байх ёстой гэдэг ийм зарчмаар. Тэгээд одоо энэ одоо зохион байгуулалттайгаар улс төрийн зорилгоор ингэдгээ одоо боль. Өс хонзон байдаг бол тэрийгээ ярь. Улс төр хийх юм бол зарчимтай хий. Арай хэтэрч байна шүү энэ одоо.

Г.Занданишатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ерөнхий хяналтын сонсголын тайлан хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

Чуулган 13 цаг болсон учраас түр завсарлана. 14 цагт дараагийн 4 дүгээр асуудлыг хэлэлцэж эхэлнэ.

13.04 цаг

2023 оны 01 дүгээр сарын 12, Пүрэв гараг,
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 09 минут.

**ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданишатар: 12-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Хэлэлцэх асуудалдаа орно.

Дөрөв.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, эцсийн хэлэлцүүлэг/

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн хэлэлцүүлгийг явуулна. Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, түр хорооны дарга Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан бөгөөд Эдийн засгийн байнгын хороо хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулган хурлын 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийг баримтлан тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулаа. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр төслийг гүйцээн

боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу ажлын хэсгээс тогтоолын төслийг дахин боловсруулж Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал, дүгнэлт санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн. Тогтоолын төслийн эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Баттулгын Дөлгөөн СЗХ-ны Үндсэн цаасны газрын дарга. УУХЯ-ны Төрийн захиргаа, удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Туулхангайн Ганбаатар, Эрдэнэс таван толгой ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, Эрдэнэс таван толгой ХК-ийн борлуулалт маркетинг, тээврийн газрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч Гомбосүрэнгийн Адъяа. Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Энэ тогтоол дээр нэлээн асуудлууд болж байгаад бас ялангуяа Эрдэнэс таван толгойтой холбогдолтой Эрдэнэс таван толгойг эргэлтэд оруулах, 1072 хувьцааг эргэлтэд оруулах гэсэн энэ заалтууд харин одоо хасагдлаа. Гэхдээ энэ дээр бас цаашидаа нэг анхаарах юм бол ингээд олон нийтэд нээлттэй компани болгоно гэсэн нэг ийм сайхан томъёолол хэлээд тэгээд Эрдэнэс таван толгойн тодорхой хэсгийг л

ингээд нэг хувьчлах ийм юм ер нь яваад байна. Сая энэний өмнө бас хэлэлцэгдсэн тогтоол дээр хүртэл оруулсан. Харин оруулчихсан байсныг нь Эдийн засгийн байнгын хорооны нь тэр Эрдэнэс таван толгой компанийг одоо олон нийтэд нээлттэй компани болгоно гэсэн заалтыг нь авч хаясан. Тэгээд цаашидаа ч одоо энэ Эрдэнэс таван толгой компанийг энэ нүүрсний энэ хулгай энэ ингээд далимдуулаад хувьчлах ийм сонирхол их явж байна.

Тэгэхээр би гол нь үг хэлээд байгаа нь стратегийн ордоо улс орноо тэжээж байгаа ордоо хувьчилж болохгүй л гэж хэлэх гээд байгаа юм. Энэ дээр бүүр нэг одоо хэдүүлээ тохирч авмаар байна. Энэ Эрдэнэтийг, энэ таван толгойг хувьчилж болохгүй. Харин одоо менежментийг нь сайжруулахгүй, өөрсдөө Монголчууд чадахгүй байгаа юм бол тэгээд гаднын менежментийн баг оруулж ирээд л ажиллуулъя л даа. Тэр олон улсын зах зээлийн түвшинд нь нүүрсээ зардаг, борлуулдаг ийм болох, ийм юмыг хийж байхгүй бол албаар муу ажиллуулаад, муу хүн томилоод хулгай зэлгий авлигал тэнд нүүрлүүлчхээд тэгээд дараа нь хувьчилж авах ийм сонирхол бас далд явдаг байж магадгүй гэж би бодож байна. Тэгээд яах вэ энэ 2 тогтоолоор бол тэрийг шургуулах гэж их оролдлоо. Энэ хувьчлалын асуудлыг. Сайхан нэр л дээ, олон нийтийн ил тод компани болгон гэж, нээлттэй компани болгоно гэж байгаа юм.

Тэгэхээр одоо ингэмээр байна. Ер нь энэ иргэдийн одоо тэр 1072 хувьцааны асуудлыг нэг мөр сайн шийдэж өгмөөр байна. Тэр 300-гаа авсан улсуудыг тэр 1072-оо авсан улсуудыг. Мөн энэ 1072 хувьцааны ногдол ашигаар байгуулагдсан тэр бүтээн байгуулалтын хувьцааны асуудлуудыг нь шийдэж өгөх хэрэгтэй. Тэр төмөр замд оруулсан хөрөнгийнхөө хувьцааг одоо бас энэ иргэд 1072 хувьцаандаа шингээж эзэмших энэ асуудлыг нь шийдэж өгөх ёстой. Ногдол ашигийг нь одоо байнга өгдөг байлгах энэ чиглэл рүү нь. Ногдол ашиг нь замаас нь

ингээд одоо булааж аваад ийшээ тийшээ оруулаад байдаг ийм байдлыг бас цаашидаа таслан зогсоох ёстой байх. Тэгээд нэг буруу ойлголт өгөөд байна. Бэлэн мөнгөөр одоо ноогдол ашгийг нь тараах гэж байна улс төрийн зорилгоор гэж үгүй. Энэ чинь одоо биржээр дамжуулаад л тэр тооцооны төвүүдийн нь дансаар нь л мөнгийг нь өгчихнө шүү дээ.

Энд нэг сонин заалт яваад байгааг л харин би жоохон гайхаад байгаа юм. Хөрөнгийн биржид бүртгэх гээд байгаа юм. Энэ чинь одоо бүртгэлтэй л компани шүү дээ. Тооцооны төвүүдээр дамжуулаад л бид нар тэр 1072-ыг ахмадууддаа мөнгөжүүлээд л өгсөн. Тэгээд яах гэж дахин, дахин ингэж ингээд оруулаад байгаа юм бэ гэдэг дээр би бас эргэлзээд, ер нь протоколд тэмдэглүүлье. Энэ Эрдэнэс таван толгойг нэг л хувьчилчих тодорхой эсэхийг нь авчих тийм сонирхол бол ил далд яваад байна, яваад байна. Энэ дээр л хэдүүлээ одоо нэг нэгдсэн бүр ойлголттой болоод, сая Эдийн засгийн байнгын хорооны гишүүд харин тэр одоо олон нийтэд нээлттэй компани болгоно гэснийг нь би авч хаясанд талархаж байна. Ингэж улс орноо тэжээж байгаа стратегийн ордуудаа бид нар одоо хамгаалж үлдэхгүй бол болохгүй. Ер нь бага буурай орнууд тийм Норвег ч тийм, Чили тийм, Финланд ч ийм стратегийн гол ордууд нь заавал төрдөө байдаг. Харин менежментийг нь тэд сайжруулж болоод байна шүү дээ. Бид яагаад болохгүй байгаа юм бэ? Үгүй ээ, тэдний туршилагаас судлаад, сураад тэгээд энэ менежментийг нь сайжруулах чиглэл рүү харин үүрэг даалгавар өгөх ёстой гэсэн тэр заалт бол ороогүй юм байна лээ. Тийм учраас цаашидаа бид нар бол харин одоо энэ менежментийн багийг яаж бүрдүүлэх вэ, менежментийг нь яаж сайжруулах вэ гэдэг юман дээр анхаарах ийм шаардлага байна гэдгийг би одоо эцэст нь хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүн хариулах уу та? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ажлын хэсгийн ахлагч хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль гээд анх одоо ажлын хэсэг гараад энийг боловсруулаад батлуулсан. Бүгдээрээ л сайхан дэмжээд баталсан. Яг өнөөдрийн нөхцөл байдалд одоо шулуухан хэлэхэд энэ ААН-ийн энэ уурхайн энэ одоо төрийн байгууллагын одоо дарга цэрэг нар цаашаа харж байгаад ингээд нууц гэрээ ч юм уу ингээд хийгээд явчихдаг энэ нөхцөл байдлаас бид нар гаргаж байгаа юм шүү дээ. Энийг бол та ч, Даваасүрэн гишүүн ч мэдэж байгаа. Бүгд мэдэж байгаа, сайхан дэмжиж байгаа. Тэгээд нэг зүйл дээр та нэг хардлага л яваад байх юм. Энэ нэг одоо Эрдэнэс таван толгой компанийн нэг 30 хувь ч байдаг юм уу, 34 ч байдаг юм уу, ингээд авчихна гээд ингээд л. Энэ ажлын хэсэг миний бие, Доржханд, Булгантуяа, Тэмүүлэн, Баттөмөр гэсэн энэ гишүүд байгаа, 5 гишүүн.

Үндсэндээ бол одоо бид тавыг л энэ нэг ийм лоббинд орчихно л гэж л хардаад байгаа юм. Би одоо шулуухан, одоо бүр эцэстээ тэсэж чадалгүй одоо ийм зүйл хэлэхээс өөр аргагүй болж байна Даваасүрэн гишүүнээ. Нөгөөтээгүүр болохоор хэрэв хардах дээрээ тулбал менежментийн баг гээд ямар менежментийн баг оруулж ирэх гэж байгаа юм гэсэн ийм хардлага чинь дахиад л ороод ирнэ. Урьд нь Таван толгой компани дээр яасан юм тэр нөгөө хөрс хуулалтын компани, менежментийн компани гэсэн бас тийшээгээ юм оруулаад л, бас л ондоо компани оруулаад л элдэв янзын компани оруулаад л, үнэтэй үнэгүй янз янзын гэрээ хийгээд бас л явсан шүү дээ. Хэрэв өнөөдрийн энд орж ирж байгаагаар Хөрөнгийн биржид бүртгэлтэй компани болгох юм бол энэ өөрөө хяналтад орчихно. Энэ өөрөө ил тод болчихно. Бүртгэлтэй биш юм. Энэ нөгөө үнэт цаасны хадгаламжийн газар гэж байгаа тийм ээ, Үнэт цаасны хадгаламж төвлөрсөн хадгаламж гэж байгаа. Тэр хадгаламжид чинь бүртгэлтэй болохоос биш яг үнэт цаасныхаа бол зах зээл дээр бол гарч ирээгүй байхгүй юу.

Тэгэхээр энэ рүү хэрэв бид нар гаргачих юм бол одоо эртээд Булгантуяа гишүүн ч хэлж байсан даа. Ер нь бол үнэт цаастай холбоотой энэ асуудал бол нээлттэйгээр ингээд явагдчихдаг, хуулийнхаа дагуу явагдаж байдаг. Тэгэхээр наанадаж бид нарын нөгөө 1072 хувьцаагаа ингээд гүйлгээнд оруулъя гэж байгаа. Нөгөө 12 оноос хойш төрсөн сая орчим хүүхдүүд маань энд одоо дахиад нэмэлтээр төрийн өмчийн өмчийн хувьцаанаасаа эзэмшлийн хувьцаанаасаа одоо нэг мянгаад сая орчим хүүхэд бол одоо хувьцаа эзэмшихсэн. Тэгээд энэ чинь нэг одоо өнөөдөр 1072 чинь нэг 18 хувь байгаа бол нэг 20 гаруй хувьтай болчих юм уу хэд болчих юм, нэг тооцооллоор гарч ирэх байх. Ингээд л болчихно. Тэгэхээр энэний одоо хяналтууд нь хүссэн хүсээгүй гарч ирнэ. Тэгээд нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ тогтоолын төсөл дээр шинэчилсэн бүртгэлтэй энэ иргэн бүрд эзэмшүүлэх асуудал, тэгээд газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ард түмэн тэгш шударга, бүтээмжтэй болгох сайн засаглал ил тод байдлыг гээд байгаа шүү дээ. Сайн засаглал ил тод байдал гэдэг дотор бол нөгөө менежментийн асуудал чинь бол орчхож байгаа байх гэж ойлгож байгаа юм. Тэгэхээр энийгээ 2023 оны нэгдүгээр улиралд багтаан танилцуулах гэж орж ирж байгаа юм. Их Хуралдаа танилцуулчихъя гээд. Тэгэхээр бид буцаад дахиад энэ дээр нь ярих ийм боломж гаргаж байна. Түүнээс биш одоо Засгийн газарт үүрэг даалгавар өгөөд тэгээд нэг цаашаагаа яг яаж хийх нь мэдэгдэхгүй, хэдүүлээ бас нэг хардлагатай ингээд үлдчихгүйгээр буцаж эргэж танилцуулаач гэсэн үг, үсгийг бүр албаар энд нь бол оруулсан юм байгаа шүү.

Тийм болохоор одоо хэдүүлээ одоо энэ протоколд таны ч протокол байж байна. Бүх л протоколынхоо дагуу бол энэ менежментийн гэдэг үг чинь бол бас бичигдээд ингээд явчихна. Мэдээж Засгийн газар бол энэ дээр бас тодорхой хэмжээний арга хэмжээ аваад, тэгээд

буцаж эргэж бидэнд танилцуулах байх гэж энэ тогтоолын төсөл орж ирж байгаа шүү. Баярлалаа.

Г.Занданишатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн тодруулъя. 1 минут.

Ц.Даваасүрэн: 1072 хувьцааг одоо ингээд арилжаанд эргэлтэд оруулчихъя гэдэг чинь өөрсдөө одоо нөгөө орлого багатай иргэд чинь зарчихна л гэсэн үг шүү дээ. Орлого багатай иргэд тэрийг чинь худалдаж авч хувьцаа эзэмшигч болж чадахгүй байхгүй юу. Харин тэгээд л тэр чинь тэрийг чинь ингээд хасуулаад байгаа юм. Ер нь бол эргэлтэд оруулна гэх л юм бол 1072 чинь нэг хэсэг хүн дээр л төвлөрөөд л явчихна. Би нэг л юмыг хэлээд байна шүү дээ. Стратегийн орд шүү дээ энэ чинь, улс орноо тэжээж яваа эд байхгүй юу. Эрдэнэт энэ хоёрын хувьд бол. Тийм учраас эд нар бол одоо төрийн мэдэлдээ зайлшгүй байх ёстой. Тэр 49 хувь дотроо цаашидаа яана уу ийнэ үү гэдгийг бол маш сайн бодож байж тогтоолоор хийхэд биш байхгүй юу энэ бол. Зүгээр нэг одоо хуулийг дагалдан гарч байгаа тогтоолоор дамжуулаад Таван толгойн хувьцааг бол шийдэх ёстой эд бол биш. Сая хоёр тогтоолд орж ирсэн шүү дээ. Энэ дээр орж ирсэн. Мөн тэр нүүрс тээвэрлэлт дээр бас дахиад ороод ирж байгаа байхгүй юу. Бас л ил тод болгоно Таван толгойг гээд л ингээд л.

Г.Занданишатар: Тэгэхээр Даваасүрэн гишүүнээ энэ манай гишүүд ч гэсэн ер нь нийт нэг юмаа их ойлгомоор байгаа юм. Энэ Засгийн газар Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг өргөн барих ёстой. Энэ хууль Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр төрийн нийтийн өмч гэж заагаад, төрийн нийтийн өмчийг зөвхөн Улсын Их Хурал мэдэж, захиран зарцуулна. Төрийн өөрийн өмчийг бол Засгийн газар захиран зарцуулж болно. Хуучин одоо байгаа хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн ба орон өмчийн тухай хууль яг тэгж зааж байгаа. Тэгтэл сая Төрийн ба орон нутгийн өмчийн хууль оруулж ирэхдээ төрийн нийтийн өмчийг

заавал Улсын Их Хурал хэлэлцэж шийдвэрлэдэг юмыг тодорхойгүй болгоод оруулаад ирсэн байна лээ. Энэ төслөөр байж байгаа. Хуучин төрийн, нийтийн өмч гэдэг бол заавал Улсын Их Хурлаар захиран зарцуулах, хувьчлах, тэр битгий хэл ашиглах асуудал Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ гэсэн хуультай. Энүүгээрээ Эрдэнэт буруудаж байгаа шүү дээ тийм.

Тэгээд Төрийн бас орон нутгийн өмчийн хууль орж ирэхээд одоо тэрнийг ажлыг хэсэгт энийг анхааруулаад бид нар чинь бөөн хэлэлцүүлэг болсон. Тэгээд энэ Даваасүрэн гишүүнээ одоо Засгийн газар та хэд ажиллаж байгаа юм чинь энэ та хэд бидний саналаар энэ байгалийн баялгийг ирээдүй ба одоо ба ирээдүйн иргэн бүрд эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш шударга, хүртээмжтэй байлгахад чиглэгдэнэ гэж ороод, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ноогдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж. Энэ ингээд 3 жил энэ Баялгийн сангийн хууль, энэ Ашигт малтмалын хууль ингээд орж ирэхгүй. Тэгээд энэнээс чинь болоод нөгөө ард түмний хяналтад байх ёстой байсан Таван толгой энэ тэр дээр чинь энэ асуудал гарч байна.

Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийнхөө энэ үзэл санааг ерөөсөө ингээд амьдралд хэрэгжүүлэх ажил 3 жил тасалдаж байна гэсэн үг. Энийгээ одоо Үндэсний баялгийн сангийн хуулийг бас өргөн барьж яаралтай хэлэлцүүлмээр байгаа. Ингэвэл энэ бас их нөгөө ард түмэнд хүртээмжтэй мэдэлд байх зарчим хангагдана гэдгийг бас онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Одоо энийгээ л ер нь баримтлаад явчихвал зүйтэй байгаа юм. Тэгээд тэр битгий хэл Ашигт малтмалын хуульд стратегийн ордуудын 10 хувийг ард түмэнд эзэмшүүлнэ гэж

хууль байгаа шүү дээ. Эрдэнэт. Тийм 10 хувь л гэж байгаа юм. Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Би бас энэ тогтоолын төслийн тэр 1072 хувьцааны үр өгөөж гэдэгтэй холбоотой заалттай л үг хэлэх гээд байна л даа. Тэр Байнгын хороо дээр хэлснээ бас тодотгож хэлэх. Тэгээд ерөнхийдөө зарчмын үед сая бас Их Хурлын дарга бас хэлчихлээ. Яг одоо сүүлийн үед болж байгаа нөхцөл байдлыг харахаар бараг аймаг бүхэн нэг уурхайтай. Нийслэл уурхайтай, сум бүхэн уурхайтай болж хувирах юм уу. Нөгөө нэг нэгдсэн байгалийн баялгийн нэгдсэн бодлого маань яг хаачих юм. Эрдэнэс таван толгой гэсэн чинь 10 хувийг нь ард иргэдэд өгнө, 40 хувийг өгнө. Одоо бас аягүй бол маргааш нэг нөхөр зуун хувийг өгнө гээд тогтоолын төсөл өргөн бариад, энэ чинь одоо зөвхөн энэ ганц нэг уурхайн асуудал биш энэ Баялгийн сангийн менежментийн асуудлаа томоороо тавьж Улсын Их Хурал дээр эхний байдлаар энийгээ том утгаараа ярихгүй бол одоо цаана нь Эрдэнэт. Эрдэнэтийг сонгуульд дөхөж байна. Одоо хэдэн хувийг нь ард иргэдэд өгнө гэх юм. Оюу толгой тэдэн хувь гээд.

Тэгэхээр энэ том асуудлаа нэгтгэж, энэ асуудлаа тавьж маш яаралтайгаар энэ Баялгийн сангийн тухай хууль зохицуулалт, менежментийн асуудлаа маш яаралтай эхэнд нь ярихгүй бол нэг ийм өм цөм энд тэндээс нь авч ингээд асуудал ярих цаг хугацааны дарааллын хувьд бол биш болчихож гээд. Тийм болохоор энэ тогтоолын төслийн тав дээр байгаа энэ заалт бол магадгүй одоо яг ач холбогдлын хувьд чухал юм шиг мөртөө энэ бол асуудлыг илүү бүдгэрүүлэх ийм тал руу орж байна. Тийм болохоор тэр Баялгийн сангийн хуулиа бас яаралтай оруулж ирээч. Энэ дээр энд ажлын хэсгийн даргад болоод бусад хүмүүст мэдээлэл байдаг уу. Засгийн газар дээр энэ боловсруулагдаж байна уу, ямар шатан дээр явж байгаа вэ, хэзээ орж ирэх ёстой вэ? Энэ асуудал маш яаралтай хэлэлцэгдэхийг л тал талаас нөхцөл байдал ингээд шаардаж байна. Одоо яваандаа

бараг сум бүхэн нэг өөрийн уурхайтай болох юм байна. Сумын ЗДТГ-ын уурхай гэж одоо гарах юм уу. Яг юу болох юм. Нөгөө нэг Үндсэн хуулийн заалт чинь хаачихсан билээ. Нийслэлийн уурхай гээд л одоо гараад ирчихсэн байгаа юм шиг байна. Тэгэхээр энэ менежмент, энэ бодлого бол үндсэндээ ингээд алдагдаж эхэлж байна. Тэгэхээр дарааллын хувьд тэр Баялгийн сангийнхаа хууль энэ хууль руу асар хурдан ач холбогдол өгч ажиллаач. Тэр нөхцөл байдал тэнд ямар шатанд явж байгаа юм бол гэдгийг л тодруулъя.

Г.Занданшатар: Хариулах уу? Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ажлын хэсэг хариулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Цогтгэрэл гишүүн тэгээд бид хэд бас яг энэ асуудлаар Байнгын хороон дээр нэлээн ярьсан. Бас санал бол нэгтэй байгаа. Зүгээр бид энэ Уул уурхайн биржийн тухай хуультайгаа уялдуулаад ер нь одоо 1072 хувьцаатай холбоотой асуудлуудаа ер нь шийдээд явчихъя. Яагаад гэхээр 1072 хувь хувьцааны асуудлыг аль 12 онд эхэлж гаргаж тавьчихаад, тэгээд тэрнээс хойш үндсэндээ бол энэ улс ажлаа хийгээгүй. Өөрөөр хэлбэл Засгийн газар энэ төр ажлаа хийгээгүй л хаячихсан байхгүй юу даа. Тэгээд энэ чинь одоо 12 оноос хойш өнөөдрийг хүртэл бол хаалттай компани хэвээрээ байгаад байдаг. Тийм болохоор бид нар нөгөө нэг хийгээгүй ажлаа өнөөдөр нөхөөд хийчихье гэдэг утгаар нь бол энэ асуудлууд бол анхнаасаа ингээд оруулж ирсэн юм.

Баялгийн сантай холбоотой асуудлыг бол би бас өөрөө бол хариулж мэдэхгүй байна. Энэ Засгийн газар хариулах болов уу. Ерөнхийдөө бол Засгийн газраас сая бас Их Хурлын дарга хэллээ. Ерөнхийдөө бол Засгийн газарт үүрэг даалгавар өгөгдөөд ингээд боловсруулалт нь бол хийгдээд явж байгаа гэсэн ийм мэдээлэлтэй байж байгаа. Тийм болохоор ер нь Баялгийн сангийнхаа хуулийг маш яаралтай түргэн оруулж ирээд, тэгээд энийг бүхэлдээ ер нь баялгийнхаа менежментийг яаж хийх юм гэдэг нь

тэрэн дээр харагдаад явчих байх. Тэгээд энэ дээр магадгүй зүгээр яг энэ тогтоолтой холбоотой тэр үед нь энэ тогтвортой холбогдолтой бас нэмэлт ч байдаг юм уу, update хийгээд явахад бол бололцоотой болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: За ойлголоо. Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар бол төрийн нийтийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдон үүсэх харилцааг Төрийн орон өмчийн хуулиар хуулиар зохицуулахгүй гэж байсан юм. Тэгээд энэ орж ирсэн хууль дээр хэн ажиллаж байгаа билээ. Ажлын дээр чинь? Бат-Эрдэнэ гишүүн ажиллаж байгаа билүү тийм ээ. Тэрнийг анхаармаар юм байна лээ. Ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа. Зарчмын зөрүүтэй санал. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

1.Тогтоолын төслийн нэгдүгээр заалтын 4, 5 дахь дэд заалтыг хасах санал гаргасан Эдийн засгийн байнгын хороо. 4 цагаас гэсэн гэж. Батжаргал дарга, Оюунчимэг дарга хоёр ирцээ бүрдүүлнэ. Энэ А танхимд ороод тэр, санал хураалт явуулна. Чуулганы танхимд гишүүд цуглая. Энэ 4, 5-ыг яагаад хасаж байгаа юм бэ? Ороогүй. Тэр олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн тэн төслийг боловсруулж Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэх гэдэг чинь зөв шүү дээ. Энийг хасаж яах юм бэ? Энэний дараа биш л дээ. Өмнө нь хэлэлцээд дууссан л даа. Тэрэн дээр байхгүй байсан л даа. Тэгэхээр тав гэхээр нөгөө юу 2 нь хасагдахаа больчихоод байна шүү дээ. Яаралтай горимоор өргөн мэдүүлэх энэ тэр гэж заадаг юм яаж байгаа юм бэ? Зүгээр л өргөн мэдүүлэх. Санал хураалт.

Туршилтын санал хураалт, үдээс хойших анхны санал хураалт учраас туршилтын санал хураалт явуулъя. Цогтгэрэл гишүүнээ дараарай. Бүртгэл гэсэн болохоор гэсэн. Адъяасүрэн, Адьшаа, Алтанхуяг. Бүртгэл. Аубакир, Баатарбилэг хоёр гишүүн уул нь байж байсан юм. Жаргалмаа, Өнөрболор 2, Саранчимэг Туваан 2. Санал хураалт явуулна. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн гаргасан саналын томъёолол.

Тогтоолын төслийн нэгдүгээр заалтын 4, 5 дахь дэд заалтыг хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Хууль баталсантай холбогдуулах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүдээ одоо санал хураалт, үгүй ээ энэ чинь тогтоолын төслөө баталъя гэсэн санал хураалт явуулах гэж байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууссан. Одоо хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Биш, тогтоол болохоор хууль биш тогтоол болохоор. Батсуурь гишүүнээ анхаараарай. Санал хураалт. 54.8 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалд орно.

14.34 цаг

Тав. “Орхоны хөндийд хот байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга

Жамъянгийн Мөнхбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Мөнхбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ. ТББХ 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явууллаа. Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Амарсайхан, Мөнхцэцэг нар тогтоолын төслийн талаар санал бодол байр сууриа илэрхийлсэн болно.

Тус Байнгын хороо тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Мөнхбат Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасныг баримтлан төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Орхоны хөндийд хот байгуулагдах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Алга байна. Ажлын хэсгийн гишүүд танилцуулъя. Ажлын хэсгийн гишүүд Цэрэнпилийн Даваасүрэн Барилга, хот байгуулалтын сайд, Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны ТНБД, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Батсүхийн Одбаатар Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Хот байгуулалтын хэлтсийн дарга, Тулгаагийн Ганзориг Нийслэлийн хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТ-гийн ерөнхий менежер. Ажлын хэсэг танилцуулаад. Байнгын хороо, Орхоны хөндийд хот байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудал орно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах, анхны хэлэлцүүлгээр нь явуулах энэ дээрээ та хэд бичээгүй байна шүү. Анхны хэлэлцүүлгээр нь явуулах горимын санал дэмжигдсэн учраас тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Орхоны хөндийд хот байгуулагдах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Анхны хэлэлцүүлэг горимын санал дэмжигдсэн. 22 гишүүн дэмжиж, олонх дэмжсэн тул тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалд оръё.

14.39 цаг

Зургаа.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2022.09.29-ний өдөр Төрийн хяналт шалгалтын тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын 20 оны 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 13, 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороо болон бусад Байнгын хороодод шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган та бүхэнд танилцуулж байна. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу ХЗБХ Зөрчил, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж гаргасан санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт Төрийн Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсгийг үндэслэн хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэн төслийн тухай тухайн зүйлтэй холбогдуулан ХЗБХ-

ноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус бүрээр нь санал хураалгаж шийдвэрлэсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хороонд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол, Төсвийн байнгын хороо дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.34, 6.35, 6.36, 6.37, 6.38, 6.39, 6.40, 6.41, 6.42, 6.43, 6.44, 6.45, 6.46, 6.47, 6.48, 6.49, 6.50, 6.51, 6.52, 6.53, 6.54, 6.55, 6.56, 6.57, 6.58, 6.59, 6.60, 6.61 дэх заалт нэмсүгэй:

6.34.авто замын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн

10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.4, 14.5 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.35.автотээврийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 14.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.36.аялал жуулчлалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйл, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.37.байгаль орчны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6, 1.7, 1.8, 1.9, 2.1, 2.2 дахь заалт, 3, 4, 5, 6 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 4, 5, дахь хэсэг 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7 дахь заалт, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28 дахь хэсэг, 6.24 дүгээр зүйл, 7.1, 7.2, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 16.1, 16.3, 16.4, 16.8, 16.10 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэг, 5.2, 5.3 дахь заалт, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 7.16 дугаар зүйлийн 1.2 дахь хэсэг, 7.17, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.38.барилгын техникийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.7 дахь заалт, 6.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 7.13 дугаар зүйлийн 16.5 дахь заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.1, 12.4, 12.5, 12.6 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.39.боловсролын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.19 дүгээр зүйл, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.9 дүгээр

зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

6.40.газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл, 7.2 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 8.1, 8.2 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 12.2, 12.3, 12.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.41.газрын тос, хийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлийн 3, 7, 8 дахь хэсэг, 16.5 дахь заалт, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 2.2, 2.3, 2.4, 2.5, 3.1, 3.3 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.42.геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйл, 5.15 дугаар зүйлийн 1.2, 1.4 дэх заалт, 2 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 8 дахь хэсэг, 7.11, 7.12, 7.13 дугаар зүйл, 7.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 9.7 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.43.мал үржлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.44.мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1,3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 4, 5 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 13.5, 13.9 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.45.нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.17, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.46.соёлын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 9.5, 9.6 дугаар зүйл, 9.7 дугаар зүйлийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14 дэх хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.47.соёлын өвийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.7, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.48.ургамал хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 13.1, 13.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.49.зам тээврийн улсын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.50.харилцаа холбооны хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.22, 10.27, 10.29, 11.2, 14.1, 14.2, 14.3, 14.13 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.1 дүгээр зүйлийн 14, 15, 17, 20 дахь хэсэгт заасан зөрчил;

6.51.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.2, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.52.хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.28 дугаар

зүйлийн 1 дэх хэсэг, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 10.12, 10.13, 10.14 дүгээр зүйл, 10.15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10.16, 10.25, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.53.хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.15, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.54.хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, 6.3 дугаар зүйлийн 2.3, 2.4 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 14, 15, 16 дахь хэсэг, 6.14 дүгээр зүйлийн 2, 3, 4, 5, 7 дахь хэсэг, 6.15 дугаар зүйл, 6.16 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, 6.25 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25, 13.7 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.55.хэмжил зүйн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.24, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.56.цөмийн болон цацрагийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.57.эм, биобэлдмэлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1.2, 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.5, 2.6, 2.7, 2.9 дэх заалт, 3 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.58.эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8 дахь хэсэг, 9.1, 9.2, 9.4 дэх заалт, 6.8, 6.9 дүгээр зүйл, 6.10 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 6 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйл, 6.19 дүгээр зүйл, 6.28 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.59.эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн, 6.15 дугаар зүйл, 6.17 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9 дэх хэсэг, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 7.15 дугаар зүйлийн 1.1, 1.5 дахь заалт, 3 дахь хэсэг, 5.1 дэх заалт, 6, 8 дахь хэсэг, 9.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.4 дүгээр зүйл, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2, 11.25 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 1.9, 6.1, 7.2 дахь заалт, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12.5 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.60.эрүүл мэндийн даатгалын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.14, 10.19, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

6.61.эрчим хүчний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйлийн 1.1, 1.3, 1.4 дэх заалт, 10.2 дугаар зүйл, 10.3 дугаар зүйлийн 1.2, 1.3, 1.4, 1.5 дахь заалт, 10.14, 10.25, 10.27, 10.29, 11.2 дугаар зүйл, 12.1 дүгээр зүйлийн 1.5, 7.2 дахь заалт, 12.8, 12.9, 12.10, 12.12 дугаар зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн, Ширнэнбандын Адьшаа, Цогт-Очирын Анадбазар, Хавдисламын Баделхан, Жигжидийн Батжаргал, Дамбын Батлут, Баагаагийн Баттөмөр, Энхбаярын Батшугар, Жадамбын Бат-Эрдэнэ,

Гочоогийн Ганболд, Сайнхүүгийн Ганбаатар, Наянтайн Ганибал, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Бадарчийн Жаргалмаа, Цагаанхүүгийн Идэрбат, Жамъянгийн Мөнхбат, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Мөнхөөгийн Оюунчимэг, Цэндийн Сандаг-Очир, Даваажанцангийн Сарангэрэл, Батсүхийн Саранчимэг, Цэдэвийн Сэргэлэн, Цэвэгдоржийн Туваан, Чинбатын Ундрам, Дамдины Цогтбаатар, Одонгийн Цогтгэрэл, Цэдэндамбын Цэрэнпунцаг, Содномын Чинзориг, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Төмөртоогоогийн Энхтүвшин цаашид ажлын хэсэг гэнэ. ХЗБХ дэмжсэн санал байна.

Энэ Барсүрэнгийн Баасандорж даргаа Засгийн газар ийм 3 хуудас хийдэл зөрчилтэй хууль оруулж ирж энийг нь одоо нөхөж гаргаж байна шүү. Төсвийн хуульд. Ийм баахан улсын байцаагчийн эрх хэмжээг хязгаарлуулаад хаячихсан. Тэгээд сүүлд нь одоо ингээд 3 хуудас юм уншиж санал оруулж байдаг Улсын Их Хуралд түүхэн рекорд тогтоосон ийм хийдэл зөрчилтэй хууль өргөн барихаа болино шүү та нар. Бөөс хуурсыг нь түүж. Сая бүгдийг нь уншсан шүү дээ. Дахиж уншсан шүү дээ би. Эндээс уншсан байхгүй юу сая. Уншсан, уншсан. Санал хураалт явуулна. Санал хураалт. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Даргаа сая би уг нь дарсан боловч сөрөг гарчихлаа. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоод, дахин санал хураалт явуулж өгнө үү хэмээн хүсэж байна.

Г.Занданшатар: Дэмжсэн боловч сөрөг гарсан учраас. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Горимын санал дэмжигдсэн учраас дахиж санал хураалт явуулъя. Зарчмын хувьд 50, 50 байсан учраас Оюунчимэг гишүүн дэмжсэн бол энэ шууд дэмжигдсэн тооцож болохоор л дэгийн зохицуулалттай. Тэгэхдээ одоо дахин санал хураалт явуулъя.

Дахин санал хураалт явуулъя. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэр 6.59 дээр бол 5.13 дугаар зүйлийн 1,3 дахь хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 1, 3, 6 дахь хэсэг, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6 дахь заалт, 8, 9, 10, 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 23, 26 дахь хэсэг, 6.2 дугаар зүйлийн 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11 дэх хэсэг, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.3, 2.4, 2.5 дахь заалт, 3, 4 дэх хэсэг, 6.4 дүгээр зүйлийн 2.1, 2.2, 2.3, 2.4, 2.7, 2.9 дэх заалт, 6.5 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5, 7, 8, 9, 10, 11, 16 дахь хэсэг, гэдэг хүртэл бас нөхөж оруулъя.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмэх.

“2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.11 дэх заалтын “6.1 дүгээр зүйлийн 27” гэсний дараа “, 28” гэж, 6.12 дахь заалтын “7.5 дугаар зүйл,” гэсний дараа “7.10, 7.11, 7.12, 7.13,” гэж, “6.5 дугаар зүйлийн 10, 12,” гэсний дараа “13,” гэж, “6.17 дугаар зүйлийн” гэсний дараа “5,” гэж, “7.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг,” гэсний дараа “7.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, 6.14. дэх заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “6.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, ХЗБХ дэмжсэн. Санал санал хураалт. 54.8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Түрүүн хүчингүйд тооцох санал хураалт явуулчхаад дахиж санал хураалт явуулах ёстой байсан байх тийм ээ. Тэгээд явуулчихсан уу, явуулсан юм. Явуулсан, явуулсан байхгүй юу. Битгий будилуулаад бай л даа. Тэгээд явуулчихсан байх чинь, одоо. Тэгсэн, тэгсэн. Хүчингүй болоод дахин явуулъя гээд 54.8 хувиар дэмжсэн байхгүй юу. Чи битгий хажуугаар нь үймүүлээд бай.

3.Төслийн 2 дугаар зүйлийг 3 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“3 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.15 дахь заалтын “10.19 дүгээр

зүйл,” гэснийг хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт. Бейсен гишүүнээ, Нямаагийн Энхболд гишүүн. Дэмжсэнээ хэлээд дэмжиж болох юм уу?

Н.Энхболд: Би дэмжээд дарсан чинь эсрэг гарчихсан байна даргаа. Тэгээд юу яая дахиад горимын санал явуулаад хүчингүй болгоод дахиж санал хураалгаж өгнө үү. Нямаагийн Энхболд гишүүнийг дэмжсэнд тооцоод шууд дэмжсэнд зарчмын хувьд болчихсон байна. Ингээд байнгын Нямаагийн Энхболд гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Нямаагийн Энхболд гишүүний саналаар түрүүний санал хураалтыг хүчингүй болгох дээр Энхболд гишүүний саналыг дэмжиж санал өгсөн боловч сөрөг гарлаа. Дахин санал болгож өгнө үү.

Г.Занданиатар: Туваан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт авуулъя. Оюунчимэг гишүүнээ, Бейсен гишүүнээ, Ганибал. 54.8 хувийн саналаар санал бичигдлээ. Горимын санал дэмжигдсэн учраас дахин санал хураалт явуулъя. Энхболд гишүүнээ. Нямаагийн Энхболд гишүүнээ. Аубакир гишүүн. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ. 4 билүү, 5 билүү?

Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх.

“4 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.” Санал хураалт. Энэ ХЗБХ дэмжсэнийг Төсвийн байнгын хороо дэмжсэн санал байна. Санал хураалт явуулаарай. Пүрэвдорж гишүүнээ санал хураалтаа. 57.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал орсон Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэн санал хураалт. Энэ санал дэмжигдсэн учраас байна шүү дээ энэ 01 сарын 01-нээс гэсэн ХЗБХ дэмжсэн санал хураалт явуулахгүй шүү дээ. Яагаад явуулна гэж 01 сарын 01-нээс явуулна гээд. Агар-Эрдэнэ даргаа та нар юу хийгээд байдаг юм. Энэ санал дэмжигдсэн зарчмын зөрүүтэй 2 санал нэг нь дэмжигдчихээд байхад энийг яагаад дахиж санал хураалгаж байгаа юм бэ? Үгүй ээ, энэ адил ижил төстэй саналын эсрэг утгатай нь дэмжигдсэн бол санал хураалт явуулахгүй гэсэн дэгийн заалт байна. Энэ 02 сарын 01-нээс гээд эхлэн дагаж мөрдөнө гэдгийг нь дэмжигдээд байхад 01 сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө гэдгийг дэмжих үү, дэмжихгүй гэж санал хураалт явуулах чинь логикийн хувьд ямар бэ? Үгүй ээ. Чи дэгээ унш, чи дэгээ ойлгодоггүй юм уу. Юу гэсэн үг юм. Ийм дэгээ ойлгохгүй улсууд байгаа.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор заавал санал хураалгая гэж байна. 5.Төслийн 3 дугаар зүйлийг 5 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“5 дугаар зүйл.Энэ хуулийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг ХЗБХ дэмжсэн санал байна бас. Санал хураалт, дэмжээгүйг дэмжинэ. Байнгын хорооны дэмжээгүй саналыг. Байнгын хорооны саналыг дэмжлээ. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна. Дараагийн асуудалд шилжье.

Долоо.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна. Индэрт урьж байна. Мөнхбаатар даргаа индэрт урьж байна таныг.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай 106 дугаар тогтоолыг 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан. Тус бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.3.5-д хувийн хэвшлийн гадаадаас авах ажиллах хүчний тоонд хязгаарлалт тогтоохгүй байх, хууль тогтоомжийн дагуу ногдуулах ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөхөөр заасан. Мөн коронавируст халдвар Ковид 19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.5-д зааснаар Засгийн газар цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон ААНБ, цалин орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээсэн билээ.

Дээрх шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхдээ коронавируст халдвар, Ковид 19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд Засгийн газар холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журамд нэмэлт оруулж, уг журмын дагуу ашигт малтмал болон

газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлөлт үзүүлсэн.

Монгол Улсын Их Хурлаас Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг 2021 онд баталж, уг хуульд гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх асуудлыг хуулиар зохицуулахаар тусгагдсан. Мөн коронавируст халдвар Ковид 19-ийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаа дуусгавар болсон. Түүнчлэн албан татвар, төлбөр хураамжийн асуудлыг шийдвэрлэх нь Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах тул Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд ААНБ-ын гадаад ажилчны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх зохицуулалтыг энэхүү хуулийн төсөлд тусгалаа. Мөн Зөвшөөрлийн тухай хуульд зааснаар зөвхөн хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгохтой холбоотой эрхээ бусдад шилжүүлэх зохицуулалттай тул Шинэ сэргэлтийн бодлого туссан төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшил, мэргэжлийн холбоодод шилжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх хүрээнд Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсхүл дадлагажихад зуучлах үйлчилгээ эрхэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой чиг үүргийг шилжүүлж болох эрх зүйн үндэслэлийг хуулийн төсөлд тусгасан.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй бөгөөд ажил олгогч, хөрөнгө оруулагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд буюу төрд төлж байгаа гадаад ажилтны ажлын байрны төлбөр хөнгөлөгдөж чөлөөлөгдөх улмаар зардлаа хэмнэх, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний

хүртээмжтэй шуурхай байдлыг бий болгох зэрэг эерэг дүн гарах юм. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Аюурсайхан сайдад баярлалаа. Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Жаргалмаа гишүүнийг индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт туссан тохиолдолд ашигт малтмал, газрын тосны салбараас бусад салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэх, эсвэл дадлагажихад нь зуучлах, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбоотой эрхээ Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шилжүүлж болохоор хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй, Монгол Улсын Их Хурлаас баталсан шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл бий болно гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг Парламент.мн сайтад байршуулж иргэд

олон нийтийн саналыг авч эхэлсэн болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг хууль хэрэгжиж эхлээд удаагүй байхад нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа зайлиггүй шалтгаан, ажиллах хүчийг дотоодоос хангах, дэмжих бодлогын талаар Улсын Их Хурлын гишүүн Чинзориг гадаадад ажиллах хүч илгээх, зуучлах эрхийг хувийн хэвшил, ТББ-д шилжүүлэх нь зохистой эсэх, гадаадад ажилтан ажиллуулах, ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх хүрээг хавтгайруулж байгаа нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогыг бууруулах эрсдэлтэй эсэх талаар Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа ажлын байрны хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг заавал хуульчлахгүйгээр Засгийн газар уян хатан зохицуулалтаар шийдвэрлэх боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Бейсен гадаадад ажиллах хүчийг илгээхдээ ямар журмаар зохицуулж байгаа талаар, дотоодын ажиллах хүчний хомсдолын талаар 2022 онд хэдэн иргэн зуучлалаар явсан болон 2023 онд хэдэн иргэн явахаар бүртгүүлсэн талаар болон тэдний эрхийг хамгаалах чиглэлээр хийгдэж байгаа ажлын талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Бейсен хөдөлмөрийн насны залуучууд гадаадад ажиллахаар явж байгаа тул дотооддоо ажиллах хүчнээ бэлтгэж, ажлын байраар хангахад анхаарах талаар санал хэлсэн болно. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 83.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын

байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Гомбосүрэнгийн Өнөрбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Содномдоржийн Дамбий, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Дугаржавын Ренчиндорж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг дэмжих хэлтсийн дарга Борын Алтантулга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний газрын дарга Загарын Буянбадрах нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүн асуулт асууя.

М.Оюунчимэг: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг бид нар батлаад энэ 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлээд одоо яг 12 дахь өдрөө болж байгаа. Энэ шинэчилсэн найруулгаар баталсан энэ хууль бол бас чамбай бас сайн хууль болсон. Тэгээд хуулийг бид нар баталж гаргахдаа шинэчилсэн найруулгаар хамгийн гол нь бас дотоодынхоо ажиллах хүчийг дэмжих, иргэдээ ажилтай орлоготой болгох, гадаадад ажиллах хүч гаргахдаа бас тодорхой бодлого баримтлах. Жишээлбэл ямар мэргэжил дээр хязгаар тогтоох вэ, ямар мэргэжлийг илүү дэмжих вэ, гадаадаас орж ирж байгаа тэр knowhow боловсрол, эрүүл мэндийн чиглэлийн ажиллах хүч орж ирвэл одоо дэмжих ч

гэдэг юм уу ингээд нэлээн сайн хууль болгож оруулж ирж гаргасан. Одоо тэгээд ингээд хэдхэн хоногийн дараа өөрчлөхөөр орж ирж байгаад бас жоохон шүүмжлэлтэй хандаж байгаа юм.

Тэгэхдээ яах вэ шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд энэ хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор шимтгэлийн асуудал дээр бол бас бодолцох хэрэг гарсан учраас нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарсан гэж хэлж байгаа. Энэ нь нөгөө гаднаас ажиллах хүч авбал сая Ковидын хуулийн үед 50 хувийн нөгөө хөнгөлөлт үзүүлж байсан. Тэгэхээр шинэ хуулиар бол энэ хөнгөлөлт уг нь байхгүй болж байгаа. Тэгэхээр одоо салбарынхан энд яг тодорхой бас мэдээлэл ил тод өгөх нь чухал байна л даа. Нэн энэ 50 хувийн хөнгөлөлтийг цаашид нь үргэлжлүүлэх нь өөрөө ямар үндэслэл, шаардлага байгаа юм. Энэ яг шинэ хуулиараа явчихвал энэ нь өөрөө яагаад болохгүй байгаа юм. Энэ хөнгөлөлтийг цаашид ер нь хэдий хугацаанд та үргэлжлүүлэх юм, энд ямар хязгаар тогтоох вэ? 50 хувийн шимтгэл гэдэг дээр энэ дээр нэгдүгээрт нь нэг тодорхой мэдээлэл авах нь өгөх нь чухал болов уу гэж бодож байна нэгд.

Хоёрдугаарт нь өчигдөр бас салбарынхан нь ч яриад л байна лээ. Энэ зуучлалыг яг гадаадад ажиллах хүч илгээх зуучлалын үйл ажиллагааг хувийн хэвшил, ТББ-аар одоо шилжүүлж болох энэ цонхыг нээж өгч байгаа нь өөрөө цаг хугацааны хувьд арай л эрт байна гэсэн шүүмжлэл байгаад байгаа юм л даа. Яагаад гэвэл энэ жишээлбэл одоо Турк улсын бусад улс орон руу хувийн хэвшил яг энэ зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим нэг ТББ, зарим компаниудын одоо яг энийг эрхлэх тэр хууль эрх зүйн хувьд арай л нэг чадавх нь чанарын хувьд болоогүйгээс болоод тэнд очоод яг Монгол иргэд одоо аюулгүй байдал нь алдагдах, хүний эрх зөрчигдөх ноцтой зөрчлүүд бол нэлээд их гарч байгаа шүү дээ. Тэгэхээр тийм нөхцөлд одоо бүр ингээд албаны шугамаар явж байгаа тохиолдолд одоо энэ зуучлалын үйл ажиллагааг хувийн хэвшил юм уу, ТББ

руу шилжүүлэх нь хэр одоо оновчтой бодлого юм бол доо. Энэ 2 дээр ингээд товч мэдээлэл авъя гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийг одоо хэлэлцэн батлахад Оюунчимэг гишүүн маш идэвхтэй, санаачилгатай ажилласан хүн. Та мэдэж байгаа энэ хууль дээр бол энэ ажиллах хүчний гадаад ажилтны энэ төлбөрөөс чөлөөлөх зохицуулалт байгаа. Ямар тохиолдолд чөлөөлөх вэ гэх юм бол энэ Монгол Улсын Засгийн газар одоо олон улсын гэрээ хэлэлцээрийн дагуу бүтээн байгуулалтыг хийж байгаа. Хоёрдугаарт стратегийн ач холбогдол бүхий гэж үзсэн энэ бүтээн байгуулалтад ажиллаж байгаа гадаад ажилтны ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх ийм эрхийг Засгийн газарт өгсөн ийм зохицуулалт байгаа. Уг хуульд одоо ямар нэгэн байдлаар одоо бусад аж ахуй эрхлэгчдийг бусад ажлын байрыг хөнгөлж болох ямар нэгэн эрхийг Засгийн газарт өгөөгүй юм. Энэ хууль бол батлагдаад 2021 онд батлагдаад, ингээд 22 оны 01 сарын 01-нээс хэрэгжиж эхэлсэн, 23 оны тийм ээ. Тэгтэл энэ хооронд бол 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлаас шинэ сэргэлтийн бодлогыг 106 дугаар тогтоолоор баталсан байгаа.

Энэ тогтоолынхоо 6.3.5-д энэ хувийн хэвшлийн гадаадаас авах энэ ажиллах хүчний ажлын байрны төлбөрийг 50 хувиар хөнгөлнө гээд ингээд заагаад тогтоочихсон байгаа. Энийгээ Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд оруулъя гэхээр тэр хууль нь өөрөө хэрэгжиж эхлээгүй ийм хууль байсан учраас энэ шинэ сэргэлтийн бодлого, Улсын Их Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд Засгийн газраас энэ Ковидын хуулийн үйл ажиллагаа нь доголдсон ААН-д одоо дэмжлэг үзүүлэх энэ эрх үүргийнхээ хүрээнд энэ Улсын Их Хурлын тогтоолыг

хэрэгжүүлээд 2022 онд ажилласан юм. Одоо ингээд нэгдүгээрт Ковидын хууль хүчин төгөлдөр хугацаа нь дууссан. Хоёрдугаарт Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль хүчин төгөлдөр хэрэгжээд эхэлсэн учраас Улсын Их Хурал энэ баталсан тогтоолоороо зохицуулсан зохицуулалтаа энэ хуульд оруулж өгөх эрх зүйн боломж нь ингээд бүрдэж байгаа юм.

Тийм учраас энийг одоо хуулийн төсөлд оруулж ингэж зөвхөн чөлөөлөх эрхийг нь өгсөн, хөнгөлөх ямар нэгэн эрх байхгүй байсныг нь хөнгөлж болох энэ эрхийг нь өгсөн байгаа. Шинэ сэргэлтийн бодлогоор бол 50 хувиар гээд маш тодорхой тоо заачихсан. Улсын Их Хурал тогтоолоо баталчихсан Засгийн газарт үүргээ өгчихсөн. Тийм учраас энэ бол хууль дээрээ хувь хэмжээ байхгүй ч гэсэн Засгийн газар бол ингээд Их Хурлын шийдвэрийг биелүүлээд ингээд явах учиртай байгаа. Зарим чиг үүргийг хувийн хэвшилээр одоо гүйцэтгүүлэх энэ асуудал бол одоо олон салбарт бол явж байгаа. Үүний нэг нь бол бас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт, гадаадад ажиллах хүчнийг зуучлахад заавал ч үгүй одоо төрөөс оролцож байх шаардлагагүй гэж үзэж байгаа. Энэ дээр бол Худалдаа аж үйлдвэрийн танхим, олон нийтийн зөвлөлүүд нь одоо чиг үүргийн ТББ нь тэртээ тэргүй хуулиар тавигддаг шаардлагууд нь бол хангагдах байх ёстой. Баримт бичгийн бүрдүүлэлт нь хуулиар журмаар заасан байгаа. Энэ бүгдийгээ бүрдүүлээд ингээд явдаг. Энийг нь хяналтыг нь бол бас хаанаас тавих вэ гэдэг бас төрөөс тавих боломжтой шүү дээ.

Тийм учраас аливаа зүйлийг одоо төр бүх юмаа ялангуяа энэ тусгай зөвшөөрөлтэй холбогдоод явахлаар дунд шатанд бас нугалаа гаргадаг, хясан боомилуулдаг. Энийг эргээд тойроод бас авлига явдаг ийм асуудлуудыг бас олон нийтийн хяналтад, олон нийтээр гүйцэтгүүлэх нь зүйтэй гэдэг санаачилгын нэг нь юм гэж хариулъя. Оюунчимэг гишүүнд.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Тэгэхээр бас энэ Аюурсайхан сайд, манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллынхан маань бас нэг анхааралдаа аваарай. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэг тусгасан нэг чухал заалт бол тухайн ажлын байран дээр гаднаас ажиллах хүч авах тохиолдол гэхэд эхлээд дотоодоосоо ажиллах хүчээ хангах, одоо дотоодын хөдөлмөрийн зах зээлээ хамгаалах, энэ тал дээр бас бодлого барина гэсэн тийм чухал заалт орсон байгаа. Тэгэхээр одоо хэрэв нэмэлт, өөрчлөлт ороод гаднаас ажиллах хүч авах тохиолдол юм боллоо гэхэд бас дотоодынхоо ажиллах хүч, хөдөлмөрийн зах зээлийг хамгаалах дээр бас сайн бодолцох ёстой шүү гэдгийг нэгд хэлмээр байна.

Хоёрт нь зүгээр Эрдэнэс таван толгой гэхэд сая нэг өнгөрсөн жил ажлын байр зарлахад зарласан 3 өдрийн өдөрлөг тэр байр битүү хүмүүстэй байсан байхгүй юу. Тэгэхээр дотоодод бас залуучууд дунд насны хүмүүс ямар их ажлын байр цалин гайгүйтэй бас ажилд орох сонирхол их байгаа нь, ийм эрэлт хэрэгцээ байгаа нь энэ хөдөлмөрийн зах зээлээс бол харагдаж байсан учраас энэ зүйлүүд дээр бас анхаарч ажиллаарай гэж хэлэхийг хүсэж байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн үг хэлчихлээ. Адьшаа гишүүн асуулт асууя.

Ш.Адьяа: Баярлалаа. Энэ хуулийн төслийг хэлэлцэж байна. Гадаадаас ажиллах хүчин авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай би энэ дээр 2 асуулт асууя. Энэ гадаадаас ажиллах хүчин авах энэ асуудал бол өнөөдөр бас зарим салбарт шаардлагатай байгаа. Гэтэл энэ нэг хөнгөлөлт чөлөөлөлт гэдэг асуудлыг шийдэхгүйгээр энэ асуудлыг шийдэх боломж гарц ер нь байсан уу? Яагаад гэхээр гадаадаас ажиллах хүчин авсны төлбөр хураамж гэдэг бол өнөөдөр Монгол Улсын бас төсөвт тодорхой

хэмжээний хөрөнгө төвлөрдөг. Түүнчлэн энэ төвлөрсөн хөрөнгөөр дотоодын хөдөлмөрийн зах зээлийг бий болгох, хамгаалах ийм төрийн бодлого зарим талаар зохицуулалт хийдэг ийм ач холбогдолтой ийм зохицуулалт байдаг. Нэн ялангуяа энэ уул уурхайн салбарт өнөөдөр энэ гаднын ажиллах хүчин оруулж ирэх, түүнчлэн төлбөр хураамжаас одоо тавь хүртэл хувиар бууруулах энэ зохицуулалт нь өнөөдрийн энэ шийдэх асуудлын нэг мөн үү? Яагаад гэхээр өнөөдөр Монгол Улсад бас ингээд дотоодын зах зээл дээр хөдөлмөрийн зах зээл дээр ажиллах хүчний цалин хөлс, бусад шалтгааны улмаас бол ажил хөдөлмөр эрхлэх асуудал нэлээн хүндрэлтэй. Нэн ялангуяа дотоодын зах зээл дээр энэ ажиллах хүчин гэдэг юм хэдийгээр ажлын байр байгаа ч гэсэн энийг бол орох ажиллах ийм сонирхолтой иргэд ер нь хэр зэрэг байна гэдэг асуудал байгаа.

Түүнчлэн одоо энд нэг зөв зүйтэй заалт орсон нь тэр төр хувийн хэвшил бол өнөөдөр энэ гадаадад ажиллах хүчин гаргах, зуучлах энэ асуудлыг бол хуулиар бас олгож байгаа нь энэ бас шинэлэг зүйл. Энэ бол одоо шийдэх ёстой. Яагаад гэхээр бүх зүйлд төр оролцдог, төрийн чиг үүргийг зарим талаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд мөн түүнчлэн төрийн бус байгууллагууд хувийн хэвшлийн хүрээнд зохицуулах ёстой асуудлыг нь ийм байдлаар шийдэх нь өнөөдөр бас энэ Засгийн газраас бас шинэлэг зүйл. Нэн ялангуяа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бас шинэлэг зүйл хийх энэ эхлэлийг тавьж байгаа сайн зүйл гэсэн ийм одоо бодолтой байна. Тэгээд дээрх асуудалдаа хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Адьяа гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

С.Аюурсайхан: Адьяа гишүүний асуултад хариулъя. Үнэхээр энэ гадаад ажилтны ажлын байрны төлбөр яагаад авч байгаа юм бэ гэх юм бол үндсэндээ дотоодоос ажиллах хүчнээ аль болохоор одоо дотоодынхоо хүмүүсийг одоо ажлын байраар хангая гэдэг энэ концепц явж

байгаа шүү дээ. Тэгээд хэрэв гадаадаас авах юм бол төлбөр оногдуулъя. Энэ төлбөр нь бол одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин үржүүлсэнтэй тэнцүү байгаа. Энэ жил 1 сарын 1-нээс 550000 төгрөгийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ шинээр бид тогтоогоод хэрэгжүүлж байгаа бол 1100000 төгрөгийг нэг ажлын байрнаас авах нь. Тэгээд энэ мөнгөө яах вэ гэхлээр бид нар Хөдөлмөр эрхлэлтээ дэмжих санд төвлөрүүлдэг. Тэгээд үүгээрээ дамжуулаад одоо ажлын байрыг одоо нэмэгдүүлэх, бий болгох, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулахад одоо зориулж ажилладаг.

Ингээд асуудлын нөгөө тал нь юу юм бэ гэх юм бол одоо ингээд эдийн засаг бас сэргэж байна. Шинэ сэргэлтийн бодлого баталлаа. Ирэх жил бол 2 жилийг аялал жуулчлалын жил болгож зарлалаа. Барилга их бүтээн байгуулалт, зам тээвэр, боомтын сэргэлт, эрчим хүч бүх салбарт одоо томоохон одоо ажлын байрнууд бас бий болгох гэж ингэж эдийн засгийг сэргээхээр Засгийн газар зорьж байгаа. Үр дүнгүүд нь гарч байгаа. Эдийн засгийн өсөлт бол таамаглаж байснаас бас өндрөөр гарч байна. Ирэх жил бол прогноз нэлээн эерэг байгаа. Валютын нөөц нэлээн бүрдүүлж байна. Тэгэхээр энэ дээр бол нөгөө талаасаа бид мөн одоо гадаадаас ажлын байрыг одоо авах нэмэгдүүлэх, зарим салбарт энийг нь бас төрийн бодлогоор дэмжих ийм бодит шаардлага байгаа юм. Энэ дээр бол Ашигт малтмал, газрын тосны салбарыг бол энэ хөнгөлөлтөд оруулахгүй байгаа. Яагаад гэвэл сая Засгийн газраас 2022 онд мөн одоо ажлын байрыг гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг 50 хувиар чөлөөлөхөд ашигт малтмал болон газрын тосны салбарыг оруулаагүй. Энэ салбараас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд бас нэгдүгээрт зонхилох мөнгө ордог. Тухайлбал 2020 онд хөдөлмөр эрхлэлтийг 22 онд дэмжих сангаас санд гадаад ажилтны төлбөрөөс дөчин тэрбум төгрөг ороход хорь гаруй тэрбум нь энэ уул

уурхайн таны хэлдэг салбараас орсон, бид авсан.

Хоёрдугаарт энэ Үндсэн хууль дээрээ заасан. Энэ бол ард түмний одоо өмч мэдэлд байдаг уул уурхайн баялаг бол. Нөгөө талаар уул уурхайн баялаг бол шавхагддаг баялаг. Энэ бол үр өгөөжийг нь одоо зарчим нь бол одоо иргэн бүрд одоо янз бүрийн хэлбэрээр үр ашгаа өгч байх ийм л одоо ард түмний улсын ийм баялаг байгаа шүү дээ. Тийм учраас энэ утгаараа энэ хөнгөлөлт чөлөөлтөд хуулийн төсөл дээрээ бид Засгийн газраа 22 онд авч хэрэгжүүлсний дагуу ашигт малтмал болон газрын тосны салбараас бусад гэж оруулсан байгаа. Энэ дээр бол бид яамны зүгээс салбаруудад энэ гадаад ажилтны тоо хэмжээний одоо энэ саналаа салбарууд өгдөг. Энэ тоо хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй байх шийдвэрийг Улсын Их Хурлаас шинэ сэргийлэлтийн бодлогоор гаргасан. Энэний хүрээнд салбар болгон тоо хэмжээнийхээ хязгаарыг тогтоогоод, энэ хязгаараа өөрсдөө хянаад ингээд ямар салбарт ямар ажлын байр вэ гэдгийг нь одоо манай яам руу ирүүлээд тэгээд ингээд Засгийн газрын хуралдаанаар ингэж шийддэг байгаа.

Энэ тусгай зөвшөөрлийг бас шилжүүлэх энэ асуудал дээр бол бас яг тантай санал нэг байна. Энэ төр хувийн хэвшлийн одоо түншлэлийг дэмжих, энэ хууль дээр төр эрхээ шилжүүлж болно гэсэн болохоос биш огт одоо төр хамтарч болно, бүрэн шилжүүлж болно. Зарим чиг үүргийг нь хянаж хамтарч оролцож болно. Огт ийм шилжүүлж болно гэсэн заалт байхгүй учраас хувийн хэвшлийн энэ хяналт гүйцэтгэлийн оролцоо байхгүй яваад байсан юм.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүн асуултаа асууя.

Н.Ганибал: Миний хувьд өмнөх сайдыг байхад танай энэ одоо Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам руу нь бас нэг хүсэлт юу, асуулт асуусан юм. Тэр асуултын хариугаа би авч чадаагүй байхгүй

юу. Асуултын агуулга нь юу байсан бэ гэхээрээ Монгол Улсын хэдэн иргэн гадаадад улс оронд ажиллаж байна вэ? Тэгээд ямар салбар руу илүү их ажиллах сонирхолтой байгаад яваад байна. Ер нь одоо цаашид аль салбар, салбар Монгол хүмүүс, Монгол залуучууд ажиллах хүсэлтэй байна гээд иймэрхүү энэ хөдөлмөрийн үндсэн асуултуудыг асуусан. Харамсалтай нь надад ирсэн мэдээлэл нь болохоороо зөвхөн тэр ажиллах хүчин зуучлах компаниудын мэдээллийг өгсөн.

Харин бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Гэр бүл Монголын одоо өрх болгон бүрээс бараг 1-2 хүн гадаад улс оронд ажиллаж байгаа. Ихэнх нь харлаж байна, хараар. Энэ хүмүүст хэн ер нь анхаарал хандуулах ёстой юм бэ? Энэ Монгол Улсын энэ иргэд өнөөдөр гадаад улс оронд ямар нэгэн албан зөвшөөрөлгүйгээр ажил хийж байгаа дээр анхаарал хандуулах яам байна уу гэдэг энэ асуудлыг бас та бүхнээс бас асууя. Энэ мэдээлэл надад ирээгүй байхгүй юу. Тэгэхээр энийг бүртгэж аваад цаашилаад энэ хүмүүсээ албан ёсны болгох энэ асуудлыг хэн хариуцах юм бэ? Одоо бид бүхэн сайн л байна л даа. Одоо энэ хууль дөнгөж хэрэгжингүүт 10 хоногийн дотор асуудлыг ингээд Монголд орж ирж байгаа ажиллах хүчинд болохоороо хөнгөлөлт өгөх, тэд нарын анхаарал хандуулсан хуулийн өөрчлөлтүүд байна шүү дээ. Харин Монголын иргэний асуудлыг хөдөлмөрлөх эрхийг нь хангах тэр хуулийн өөрчлөлтүүдээ та бүхэн түрүүлээд оруулж ирээч. Энэ асуудлуудаа мэддэг баймаар байна. Өнөөдөр Солонгос улсад одоо хараар ажиллаж байна л гэнэ. Тэр ажиллах хүчин гаргаж байгаа тэр компаниуд дээр бас асуудал байдаг юм шиг байгаа юм. Гаргахдаа ажиллах цалинг нь блоклодог. Нэг эсвэл дундаас нь тодорхой хэмжээний хураамж авахдаа өндөр хуваарь авдаг. Энэ асуудлуудыг цэгцэлж байж өнөөдөр тэр хүмүүс яагаад харлаад байгаа гэдэг асуудлыг бид нар оношлох хэрэгтэй. Ингэж явж байж энэ хуулийн төслүүд маань зөв явахгүй бол өнөөдөр Монгол Улсад ажиллах хүн гэж ер нь бараг байхгүй боллоо шүү.

Саяхан одоо Хятадаас олон ажилтан орж ирээд л Монголд их ажиллах хүчин бий боллоо л гэдэг байсан. Одоо Монголчууд Хятад руу очиж ажилладаг болчихсон шүү дээ. Мэдэж байгаа биз дээ. Яамных минь ээ. Одоо Сүхбаатар аймагт одоо Эрдэнэцагаан сум байдаг. Туслах малчид ихэнх нь Өвөр Монголд очиж мал малладаг болсон. Шалтгаан нь Монгол Улсад мал маллаад олдог орлого гэж байхгүй болсон. Өнөөдөр бид нарын оруулж ирэх гол хууль бол энэ төрийн албан хаагч байна уу, ажиллах хүчнийхээ энэ цалингийн доод хэмжээг нэмэх цалинг нэмэх. Дээрээс нь Монгол хүний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болгон үнэ цэнтэй болох тал дээр ажиллахгүй бол бид бүгд өөрсдөө гадагшаа яваад одоо энэ хуулиар орж ирэх хөнгөлөлттэй орж ирэх хэдэн нарийн мэргэжлийн тогооч байгаа байх, хэдэн буудлын менежерүүд байгаа байлгүй. Хэдэн аялал жуулчлалын менежерүүд л орж ирэх байх. Өөр ер нь Монголд орж ирээд ажиллах хүн гэж байхгүй дээ дэлхийд. Ийм бага цалинтай, өөрсдөө дайждаг энэ улс оронд хэн ирэх вэ дээ. Тэгээд энгийн жишээ. Өнөөдөр малын үнэ, мах, арьс шир, ноос ноолуур бүгд үнэ цэнгүй учраас туслах малчин Өвөр Монголд очиж мал малладаг болсон шалтгаан нь. Тэгэхээр бид энэ иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлэх, энэ үнэ цэнтэй байлгах, Монгол хүн чинь өөрөө үнэ цэнтэй байлгах энэ асуудлуудаа яг энэ хууль шигээ 12 хоногийн дотор биш байлаа гэхэд нэг 24 хоногийн дотор оруулж ирээч. Ингэж байж бид нар өнөөдөр Монгол хүн өөрийгөө одоо хамгаалах Монголдоо амьдарч болох энэ.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг хариулъя. ТНБД Өнөрбаяр хариулъя, 87 дугаарын микрофон өгье. Ажлын хэсгийн хэд вэ? 85 дугаар микрофоноо өгчих. Өнөрбаяр дарга асуултад хариулъя.

Г.Өнөрбаяр: Ганибал гишүүний асуултад хариулъя Өнөрбаяр. Бидэнд байгаа мэдээллээр бол хилийн чанадад бол 100 гаруй мянган Монголчууд сурч ажиллаж хөдөлмөрлөж байгаа гэсэн ийм

мэдээллүүд байдаг. Сая энэ шинээр батлагдсан Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль дээр энэ Монгол Улсаас хилийн чанадад байгаа дипломат төлөөлөгчийн газар энэ консулын газрууд тухайн улсад одоо хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг бүртгэх аль салбар дээр нь ажиллаж байгаа, ялангуяа таны яриад байгаа энэ цалин хөлсний бүтцийн судалгаатай холбоотой мэдээллүүдийг одоо нарийвчилж ирүүлэхээр энэ хуулийн төсөл дээр бол бас тусгасан. Тэрнээс гадна энэ хэрэгжиж байгаа хууль дээр бол гадаадад ажиллаж байгаад буцаагаад эх орондоо ирж ажиллах, өөрөөр хэлбэл хөдөлмөр эрхлэлтийг дэмжих энэ цогц бодлогыг энэ хуулийн төсөл дээр бас нарийвчлан оруулсан. Манай яам бол Япон, Солонгост одоо ажиллах хүч гаргах, зуучлах энэ чиглэл дээр чиг үүрэгтэй бас ажиллаж байгаа.

Хамгийн сүүлийн байдлаар бол БНСУ-д бол нэг 4400 орчим хүн бол одоо албан ёсны зөвшөөрөлтэйгөөр бол ажиллаж байгаа. Япон улсад бол нэг 80 гаруй иргэн ялангуяа манай яамны шугамаар бол одоо бас ажиллаж юу зуучлагдаад ажиллаж байгаа гэсэн ийм тоо баримт, статистик мэдээллүүд байгаа. Цаашидаа бол бид нар энэ бусад улс орнуудад таны яриад байгаа аль салбар дээр ямар мэргэжлээр ямар цалин хөлстэйгөөр ажиллаж байгаа ийм тооцоо судалгаа гаргаж бас ажиллаж байгаа. Ер нь бол дэлхий дахин дээр бол энэ ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний бас нэлээд өөрчлөлтүүд хийгдэж байгаа. Энэ чиглэлийн бүтцийн судалгаануудыг бол одоо бид нар бас нэгтгээд холбогдох арга хэмжээнүүдээ бол авч ажиллаж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Ажиллах хүч гадаадад гаргах, гаднаас ажиллах хүч авах тухай хуулийн харилцаа орж ирж байна л даа. Ер нь энэ бодлого орж ирж байгаагийн цаана Монгол Улсад энэ хөдөлмөрийн зах зээлийн

эрэлт, нийлүүлэлтийг хаана, ямар байгууллага судалж, ямар тооцоо шинжилгээ, дүгнэлт гаргадаг вэ? Яг энэ ямар судалгаа шинжилгээ дээр үндэслэж гарч байгаа тооцоо баримтууд байна вэ? Ер нь одоо яг өнөөдөр Монгол Улсад ажил ажилгүй нь биш ажиллаж байгаа нь ажил ажиллангаа ядуурдаг ийм л тогтолцоо бий болчихсон. Нөгөө нэг ипотекийн зээл бусад зээлүүд олон зүйлд хэдэн төгрөгийн цалин аваад тэгээд ажиллангаа ядуурдаг ийм тогтолцоо. Юун тэр бусад орнууд руу Сүүл Солонгос руу явж ажил хийх байтугай, Эрээнд гарч аяга угаахад Монголоос 2 дахин өндөр цалинтай. Хэдэн зуун сая ажиллах хүчинтэй Хятад улсууд гарахад нөхцөл байдал одоо ийм л болчихоод байгаа юм. Тэгээд өмнө нь энэ хууль бас орж ирж байсан. Энэ дээр би бас ажлын хэсэг болоод яамныхнаас асууж л байсан. Ер нь одоо Монгол Улсад тэр ажлын байр байна. Ажлын байрыг чанартай ажлын байр гэдэг ойлголт олон улсад байдаг юм байна. Энэ ажлын байр, ажлын байрны чанараас хамаарч энэ шилжилт хөдөлгөөний бодлого чинь цаана нь яваад байна.

Тийм болохоор Монгол Улсад яг ямар цалинтай, нөхцөл байдалтай байвал энэ шилжилт хөдөлгөөн зөв зүйтэй болгох гээд байгаа юм бэ? Зөв зүйтэй шилжилт хөдөлгөөн болох гээд байна. Уг нь болдог сон бол гаднаас ердийн бага цалинтай ажилчид Монголд орж ирдэг тогтолцоо бол одоо, өнөөдөр чинь Монгол Улс ер нь ажиллах хүчний хомсдолтой орон болчих, зүгээр судалгаа шинжилгээ та нар дээр ямар тооцоо баримтууд одоо байдгийг мэдэхгүй. Тэгэхээр энэ дээр нэг ганц 2 асуулт байгаа юм. Ер нь Монгол Улсад гадаадад ажиллаж байгаа нийт ажилтнуудын Монгол Улсад оруулж байгаа санхүүгийн тэр гүйлгээ, тооцоо, санхүүгийн гүйлгээ шилжүүлэх Монгол Улсад одоо энэ Оюу толгойгоос аваад Монгол Улсад ажиллаж байгаа гаднын ажиллах хүчний гадагшаа урсаж байгаа энэ валютын харьцаа өнөөдөр яг ямар байдалтай байна вэ? Мэдээж гаднаас орж ирж байгаа нь олон биш хүн асар өндөр

цалинтай шилжүүлэг явагдаж энэ дээр яг тодорхой тийм тоотой баримттай зүйл хэлээч.

Хоёрдугаарт нь ер нь энэ асуудал бол явсаар байгаад тэр нэг халамжаас хөдөлмөрт гэдэг нэг уриа лоозон төдий юм яваад, эргээд бараг энэ хөдөлмөрөөс халамжид гэдэг яг хөрсөн дээрээ бодит байдал дээрээ тийм л бодлого болоод л хувирчихсан шүү дээ. Өнгөрсөн хугацаанд яг ажлын байрыг нэмэгдүүлсэн, ажлын байрыг чанаржуулсан, цалин хөлсийг нэмэгдүүлэх бодлого барьсан. Техник технологийг илүү шингээх бодлого барьсан ямарваа нэгэн тийм бодлогын шинэчлэл, өөрчлөлт өнгөрсөн хугацаанд гараагүй. Энэнээс улбаалаад хөдөлмөрөөс халамжид илүү шилжсэн өнгөрсөн хугацаанд. Энэнээс улбаалаад ажиллах хүчний хомсдолтой болсон бүтээн байгуулалт олон салбар одоо ажиллах хүчний хомсдолоос болж яг одоо бодит байдал тийм л бодит байдалтай байгаа юм.

Тэгэхээр саяын нэг асуултуудад хариулт өгөөч. Ер нь чанартай ажлын байр гэдэг тодорхойлолт, ажлын байрыг чанаржуулах гэдэг ойлголт одоо танай яамны энэ бодлогын одоо энэ хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт олон зүйл дээр байна уу? Байвал тэр тоо хэмжээ тэр авах ёстой тэр цалингийн тоо хэмжээ хэд вэ? Хоёрдугаарт нь тэр ер нь том дүнгээрээ гадагшаа ажиллах хүчинд шилжиж байгаа гаднаас ажиллах хүчний чиглэлээр ажиллаж байгаа иргэдийн Монгол Улсад шилжүүлж байгаа мөнгөний энэ тооцоо балансыг өнөөдөр яг бодит байдал дээр яг ямар байна вэ?

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад Аюурсайхан сайд уу, ажлын хэсэг хариулах уу? ТНБД Өнөрбаяр хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофоныг өгье.

Д.Өнөрбаяр: Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяанд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сургалт үнэлгээ, судалгааны институт гэж байдаг.

Энэ судалгааны институт маань ялангуяа энэ Монгол Улсын хэмжээнд гарч байгаа ажлын байрууд түүний цалин хөлсний бүтцийн судалгаа, хаана ямар ажлын байрууд эрэлт хэрэгцээтэй байгаа судалгаануудыг улирал тутам гаргаж, олон нийтэд мэдээлдэг. Ялангуяа бүс бүсээр нь бол одоо бас гаргаад мэдээлээд явдаг. Мөн энэ хуулийн үйлчлэлийн хүрээнд бол хийж өгсөн бас нэг чухал онцлог нь бол ААН байгууллагууд ямар ажлын байр бий болгох, ямар төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, энэ чиглэлээр одоо бас нарийвчилсан тоон мэдээллүүдийг гаргаад манай судалгааны институттэй гаргаад ахиц дэвшил гаргаж байгаа асуудал бол байгаа.

Таны чанартай ажлын байр гэдэг бол энэ их чухал асуудал юм. Олон улсын болон олон улсын хөдөлмөрийн байгууллага болон гишүүн улс орнуудад бас уриалж байгаа чухал уриалгатай бол энэ нийцэж байгаа. Энийг бол зохистой ажлын байр гэж томъёолж байгаа. Зохистой ажлын байр гэдэг бол эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрахаас гадна тухайн хүний авч байгаа цалин хөлс бол амьдрал ахуйд нь бас хүрэлцэхүйц байхаас гадна хөгжиж дэвших энэ боломж бололцоогоор одоо бас хангах гэсэн ийм одоо бас өргөн хүрээтэй чухал ойлголт юм гэдгийг бол бас хэлэх ёстой. Монгол Улсад бол одоо сүүлийн бид нар нийгмийн даатгалын дата баазын судалгаануудыг аваад үзэхэд бол энэ өнгөрсөн 22 оны эцсийн байдлаар бол нэг 8461 одоо гаднын ажиллах хүч бол Монгол Улсад ажиллаад тухайн хүмүүсийн НДШ-д одоо төлж байгаа мөнгөн дүн бол нэг 95.9 тэрбум төгрөг бол байгаа. Энэ 8000 гаруй энэ гаднын ажиллах хүч маань 2000 гаруй одоо ААН, байгууллагуудад одоо бас ажиллаж байгаа гэсэн ийм тооцоо судалгаа бол бас байгаа.

Харин гаднаас гадаадад одоо бас ажиллаж амьдраад Монгол руу бол одоо бас мөнгийг нь шилжүүлж байгаа энэ нарийн тооцоо мэдээллүүд бол одоо бас Монгол банкин дээр бол гарах байх. Цаашидаа бол бид нар энэ улс орон

болгоноор нь энэ нарийн тоо судалгааг одоо бас гаргаж дүн шинжилгээ хийж ажиллах ёстой гэдэгтэй бол санал нэг байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүн тодруулж асуух уу?

О.Цогтгэрэл: Тэр саяын дахиад л энэ судалгаа шинжилгээ дээр ажиллах хүчинд ер нь гадагшаагаа нийтдээ хэчнээн хэмжээний валют төлөөд байгаа юм. Гадагшаа энэ тоо баримтууд чинь ингээд хангалттай бус дутмаг ийм тоо баримтууд дээр бид нар ингээд дүгнэлт гаргаад байгаа байхгүй юу. Асуудлаа томоороо хараад, тэгээд яг хөрсөн дээрээ буусан энэ судалгаанууд чинь гарахгүй, тэр тоонуудыг мэдэхгүйгээр энэ шийдвэрүүд энэ дүгнэлтүүд яг яаж гарч байгаа вэ гэдэгт бол эргэлзэж байна.

Хоёрдугаарт нь ер нь өнгөрсөн долоо хоногт би нэг Улсын Их Хурлын даргад нэг тогтоолын төсөл өргөн барьсан. Тэр тогтоолын төслийн утга санаа бол зах зээлийн аргаар нь ААН-үүдийг цалин нэмэх хөшүүрэг хийе. Цалингаа нэмсэн ААН-үүдэд татварын тодорхой хэмжээний дэмжлэг олгодог болгоё. Төрөөс дэмжлэг бол татвар хөнгөллөө, ААН-үүд өөрсдөө ажилтныхаа цалинг нэмэх сэдлийг бий болгоё. Энэ зүгээр нэг шинэ санаачилга биш одоо Япон улсад хэрэгжиж байгаа ийм сайн туршилага юм байна л даа. Тэгэхдээ энэ чинь тодорхой хэмжээний маш олон зохицуулалтуудаар энийг бас давж гарах. Тэгэхээр энийг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад нэмж хариулъя. Нэмж хариулъя. Ажлын хэсэг Өнөрбаяр дарга.

Г.Өнөрбаяр: Цогтгэрэл гишүүний асуудал бол бас их чухал. Ер нь бол бид нар энэ ялангуяа нийгмийн даатгалтай ч холбоод энэ тэтгэвэр бага байна гэдэг ч юм уу энэ асуудлууд бол эцсийн дүндээ явж яваад эцсийн дүндээ бол цалин хөлстэйгөө уялдаж байгаа юм. Цалин хөлс бага байгаа

учраас тэтгэвэр бага байна. Тэтгэвэр бага тогтоогдохоор тухайн хүмүүсийн нийгмийн хамгаалал бас сайн хангагдахгүй байна гээд энэ бүх бодлогууд бол бас уялдаатай юм. Тийм учраас Монгол Улс бол цаашидаа ялангуяа энэ цалин хөлсний тогтолцоо, энэ цалин хөлсний бүтцийн бодлого дээрээ бол бас их ахиц дэвшил гарвал үр дүнд хүрнэ гэдэгтэй бол санал нэг байна. Өмнө нь бол бид нар нэг 15 оны үеийн судалгаагаар бол гадаадад ажиллаж байгаа Монголчууд бол жилд бол нэг 4.8 орчим сая долларын одоо бас мөнгөн шилжүүлгүүд хийгдсэн байна гэсэн ийм одоо сүүлийн тоо бол бас байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүнийг асуултаа асуусны дараа санал хаалтууд явагдах учраас гишүүд танхимдаа ороорой. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Энэ гадаадаас ажиллах хүчин авах, гадаадад ажиллах хүчин илгээх энэ одоо хуулийн төслийн төсөл хууль бол 2001 онд батлагдсан энэ хууль бол маш их хүнд сурталтай хууль. Тэгээд энэ хүнд сурталтай хуулиар би нөгөө Гадаадын харьяатын дарга байж байхдаа нэг асуудлыг цэгцэлсэн юм. Яасан бэ гэхээр Энхболд ах нөгөө сум болгонд нэг хос үүргэвчтэй нөхдүүд нэг шашин суртлаа яваад байдаг байсан шүү дээ. Сум болгонд явдаг. Тэгээд одоо ингээд шашны янз янзын проблем гаргадаг. Тийм одоо хүмүүс маш их байсан. Сум болгонд л явдаг. Тэгэнгүүт тэд нар яадаг вэ гэхээр нэг шашны сүм дээр бүртгэл бүртгээд ороод ирдэг. Тэгээд тэндээсээ хэдэн зуугаараа энд тэнд очиж ажилладаг ийм байсан. Манайх бол яах вэ шашны хувьд бол аль ч шашныг хүндэтгээд явдаг. Тэгэхдээ бас энэ бас цаашидаа ингэж хэт нэг талын шашны мормоны шашин одоо тэр шашныхан хэт орж ирж ингэж шашинд түгээх юм бол цаашидаа асуудалд орохоор байсан юм.

Тийм учраас энэ хуулийг ашиглаж байгаад яасан бэ гэхээр нөгөө шашны байгууллагад та нар хэрэв нэг одоо тэр

сумд ажиллах тэр хүнээ ажиллуулахын тулд 5 Монгол хүний цалин төл, НДШ төл гэсэн юм. Тэгээд шахчихсан чинь бүгдээрээ гараад явчихсан байхгүй юу. Өнөөдөр одоо тэр сум болгонд хосоороо явдаг энэ шашин сурталчилдаг хүмүүс одоо Монголд байхгүй болсон байгаа. Ийм нэг асуудлыг шийдсэн.

Нөгөө нэг асуудал нь нийтдээ 1990 оноос 2000 өнөөдрийг хүртэл одоо юу байдаг юм, 32 жилийн туршид Монгол Улсын төр 12000 гадаадын иргэнийг хууль бусаар ажиллаж амьдарч байсан гадаадын иргэнийг албадан гаргасан юм. Тэрний нэг хэсгийг энэ хуулийн дагуу бас гаргасан байхгүй юу. Тэрний 6000-ыг нь тэр 12000 гадаад иргэний 6000-ыг нь би 3 жил Гадаадын харьяатын даргаар ажиллахдаа гаргаж байсан. Энэ хуулийг ашиглаж. Монголчууд Монголдоо тайван амьдрах тэр боломжийг хангаж өгч байсан. Тэгэхээр энэ хуулиар хүмүүс яадаг вэ гэхээр нөгөө нэг гадаадын ажилчид оруулж ирнэ гэхээр Гадаадын харьяатын байгууллага руу л одоо та нар хүнд сурталтай байна энэ тэр гэж дайрдаг. Тэгээд хамаг гол асуудал нь нөгөө энэ нийгмийн хамгааллын яаман дээр Засгийн газрын тэр квот дээр, тэгээд одоо ингээд хуучин бас Хөдөлмөрийн яам энэ тэр дээр байдаг байсан байхгүй юу даа. Тэгээд энэ асуудлыг ялангуяа одоо гадаадаас нэг ажиллах хүчээ аваад одоо энд нарийн мэргэжлийн ажилтан ажиллуулахын тулд заавал 5 хүн ажиллуулах зайлшгүй шаардлагатай болно. Аль эсвэл 3, 4 хүн ажиллуулъя гэх дээр Засгийн газрын тогтоол гаргуулаад явуулалтай биш. Тэр компани одоо 5 хүн ажиллууллаа гэхэд 25 хүн хий НДШ төлдөг ийм л зохицуулалттай байсан. Тэгэхээр энэ асуудлуудыг яаж шийдвэрлэж байгаа вэ? Энэ ажиллах хүчний зөвшөөрөл олгох асуудлыг ялангуяа энэ яамны зүгээс яаж либералчилж байгаа вэ гэдэг дээр л та бүхнээс хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүний асуултад хэн хариулах вэ? Ажлын хэсэг Өнөрбаяр дарга хариулъя. 85 дугаар микрофон.

Г.Өнөрбаяр: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Нэгдүгээрт бол бид нар ялангуяа энэ шашины чиглэлээр орж ирж байгаа энэ ТББ-ын нэр дээр орж ирж байгаа хүмүүсээс 15 оноос бол одоо бас төлбөр хураамжууд бас авдаг болсон. Одоо бол тоонууд бол маш багасаад энэ асуудал бол цэгцэрсэн.

Энэ ажиллах хүчтэй холбоотой асуудлыг бол энэ хуулийн дагуу бид нар бол бүх үйлчилгээг бол цахим болгосон. Урьд өмнө нь бол олон байгууллагаас тодорхойлолт бичиг аваад ингээд олон шат дамжлага дамждаг байсан бол тухайн байгууллагууд одоо бүх бичиг баримтуудаа бүгдээрэнг нь цахимаар илгээгээд, тухайн одоо зөвшөөрөл хүссэн бичиг хаана явж байгааг одоо бүгдээрээ хойноос нь хянаад ингээд ААН-үүд байгууллагад бол ямар нэгэн хүндрэлгүйгээр одоо энэ асуудлуудыг бол бүрэн шийддэг болсон. Тийм учраас өөрөөр хэлбэл одоо бол ААН байгууллагууд дээр ямар нэгэн тийм хүндрэл үүсгэх тийм асуудал байхгүй. Бүх асуудал бол цэгцэрсэн гэдгийг бол бас хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлъя. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд суудлаа эзэлъя. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Бүртгэлийн санал хураалт явуулъя, санал хураалт. Байнгын хорооны саналаар Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хурааа. Санал хураалт. 53.7 хувиар санал дэмжигдлээ. Нямаагийн Энхболд гишүүний, санал, санал өгсөн боловч ороогүй юм уу? Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүллээ. Дараагийнхаа асуудалд оръё.

15.53 цаг

Найм.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын ерөнхий хууль, ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна. Аюурсайхан сайдыг индэрт урьж байна.

С.Аюурсайхан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс 1995 онд даатгуулагч бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр шимтгэл төлж сан бүрдүүлэх, уг сангаас төлсөн шимтгэл авч байсан цалин хөлстэйгөө уялдаатай тэтгэвэр, тэтгэмж авах агуулга бүхий нийгмийн даатгалын тогтолцоог шинээр бүрдүүлсэн нь нийгмийн хамгааллын салбарт хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг болсон юм. Нийгмийн даатгалын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 31 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх, ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн хувь хэмжээг өөрчлөх, нийгмийн даатгалын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зэрэг тэтгэвэр авагч, даатгуулагчийн эрх ашигт нийцсэн олон арга хэмжээг хуульчлан хэрэгжүүлсэн. Сүүлийн жилүүдэд нийгмийн даатгалын чиглэлээр авч хэрэгжүүлж буй зарим бодлого, үйл ажиллагаа болон ирээдүйд ирэх хүн амын насжилтаас хамааран нийгмийн

даатгалын сангийн зардал улам өсөж, тэтгэврийн даатгалын сангийн алдагдал нэмэгдэхээр байгаа тул нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн тогтвортой бие даасан байдлыг хангасан сангийн менежментийг хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Түүнчлэн Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн даатгалын тогтолцоог шинэчлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилтуудыг тусгасан нь энэхүү хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна. Иймд нийгмийн даатгалын харилцааг зөвхөн нийгмийн даатгалын хуулиар зохицуулах сангийн тогтвортой байдлыг бүрдүүлэх, уг хөрөнгийг эрсдэлгүй, үр өгөөжтэй удирдах, даатгалын сангийн бодит хуримтлалыг эхлүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх нийгмийн даатгалын санг бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгасан.

Мөн даатгалын сангийн хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, нэрийн дансыг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх, шимтгэлийн өр хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцооллыг хийх сангийн эрсдэлийг үнэлэх, санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах зэрэг зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллага, ажилтнуудын үүрэг хариуцлагыг

нэмэгдүүлж, үйл ажиллагаа нь ил тод нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг дээшлүүлэх зарчмыг хуулийн төсөлд тусгасан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжих, сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах боломж бүрдэх, түүнд тавих хяналт сайжрах, нийгмийн даатгалын засаглал оновчтой болж ажлын уялдаа холбоо хангагдах, даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн бодит хуримтлал үүсэх, ажил олгогч, даатгуулагчийн чиг үүрэг ойлгомжтой тодорхой болгох, нийгмийн даатгалын үйлчилгээ цахимжиж түргэн шуурхай, ил тод нээлттэй, хяналттай болно. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн төсөлтэй уялдуулан 49 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм. Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон иргэнд нэмэлт зардал үүсэхгүй юм. Харин хуулийг 2024 оноос хэрэгжүүлнэ гэвэл даатгуулагчийн төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн 2 хувийг мөнгөжүүлэх зориулалтаар тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн татаас 291.6 тэрбум төгрөг, зарим иргэдийн шимтгэлийг улсын төсвөөс хариуцахад 48.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэх тооцооллыг хийлээ.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг ишидвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоо, зарчим, төрөл, хэлбэр, хамрах хүрээг тогтоох, нийгмийн даатгалд даатгуулах, шимтгэл төлөх, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, уг сангийн хөрөнгийг хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох харилцааг тусгасан.

Мөн даатгалын сангийн хөрөнгө, хөрөнгө оруулалтын удирдлага, мэдээллийн нэгдсэн сан, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын итгэлцүүр, шимтгэлийг нөхөн төлүүлэх, буцаан олгох, тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, нэрийн дансыг мөнгөжүүлэх, мөнгөжүүлсэн орлогыг өвлүүлэх шимтгэлийн өр хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, нийгмийн даатгалын сангийн хэтийн тооцоолол хийх, сангийн эрсдэлийг үнэлэх, санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий мэргэжлийн хороог ажиллуулах, нийгмийн даатгалын байгууллага, ажилтнуудын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, үйл ажиллагаа нь ил тод нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг дээшлүүлэх зарчмыг хуулийн төсөлд тусгасан байна. Хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын хамрах хүрээ өргөжиж, сангийн чөлөөт үлдэгдэл хөрөнгийг санхүүгийн хэрэгсэлд оруулах боломж бүрдэж, түүнд хяналт тавих, сайжрах, нийгмийн даатгалын засаглал оновчтой болж ажлын уялдаа холбоо хангагдах, даатгуулагчид тэтгэврийн даатгалын шимтгэлийн бодит хуримтлал үүсгэх, ажил олгогч, даатгуулагчийн чиг үүрэг ойлгомжтой тодорхой болох, нийгмийн даатгалын үйлчилгээ цахимжиж, түргэн шуурхай, ил

тод нээлттэй болох бөгөөд төсөл батлагдсанаар улсын төсөвт 334 тэрбумын санхүүжилт шаардлагатай байгаа талаар тооцоолол хийгдсэн.

Хуулийн төслийг www.dparliament.mn цахим сайтад байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат нийгмийн даатгалын хөрөнгийг арилжааны банканд байршуулахад баримталж байгаа зарчим, сонгон шалгаруулалтын асуудал, Тэтгэврийн санг Баялгийн сантай уялдуулах, засаглал менежментийг сайжруулах чиглэлээр хуулийн төсөлд оруулж буй шинэчлэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг хуулийн төслийг боловсруулахтай холбогдох яамдын саналыг авсан эсэх талаар мөн хуулийн төслийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн санхүүжилтийн нөөц боломж байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг хуулийн төслийн гол менежментийн шинэчлэл болон салбарын эрдэмтэн судлаачдаас санал авсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн групп тогтоолгосон иргэдийг 2 жил тутам эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор оруулдаг байдлыг хэрхэн цэгцлэх, хуулийн төсөлтэй холбоотой гадаад орны туршилагыг судалсан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа тэтгэврийн нөөц сан болон сайн дурын давхар даатгалтай байх зохицуулалт шинэчилсэн найруулгын төсөлд хэрхэн туссан талаар, мөн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ гэртээ хардаг өрх толгойлсон ээжүүдийн НДШ-ийг төрөөс төлөх зохицуулалт хуулийн төсөлд туссан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Туваан хуулийн төсөлд тэтгэврийн зөрүүг арилгах чиглэлээр ямар зохицуулалт туссан талаар, богино хугацаанд өндөр шимтгэл төлж тэтгэврээ өндрөөр тогтоолгосон хүмүүсийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх, зөрүүг арилгах талаар эдийн засгийн тооцоолол хийгдсэн эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн

Жаргалмаа нийгмийн даатгалын санг сангийн Капитал банкнаас авах өр авлагын асуудал, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эхчүүдэд олгох тэтгэмжийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тэтгэмжийг 16 нас хүртэл олгож байгааг 18 нас болгож өөрчлөх талаар салбарын яам ямар бодлого баримталж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг Нийгмийн даатгалын санг Баялгийн сангаас нэг удаа мөнгөжүүлэх боломж, мөнгөжүүлэх боломж, тэтгэврийн нөөц сангийн болон сайн дурын давхар даатгалтай байх зохицуулалт, тэтгэврийн зөрүүг үе шаттай арилгах, тэтгэвэр бодох аргачлалыг шинэчлэх, засаглалыг сайжруулах талаар анхаарч ажиллах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хуулийн төслийг хэрэгжүүлэхэд нарийвчилсан тооцоо судалгаа хийх, Улсын Их Хурлын гишүүн Бейсен, Туваан нар тэтгэврийн зөрүүг арилгах, тэтгэврийн зээлтэй иргэд нас барсан тохиолдолд шимтгэл төлөлтийн хэмжээнээс хамаарч зээл төлөлтийн асуудлыг уян хатан зохицуулалт хийх шаардлагатай байгаа талаар тус тус саналаа илэрхийллээ. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 83.3 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмыг хууль хүчингүй болсонд тооцох тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй тооцсонд хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн 14 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 15 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 20 оны болон

21 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 он, 2020, 2021 оны төсвийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022, 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд сайд Төмөрбаатарын Аюурсайхан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Гомбосүрэнгийн Өнөрбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Амарсайханы Хишигбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг зохицуулалтыг газрын дарга Басангийн Батжаргал, НДЕГ-ын Бодлогын

хэрэгжилт судалгааны газрын дарга Цэнд-Аюушийн Ганцэцэг, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын дарга Бумчанагийн Даваахүү, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Сүхбаатарын Орхон, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Болдбаатарын Гэрэлсайхан нар оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Баттөмөр, Ц.Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа. Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд одоо өөрчлөлт оруулах шинэчилсэн найруулга орж ирж байгаа. Мэдээж энэ бол нийгмийн тэр чигтээ бүхэлдээ хүлээж байгаа хууль. Хүн амын цонх үе нээгдэж байна. 3 хөдөлмөр эрхэлж байгаа хүний нийгэмд төлсөн нийгмийн даатгал нэг хүний тэтгэврийг төлж байна гэдэг юм уу маш олон мэдээлэл бас иргэдэд маань байгаа. Нийгмийн даатгалын сан хөрөнгөгүй болсон байна гэдэг ийм мэдээлэл байгаа. Үнэхээр бид хөдөлмөрлөсөн хөлснийхөө төлсөн нийгмийн даатгалынхаа хэмжээгээр тэтгэвэр авдаг цаг хэзээ ирэх вэ гэдэг зүйлийг олон нийт маань асууж байгаа.

Өнгөрсөн ч чуулганаараа бид нар Ахмад настны тухай хууль болон Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг байгуулаад ажиллаж явахдаа хөдөө орон нутгаар явж ахмадуудтай уулзаж байхад тэтгэврийн зөрүүгээ хэзээ арилгах юм бэ? Хувь тэнцүүлсэн тэтгэврийн тогтолцоогоо хэзээ засах вэ гэдэг юм уу маш олон асуудлыг бидэнд тавьж байсан. Юутай ч энэхүү тэтгэврийн шинэчлэл хийхээр ийнхүү хуулийн төсөл маань чуулганы нэгдсэн хуралдаанаар орж ирж байгаад үнэхээр их баярлаж байна. Уржигдар бас

бид нар Байнгын хорооны хуралдаанаараа хэлэлцсэн. Хэд хэдэн асуудлыг ярьсан. Би нэгэнт олон нийтдээ мэдээлэл өгөх бас үүрэгтэй энэ чуулганы танхимд сууж байгаа учраас хэд хэдэн зүйлийг би дахин асууя.

Яг өнөөдрийн байдлаар нийгмийн даатгалын сангийн мөнгө хэчнээн хэмжээгээр тоологдож байна вэ? Бид өрширнийхээ асуудлыг эцэслэн шийдвэрлэж чадсан уу? Цаашидаа хуульд өөрчлөлт орсноор нийгмийн даатгалын сангийн үлдэгдэл үржих, өсөх тэр боломжийг бий болгож чадах уу энэ хуулийн төсөл маань. Нөгөө талаар гадаад улс оронд ажиллаж амьдарч байгаа иргэдийнхээ нийгмийн даатгалын асуудлыг хэрхэн яаж зохицуулах вэ? Өнөөдөр нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаа энэ хууль батлагдсанаараа зөв зохион байгуулалтад орж, бусад хууль бусад яамнуудтай харилцан хамааралтай байгаа асуудлуудыг шийдвэрлэж чадах уу, үгүй юу гэдэг нэг асуулт байна.

Нөгөө талаар, мөн Нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүний хувиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ асуудалд ихээхэн анхаарч ажиллаж байгаа. Энэ дээр хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ижгий аав бол хөдөлмөр эрхлэх ямар ч боломжгүй байдаг. Эдгээр ижгий аавыг нийгмийн даатгалд хамруулах тэр боломж хуулиар хэрхэн яаж зохицуулагдсан бэ? Зүйл заалт орж ирсэн байсан. Гэхдээ би олон нийтэд мэдээлэл өгөх үүднээс ийнхүү асууж байгаа.

Хоёрдугаарт нийгмийн даатгалаас тэтгэвэр тэтгэмж олгох бас хуулийн төсөл байгаа. Энэ дээр нэг зүйл заалт байгаа. 16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асарч байгаа ижгий аавд тэтгэмж олгодог. Уг нь Монгол Улсын хуулиараа Үндсэн хуулиар 1-18 нас хүртэлх хүнийг хүүхэд гэж нэрлэдэг байгаа. Гэтэл энэ хуулиар болохоор 16 хүртэл тэтгэмж олгогчлоод 18 нас хүртэл тэтгэмж олгохгүй байгаа. Энийг энэ зохицуулалтаар шинэчлэн засаж чадсан уу,

үгүй юу гэдэг зүйлийг асууя. Тэгээд дараа нь хариултаа авчхаад нэмж асууя. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Нийгмийн даатгалын сангийн энэ удирдлага менежмент, хяналт бол маш чухал л даа. Энэ бол ерөөсөө нийгмийн хамгааллын одоо том зорилго чиг үүрэгтэй. Энэ бол ашиг орлого олох ийм чиг үүрэг бизнесийн санаа байх ёсгүй. Хамгийн гол нь мэдээж энийг бол арвижуулах шаардлага бол байгаа. Гэхдээ арвижуулахдаа одоо хяналтдаа ингэж арвижуулна. Тийм учраас энэ хуулийн төсөл дээр энэ ямар одоо эх үүсвэртэй хөрөнгө оруулж арвижуулах уу гэдэг нь хамгийн түрүүнд одоо баталгаатай эх үүсвэр байх ёстой. Хоёрдугаарт энэ дээр нь бол олон нийтийн бас хяналттай хийх ёстой гэдэг зарчмыг барьсан.

Нэгдүгээрт бол Засгийн газрын үнэт цаас, хоёрдугаарт Төв банкны үнэт цаас, гуравдугаарт төрийн сан дахь одоо хадгаламжийн мөнгөн хадгаламж, дөрөвдүгээрт бол системийн ач холбогдолтой арилжааны банкиг Монголбанкны одоо зөвлөмжөөр гэсэн ийм одоо асуудлуудад хөрөнгө оруулахаар ийм зохицуулалтыг хийсэн байгаа. Нийгмийн даатгалын санг ер нь бол олон нийт бол их будилаантай, ер нь бол дампуурсан, мөнгөгүй байгаа, өртэй гэдэг ийм түгээмэл ойлголт бол байдаг. Бодит байдал дээр одоо нийгмийн даатгалын санд бол чөлөөт үлдэгдэл нь 993.2 тэрбум төгрөг байна. Энэнээс бол Тэтгэврийн даатгалын сан дээр 467 тэрбум, тэтгэмжийн даатгалын сан дээр 117.5 тэрбум, үйлдвэрлэл мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан дээр 362.1 тэрбум, ажилгүйдлийн даатгалын сан дээр 38.3 тэрбум төгрөг гээд ийм одоо чөлөөт үлдэгдлүүд байна.

Манай сан маань бол энэ 22 оны байдлаар бол ашигтай ажилласан байгаа.

Төлөвлөгөө бол 200 орчим тэрбум төгрөгийн алдагдалтай төслийг баталсан. Гүйцэтгэлээрээ бол ямар ч л байсан сан маань 100 шахам сая төгрөгийн одоо ашигтайгаар ингэж бол гарсан. Цаашидаа нийгмийн даатгалын санг аль болохоор одоо төсвийн татаас багатайгаар дотоод нөөц боломжоороо одоо ингэж удирдлага, зохион байгуулалтыг нь зөв менежментийг хийснээр үр дүнтэйгээр ингэж авч явах боломжтой гэж ингэж үзэж байгаа. Энэ чиглэлээр олон одоо зохицуулалтууд шинэ хуулийн төсөлд орсон байгаа. Улсын төсвийн татаасаар нийгмийн даатгалын сан бол зөвхөн одоо энэ 1995 оноос өмнө одоо тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэвэр мөн түүнчлэн цэргийн албан хаагчдын тэтгэврийн одоо улсын төсвөөс олгодог. Энэ тоог бол бид 2022 онд 950 орчим тэрбум төгрөгийг улсын төсвөөс авч байсан бол 2023 онд үүнийг багасгаад 540 орчим тэрбум төгрөгийг одоо авч байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн одоо татаасыг бууруулах энэ зарчмыг бид нар хэрэгжүүлж байгаа.

Үндсэндээ 2019 онд энэ нийгмийн даатгалын санд төсвөөс олгож байгаа татаас бол төсвийн орлогын 9.2 хувь байсан. Дэлхийн банк бол тэр үед нь 2050 он гэхэд энэ төсвийн татаас чинь төсвийн орлогын 37 хувь болох нь байна гэдэг анхааруулгыг өгч байсан. Бид одоо энэ зүй зохистой энэ менежментийг хийсний үр дүн дээр энэ тоо ихсэх биш, харин 2023 онд төсвийн нийт орлогын 2.7 хувьд одоо барьж, ингэж одоо төсвийг баталж хэрэгжүүлж байна. Энэ юуны асуудлууд дээр ажлын хэсэг дээр нэмээд хариулъя.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуултад ажлын хэсгээс нэмж хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя. Ажлын хэсгийн 85 дугаар микрофон. 83.

Г.Өнөрбаяр: Жаргалмаа гишүүний асуултад бас нэмж тодруулъя. Сүүлийн үед бол энэ нийгмийн даатгалын сан алдагдалтай явж ирсэн. Улсын төсвөөс ихээхэн хэмжээний татаас өгч байгаа гэсэн ийм буруу ойлголт бол бас байгаа.

Энэ бол одоо тийм зүйл байхгүй гэдгийг бол хэлье. Сүүлийн жилүүдэд бол нийгмийн даатгалын сан бол улсын төсвөөс ямар нэгэн татаас аваагүй өөрөө өөрийгөө болгож ирсэн. Улсын төсвөөс өгч байгаа татаас бол 1995 оноос өмнө тэтгэвэрт гарсан хүмүүс, цэргийн албан хаагчдын тэтгэвэрт өгч байгаа мөнгөн дүнгүүд бол манай сан дээр тавигддаг учраас ингээд алдагдалтай юм шиг одоо бас харагдаад байдаг. Энэ мөнгө бол одоо ийм 2 зориулалтаар өгч байгаа гэдгийг хэлье.

Энэ бас нэг зүйлийг бас тодруулж хэлэхэд бол 16, 17, 18, 19 онуудад бол улсын төсвөөс мөнгөн дүнгүүд өгсөн. Энэ мөнгөн дүнгээ Ковидын үеэр бол 917 орчим тэрбум төгрөгийг ковидын үеэр чөлөөлсөн. Энэ чөлөөлсөн мөнгө бол нийгмийн даатгалын сангаас гарахдаа улсын төсвөөс өгсөн татааст нь одоо ингээд шилжүүлэн суутгасан. Дүгнэж хэлэхэд бол одоо сүүлийн жилүүдэд бол нийгмийн даатгалын сан бол улсын төсвөөс ямар нэгэн татаас аваагүй, өөрөө өөрийгөө бүрдүүлж ирсэн. Түрүүн манай сайд бол одоо бас хэлсэн. Нийгмийн даатгалын сангийн харилцахын үлдэгдэл бол нэг 990 гаруй тэрбум төгрөг байгаа. Дээр нь нэмээд ААН байгууллагуудаас авах авлага бол одоо сүүлийн байдлаар бол нэг 364 тэрбум, энэ банкнуудаас болон авах ёстой мөнгөн дүн бол 171 тэрбум төгрөг гээд. Ингээд манай сан бол одоо бас боломжийн байгаа гэдгийг хэлье.

Дээр нь нэмээд энэ гадаадад байгаа иргэдийг бас нийгмийн даатгалд хамруулах талаар бол энэ хуулийн төсөл дээр бол бас бичсэн. Бид нар бол нийгмийн даатгалын бүх үйлчилгээнүүдийг цахимжуулаад, дэлхийн аль ч улс орноос бол нийгмийн даатгалд хамрагдах энэ боломж бололцоонууд бол бүрэн нээгдсэн. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол одоо 6 улстай бол нийгмийн хамгааллын хэлэлцээр бол байгуулсан. Энэ бол Монголчууд хамгийн ихээр одоо оршин суудаг Чех, ОХУ, Турк, Солонгос, Польш, Унгар гэсэн 6 улсуудтай бол нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулсан. Энд

ажиллаж амьдарч байгаа иргэд бол тухайн улсад ажилласнаа улсад тооцуулах, мөн 2 улсаас тэтгэвэр авах энэ боломж бололцоонуудыг бол одоо бид нар бүрэн нээж өгсөн.

Цаашид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам Швед болон бусад Монголчууд хамгийн ихээр Казахстан гээд Австри, Канад гээд Монголчууд хамгийн ихээр оршин сууж байгаа улс орнуудтай нийгмийн хамгааллын хэлэлцээр байгуулах талаар бол одоо гэрээ хэлэлцээрүүд бол хийгдээд явж байгаа. Мөн энэ хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ хараад гэртээ сууж байгаа эцэг эхчүүд байгаа. Ажил хөдөлмөр хийж чадахгүй зайлиггүй одоо хүн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдээ хараад ингээд гэртээ суух зайлиггүй шаардлага байдаг. Энэ хүмүүсийг бол бид нар энэ удаагийн шинэчилсэн найруулгын хүрээнд бол одоо тэтгэврийн даатгалын шимтгэлийг нь бол улсаас бүрэн даахаар бол одоо бас оруулж ирж байгаа гэдгийг бол одоо бас танд хэлье. Ерөнхийдөө бол сая ийм зүйлүүд яригдсан гэж ойлголоо.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүн тодруулж асуух уу? Жаргалмаа гишүүн тодруулж асууя.

Б.Жаргалмаа: Би түрүүн нөгөөдөх 16, 18 насны тэтгэмжийнхээ юу хариултыг авчихъя. Тийм ээ. Нөгөө талаар энэ даатгалын тогтолцоо маань сайн дурын болон албан журмын гэсэн 2 юутай зохицуулалтайгаар орж ирж байгаа. Хувийн тэтгэврийн сан бүрдүүлэх, давхар даатгалтай байх тэр боломжийг яг энэ хуулийн зохицуулалтаар хийгдэж байгаа болов уу? Энэ дээр тайлбар авъя? Тэгээд олон нийтдээ бас мэдээллийг өгөхдөө тэтгэврийн шинэчлэлийг хийх реформ хийх энэ ажил ийнхүү Улсын Их Хурлын чуулганаар эхэлж байгаа гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Ямарваа нэгэн байдлаар эцсийн шийдвэр гаргах хэлэлцүүлгийн шат үргэлжилнэ. Зүгээр яагаад би энийг хэлээд байна вэ гэхээр олон нийтэд маань нэг мэдээллийг авангуутаа тэр мэдээллээрээ

иргэд олон нийтэд шаардах тийм ээ, ийм нөхцөл байдал үүсгэдэг учраас хэлэлцүүлэг эхэлж байгаа шүү гэдгийг бас хэлэхийг хүсэж байна. Баярлалаа та бүхэндээ.

Л.Мөнхбаатар: Жаргалмаа гишүүний асуусан асуултад нэмж хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгье.

Л.Өнөрбаяр: Хүүхдээ гэртээ хараад ажил хөдөлмөр хийж чадахгүй байгаа ээжүүдийн одоо нөгөө нэг хүүхдүүд нь 16 насаараа байна уу, 18-аар одоо төлөх юм уу гэдэг асуудал яригдаж байна. Манайх бол хууль дээр бол хүүхэд бол 18 нас гээд орсон учраас яг 18 насаараа ингээд зохицуулалт хийгээд оруулж ирсэн гэдгийг хэлье. Бид нарын оруулж ирж байгаа Монгол Улс бол олон давхаргат тэтгэврийн тогтолцоотой байна гэж томъёолж байгаа. Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр ч гэсэн ийм байгаа. Бид нар бол олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бол санал болгож байгаа. Энэний 3 дахь давхарга нь бол Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль байгаа. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийг бол сайн дураар байхаар бол бид нар хуулийн төслийг оруулж ирсэн.

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Өнгөрсөн хавар Засгийн газраас өргөн барьсан Нийгмийн даатгалын багц хууль, миний өргөн барьсан 4 хууль, нийгмийн даатгалтай холбоотой 4 хууль, нэг тогтоолын төсөл төсөлтэй эсрэг тэсрэг байр суурьтай байсан учраас Засгийн газар аргагүйн эрхэнд татаж авч авсан байгаа. Тэгээд энэ одоо багц хуулийг Аюурсайхан сайд сайд болонгуутаа маш хурдтайгаар энэ асуудлыг оруулж ирж байгаад баяртай байна. Тэгэхээр Монгол Улсын Их Хурлын гишүүд орон нутагт очиж уулзалт хийгээд тэр иргэдийнхээ саналыг энэ одоо чуулганы танхимд илэрхийлдэг. Тэгээд би энэ ба нийгмийн даатгалын багц хуулийг уншаад нэлээн тэмдэглэл хэлсэн. Тэгээд дээрээс нь энэ

чуулганд суудаг учраас бас энэ гишүүдийн ярьдагтай бас харьцуулж бас ямар зүйл ярьдаг вэ гэдгийг нь бас хэлж, ямар шинэчлэл хийсэн юм бэ гэдгийг хэлье.

Олон давхарга, давхаргад тэтгэврийн тогтолцоонд шилжих олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бүрдүүлнэ гэж 10 дугаар тойргийн Тогтохсүрэн ярьдаг. Тэтгэвэр бодох 5, 7 жилийг 5 жил болгоно гэж миний өргөн барьсан хууль одоо энэ хуультай хамтатгаад хэлэлцэгдээд явна. Тийм. Тэтгэврийн зөрүүг арилгах асуудлаар нэгдүгээр тойргийн Тэмүүлэн гишүүн идэвхтэй ярьдаг байгаа. НДШ-ийг нэмэхгүй гэж, өөрөөр хэлбэл ОУВС-ийн хөтөлбөрт ороход л Баттөмөр 16 дугаар тойргийн Баттөмөр гишүүн энэ асуудлыг эсэргүүцэж ярьж байсан. Өнөөдөр хүртэл энэ байр суурин дээр байж байгаа. Малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийг шимтгэлийн 5 жилийг 50 хувийг улсаас төлнө гэдэг энэ асуудлаар 3 дугаар тойргийн Адьяасүрэн гишүүн ярьж байсан. Жил бүр ахмадын тэтгэвэр инфляцын түвшинтэй уялдан автоматаар нэмнэ гэдэг ийм энэ хуулийг бол би Их Хуралд өргөн барьчихсан байж байгаа.

Дээрээс нь ЗГХЭГ-ын сайд Амарбаясгалан сүүлийн үед энэ талаар ярьж байгаа. Олон жил ажилласныг урамшуулдаг тэтгэврийн бодолтыг оруулсан байна. Цалингийнхаа 80 хүртэл хувиар тэтгэврээ авдаг болно гэдэг энэ асуудлыг 28 дугаар тойргийн Анужин гишүүн ярьж байсан. Ихэр хүүхдийн ээжийн амаржсаныг амарсны тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх асуудлаар 26 дугаар тойргийн Одонтуяа гишүүн хэд хэдэн удаа санал гаргаж ирснийг та бүхэн мэдэж байгаа. Даатгуулагчийн нэрийн дансыг мөнгөжүүлнэ. Мөнгөжүүлсэн тохиолдолд өвлөгдөнө гэж 14 дүгээр тойргийн Батжаргал гишүүн ярьдаг. Яг энэтэй агуулга бүхий Хамтын тэтгэврийн тухай хуулийг бас миний бие өргөн барьчихсан байж байгаа. Нийгмийн даатгалын сангийн мөнгийг найдвартай санхүүгийн хэрэгсэлд

оруулна гэж яг энэ асуудлаар Ганибал гишүүн бид хоёр 12 дугаар тойргийн Ганибал гишүүн бид хоёр Монголбанкны үнэт цаасанд нийгмийн даатгалын чөлөөт үлдэгдлийг байршуулах тогтоолын төслийг өргөн барьчихсан байж байгаа.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлдвэрлэлийн осолд орсон иргэдийн сул зогсолтын шимтгэлийг чөлөөлөх асуудлаар 27 дугаар тойргийн Жаргалмаа гишүүн удаа дараа ирж байгаа. Хувийн нэмэлт тэтгэврийг хүлээн зөвшөөрнө гэдэг энэ асуудлаар Учрал гишүүн 28 дугаар тойргийн Учрал гишүүн удаа дараа ярьсныг та бүхэн мэдэж байгаа. Нийгмийн даатгалын засаглал менежментийг олон улсын жишигт хүргэх тухай асуудлаар бол 23 дугаар тойргийн Булгантуяа гишүүн санал гаргаж байсан. Тэгээд энэ нь одоо нийгмийн даатгалын багц хуулийг улс төрийг улс төрчийн одоо зангаргаар зоригтой шинэчлэл хийж, ялангуяа бага ард түмний төлөөлөл болсон Их Хурлын гишүүдийн саналыг тусгаж оруулж ирж байгаа Аюурсайхан сайддаа энэ Их Хурлын гишүүдийн өмнөөс бас талархал илэрхийлье. Мөн салбарын асуудлаа сайн мэдэж ажиллаж байгаа Төрийн нарийн бичгийн дарга Өнөрбаяр, мөн НДЕГ-ын газрын дарга Ганцэцэг дарга та нарт бүгдэд нь баяр хүргэе. Тэгээд энэ хаврын чуулганаар заавал энэ хуулиа тал талаас нь дэмжиж, батлахын төлөө Их Хурлын.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Пүрэвдорж гишүүн үг хэлчихлээ. Одоо Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Монголын энэ тэтгэврийн тогтолцоог өөрийг нь тэтгэвэрт гаргая, энэ тэтгэврийн тогтолцоогоо шинэчилье, энэ тэтгэвэрт гарах болчихлоо. Өөрчлөх болчихлоо гэдэг эрэлт хэрэгцээ шаардлага одоо бүхий л зүйл өнгөрсөн багагүй хугацаанд бага биш хугацаанд бараг энэ 30 жилийн асуудал болж яригдаж одоо ч гэсэн дөнгөж хэлэлцэх эсэх нь ингээд орж ирж байна л даа. Тэгэхээр яг энэ хуулийн үзэл санаа яг

юу вэ? Одоо бид нар нэг тийм цалингаас тэтгэвэр тогтооно энэ тэр гээд, яах вэ эд нарыг одоо цаг үеийн асуудлуудыг яриад хэлээд явах л байх л даа. Тэр төлсөн хуримтлал хуримтлалаасаа шимтгэлээсээ дансан дахь мөнгөнөөсөө тэр цалин, тэтгэврээ авдаг тэтгэврээ тогтоолгодог авдаг энэ хуримтлалын тогтолцоо руу хагас хуримтлалын тогтолцоо руу шилжихэд энэ хуулийн үзэл санаа яг яаж ямар өөрчлөлтүүд өнөөдөр хийгдэж байгаа вэ?

Тэрнээс биш цалингаас тэтгэвэр тогтооно гэдэг бол яг үнэндээ эв хамтын тогтолцоо гэж хэлдэг арга ядсан л зүйл шүү дээ. Яг өнөөдрийн байгаад Монгол Улсын тэтгэврийн тогтолцоогоор нийт тэтгэвэр авч байгаа иргэдийг нь одоо хэд нь байна уу, бараг 80, 90 хувь нь тэтгэврийн доод хэмжээ авдаг. Энэ нь тэтгэвэр биш одоо үндсэндээ тийм тэтгэмжийн тогтолцоо болоод хувирчихсан нөхцөл байдал. Энэ дээр тэр яг бодлогын үзэл баримтлалын ямар шинэчлэл одоо энэ дээр хийгдэж байгаа вэ?

Хоёрдугаарт нь яг энэ тэтгэвэр шимтгэлээс тооцоод эв хамтын сангаас дундын сангаас одоо нэг тэтгэмж аваад явж байхад энд нэг том асуудал, төрийн тусгай албан хаагчид гээд нэг бүхэл бүтэн бол арми байдаг. Энэ хүмүүс яг одоо цалин авч байгаа үедээ НДШ-ээ бичилт хийлгээд чөлөөлөгддөг. Улсаас төлдөг, төлдөг ч юу байх вэ төлдөггүй. Цалин тэтгэвэрт гарч байгаа хугацаа бусад салбарынхнаас өөр. Дахиад тогтоолгож байгаа хувь хэмжээ 40 биш 80 хувь байдаг гээд. Энэ чинь хэн нэгний төлсөн тэтгэмжээс л шимтгэлээс л явж байгаа шүү дээ. Тэгэхээр энэ ялгаатай байдлууд дээр ямарваа нэгэн ийм шударга ёсны зарчим дээр энд ямарваа нэгэн өөрчлөлтүүд энд байгаа юу? Яг одоо байгаа шинэчлэл дээр. Нөгөө талд нь тэр хуримтлалын болоод хагас хуримтлалын тогтолцоо руу ороход энэ хууль ямар бодит алхмууд хийж байгаа вэ?

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Одоо манай тэтгэврийн тогтолцоо бол энэ хуваарилалтын тогтолцоо байгаа. Эв санааны зарчим дээр үндэслэсэн. Тэгэхээр энэ бол цаашидаа бас олон жил явах боломжгүй болж байна. 1960 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон хүмүүс бол энэ эв санааны одоо зарчмын дагуу тэтгэврээ тогтоолгоод ингээд явж байгаа. 1979 оноос хойш төрсөн иргэд бол одоо ингээд нэрийн дансны аргаар буюу энэ хуримтлалын зарчмаараа тэтгэврээ авахаар бид зохицуулалт хийгээд одоо анх 2029 оноос эхлээд ингээд тэтгэвэр нь тогтоогдоод явах юм. Эдгээр 60-97 онд төрсөн хүмүүс бол сонголтоороо. Бидний хийсэн тооцооллоор бол энэ бид энэ эрх зүйн шинэчлэлээ одоо нэн яаралтай хийж, хийсвэр байгаа нэрийн дансыг мөнгөжүүлж, тэрийг одоо санхүүгийн эргэлтэд оруулдаг нөөц хувилбаруудыг хуримтлал бий болгодог, байгалийн баялгаасаа хуримтлалын сан бий болгож ингэж зохицуулалтыг хийхгүй бол эргээд одоо энэ тэтгэвэрт нэрийн дансны аргаар гарч байгаа хүмүүс бол хэтдээ бас тэтгэвэр нь багаар тогтоогдох эрсдэлтэй болох юм.

Тийм учраас энэ хуваарилалтын тогтолцооноосоо хуримтлалын тогтолцоонууд руу шилжинэ. Ингэхдээ бүтэн хуримтлалын тогтолцоонд шилжихэд бол цаг хугацаа байгаа. Гэхдээ бид нар энийг бол хийхээр одоо эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа. Нэн яаралтай хагас хуримтлалын тогтолцоонд одоо шилжих шаардлагатай. Энэ чиглэлээрээ хуулийн төслөө одоо боловсруулсан байгаа. Хамгийн түрүүнд одоо энэ хууль батлагдаад энэ нэрийн дансыг мөнгөжүүлнэ. Энэ бол маш том ажил. Одоогийн байгаа төлж байгаа шимтгэлийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төлөгдөж байгаа шимтгэлийн 2 хувийг нь одоо энэ нэрийн дансыг одоо

мөнгөжүүлэхэд бид нар хэрэглэх юм. Энэ дээр бол одоо улсын төсвөөс жилдээ нэг 300 орчим тэрбум төгрөг орох юм. Сангийн яамтайгаа бид тооцоогоо нийлсэн.

Хоёрдугаарт бид байгалийн баялгаасаа энэ иргэдэд очих ёстой. одоо энэ үр шимийг нь хуримтлалын сан бий болгоод, энэ энүүгээрээ дамжуулаад одоо энэ нэрийн дансыг мөнгөжүүлэх юм. Иргэдийн нэрийн дансыг. Одоогийн байгаа эрх зүйн орчин нь ганцхан эрх зүйн орчин нь Ирээдүйн өв сангийн тухай хууль 2029 оноос хэрэгжинэ. Жил болгон улсын төсөвт байгалийн баялгаас тодорхой тооны мөнгө хуримтлуулна. Энэ мөнгөнөөс нь иргэдийн нэрийн дансыг мөнгөжүүлэхэд хэрэглэхээр зохицуулсан байгаа. Удахгүй Баялгийн сангийн хууль бас батлагдаад хэлэлцэгдээд ирэхээр мөн бид энэ тэтгэврийн нэрийн сан, данс одоо энэ хуримтлалын сан руугаа оруулах нөхцөлийг нь бүрдүүлнэ. Ингээд зөвхөн нийгмийн хамгаалал, тэтгэврээ аваад зогсохгүй орон сууц, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсролын үйлчилгээг мөн нэрийн данснаас авч хэрэгжих ийм томоохон шинэчлэлийн суурийг нь бид нар бас тавьж өгч байгаа юм.

Хоёрдугаарт энэ үндсэндээ энэ Нийгмийн даатгалын ерөнхий хуулиараа нийгмийн даатгалын бүх харилцаа явагдах ёстой. Таны тавьж байгаа зарчим маш зөв. Тэгэхээр энэ бол үндсэндээ сая төсвийн реформ юу болсон юм бэ гэх юм бол гишүүд тойрог руугаа төсвийн мөнгөнөөс татахгүйгээр төрийн нэгдсэн бодлогоор төсвийг зарцуулах бид нар энэ суурийг нь тавиад хэрэгжүүлээ шүү дээ анхны. Энэний дараагаар Засгийн газар цалингийн реформыг эхлүүлсэн I сарын 1-нээс. Салбар болгон сайд болгон салбар руугаа хуулиараа өөрөөр цалингийн шатлал авдаг биш төрийн албаны нийгмийн Хөдөлмөрийн яамны одоо бодлогоор бүх одоо салбарууд нэгдсэн нэг цалингийн бодлогоор явж байна. Энэ суурийг нь бид нар тавьсан. Цаашидаа энэ суурин дээрээ бид нар цалингийн нэмэгдлийг одоо үргэлжлүүлнэ.

Энэтэй нэг адил салбар салбараараа одоо өөр, өөр нийгмийн даатгалын харилцааг зохицуулсан асуудлыг цэгцлээд зөвхөн нийгмийн даатгал хүн бүр одоо шүүхийн өмнө хуулийн өмнө эрх тэгш гэж заасан мөртөө зарим ахмадууд нь өөр зохицуулалттай, зарим нь өөр зохицуулалттай байж таарахгүй гэдэг зарчмыг баримталж байгаа.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Түрүүн ТНБД-ын хариултад нэг гарч байна лээ л дээ. Улсын төсвөөс нийгмийн даатгалын сан татаас авахгүй байгаа гэж. Одоо миний санаж байгаагаар бараг нэг их их наяд шахуу 800-гаад тэрбум ч билүү төгрөг 23 онд сууж байсан санагдаж байна. Тэгэхээр энэ мөнгөний задаргаа яг ямар бүтцэд яваад байгаа юм бэ? Тэр түрүүний тэр төрийн тусгай албан хаагчидтай холбоотой нэмэлт зардал байна уу? Яг тэр татаасны задаргааг та нэг хэлж өгөөч. Үнэхээр энэ бол төсөвт асар том дүн явж байсан. Бараг нэг их наяд төгрөг явж байгаа шүү дээ. Нэг их наядыг улсын төсвөөс татвар төлөгчдийн мөнгөөр уг нь бол хуримтлалаар явах ёстой энэ санг санхүүжүүлээд л явж байгаа шүү дээ.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Аюурсайхан сайд хариулъя.

О.Цогтгэрэл: Одоогийн хүчин төгөлдөр нийгмийн даатгалын хууль бол 1994 онд батлагдаад, 1995 оноос эхлээд хэрэгжсэн байгаа. Тэгэхээр энэнээс өмнө одоо төр яаж явсан гэх юм бол 95 оноос өмнө одоо энэ төрөөс нийгмийн даатгалыг хариуцаж байсан. Тэгээд энэ бол ажил олгогч болон даатгуулагч хувь хэмжээгээрээ 95 оноос эхлээд зохицуулсан. Тийм учраас 95 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг төр хариуцаж байгаа. Үүний зэрэгцээгээр цэргийн албан хаагчдын тэтгэврийг төр хариуцаж байгаа. Тэр бол өөр зохицуулалттай явж байгаа. Энэ

хүмүүсийнхийг төр хариуцаж байгаагийн хувьд нийгмийн даатгалын санд одоо зохих төсвийг нь бүрдүүлдэг. Энэ нь 2022 онд 955 орчим тэрбум төгрөг байсан бол 2023 онд бид бууруулаад 550 орчим тэрбум төгрөг болгоод бууруулсан байгаа гэдгийг танд хэлье. Нийгмийн даатгалын сангийн одоо тэнцэл энэ жил 22 оны хувиар бол ашигтай гарсан байгаа. Зуу орчим сая төгрөгийн.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Нийгмийн даатгалын ерөнхий хууль хуулийн шинэчилсэн найруулга орж ирж байна. Дагалдах одоо багц хуулиуд орж ирж байна. Оройтож байна энэ хууль орж ирэлт нь. Аль хэзээний орж ирсэн, тэгээд татаж авч аваад удахгүй оруулж ирнэ гэсэн тэгээд оройтож байна. Яагаад оройтож байна гэхээр энэ хооронд чинь одоо маш их юм боллоо. Ковид боллоо, дээрээс нь инфляц галзуурлаа. Юмны үнэ галзуурлаа. Ингээд нөгөө бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500000 болгоод, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400000 болгоод ингээд явсан энэ ажил маань ямар ч үр дүнгүй болчихлоо. Инфляцад энэ юмны өсөлтөд энэ тэтгэврийн одоо нэмэгдэл чинь буцаад идэгдчихлээ. Тэгэхээр бол оройтож байна гэж хэлж байгаа нь ийм учиртай. Хэдэн тодорхой асуултууд асууя.

НДШ гээд байгаа. Одоо иргэн өөрөө төлж байгаа, ажил олгогч төлж байгаа, дээрээс нь сайн дураар бас төлж байгаа. Энэ хуулийн чинь концепц дээр энэ шимтгэлийг ер нь уртдаа ер нь юу гэж харж байгаа юм бэ? Нэмэгдэх юм уу, хасагдах юм уу, энэ хэвэнд нь барих юм уу? Энэ дээр нэг тодорхой хариулт авъя.

Хоёрдугаарт энэ одоо Хамтын тэтгэврийн тухай хууль гээд хууль хэрэгжиж байгаад АН-ын үед санаачлаад хэрэгжиж байгаад энэ хуулийг одоо хүчингүй болгосон. Энэ хууль амьдралд бол маш хэрэгтэй хууль байсан юм. Хоёулаа зэрэгцээд бүх одоо мөнгөө зардлаа төлж явж байгаад нэг нь хорвоогийн мөнх бусыг

үзүүлэхээр нөгөөдөх дээр нь бүх ачаалал шууд ирж байгаа энэ асуудал үүсчхээж байгаа юм. Тэгэхээр энэ дээр компенсац хийсэн ийм хууль байсан. Тэгэхээр энэтэй адил ямар одоо зохицуулалт энэ хуулиуд дотор чинь орж ирж байгаа вэ? Энэ дээр ер нь зөв байсан юм уу, буруу байсан юм уу гэдэг дээр нэг хариулт авъя.

Хоёрдугаарт яг энэ хууль чинь хэрэгжээд ингээд эхэлнэ. Одоо юуны хуваарилалтын тогтолцооноосоо хуримтлал руу хагас хуримтлал руу орно л гээд байна. Олон давхаргат тэтгэврийн тогтолцоо руу орно л гэж байна. Яг тэтгэвэр авагчдын тэтгэвэр нэмэгдэх үү, хасагдах уу? Та хэд нэг одоо шулуухан хэлээдхээч. Сайн дураар төлж байгаа хүмүүсийн тэтгэвэр нэмэгдэх үү, хасагдах уу? Энэ дээр нэг хариулт авмаар байна.

Дараагийн тодорхой асуулт бол энэ бүгд манай хөгшчүүдийн нэг ярьдаг асуудал чинь энэ тэтгэврийн зээл шүү дээ. Тэтгэврийн зээлийг ерөөсөө өөрсдөө хэрэглэдэггүй манай Монголчууд ач зээ нар хүүхдүүддээ машин тэрэг, сургуулийн төлбөр аваад л ойр зуурын юманд маш урт хугацаагаар ингээд аваад өгчихдөг. Тэтгэврийн зээлийн яг одоо хэдэн тэтгэвэр авагч хэдэн төгрөгийн зээлтэй байна вэ? Нөгөө Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар тэтгэврийн зээл тэглэснээс хойших хугацааны асуудлыг би асууж байна.

Таваас юу, тэтгэврийн одоо бодох жилийг 7 жилийг 5 жил болгож байгаа энэ одоо зохицуулалт нь хууль дотор орж ирж байгаа гэж ингээж ойлгож байгаа. Тэгэхээр энэ одоо зохицуулалтын хүрээнд одоо өмнө нь одоо 7 жилээр тогтоолгочихсон хүмүүсийг 5 жилээр бодохдоо нөхөн энэ асуудлыг нь одоо тооцох уу? Өмнө нь энэ хуулиар одоо хууль өөрөөр хэлбэл арагшаагаа яаж хойшоо ухарч үйлчлэх үү гэдэг ийм асуултыг асууя.

Монгол Улс одоо энэ Нийгмийн даатгалын хууль, хуультай явж байгаа. Дээрээс нь энэ Нэрийн дансны хууль гээд

хуультай. Энэ ерөөсөө хүчингүй болоогүй, хууль хэрэгжээд явж байгаа. Тэгээд энэ нэрийн дансанд чинь одоо мөнгө байна уу? Хэдэн одоо их наяд төгрөгийн одоо хуримтлал энэ нэрийн дансанд чинь байх ёстой юм бэ? Энэ асуудлыг одоо энэ хууль оруулж ирж байгаа энэ салбарын яам, Сангийн яамны зүгээс одоо яг энэ асуудал дээр ямар байр суурьтай хандаж байна вэ? Хууль маань хэрэгжээд байдаг, сан нэрийн данс мөнгөгүй байгаад байдаг. Тэгээд хэдүүлээ хуримтлалын тогтолцоо.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Туваан гишүүний асуултад хариулъя. Бид ер нь одоо урт хугацаандаа НДШ-ийн хувь хэмжээг нэмэгдүүлэхгүй. Хувь хэмжээ бол хэвээрээ байна. Гагцхүү тэтгэвэрт гарч байгаа хүмүүс бол тэтгэвэр нь одоо нэмэгдэх энэ нөхцөл боломж нь бол энэ хуулийн үр дүнд бол бодитоор бий болно. Ямар эх үүсвэрээс вэ? Нэгдүгээрт таны хэлдэг тэтгэврийн дунджийг одоо 2019 оноос эхлээд одоо 6, тэгээд 7 жилээр одоо тооцсоноос болоод одоо бид тооцоо хийсэн. Энэ нэг тэтгэвэр авагч дээр бол нэг жар дунджаар жар орчим мянган төгрөгийн одоо ийм одоо зөрүү үүссэн. Бид 5 жилээр дунджийг тооцдог болохоор 19 оноос өнөөдрийг 22 оныг дуустал нийтдээ 48 орчим мянган ахмадуудын тэтгэврийг бол залруулах ийм шаардлагатай байгаа. Илүү багаар тогтоогдсон байгаа хүмүүсийг. Энд бол бид асуудлыг шийднэ. Мөн түүнчлэн энэ 23 онд бол нэг 20 орчим тэрбум төгрөгийг бид энэ одоо бага тогтоогдсон хүмүүсийг одоо нөхөж олгох дээр 19-өөс 22 онд бол нэг 60.4 тэрбум төгрөгийг одоо нөхөж олгохоор бид Сангийн яамтай тооцоогоо нийлүүлсэн. Энийг бол хууль хэрэв батлагдах юм бол нөхөж олгоод ингээд явна.

Хамгийн гол таны асууж байгаа одоо хамтын тэтгэврийн зарчим тэтгэвэр өвлөгддөг байх энэ зарчим бол таны ярьж байгаа нэрийн дансыг мөнгөжсөн байхтай

нягт холбоотой юм. Одоо нэрийн данс мөнгөжсөн үү үгүй, хийсвэр бичилттэй. Тэгэхээр бид нар энэ хамтын тэтгэврийн зарчим мөн тэтгэвэр өвлөгддөг байхыг энэ асуудлыг бол дэвшүүлж байгаа. Хэрэв одоо хань ижил нь одоо нас барах юм бол хань ижил нь тэтгэвэр нь одоо шууд 20 хувиар нэмэгдэж байхаар нэгдүгээрт. Хоёрдугаарт энэ тэтгэвэр нь бол одоо тодорхой хувь хэмжээгээр өвлөгддөг байхаар зохицуулалтыг хийж өгсөн байгаа. Энийг хийхийн тулд нэрийн дансыг зайлшигүй мөнгөжүүлэх ёстой. Тийм учраас энэ мөнгөжүүлэх асуудал дээр бид нар бас маш онцгой анхаараад, хамгийн гол яагаад хэрэгжихгүй байсан юм бэ гэхээр мөнгөжсөөгүй, хийсвэрээр бичигддэг. Маш их хэмжээний мөнгө хэрэгтэй байдаг. Тийм учраас бид нар энийг хамгийн түрүүнд бол одоо байгаа шимтгэлийг нэмэхгүйгээр 2 хувиар одоо төлж байгаагийн 2 хувиар мөнгөжүүлнэ.

Энэ бол дээрээс нь нэмээд байгалийн баялгаас олж байгаа үр шимээр энэ одоо нэрийн дансаа үе шаттайгаар мөнгөжүүлээд хагас хуримтлалын тогтолцоонд шилжээд ингээд цаашидаа одоо олон чухал энэ зохицуулалтуудыг тэтгэврийнхээ, нийгмийн даатгалынхаа шинэчлэлийн хүрээнд хийгдэнэ гэдэг ийм одоо асуудлыг дэвшүүлж байгаа. Бусад нэмэгдэж байгаа энэ асуултууд өөр ажлын хэсгээс нэмээд хариулбал.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Өнөрбаяр дарга ажлын хэсгийн 83 дугаар микрофон өгье.

Г.Өнөрбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Түрүүн Цогтгэрэл гишүүн бас хэлсэн. Нийгмийн даатгалын хууль бол одоо бас халамжийн хууль биш гэдэгтэй бол санал нэг байна. Нийгмийн даатгалын хууль бол ажил хөдөлмөр хийж байгаа баялаг бүтээгчдийг одоо бас дэмжих энэ бодлого зорилтоо бас уялдах ёстой. Нөгөө талаасаа бас зайлшигүй төрийн зүгээс дэмжих ёстой хүмүүсийг бас дэмжих энэ бодлоготой бас уялдах ёстой. Бид нарын оруулж ирсэн энэ

нийгмийн даатгалын багц хууль маань тогтолцооны өөрчлөлтийг хийх буюу системийн өөрчлөлтийг хийх энэ бодлоготой бас уялдаж байгаа. Тэгэхээр олон давхаргат тэтгэврийн тогтолцоонд шилжсэнээр даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжууд бүрдэнэ. Нэрийн дансанд шилжсэнээр ажил хөдөлмөр хийж байгаа баялаг бүтээгдэж байгаа НДШ-ийг өндөр төлж байгаа ийм хүмүүсийн тэтгэвэр бол өндөр тогтоогдоно. Ялангуяа 1979 оноос хойш төрж байгаа хүмүүс дээр бол яг ажил хөдөлмөр өндөр төлсөн хүмүүсийнх бол бас өндөр төлөх ийм боломжууд нь бол бас нээгдэнэ. Нөгөө талаасаа нэрийн данс мөнгөжсөн тохиолдолд тэр нь бас тодорхой хэмжээнд өвлөгдөх ийм зохицуулалтуудыг бол бид нар бас оруулж ирсэн гэдгийг хэлье.

Тэтгэврийн зээлийг тэглэсэн. Тэтгэврийн зээлийг тэглэсний дараачаар ахмадууд маань одоо бас тэтгэвэр авч байгаа, юу зээл авч байгаа. Монголбанкны сүүлийн мэдээллээр бол 197000 орчим тэтгэвэр авагчид бол 488 орчим тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг бол одоо бас авсан байна лээ гэдгийг бол бас хэлье.

Бид нар бол ер нь 5, 7 жилийг 5 жил болгох асуудал бол 2019 онд оруулж ирсэн. 2019 оноос хэрэгжиж эхэлсэн. Энд бол нэг 40 тэр хууль батлагдсанаас хойш бол нэг 47000 орчим хүн одоо хэрэв эргэж үйлчилбэл одоо хамрагдахаар ийм тооцоолол байгаа. Жилд бол нэг 15000 орчим хүний тэтгэвэр тогтоолттой холбоотой яг энэ асуудал яригдана. Жилдээ бол нэг 20 орчим тэрбум төгрөгийн зардал гарна гэсэн ийм нарийвчилсан тооцооллуудыг одоо бас манайхан хийсэн гэдгийг бол хэлье.

Нэрийн дансны хуулийг мөнгөжүүлэх тухай чухал асуудлыг бас хөндлөө. Өнөөдөр тогтолцоогоороо бол бид нар ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүсийн шимтгэлээр ахмадуудын тэтгэврийг тавиад явж байгаа. Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол юу гэж үзэж байгаа вэ гэхээр энэ ажил

хөдөлмөр хийж байгаа энэ хүмүүсийн нэрийн дансан дээр одоо бичилт хийгдээд явж байгаа асуудлыг бол ямар нэгэн байдлаар одоо бас мөнгөжүүлэх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Өнгөрсөн хугацаанд бол өөрөөр хэлбэл ийм бичилт хийгдээд явж байгаа мөнгөн дүнг бид нар өчигдрийн байдлаар бол одоо бас тооцож үзсэн. Ингэхэд бол нэг 24 орчим их наяд төгрөгийн одоо бас ийм асуудал бол бас байгаа. Энийг бол мөнгөжүүлэх ёстой гэж бодож байгаа.

Мөн 1995 оноос өмнө ажил хөдөлмөр хийж байсан хугацаа байгаа. Хүмүүсийн өөрөөр хэлбэл одоо тэтгэврийн хугацааг ингээд бодоод үзэхэд 2 хугацаа яригдана. 95 оноос өмнө улс хариуцаж байх үеийн хугацаа, 95 оноос хойш одоо өөрөөр хэлбэл шимтгэлээ бодитой төлөөр төлөөд явж байгаа ийм 2 хугацаанд бол нэлээд олон хүмүүсийн тэтгэвэр бол хуваагддаг. Тэгэхээр 95 оноос өмнө улсад ажилласан жилүүдийн шимтгэлийг бол улс бол бас буцааж өгөх ёстой энэ санд нь бол буцааж өгөх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Энэ дээр бол тооцооллууд хийгээд үзэхэд бол бас 8, 9 орчим их наяд төгрөгийн асуудал яригдана гэсэн ийм тооцооллууд байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Тэгэхээр ахмадууд маань хөдөө орон нутгаар явж байхад нэг зүйл ярьдаг. Тэр нь юу вэ гэхээр энэ тэтгэвэр мэдээж бол бага байна гэдгийг ярьж байгаа. Хоёрдугаарт нь энэ тэтгэврийн зөрүү. Ижил цаг хугацаанд ижилхэн одоо ажил гүйцэтгэсэн хүмүүс тэтгэвэрт гарахаараа тэнгэр газар шиг маш ийм зөрүүтэй тэтгэвэр аваад байна. Энэ чинь шударга юм уу гэдэг ийм асуудлыг их тавьдаг. Тэгэхээр энэ тэтгэврийн зөрүү, тэтгэврийн тэгш бус байдал дээр одоо энэ хууль дээр ямар одоо асуудал ямар байдлаар оруулж ирж байгаа вэ?

Дээрээс нь энэ юмны үнэ, инфляц өсөж байгаатай холбогдуулж энэ

итгэлцүүр барьж энэ жил болгон энэ инфляц их байгаад байгаа, үйлдвэрлээд байгаа Засгийн газар энэтэйгээ уялдуулж энэ тэтгэврийнхээ хэмжээг барьж явахгүй бол ахмадууд чинь ер нь тэгээд л улам л ядуураад, улам л нийгмийн одоо асуудал нь хүнд болоод байх юм байна. Тэгэхээр энэ дээр энэ итгэлцүүрийнхээ асуудлыг индексжүүлэх гэдэг энэ асуудал дээрээ бас нэг тодорхой хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Тэтгэврийн зөрүү бол тулгамдсан асуудал. Бид энийг шийдэх ёстой. Ижил ажил мэргэжил хашиж байсан хүмүүс өөр, өөр цаг хугацаанд одоо тэтгэвэрт гараад, тэгээд өөр, өөр тэтгэвэр тогтоогдоод байгаа. Юунаас болж байна вэ гэх юм бол итгэлцүүрийг жил болгон зөв байдлаар тогтоож, тэтгэвэрээ тооцож чадахгүй байгаа юм. Бид 2014 онд баталсан итгэлцүүрийг одоо хүртэл хэрэглээд байхаар тэтгэврийн зөрүү үүнтэй болж үүсээд байгаа юм. Тэгэхээр шинэ одоо энэ хуулийн шинэчлэлээрээ бид нар жил болгон одоо энэ тэтгэвэр тогтоох, тооцох итгэлцүүрийг жил болгон шинэчлэхээр заасан байгаа. Тэгэх юм бол энэ зөрүү үүсэхгүй гэсэн үг.

Хоёрдугаарт үнийн өсөлттэй уялдуулаад жил бүр, бүр хугацаа зааж өгсөн байгаа. Нэгдүгээр улиралд багтаагаад Засгийн газраас үнийн өсөлттэй уялдуулаад тэтгэврийг нэмэгдүүлнэ гээд ингээд заачихсан байгаа. Тэгэхээр цаашидаа бол тэтгэврийн зөрүү үүсэхгүй. Тэтгэвэр бол одоо ингээд үнийн өсөлттэй уялдаад өсөх нь. Энэнээс өмнө бид нар одоо үүсчихсэн байгаа зөрүүг арилгаж байгаад хуулиа өөрчлөхгүй бол цаашидаа энэ тэгш бус байдал одоо.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

М.Оюунчимэг: Энэ нийгмийн даатгалын багц хууль орж ирж байгааг

бол бүрэн дэмжиж байгаа. Ер нь цаг бас жоохон оройтсон гэж хэлж байгаатай бол санал нэг байгаа. Өмнө нь орж ирсэн боловч Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хооронд бас санхүүжилттэй холбоотой асуудлуудыг зайлиггүй тодотгох шаардлагатайгаас Засгийн газар буцаад татаж авсан. Одоо ингээд орж ирж байна. Тэгээд одоо яг ингээд харж байхад яг энэ тогтолцоо өөрчлөх, өөрөөр хэлбэл өнөөдөр шимтгэл төлж байгаа хүмүүс маань ирээдүйд би хэдийг төлсөн энэ нь ирээдүйд миний амьдралын баталгаа болох ёстой. Тэрийгээ ингээд шилэн дансаар харж мэддэг байх. Одоо тэтгэвэр авч байгаа хүмүүс маань миний тэтгэвэр инфляцтай уялдаж жил бүр нэмэгдэх ёстой. Аль болохоор ахиухан тэтгэврээ бас нэмэгдүүлчих юм сан гэж.

Нөгөө талаасаа өнөөдөр энэ НДШ төлж байгаа хүмүүс маань энэ нь өөрөө барьцаа болоод ипотекийн зээл авчихдаг. Орон сууц, эрүүл мэнд боловсролдоо бас хамрагдчихдаг гээд ийм уялдаа холбоо, шинэчлэлийг бид бол урт хугацаанд хүсээж байгаа. Тэгээд энэ заалтуудыг хийх үндэслэлээр бас орж ирж байгаа гэж хэлж байна. Тэгээд энэтэй бол би нэг санал нийлж байна. Хамгийн гол нь энэ бүхэн хэрэгжихэд юу чухал вэ гэхээр санхүүжилт, энэ механизм санхүүжилтийн механизм чухал байгаа. Одоо ингээд Сангийн яамнаас өгсөн саналаас ингээд харж байхад одоо тэтгэврийн нөөц сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхдээ шимтгэлээ дайчлаад бүрдвэл харин улсын төсөвт ачаалал өгөхгүй байх тал дээр онцгой анхаар гээд тийм санал өгсөн байна л даа.

Тэгэхээр одоо яг салбарын яамны нийгмийн даатгалын багц хууль маань хэрэгжээд эхлэхэд одоо яг нэг даатгуулагч, ажил олгогч гээд нэг, нэг энэ 2 хүн маань өөрөө нөөц бүрдүүлэх нэг үндэс болно гэж байгаа. Гэтэл Сангийн яамны хувьд бол энийг өнөөдөр 2022 онд нийгмийн даатгалын сангийн шимтгэл 287 тэрбум төгрөгөөр давж биелсэн. Эндээс харахад шимтгэлээ дайчлаад нөөц бүрдүүлчих

бололцоо байна гэж харж байгаа юм байна. Тэгэхээр энэ дээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан маань ямар байр суурьтай байгаа вэ? Үнэхээр ингээж нийгмийн даатгалын сангийн шимтгэл 2022 онд ингээж 287 тэрбум төгрөгөөр нэмэгдээд тийм ээ давуу биелээд ингээж орж байсан бол энэ шимтгэл өөрөө нөөц сан бүрдүүлэх эх үүсвэр болох бололцоо байгаа юу эсвэл бололцоогүй зүйл үү? Тэгээд энэний эх үүсвэрийн асуудал, ялангуяа энэ нөөц сангийн эх үүсвэрийг яаж бүрдүүлэх, улсын төсвөөс гарахгүй байх зохицуулалт гэж хэлсэн байгаа. Тэгээд та бүхэн маань бас энийг Засгийн газрын тогтоосон хэмжээгээр гээд өөрчилж заасан байна л даа. Энэ 9.6 дээр, 9-дүгээр зүйлийн 9.6 дээр. Тэгэхээр энэ нөөц сангийн эх үүсвэрийг та бүхэн маань яаж ингээж харж байгаа вэ гээд. Тэгээд энэ дээр нэгдүгээрт нэг тодорхой хариулт авахыг хүсээж байна.

Ер нь бол энэ санхүүжилтээр төсөв дээр 3 төрлийн ачаалал ирж байгаа юм байна лээ шүү дээ. Тийм ээ. 7 жилийг 5 жил болгохоор жилд 20 тэрбум, нөгөө 10-аас дээш жил хамт амьдарсан нэг нь одоо нас барсан тохиолдолд 20 хувийг нь өвлүүлж гэвэл жилд 6 тэрбум гээд нийтдээ 300 орчим тэрбум төгрөгийн асуудал бас энд ингээд яригдаж байна. Тийм ээ. Тэгэхээр энэ санхүүжилтүүдийг яаж шийдэж байгаа вэ, яаж орох вэ? Хамгийн гол нь санхүүжилтийн механизм маань тодорхой тооцоо судалгаатай байж байж бид өнөөдөр нийгмийн даатгалын багц хуулиа ингээд тогтолцоогоо өөрчлөх гаргаад ирээд, энэ нь өөрөө хэрэгжих ёстой. Тэгэхээр энэ дээр яаж харж байгаа вэ?

Гурав дахь асуудал нь ерөнхийдөө бас ингээж хэлж байгаа шүү дээ. Одоо бид бол хуримтлалын тогтолцоо дээр явж байгаа. Тэгэхээр одоо энэ нөөц сан бүрдүүлэх гэж ярьж байгаа чинь ерөнхийдөө эхлээд хагас хуримтлал, дараа нь бүрэн хуримтлал руу одоо шилжих гэсэн асуудал яригдаж байгаа л даа. Тэгэхдээ энэнээс сая ингээд одоо жишээлбэл орон

сууцын моргейжийн нэг зах зээлийн баахан савлагаа болоход хуваарилалтын зарчимтай улс орнууд тогтвортой авч яваад, харин хуримтлалын тогтолцоотой улс орнуудын тэтгэврийн сангууд ихэнх нь дампуурсан. Хүнд байдалд орсон. Сая энэ ковидын нөхцөл байдлын үед хагас болоод бүрэн хуримтлалын сангууд яаж ажилласан бэ? Энэ дээр та бүхэн маань бас гадаадын улс орнуудын тооцоо судалгаа харсан уу? Одоо бид нар хагас хуримтлал руу орох 2029 он гэхэд бүрэн хуримтлал руу шилжих ийм том зорилго тавиад энэ нийгмийн даатгалын багц хуулиар орж ирж байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр надад ч гэсэн бас мэдээллүүд байгаа. Энэ ковидын нөхцөл байдлын үед тэтгэврийн сангууд хэрхэн яаж ажилласан байна гээд. Тэгэхээр энэ дээр хариулт авчихъя эхлээд.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ тэтгэврийн нөөц сан нэрийн дансыг мөнгөжүүлнэ гэдэг бол одоо ерөөсөө л энэ бид нарын хийх гээд байгаа суурь асуудал. Тийм ээ. Тэгэхээр энийг хэрэв хийж чадах юм бол энэтэй уялдуулаад одоо тэтгэвэр шударгаар тогтоогдох, цаашилаад хэн хэдэн жил хэдэн төгрөг төлснийхөө хариуд тэр хэмжээгээрээ тэтгэвэр тогтоолгодог байх энэ бүх асуудлууд чинь зохицуулагдаад явах юм. Тэгэхээр хамгийн гол асуудал нь энийгээ яаж мөнгөжүүлэх вэ гэдэг. Энийг мөнгөжүүлж чадаагүй учраас л энэ олон жил ингээд маш их олон асуудлууд бугшаад яваад байгаа юм л даа. Тэгэхээр энэ бол дан ганц нийгмийн даатгалын сан бол өөрөөсөө энэ их олон жилийн одоо хийсвэр бичигдсэн энэ дансыг бол мөнгөжүүлж бол чадахгүй. Тийм учраас энэ заавал ч үгүй төрөөс, Засгийн газраас энэ дээр анхаарч энийг мөнгөжүүлж хуримтлалыг бий болгох ийм шаардлагатай. Энэ ч утгаар бол Сангийн яам бас энэ төслийг одоо Улсын Их Хурлаар одоо хэлэлцүүлэхийг дэмжсэн, Засгийн газар дээр дэмжсэн. Засгийн

газраас бас шийдвэр бодлого нь гарсан байгаа.

Энэ дээр хамгийн түрүүнд бол одоо байгаа шимтгэлийн хэмжээг өөрчлөхгүйгээр 2 хувийг нь энэ бол жилдээ нэг 300 орчим тэрбум төгрөг байгаа. Энийг бол одоо нэрийн дансанд хийх юм нэгдүгээрт.

Хоёрдугаарт ер нь бид нарын одоо гол мөнгөжүүлэх эх үүсвэр хаана байна гэх юм бол байгалийн баялагт байгаа. Үндсэн хууль дээрээ заасан ард иргэд хувь хишгээ авах янз бүрийн байдлаар хүртэх. Бид нар одоо 19 онд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа стратегийн ач холбогдолтой орд газрын үр ашгийн дийлэнхийг нь одоо ард түмэнд хүртээнэ гээд заачихсан. Энэ бол орон сууц, боловсрол, нийгмийн хамгаалал олон төрлөөр байх боломжтой юм. Тэгээд одоо байгаагийн цорын ганц одоо хүчин төгөлдөр хууль нь Ирээдүйн өв сангийн тухай хууль байгаа юм. 2029 оноос эхэлж хэрэгжинэ. 29 оноос эхлээд Ирээдүйн өв сан бол энэ байгалийн баялгаас Ирээдүйн өв сангаар дамжуулж, улсын төсөвт тодорхой хуримтлалыг бий болгоно гээд зохицуулалт заачихсан.

Бид нар энэ дээр тодорхой бүр тоо тавьсан. 30 хувийг нь шууд одоо энэ нэрийн дансыг мөнгөжүүлэхэд нөөц сан руу төвлөрүүлж гээд заасан төсөл дээр. Яагаад гуч хувь юм бэ гэх юм бол одоо нийт иргэдийн маань гуч орчим хувь нь бол НДШ төлж байна. Тийм учраас энэ хүмүүс байгалийн баялгаасаа бас хүртэж, нэрийн дансаа мөнгөжүүлэхэд нь бас хувь авах ёстой гэдэг ийм зарчмыг дэвшүүлсэн. Сангийн яамнаас бол хатуу гуч гэх нь зарчмыг нь бол дэмжиж байгаа, ойлгосон. Хатуу гуч биш энийгээ бол хувьгүйгээр хувь хэмжээг нь бол тухайн үед бол Засгийн газар тогтоох боломжтойгоор найруулъя гээд энэ дээр бол манайх зөвшөөрөөд ингээд явж байгаа.

Үүнээс гадна одоо бол Баялгийн сангийн хууль хэлэлцэгдээд батлагдах

ёстой. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ёстой. Үндсэн хуулийнхаа энэ байгалийн баялгийг иргэдэд хүртээх энэ одоо зарчим бол хууль тогтоомждоо тусгалаа олох ёстой. Ингээд явах юм бол бид нар энэ одоо энэ нөөц сангаа мөнгөжүүлэх, эх үүсвэрийг улам тодорхой, улам одоо оновчтой ийм болох ийм боломжтой болох юм гэдгийг танд хэлье. Тэгээд нөөц сангаа бүрдүүлэхдээ зөвхөн одоо тэтгэврээ зүй зохистой байдлаар одоо тогтоолгоод, тэрийгээ өвлүүлээд, хамтын тэтгэврийн зарчим хэрэгжээд зогсохгүй энэ нөөц нэрийн дансныхаа нөөц сангаа мөнгөөр мөнгөжсөн хөрөнгөөрөө орон сууц авах, боловсролын үйлчилгээ авах, хүүхдээ сургуульд сурах магадгүй хүнд эрүүл мэндийн одоо хүнд хагалгаанд орох юм бол энэ сангаасаа авдаг байх энэ зохицуулалтыг нь бүх эх үүсвэрийг нь одоо хуулиар одоо тогтоогоод ингээд явж байгаа юм. Нэмэлт асуултууд дээр ажлын хэсгээс нэмээд хариулъя.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн 83 дугаар микрофон Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Бид нар бол энэ орж ирж байгаа хуулийн төслийн хүрээнд хийж байгаа нэг том чухал шинэчлэл бол энэ хамрагдалтыг нэмэгдүүлэх асуудал бас их чухал байна. Нийгмийн даатгалын системд хамрагдахгүй олон зуун мянган хүн байгаа. Энийг бол өөрөөр хэлбэл нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах энэ бодлогыг бид нар бас оруулж ирж байгаа. Мөн нийгмийн даатгал авлагаа авах, нийгмийн даатгалын харилцааг олон хуулиар одоо шударга бусаар тогтоодгийг одоо бас болиулах энэ асуудлуудыг бид нар бас оруулж ирж байгаа. Мөн нийгмийн даатгалын хуулийг нөхөн төлөлтийг хориглох энэ асуудлуудыг бид нар бас оруулж ирж байгаа. Мөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдэж байгаатай нэмэгдэж байгаа цалин орлого нэмэгдэж байгаатай уялдаатай нийгмийн даатгалын

одоо өөрөөр хэлбэл орлого талдаа бол одоо бас нэмэгдэнэ гэдгийг бол бас хэлье.

Та сая бас энэ бусад улс орнуудад энэ ковид эдийн засгийн нөхцөл байдлын үед бол энэ тэтгэврийн сангууд яаж ажиллав. Энэ дээр бас та нар ямар тооцоо судалгаа хийсэн бэ гээд тодорхой зүйлийг бас асуулаа. Бусад улс орнуудын тэтгэврийн даатгалын сангууд ямар байна гэхээсээ илүү тухайн засаглал нь ямар вэ гэдэг асуудал нь бол эхлээд чухал юм. Төрийн байгууллагууд төр менежмент хийж байгаа тэтгэврийн сангууд нэг өөр байна. Байгууллагын дэргэд тэтгэврийн сангууд байна, хувийн хэвшлийн тэтгэврийн сангууд байна. Ажил мэргэжлийн тэтгэврийн сангууд байна гээд энэ болгоны менежментүүд нь бас өөр юм. Ерөнхийд нь бол энэ ковидын нөхцөл байдлын үед бол ялангуяа энэ хувийн тэтгэврийн сангууд дээр бол бас тодорхой хэмжээний алдагдал үүрсэн гэдгийг бол одоо бид нар бас тооцоо судалгаануудыг хийж үзэж байгаа.

Санхүүгийн зах зээл, хөрөнгийн зах зээл унасантай уялдаад энэ тэтгэврийн сангуудын орлого бас буурах нэг хандлага байна. Манайд ч гэсэн ажиглагдсан энэ ковидын нөхцөл байдлын үед ажлын байраа алдах, ажилгүйдэлд өртөх, энийг дагаад өөрөөр хэлбэл цалин хөлс, орлого нь буурах ийм хандлагууд тэтгэврийн санд бас нөлөөлөл үзүүлсэн. Мөн тэтгэврийн сангуудаас ажил хөдөлмөр хийж байгаа хүмүүстээ бас хөнгөлөлт, чөлөөлөлт шимтгэлийн одоо өөрөөр хэлбэл урамшуулал өгөх энэ ажиллагаанууд одоо бас хийгдсэн. Мөн бас нэг анхаарах ёстой асуудал бол энэ койнттой холбоотой залилан мэхлэх асуудлууд бол энэ тэтгэвэр хувийн тэтгэврийн сангууд дээр одоо бас яригдсан ийм асуудлууд бий. Тухайлбал зарим хувийн тэтгэврийн сангууд бол койн худалдан аваад энэ тэтгэврийн сангууд нь одоо бас хүнд байдалд орох ийм нөхцөл байдлууд байгаа.

Ерөнхийдөө бол эдийн засгийн хамтын ажиллагааны орнуудын

тэтгэврийн сангуудын ялангуяа энэ хувийн хэвшлийн менежмент хийж байгаа тэтгэврийн сангуудын орлого бол дунджаар нэг 10 орчим хувиар буурсан гэсэн ийм судалгаанууд байгаа. Эдийн засаг сэргэх хэрээр энэ сангуудын орлого бол одоо буцаад сэргэх ийм хандлагууд бол ажиглагдаж байна гээд хөндлөнгийн экспертүүд одоо бичсэн тооцоо судалгаануудтай бол бид нар бас байнга танилцаж байгаа. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүн тодруулж асуух уу?

М.Оюунчимэг: Бас судалгаа тооцоо хийж байгаа юм байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны байр суурь нь бол НДШ дээрээ тулгуурлаад, шимтгэлээ дайчлаад энэ нөөц сан бүрдүүлэх эх үүсвэр болгох бололцоо бол байхгүй учраас төсөвтэйгөө уях нь чухал. Байгалийн баялгийн сантайгаа уях нь чухал гэж үзэж байгаа юм байна. Тэгэхээр энэ санхүүжилтийн механизмынхаа схемийг Сангийн яамтайгаа яриад, яг энэ хэлэлцүүлгийн явцад хууль батлахаас өмнө маш тодорхой болгох нь бол чухал байгаа нь бол харагдаж байна шүү гэдгийг хэлье.

Хоёрт нь нэг зүйл байгаа юм. Одоо ингээд нийгмийн даатгалын сангийн үндэсний зөвлөл, ЭМД-ын сангийн үндэсний зөвлөл гээд хараад үзэхэд нэг талаасаа Үндэсний зөвлөлийн дарга нь өөрөө хяналт тавиад тавиад байгаа байдаг. Гэтэл одоо сайд нь өөрөө Үндэсний зөвлөлийн дарга байхаар нэг гараараа нөгөө зарцуулах юмаа хийчихдэг. Нөгөө гараараа хяналт тавих. Гэхдээ энэ нь хяналт тавьж чаддаггүйгээс болоод нийгмийн даатгалын сангийн мөнгийг бид нар одоо Капитал банканд тавиад туучихсан зүйлүүд гарсан. ЭМД-ын сангийн мөнгөн дээр бас асуудлууд ингээд үүсээд яваад байгаа. Тэгэхээр.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Оюунчимэг гишүүн Нийгмийн даатгалын сангийн засаглал, менежментийн асуудлыг хөндөж ярилаа. Бид нар бол ер нь энэ бусад улс орнуудын жишигийг үзэхэд бол энэ засаглал нь тухайн даатгалын санг хувийн хэвшлийнхэн менежмент хийж байгаа юм уу, мэргэжлийн байгууллагууд менежмент хийж байгаа юм уу, төр нь менежмент хийж байгаа юм уу гэдгээс шалтгаалаад засаглалын менежментүүд юу хэлбэрүүд нь бол өөр өөр байдаг. Бид нар бол энэ нийгмийн даатгалын энэ шинэчилсэн найруулгаар бол энэ засаглалын асуудлуудыг бол олон улсын жишигт нийцүүлж оруулж ирж байгаа. Ерөнхийдөө бол өөрөөр хэлбэл өнөөдрийн нийгмийн даатгалын тогтолцоонд бол мэргэжлийн хороодыг бид нар бас оруулж ирж байгаа акторын, эрсдэлийн удирдлагын, хөрөнгө оруулалтын гээд олон мэргэжлийн хяналтын гээд олон мэргэжлийн хороод ажиллаад, энэ нийгмийн даатгалын сан дээр ямар эрсдэл үүсэх юм, өнөөдрийнхөөр явбал ямар өөрчлөлтөд хүрэх юм, энэ параметрийн өөрчлөлтүүд нь одоо ямар үр дагавруудыг бий болгох юм гэдэг энэ тооцоо судалгаануудыг хийх мэргэжлийн баг.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Яах уу гүйцээж хариулах уу? Хариулт хангалттай юу? Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Нийгмийн даатгалын багц хууль орж ирж байна. Энэ хууль бол яах аргагүй нэлээн их бодох ёстой, энэ хүмүүсийн ирээдүйн амьжиргаа, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн багц нэлээн гол хууль. Тэгээд би бол нэг ийм хэд хэдэн санаа бодоод байгаа юм. Аль болохоор хүн олон жил тогтвортой НДШ төлөх тэр сонирхол механизмыг бүрдүүлсэн эрх зүйн орчныг л бид бүрдүүлэх ёстой. Тэгж байж наад ирээдүйн баталгаагаа улсууд чинь найдвартай хангаж явах боломж нь бүрдэх ёстой юм. Тэгэхээр энэ хуулийн үзэл санаа бол нэгдүгээрт ийм санаа байх ёстой гэж.

Хоёр дахь санаа нийгмийн даатгалын сан, нэрийн данс өөрөө мөнгөжих ёстой юм. Мөнгөжих ёстой. Бид нар эв санааны нэгдлийн тэтгэврийн тогтолцоотой явсан улсууд гээд яриад байна. Үнэн. Энэ бол 12, 3 жилийн л асуудал байгаад байх шиг байгаа юм. Ингээд тооцоо бодоод үзэхээр зэрэг. Би хэд нэг 55-аас 60-аас гээд тэтгэвэрт гардаг. Тэгээд дундаж наслалт энэ юмаа бодоод үзэхээр нэг тийм зөрүүний л асуудал бидэн дээр яригдах юм байна даа гэсэн нэг ийм л тооцоо харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр би бол юу гэж хэлэх гээд байна гэхээр зэрэг НДШ-ийн орлого гэдэг бол 3 зүйлээс л бүрдээд байгаа шүү дээ. Ажил төлөгчийнх юу ажил олгогчийнх, даатгал төлөгчийнх, тэгээд төрөөс санхүүжиж байгаа гэсэн ийм л 3 хэсэг байгаа. Тэгэхээр ер нь энэ хууль батлагдаад гарснаас хойш НДШ төлөгчдийн мөнгийг нэрийн дансанд нь мөнгөжүүлж оруулах, тэр эв санааныхаа нэгдлээр өмнөх тэтгэвэр авч байгаа улсуудад авахдаа инфляцын түвшинээс багагүй хүүгээр тэр сангаас нь төр авч тэтгэвэр тэтгэмжийг нь тавьдаг энэ тогтолцоо руугаа шилжих ёстой. Тэрнээс 1 хувь, 3 хувь эд нарыг мөнгөжүүлэх тухай яривал явахгүй. Энэ явахгүй. Тэгээд ингээд тооцоо хийгээд үзэхээр бид нар чинь нэг 3.7 их наяд төгрөгийн тэтгэвэр тавьж байгаа улсууд.

Тэгэхээр төр өөрийнхөө гаргаж байгаа хэсэг дээр нь өнөө тооцоололтынхоо юуг үзэхээр зэрэг нэг 1.7 орчим их наядын юм уу тийм хэмжээний мөнгө л тухайн жилд зээлээд явах юм байна. Энэ нь үндсэндээ нэг 10 жилийн ийм цикл яваад, тэгээд тэрнээс хойш бол нэрийн дансныхаа хэвийн үйл ажиллагаа руу шилжчихэж болох юм байна гэж ингэж л хараад байгаа шүү дээ би бол. Тэгэхээр энүүнийг та хэд нэг энэ хуулийнхаа төсөл дээр ер нь яаж тооцож, илүү тодруулах бололцоо боломж байна уу гэж нэг ийм зүйл байна.

Хоёрдугаарт цалин, тэтгэвэр тэтгэмж, инфляцын түвшинтэйгээ уялдаж автоматаар тухайн жил бүрдээ

хөдөлж явдаг тийм хууль зүйн зохицуулалтыг бид хийх ёстой юм. Тэрнээс тэтгэвэр нэмэх тухай асуудал байн байнга яриад байдаг биш. Ерөөсөө хүний мөнгийг байгаа түвшинд нь тэр худалдан авах чадварынх нь түвшинд байлгах үүднээс ийм зохицуулалтыг л хийх ёстой гэж бодоод байна би бол. Тэгэхээр энүүнийг энэ хуулийн түвшинд нь та нар юу гэж ойлгож хараад байна гэж.

Хамтын тэтгэврийн тухай бид нар яриад байдаг юм. Энэ бол нэг их тийм зөв зохицуулалтаа л олох ёстой байх. Гэхдээ миний хамгийн түрүүн ярих ёстой зүйл үнэхээрийн НДШ төлөөд, нэрийн дансанд юм мөнгө орж байгаа бол тэтгэвэрт гарсан ч, гараагүй ч эрсдэл хүлээчихсэн бол тэрний үлдэгдлийн хэдэн хувийг үлдсэн улсад нь өгөх ёстой юм гэдэг л зүйл байгаа. Мэдээж эв санааны нэгдлийн тэтгэврийн тогтолцоотой яваа улсууд тодорхой хэсэг нь тэр рүүгээ явдаг, тодорхой хэсэг нь тэр үлдэж байгаа улсууддаа очдог ийм л хэлбэрийг л бид зохицуулах ёстой. Тэгэх юм бол би нэг хамтын тэтгэвэр энэ тэр гэдэг юм яригдаад баймгүй зүйл л гэж л ингэж л хараад байгаа юм.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Ажлын хэсэг хариулъя. Өнөрбаяр дарга.

Г.Өнөрбаяр: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Өнөрбаяр. Бид нар энэ Нийгмийн даатгалын хуулиараа бол олон жил ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг дэмжих энэ бодлогыг бол бид нар оруулж ирсэн. Одоогийн бид нарын хэрэгжиж байгаа хуулиар бол олон жил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийг одоо бас дэмжихгүй ийм бодлоготой одоогийн тогтолцоо байгаа. Өөрөөр хэлбэл эхний хорин жилд 2.25-аар одоод 20-ос дээш жилд нэг 1.5-аар бодоод бууруулж боддог. Тэгэхээр өөрөөр хэлбэл хүний олон жил ажиллаж ажиллах тусам тухайн хүний тэтгэврийг бууруулж болохоор тухайн хүн улсад илүү олон жил ажиллах сонирхол нь байхгүй байна. Бид нар бол шинэ хуулийн төслөөрөө бол өөрөөр хэлбэл 20-оос дээш

жил ажиллаж байгаа энэ хүмүүсийнхийг бол 2 хувиар бодохоор ингээж оруулж ирсэн. Цаашидаа бол өөрөөр хэлбэл энэ тогтолцоо энэ хууль батлагдаад явбал олон жил ажиллах тутам тухайн хүний тэтгэвэр өндөр тогтоогдох ийм бодлого бол одоо бас хэрэгжинэ.

Гэхдээ нэг зүйлийг одоо бас хэлэхэд түрүүн Цогтгэрэл гишүүний асуултад гараад байна лээ. Ерөөсөө манай тэтгэврийн тогтолцооны бодолд бол их сайн бодолтой. Асуудал юундаа байна вэ хүмүүс бага тэтгэвэр аваад байна гээд байгаа асуудал юундаа байна вэ гэхээр өнөөдрийн цалин хөлсний тогтолцоондоо байгаа юм. Цалин хөлс нь бага байгаа учраас тэтгэвэр нь бага тогтоогдоод байгаа юм. Тийм учраас Монгол Улс бол цаашидаа ялангуяа энэ цалин хөлсний бүтцийн тогтолцоо дээрээ бол одоо бас ахиц дэвшил гаргавал тэтгэврийн бол сайн нөлөөлөл үзүүлнэ гэж нэг хэлэх гэсэн юм.

Хоёрдугаарт бас Батжаргал гишүүн нэрийн дансны асуудал үүсвэл өөрөөр хэлбэл тухайн хүний нэрийн дансан дээр тодорхой хэмжээнд мөнгөжвөл тэр асуудал нь бол өвлөгдөх энэ боломж нь энэ хуулиар бас нээгдэнэ. Мөн 79 оноос хойш төрсөн хүмүүс бол тэтгэвэр тогтоох бодолт нь өөр аргаар бодогдож байгаа. Энэ бол өөрөөр хэлбэл тухайн хүн улсад ажиллаад нэрийн дансандаа ямар хэмжээний мөнгө хуримтлуулна уу, тэр хуримтлуулсан мөнгөн дүнг нь бол амьдрах дундаж хугацааны илэрхийлэлд нь хуваагаад олгоно. Энэ тохиолдолд өөрөөр хэлбэл олон жил ажилласан их мөнгө төлсөн хүмүүсийн тэтгэвэр бол өндөр тогтоогдох энэ боломжууд бол бас нээгдэнэ гэдгийг бол бас хэлье.

Мөн таны ярьсан энэ тэтгэвэр бол өөрөөр хэлбэл сонгуулийн өмнө бас нэмэгддэг энэ одоогийн тогтолцоо биш. Аль болохоор тухайн жилийн инфляц үнийн өсөлттэй уялдуулаад автоматаар нэмэгддэг байх нь бол энэ тэтгэврийн худалдан авах чадварт бол одоо сайн нөлөөлөл үзүүлнэ. Бид нарын оруулж ирж

байгаа хуулийн төсөл дээр бол тэтгэвэр бол тухайн жилийнхээ инфляц үнийн өсөлттэйгөө уялдаад автоматаар одоо бас нэмэгддэг байх энэ зохицуулалтыг оруулж ирсэн жил болгон. Ингэвэл өөрөөр хэлбэл ахмадуудын болон хүмүүсийн төлсөн НДШ болон өөрөөр хэлбэл үнэ цэнтэй хэвээрээ хадгалагдаад, жил болгон өөрөөр хэлбэл тухайн иргэн өөрөө тэтгэврийн хэдэн хувиар өсөж бодогдох вэ гэдгээ бол одоо бодох бүрэн боломжууд нь бол бас иргэдэд байгаа гэдгийг хэлье. Ингээд анхаарал тавсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүн тодруулж асууя.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ хуулийг одоо бид нар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд хэлэлцүүлгийн түвшинд мэдээж нэлээн сайжруулах байх. Тэгээд ер нь бол үнэхээрийн л тэтгэврийн буюу энэ нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэл хийе л гэж бодоод байгаа бол бид наад мөнгөжүүлэлтийнхээ юмыг л их зоригтой хийх ёстой. Энэ сангаа өөрийг нь зөв менежменттэй байлгах, тэгээд инфляцын түвшинээс доошгүйгээр арвижиж явдаг тухай ойлголт. Энэ юмыг л бид суурь харилцаагаар нь зөв хийж чадах юм бол цаашид энэ тэтгэвэр тэтгэмжийн асуудал дээр нэлээн гайгүй юм болох болов уу гэж.

Хоёр дахь миний нэг тодруулчихмаар байгаа зүйл бол төрөлхийн гэдэг юм уу олдмол хэр нь нөхөн сэргээгдэж чадахааргүй тэр хөгжлийн бэрхиээлүүдийг 2 жил тутам хөдөлмөр магадлалын комиссоор оруулна энэ тэр гээд л ингээд улсад чирэгдэл учруулж байх ер нь хэрэг байна уу? Ийм тов тодорхой зүйлүүдийг бол нэг үзээд шийдсэн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад нэмж хариулъя. Ажлын хэсэг.

Г.Өнөрбаяр: Энэ хуулийн бас нэг чухал зорилт бол таны хэлээд байгаа энэ мөнгөжүүлэх бодлоготой бол бид нар бас

уялдаж байгаа. Нийгмийн даатгалын тэтгэврийн нөөц санг бол одоо бага багаар ингээд мөнгөжүүлээд явбал энэ өөрөө манай нийгмийн даатгалын тогтолцоонд ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүст мөн өөрөөр хэлбэл нийгмийн даатгалд хамрагдаж байгаа бүх хүмүүст эерэг сайн нөлөөлөл үзүүлнэ гэсэн энэ агуулгаар мөнгөжүүлэх асуудлыг бол бид нар бас оруулж ирсэн байгаа.

Хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг та бас хөндөж ярилаа. Бид нар бол нэг 80 гаруй өвчний төрлөөр бол өөрөөр хэлбэл хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог. Таны ярьсан тодорхой өвчнүүдийн тохиолдолд бол өөрөөр хэлбэл бид нар хугацаа заахгүйгээр бол би шууд оруулж ирж байгаа. Мөн энэ хууль дээр оруулж ирж байгаа бас нэг чухал заалт бол манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хөдөлмөрийн чадвар алдалтын одоо өөрөөр хэлбэл ийм эмнэлэг байгаа. Энэ эмнэлгийг бол бид нар нийгмийн даатгалын дэргэд ажиллуулахаар оруулж ирж байгаа юм. Одоо өөрөөр хэлбэл бид нар хөдөлмөрийн чадвар алдсан хүмүүсийг нэг удаа ингэж үзээд, тодорхой хугацааны дараа бас дахиж нэг үздэг. Энэ хооронд өөрөөр хэлбэл тухайн хүмүүсийг нөхөн сэргээх, эмчлэх, эдгээх буцаагаад ажил хөдөлмөрийн зах зээл дээр гаргах энэ боломжуудыг нь бол бид нар бас сайн хангаж өгч чадахгүй байна. Энэ хууль батлагдвал энэ эмнэлэг маань ажилдаа ажиллагаанд ороход хөдөлмөрийн чадвараа алдсан хүн болгонтой одоо бас тулж ажиллах, тэд нарыг эдгээх, нөхөн сэргээх энэ чиглэлийн ажиллагаанууд бас хийгээд явагдана. Тэгвэл энэ чиглэлээр бол одоо бас ахиц дэвшил гарна гэж бид нар бас хуулийн төсөл дээр оруулж ирсэн. Бас нэг шинэ чухал үзэл санаа гэж ойлгож байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: 2 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа цуглаарай. Одоо Баттөмөр гишүүн асуулт асууя.

Б.Баттөмөр: Энэ нийгмийн даатгалын асуудал улс орны нийгэм, эдийн засгийн одоо чухал асуудлуудын нэг. Энэ бол одоо өнөөдөр ингэж орж ирж байгаа нь бол зүйтэй гэж ингэж үзэж байгаа юм. Энэ Алсын хараа 2050 гэдэг хөгжлийн бичиг баримтыг бид боловсруулахад Аюурсайхан сайд бид нар бас хамтарч энэ дээр энэ хөгжлийн үе шат болгонд одоо нийгмийн даатгалын шинэчлэлүүдийг хийж авах нь зүйтэй гэсэн ийм санааг бол оруулж ирсэн юм. Тэгээд энэ өнөөдөр бас ингээд ороод ирж байна гэж ингэж үзэж байгаа. Ингээд энэ нийгмийн даатгалын хууль маань батлагдаад одоо 2094 онд миний ойлгож байгаагаар батлагдсан байх гэж ингэж бодож байна. Олон удаа өөрчлөлт орсон.

Өнөөдөр Монголын одоо энэ ажил олгогчдын нэг 80 орчим хувь нь 82 ч орчим гэдэг байх. 80 орчим хувь нь одоо нийгмийн даатгал төлж, 750-иад мянга гээд ингээд үзэхээр нийт хүн амын бараг 4 хүний 1 нь энэ даатгал, халамж одоо авч байна л даа энэ сангаас. Тэгэхээр энэ бол одоо их ач холбогдолтой ийм л юм байгаа юм л даа. Энэ хуулийн төслийг бол өнөөдөр ингээд шилэнгээр тараасныг нь сая авлаа. Гүйцэд сайн уншиж чадаагүй байна. Тэгэхдээ ингээд хальт харахад бол нэлээн их маш их олон асуудлуудыг шийдэхээр орж ирж байгаа ийм юм байна л даа. Хамгийн гол нь энд бол даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөлийг одоо бүрдүүлж байгаа юм байна. Хуримтлалын нэгдсэн сан байгуулж иргэд одоо бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийхээр төлөвлөсөн нь бол цаг үе болсон асуудал гэж бодож байгаа.

Бидний энэ Пүрэвдорж гишүүн бид нар санаачилсан тэр нэг 7 жилийг 5 жил болгож ингэж оруулж ирж байгаа нь бол зүйтэй байна. Засгийн газар ингээд оруулж ирж байгаа нь бол зүйтэй гэж ингэж бол ойлгож байгаа. Энэ бүх зүйлээ тооцож оруулж ирж байгаа гэж бодож байгаа. Энд бас нэг олзуурхах учиртай юу вэ гэхээр энэ байгалийн баялгаас одоо олох орлогыг нэрийн дансанд одоо оруулна гэдэг бол маш

зөв санаа байгаа. Бэлэн мөнгө тараах биш, нэрийн дансаараа дамжуулаад тодорхой санхүүгийн хэрэгслүүдэд хувьцаанд хөрөнгө оруулах энэ боломжууд одоо бүрдэнэ гэж ингэж ойлгож байгаа юм. Бас нэг зүйл нь бол нийгмийн даатгалын сангийн үлдэгдлийг санхүүгийн одоо хэрэгслүүд энэ чинь одоо хөрөнгийн зах зээл хөгжиж байгаа энэ үед одоо бодит өөрөөр хэлбэл найдвартай энэ санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах энэ одоо асуудал одоо зөв ингэж орж ирж байна.

Мөн нийгмийн даатгалын энэ засаглалыг оновчтой болгох чиглэлээр бас нэлээн гол заалтуудыг нь оруулж ирсэн. Ийм зүйлүүд бол байна гэж ингэж бодож байгаа юм. Хэд хэдэн асуултууд байгаа юм. Нэгдүгээрт нь бол юу вэ гэхээр энэ салбарын хууль тогтоомжуудаар зохицуулагддаг энэ гааль, татвар одоо Цэц одоо цэргийн байгууллагуудыг нийгмийн даатгал, шимтгэл төлөх харилцаа бол бас өөр өөр байдаг. Энийг зохицуулахдаа одоо яаж зохицуулж байгаа вэ гэсэн нэг асуулт байгаа.

Энэ цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж гэдэг юм бол яах вэ ялангуяа энэ тэтгэвэр гэдэг асуудал бол яах вэ шууд биш утгаар энэ бүтээмж гэдэг юмтай их холбоотой. Бид чинь нөгөө бүтээмжээ бодолгүйгээр цалин нэмээд байдаг, тэр нь буцаад юу вэ гэхээр нөгөө хани унаад эцэст нь нэмсэн нэмээгүй 2 бараг ялгаагүй болчихдог. Тэгэхээр энэ бүтээмж гэдэг юмыг та нар энэ яаж тооцож байгаа вэ? Цалинтайгаа, тэгээд тэтгэвэр тэтгэмжийн сангийнхаа үйл ажиллагаатай энэ бүтээмж гэдэг юмыг та нар хэр зэрэг тооцож байна гэсэн ийм зүйл.

Дараагийн асуулт бол юу вэ гэхээр энэ малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид одоо нийгмийн даатгалд хамрагдалт байхгүй. Малчдын хувьд бол бараг байхгүй байгаа. Энэ асуудлуудыг яаж оруулж ирж байгаа вэ гэж. Энэ гадаадад одоо Монголын 300-гаад мянга хүн ажиллаж амьдарч байгаа шүү дээ. Тэр хүмүүс одоо энэ Монголдоо одоо шимтгэл төлөх энэ

харилцааг бол та нар одоо энд юу гэж орж ирж байгаа юм бэ? Ийм, ийм асуултууд хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Баттөмөр гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Бид нар нийгмийн даатгалын харилцааг бол зөвхөн Нийгмийн даатгалын хуулиар зохицуулна. Нэг хуулиар зохицуулна гэдэг ийм зохицуулалтуудыг бол бид нар оруулж ирж байгаа. Гэхдээ бусад хуулиар зохицуулж байсан нийгмийн даатгалтай холбоотой харилцааг энэ хууль руу оруулж ирэхдээ иргэдийн нийгмийн хамгааллыг одоо дордуулсан ийм харилцааны зохицуулалтуудыг бол бас оруулж ирээгүй гэдгийг бол бас хэлье. Та бас бүтээмжтэй холбоотой асуудал ярилаа. Тухайн хүн олон жил ажиллаад илүү өндөр НДШ төлбөл нэрийн дансан дахь одоо өөрөөр хэлбэл мөнгө нь илүү арвижих, илүү тэтгэвэр авах энэ боломж нь бол иргэдэд илүү хадгалагдаж өгч байгаа гэдгийг бас хэлье.

Түрүүн хэлсэн илүү олон жил ажиллах тусам авах тэтгэврийн хэмжээ нь бол одоо өөрөөр хэлбэл өндрөөр бодогддог энэ бодолтын хувилбаруудыг бид нар бас санал болгож байгаа гэдгийг хэлье. Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтын асуудал бол одоо бас үнэхээр чухал юм. Малчдын нийгмийн даатгалыг бол одоо үндсэндээ хамрагдах хамрагдалтыг нэмэгдүүлэх энэ шинэ бодлогыг бол бид нар хуулийн төсөл дээр оруулж ирсэн. Одоогийн байдалаар бол нэг 20 орчим мянган малчин бол нийгмийн даатгалд бол одоо ингээд хамрагдаад явж байгаа. Гэтэл улсын хэмжээнд бол өөрөөр хэлбэл нэг 200000 орчим малчин бол одоо байгаа. Энэ малчдыг бол нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах бол зайлиггүй шаардлага байгаа. Тийм учраас бид нар малчдын 5 жилийн одоо нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын шимтгэлийг 50 хувийг төрөөс төлье, тэгээд өөрөөр хэлбэл хамрагдалт

нэмэгдүүлье гэдэг ийм урамшууллын тогтолцоог бол оруулж ирсэн. Малчдыг өнөөдөр бид нар нийгмийн даатгалын тогтолцоонд оруулж ирэхгүй бол хэзээ нэгэн цагт энэ бол халамжийн тэтгэвэр авагчид бас болно. Тийм учраас бид нар малчдын нийгмийн хамгааллыг одоо бас сайжруулахын тулд аль болохоор одоо тийм урамшууллын механизмаар энэ хуулийн төсөлд оруулж ирсэн гэдгийг бол бас онцолж хэлье.

Гадаадад байгаа Монголчуудыг нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах нь манай бодлогын бас нэг чухал зорилт байгаа. Нийгмийн даатгалын бүх үйлчилгээ маань цахимжсан. Дэлхийн аль ч улс орноос бол нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагдах, сайн дураараа төлөх бүх боломжууд нь бол нээлттэй байгаа. Энэ талаар бол манайх бол ЭСЯ, Дипломат төлөөлөгчийн газартай хамтраад бас холбогдох арга хэмжээнүүдийг бол нэлээд идэвхжүүлж байгаа. Түрүүн хэлсэн Монголчууд хамгийн их олноор ажиллаж амьдарч байгаа 6 улстай нийгмийн хамгааллын хэлэлцээрийг манай яам байгуулсан. Энэ 6 оронд ажиллаж амьдарч байгаа Монголчууд бол 2 улсад ажилласан жилээ улсад ажилласнаар тооцуулах, 2 улсаас одоо тэтгэвэр авах энэ боломж бололцоонуудыг нь бол бид нар бас нээж өгсөн. Цаашид Монголчууд хамгийн олноороо ажиллаж амьдардаг бусад улс орнуудтай бид нар нийгмийн хамгааллын хэлтсээр байгуулахаар холбогдох яриа хэлэлцээрүүдийг одоо бас хийж ажиллаж байгаа гэдгийг танд дуулгая. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр нийгмийн даатгалын шинэчлэл бол бас манай ард түмний хамгийн их хүсэн хүлээж байгаа нийгмийн бодлогын томоохон одоо ийм төсөл хууль байгаа. МАН 2020 оны сонгуульд орохдоо ч гэсэн ард түмэндээ амласан нийгмийн даатгалын шинэчлэл

хийнэ, хуримтлалын сан санг бүрдүүлж баялгийн сангаар дамжуулан иргэн бүртээ одоо орлого амьжиргааны түвшнийг одоо шийдэх боломжийг өгнө гэж амласан байгаа. Тийм учраас хуулийн төслийг бол үзэл баримтлалыг нь дэмжиж байна. Нэг хэд хэдэн асуулт байгаа юм. Ер нь улс орнууд энэ тэтгэвэр тэтгэмжийн тооцоолол хийхдээ аль болохоор даатгуулагчид ашигтай байх нөхцөлийг үндэслэн тооцооллыг гаргадаг. Тэгэхээр энэ одоо манай төслийн одоо зарим заалтууд дээр бол энэ даатгуулагчид одоо ашиггүй байж болохуйц ийм 1, 2, 3 заалтууд байгаад байна. Жишээлбэл төслийн 28.4 дээр хөдөлмөрийн чадвар бүрэн алдсан даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр нь тэтгэвэр авч байсан хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг өндөр настны тэтгэвэр тогтоолгох тухай үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцно гэгчихсэн байгаа юм.

Тэгэхээр одоо нөгөө иргэн маань харьцангуй одоо өндөр цалинтай ажил хийж байгаад сүүлийн одоо хэдэн жилдээ тэтгэвэр тогтоохын өмнөх жилдээ ч гэдэг юм уу нөгөө хөдөлмөрийн одоо чадвараа алдсаны одоо бага тэтгэмж авч байгаа шүү дээ. Тэгэхээр ингэж тооцох маань одоо тухайн даатгуулагчид ашиггүй байдал үүсэх юм биш үү? Энэ дээр одоо ямар байр суурь баримталж байгаа вэ? Тэгээд мөн одоо ер нь тэтгэврийн доод хэмжээг тооцох энэ одоо хуучин одоо одоо хэрэгжиж байгаа хуулиас хэр одоо ялгаатай концепт барьсан бэ? Одоо бол бид нар энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан одоо тооцоод байгаа. Ер нь энэ хууль маань даатгуулагчдаа хэр одоо дэвшилттэй, даатгуулагчид одоо ашигтай байдлаар шийдсэн ямар одоо ийм дэвшил орж байгаа вэ гэдгийг асуумаар байна.

Хоёрдугаарт нь түрүүн Баттөмөр гишүүн бас асуусан. Одоо энэ албан бус хэвшил гэж одоо мэргэжлийн үгээр яриад байгаа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид гээд. Эдгээр бол бараг дөрөвний

нэг орчим нь л одоо даатгуулдаг. Тэгэхээр сая энэ одоо ТНБД-ын хариулт бол яг одоо энэ хэвээрээ буюу сайн дурын гэдгээрээ л үлдээж байгаа юм байна л даа. Тэгэхээр одоо энэ албан бус хэвшилд ажиллаж байгаа одоо иргэдийнхээ даатгалаас одоо үр шимээ хүртэх энэ боломжийг одоо яаж нэмэх юм бэ? Нэлээд олон судлаач бол энэ сайн дурын даатгал гэдэг ерөөсөө одоо албан ёсны албан албан журмын даатгал одоо өөрчлөхгүй бол малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, түр хугацааны ажил эрхэлж байгаа хүмүүс маань одоо тогтмол нийгмийн даатгалын шимтгэл төлж чаддаггүй байдаг. Тэгээд явж байтал нэг өдөр одоо хөдөлмөрийн чадвараа алдана. Хүнд одоо өвчнөөр өвчилнө ч гэдэг юм уу ийм тохиолдолд одоо нийгмийн даатгалаас ямар ч одоо халамж авахгүй ийм хүнд нөхцөлд ордог. Тийм учраас энэ албан бус хэвшилд байгаа хүмүүсийнхээ даатгалыг албан журмын болгож өөрчлөх боломжгүй юу? Сайн дурын гэдгээр ингээд үлдээчихээр дахиад л одоо энэ 10 жилийн дараа мөн л одоо манай энэ хүмүүсийн олонх нь ингээд даатгалд хамрагдаагүй, нийгмийн даатгалын үр шимийг одоо авах боломжгүй болчихно. Энэ дээр ямар дэвшил ямар одоо урамшууллын бодлого барьж байгаа вэ?

Л.Мөнхбаатар: Мөнхцэцэг гишүүний асуултад ажлын хэсэг хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Дэлхийн аль ч улс оронд бол нийгмийн даатгалын тогтолцоо бол аль болохоор сонголттой байдаг. Тэгэхээр өөрөөр хэлбэл албан журмаар даатгуулах, сайн дураар даатгуулах энэ бодлого бол манай нийгмийн даатгалын одоогийн тогтолцоо нь ч байгаа. Бид нар цаашид шинэчлэлийн хүрээнд ч гэсэн энэ сайн дурын тогтолцоог бол хэвээр хадгална. Гэхдээ бусад улс орнууд болон жишигийн дагуу бид нар ялангуяа нийгмийн даатгалд хамгийн их хамрагдахгүй байгаа малчдыг хамруулахын тулд урамшууллын механизмыг оруулж ирж байгаа юм. Бусад улсад ч гэсэн одоо хамгийн сайн жишиг нь бол энэ урамшууллын механизм байдаг.

Түүрүүн хэлсний дагуу бид нар малчдыг 10 жилээр нийгмийн даатгалын төлсөн тохиолдолд нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх нь үүсдэг. Бид нар бол 5 жилийнх нь 50 хувийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцаад, малчдыг аль болохоор хамруулах энэ бодлогыг нь бол оруулж ирж байгаа.

Мөн энэ шинэчлэлийн хуулийн бас нэг чухал зүйл нь бол манай нийгмийн даатгалын тогтолцоонд бол манай нийгмийн даатгалын ажилтнууд аль болохоор соён гэгээрүүлэх, урт ялангуяа энэ даатгуулагчтай одоо бас ажиллах энэ боломж бололцоонуудыг нь бол бид нар энэ хуулийн төслөөр бол илүү их нээж өгч байгаа. Тийм учраас манай ажилтнууд өөрөөр хэлбэл нийгмийн даатгалд хамрагдахгүй байгаа энэ хүмүүст нийгмийн даатгалд хамрагдах ямар ач холбогдолтой талаар бол өөрөөр хэлбэл ажиллах шинэ бодлого, үзэл санаанууд бол энэ хуулийн төсөлд бас орж ирсэн. Нөгөө талаасаа бас тэтгэвэр авагчдад буюу тэтгэвэрт гарах нь дөхсөн хүмүүстэй өөрөөр хэлбэл тулж ажиллах, тэд нарт насжилттай холбоотой болон тэтгэвэр бодох томъёоллууд, тэтгэвэрт гарах одоо бэлтгэлүүд, тэтгэврийг хэрхэн яаж боддог вэ энэ талаар өөрөөр хэлбэл сургалт, мэдээллийн ажиллагаануудыг хийж өгөхөөр бол тодорхой бас шинэ зохицуулалтуудыг оруулж өгсөн гэдгийг хэлье. 85 дээр нэмж тодруулъя.

Л.Мөнхбаатар: Учрал гишүүн асуулт асууя. Учрал гишүүний микрофоныг өгье.

Н.Учрал: Даатгал бол тодорхой хүний хүсээгүй гэнэтийн эрсдэл дээр суурилсан санхүүгийн бүтээгдэхүүний үндсэн зарчимтай. Тэтгэвэр бол тооцож болдог гэдгээрээ онцлогтой. Тэгэхээр Нийгмийн даатгалын ерөнхий хууль бол гол концепц нь ажил хөдөлмөрлөх, ажиллах, хөдөлмөрлөх сонирхлыг нэмэгдүүлэхэд л орших ёстой. Нэг ёсондоо нийгмийн даатгал төлөөд үр шимийг нь хүртэж байх оршино. Тэгвэл өнгөрсөн хугацаанд

тэр ажил олгогчийн төлдөг 8.5 хувь, ажилтны төлдөг 8.5 хувь эргээд эзэндээ үр өгөөжөө хүртдэггүй болохоор иргэд өөрөө НДШ төлөхөөс зайлсхийдэг. Ажил олгогч дургүй, ажилтан ч дургүй. Төр ч сонирхолгүй. Яагаад гэвэл төсвөөс жил болгон дарамт учруулж байгаа учраас. Хэн хэн нь сонирхолгүй энэ систем. Нэг ёсондоо тэтгэврийн сан өөрөө тэтгэвэртээ гарчихсан гэж би олон жил ярьсан. 2020 онд Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн мэдүүлсэн. Үүнээс хойш Хөдөлмөр, нийгэм хамгааллын үе үеийн сайдууд энэ хуулийг оруулж ирээд буцдаг байсан.

Харин энэ удаа энэ Аюурсайхан сайд Засгийн газраар энэ асуудлыг оруулж ирээд яг бидний олон жил ярьсан асуудлуудыг шийдвэрлэх гээд оруулж ирж байгаад бол би өнөөдөр их сэтгэл хангалуун байна. Засгийн газар дээр ч гэсэн энэ асуудлыг ярьсан. Нэгд, иргэддээ мэдээлэл дуулгахад 17 хувийн тодорхой хувь нь хуримтлал шилжисж байгаа гэдгээрээ энэ хууль их онцлогтой. Нэг ёсондоо бол тэр 2 хувь нь хуримтлалд шилжсэнээрээ хуримтлал суурьтай болох буюу хагас хуримтлалд шилжисж байна. Тэтгэвэр олон давхаргад болж байна. Ингээд хуримтлал тодорхой хувь нь шилжсэнээрээ тэр хуримтлал шилжсэн хэсэг нь өвлөгддөг байх нөхцөл бол эндээс бүрдэнэ гэж ойлгож байгаа.

Дээрээс нь 7 жил нөгөө 5 жилийн асуудлыг энэ хуулиар шийдвэрлэж байна. Мөн Хувийн нэмэлт тэтгэврийн хуулийг өргөн мэдүүлж орж ирж байгаа. Өнөөдөр банкнууд бол тэтгэврийн санг ТББ-ын статустайгаар байгуулаад эхнээсээ иргэд тэтгэвэрт гараад эхэлчихсэн. Иргэдийн эрх ашгийг хэн хамгаалах вэ гэдэг нь ойлгомжгүй байсан бол өнөөдөр Хувийн нэмэлт тэтгэврийн хууль орж ирснээрээ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах бололцоог бүрдүүлж байгаа. Дээрээс нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн энэ хууль бол инфляцтай уялдуулж, тэтгэврийг индексжүүлэх агуулга энэ хуульд орж ирж байна. Энэ бол өөрөө хамгийн том дэвшил.

Инфляц ямар байна түүнтэй холбогдуулаад жил бүр тэтгэврийг нэмээд явах нөхцөл бүрдсэнээрээ цаашидаа тэтгэврийн зөрүү арилах суурь тавигдаа.

Тэгэхээр тэтгэврийн шинэчлэл хийе гэж 20 онд Улсын Их Хурал бүх шатны сонгуульд нэр дэвшигчийн МАН-ын мөрийн хөтөлбөрт суусан. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон энэ шинэчлэл одоо хийгдэх гэж байгаа. Эхэл бол зөв тавигдаж байна гэж харж байна. Цаашидаа Засгийн газрын зүгээс энэ концепцыг алдагдуулахгүйгээр Их Хуралд батлуулахад одоо Их Хурлын гишүүдийг анхаарал хандуулаасай гэж хүсэж байна. Дээрээс нь сая бас ажлын хэсэг хэлж байна. Нийгмийн даатгалыг цахимжуулах ажлыг Цахим хөгжлийн яам ч гэсэн бас дэмжисж ажиллана. Дэлхийн өнцөг булан бүрд суугаа Монголчууд энэ нийгмийн даатгалаа төлөх нөхцөл бололцоог бол бүрдүүлэхэд анхаарах ёстой гэж. Тэгэхээр Их Хурал дээр ажлын хэсэг байгуулагдах байх. Хувийн нэмэлт тэтгэврийн хууль буюу гишүүдийн санаачилсан энэ хуулийг нэгтгээд хэлэлцээд явах ийм бололцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хоёрт бол энэ нийгмийн даатгалын санг мөнгөжүүлэх асуудал одоо Засгийн газар дээр ажлын хэсэг байгуулагдаад явж байгаа энэ уул уурхайн баялгийг хуримтлал суурьтай тэтгэврийн сангаар дамжуулж иргэддээ хишиг хүртээх нөхцөл бололцоог бүрдүүлэх ийм бол одоо зайлиггүй шаардлагатай байгаа учраас Хуримтлалын сангийн хууль, Баялгийн сангийн хуультай хэрхэн концепцыг бас уялдуулах талаараа бас Аюурсайхан сайд энийг бас Их Хурлын гишүүдэд тайлбарлаж өгөөч гэж хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Учрал сайдын асуултад Аюурсайхан сайд хариулъя.

С.Аюурсайхан: Учрал гишүүний асуултад хариулъя. Учрал гишүүн маань бас энэ тэтгэврийн реформ, нийгмийн даатгалын сангийн реформд бол нэлээн одоо идэвхтэй ажиллаж байгаа. Өөрийнх

нь санаачилсан одоо хуулийн төсөл байгаа. Хамгийн гол нь бас Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа ерөнхий хуулийн төслийг хүлээгээд одоо ингээд хэлэлцэгдэхгүй бас нэлээн удчихлаа. Тэгээд бас энэ завшааны дагуу Учрал гишүүний маань хууль нэгтгэгдээд хэлэлцэгдээд илүү одоо олон сайн санаанууд шилдэг туршлагауд шингээд явах байх гэж итгэж байна. Тэгээд хувийн нэмэлт тэтгэврийн хууль бол маш чухал. Энийг бол багц хууль дотор байгаа. Бид тэтгэврийг угаасаа олон давхаргат тогтолцоо руу шилжүүлж байгаа.

Нэгдүгээрх нь бол халамжийн сангаас авч байгаа тэтгэвэр, хоёрдугаарт нь нийгмийн даатгалын сангаас авч байгаа тэтгэвэр, гуравдугаарт нь хувийн нэмэлт тэтгэврийн сангаас авч байгаа ийм тэтгэвэр байх юм. Тэгээд тэтгэвэр, хувийн нэмэлт тэтгэврийн сан бол одоо шууд хууль нь батлагдах юм бол энэ бол бүрэн хуримтлалын тогтолцоо. Энэ хууль хэрэгжих юм бол одоо манай энэ нийгмийн даатгалын ерөнхий хуулиараа нийгмийн даатгалын сан нөөц сан нэрийн дансыг мөнгөжүүлж эхэлж байгаа. Энэ бол хагас хуримтлалын сан руу явж байгаа. Нөгөө талдаа бүрэн хуримтлалын зарчмаар хувийн нэмэлт тэтгэврийн сан одоо хэрэгжээд явах юм бол энэ хуулийнхаа дагуу тэрэн дээр одоо шилдэг туршлага, шилдэг менежмент, шилдэг хөрөнгө оруулалтын одоо энэ зарчмууд ингээд хэрэгжээд явах юм бол нийгмийн даатгалын ерөнхий сан дээрээ бас сайн жишээнүүд болоод хэрэгжих болно гэж үзэж байгаа.

Энэ хуримтлалын сан бол үндсэндээ энэ олон жил хоосон явсан хийсвэр бичилттэй хэдэн их наядаараа тооцогдож байгаа энэ нэрийн дансыг бодитоор мөнгөжүүлэхэд маш чухал хөрөнгө оруулалт нь болох юм. Монгол Улсын Ерөнхий сайд Синганур улсад 2022 оны 7 сард хийсэн албан ёсны айлчлалын үеэрээ Синганурын хамтын ажиллагааны байгууллагатай хуримтлалын сангийн туршлагыг Монгол Улсад нэвтрүүлэх

талаар яриа хэлэлцээр байгуулаад, гэрээнд гарын үсэг зурсан. Энэний дагуу бид нар одоо тодорхой одоо үе шаттайгаар хамтын ажиллагааны төслөө хэрэгжүүлж байгаа. Нэгдүгээр үе шатаа хэрэгжүүлээд, хоёрдугаар үе шат руугаа орсон. Энэ хуримтлалын санг бол манай улсын хувьд байгалийн баялгаасаа үүсэх боломжтой. Энэ чиглэлээрээ хууль дээрээ маш тодорхой зүйл тусгасан байгаа. Улмаар удахгүй Баялгийн сангийн хууль батлагдахаараа энэ Нийгмийн даатгалын ерөнхий хууль энэ тэтгэврийн сан руугаа одоо илүү одоо тодорхой байдлаар уяж өгөөд улмаар үүнийгээ тэтгэвэр авагчид тэтгэврээ зөвхөн тодорхой хэмжээгээр нь өвлүүлээд, хамтын тэтгэврийн зарчим хэрэгжүүлээд зогсохгүй тэтгэврээ мөн одоо зохих ёсоор тогтоолгоод зогсохгүйгээр орон сууц, боловсрол, эрүүл мэндийн хэрэгцээндээ мөнгөжсөн сангаасаа авах энэ боломж нь бодитоор бас бүрдэх юм. Үндсэн хуулийн маань зарчим ч гэсэн бас тийм байгаа гэдгийг хэлье.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Одоо дэмжсэн 3, дэмжээгүй 3 хүртэл гишүүд үг хэлж болно. Үг хэлэх гишүүд алга байна. Байнгын хорооны саналаар санал хураана. Гишүүд суудлаа эзлээрэй. Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох

тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлүүлэх тухай, Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд

өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Татварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эдийн засаг Эдийн засгийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, ЭМД-ын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор хураана.

Их Хурлын гишүүд санал хураалтдаа бэлтгээрэй. Саналын томьёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт. 53.7 хувиар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ. Дараагийнхаа асуудал руу нь орё.

17.34 цаг

Ес.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.01.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлснээс хойш тэтгэврийн даатгалын хамрах хүрээг өргөтгөх, сангийн чадавхыг бэхжүүлэх, тэтгэврийн нас шимтгэл төлсөн хугацааг үе шаттайгаар өсгөх, үнэ ханшийн өсөлт, амьжиргааны өртөгтэй уялдуулан тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, хүүхдээ асрах хугацаанд эхчүүдийн шимтгэл төлөлт тасрахгүй байх зэрэг олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тэтгэврийн даатгалын сангаас 2022 оны 11 дүгээр сарын байдлаар 474.3 мянган тэтгэвэр авагчид 2.8 их наяд төгрөг зарцуулаад байна. Өндөр насны тэтгэвэр авагчдын тоо нийт тэтгэвэр авагчдын 78.2 хувь буюу 371 мянгад хүрсэн. Түүнчлэн 10 даатгуулагчид ногдох тэтгэвэр авагчийн тооны харьцаа 2020 онд 4 байгаа бөгөөд 2025 оноос эхлэн хүн ам зүйн цонх үе хаагдаж, дундаж наслалт нэмэгдсэнээр нийт хүн амд эзлэх тэтгэвэр авагчдын тоо өсөж, 2030 онд 7, цаашид 2050 онд 9 тэтгэвэр авагч болохоор байна.

Хүн амын дундаж наслалт 2021 онд 71 жил болж, 26 жилийн өмнө буюу Нийгмийн даатгалын хуулийг анх батлах үеийн дундаж наслалтын түвшинтэй харьцуулахад 7.3 жилээр өссөн. Тухайлбал

эрэгтэйчүүдийн дундаж наслалт 67.1 болж 6 жилээр, эмэгтэйчүүдийнх 76.5 болж 11 жилээр тус тус өссөн байна. Тэтгэврийн насны хүн 2021 онд нийт хүн амын 10 хувийг эзэлж байсан бол 2030 онд 13.4, 2050 онд 19.4 хувьд хүрэхээр байна. Ирээдүйд бий болох хүн амын насжилт, тэтгэвэр авагчдын тооны өсөлт нь цаашид тэтгэврийн даатгалын сангийн зардал улс улсын төсвийн ачааллыг нэмэгдүүлэхээр байгаа тул хуулийн шинэчлэлийг зайлшгүй хийх шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн тав дахь хэсэгт өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй гэж заасан байдаг. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого Монгол Улсыг 2021-ээс 25 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийх, хувийн тэтгэврийн нэмэлт даатгалыг нэвтрүүлнэ гэж тус тус заасан.

Иймд дээрх үндэслэл, шаардлагад нийцүүлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлд олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн насыг жил бүр 3 сар нэмэгдүүлж буйг хэвээр үргэлжлүүлэх, тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинээр жил бүр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох аргачлалд өөрчлөлт оруулж, илүү олон жил шимтгэл төлөхийг урамшуулах, тэтгэвэр тогтоолгох дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр эсвэл нөхрийнх нь өндөр насны тэтгэврийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлдэг болох, хөдөлмөрийн

хүнд нөхцөлөөр цаашид тэтгэвэр тогтоохгүй байх зэрэг болон бусад зохицуулалтыг тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Тэтгэврийн даатгалын сан урт хугацаанд тогтвортой ажиллах, хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчин бүрдэж, ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжтой болох, төлсөн шимтгэлтэйгээ уялдсан тэтгэвэр тогтоох аргачлал нэвтрэх, хууль хоорондын зөрчил арилж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах зэрэг эерэг үр дагавар бий болох юм. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан 22 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм. Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон иргэн төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд одоо байгаа нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд нэмж хүний нөөц шаардахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой юм.

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг ишийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Өмнөх хуулийн ажлын хэсэгт ажилласан ажлын хэсгийн гишүүд хэвээрээ байгаа. Одоо чинь санал, дүгнэлтээ уншина тийм ээ. Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Батсүхийн Саранчимэг танилцуулна. Саранчимэг гишүүнийг индэрт урьж байна.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн

тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч олон давхаргат тэтгэврийн тогтолцоог нэвтрүүлэх, тэтгэврийн насыг жил бүр 3 сараар нэмэгдүүлж байгааг хэвээр үргэлжлүүлэх, тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинээр жил бүр нэмэгдүүлэх, тэтгэвэр бодох аргачлалд өөрчлөлт оруулж, илүү олон жил шимтгэл төлөхийг урамшуулах тэтгэвэр тогтоолгох дараалсан 7 жилийг 5 жил болгож бууруулах, нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр эсхүл нөхрийнх нь өндөр настны тэтгэврийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлдэг болох, хөдөлмөрийн хүнд нөхцөлөөр цаашид тэтгэвэр тогтоохгүй байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төслийг боловсруулсан байна. Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн даатгалын сан урт хугацаанд тогтвортой ажиллах, хувийн нэмэлт тэтгэврийн эрх зүйн орчин бүрдэж, ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжтой болох, төлсөн шимтгэлтэйгээ уялдан тэтгэвэр тогтоох аргачлал нэвтрэх, хууль хоорондын зөрчил арилж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангах зэрэг эерэг үр дагавар бий болгох, хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон иргэн төрийн байгууллагад нэмэлт зардал үүсэхгүй, одоо байгаа нийгмийн даатгалын тогтолцооны хүрээнд нэмж хүний нөөц шаардахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг D-парламент.мн цахим сайтад байр байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн нь цаг үеэ олсон чухам л чухал алхам болсон бөгөөд хуулийн төсөлд ахмад настны тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан

нэмэгдүүлэх, эдийн засгийн тооцоолол, судалгааны талаар болон хуваарилалтаас хагас хуримтлалын тогтолцоонд шилжих шилжилтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг уг хуулийн төсөл батлагдсанаар нийгмийн даатгалын сангийн алдагдал хэдэн хувиар буурах тооцооллын талаар болон Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт тэтгэвэр авагчийн тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулж жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэмэгдүүлнэ гэсэн зохицуулалт нь хуулийн төсөл батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болох эсэх талаар, эдийн засгийн хямралт нөхцөл байдалтай инфляц өндөр байгаа тохиолдолд төсөвт хэр хэмжээний нэмэлт зардал гарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Туваан хувийн тэтгэврийн тогтолцооны эрсдэлийг хаах зохицуулалт хуулийн төсөлд туссан эсэх талаар, өндөр настны тэтгэврийг тогтоохдоо 7 жилийн дунджаар биш 5 жилийн дунджаар тогтооход хэдэн төгрөгийн нэмэлт зардал гарах тооцоо судалгааны талаар, хэсэг хугацаанд НДШ-ээ өндөр төлж тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тоо болон тэтгэврийн хэмжээ энэ шалтгааны улмаас иргэдийн тэтгэврийн зөрүү харилцан адилгүй болж, иргэдийн дунд бухимдал үүсээд байгаа тул дахин ийм хуулийн цоорхойг гаргахгүйн тулд хуулийн төсөлд анхаарсан эсэх талаар, нас барсан тэтгэвэр авагчийн эхнэр эсхүл нөхрийнх нь өндөр насны тэтгэврийн хэмжээг хэдэн хувиар нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгасан талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа тэтгэвэр тогтоолгосон иргэдийн үргэлжлүүлэн ажил хөдөлмөр эрхлэх зохицуулалтын талаар, ахмад настны асрамжийн газрын ихэнх ахмадуудын тэтгэврийг үр хүүхдүүд нь авч хэрэглэх асуудлыг таслан зогсоож ахмадуудад зөвхөн гарт нь олгох асуудлыг хуулийн төсөлд тусгасан эсэх талаар, хил дээр ажиллаж байгаа алба, албан хаагчдын эхнэр эсхүл нөхөр тэтгэвэр тогтоолгох боломжгүй байдаг асуудал хуулийн төсөлд туссан эсэх талаар тус тус асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу жаран хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн тухай, дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэгч журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр,

тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Хэн байна вэ? Ж.Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Энэ нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль. Энэ багц хуулийн одоо хамгийн гол амин хэсэг тэтгэвэртэй холбоотой. Тэгэхээр энэ дээр би түрүүн бас нэг асуулт асуугаад хариулт сайн авч чадаагүй. Яг сайн дураар шимтгэл төлж байгаа иргэдийн тэтгэвэр нэмэгдэх үү, буурах уу? Яг энэ дээр одоо ажлын хэсэг сайд нэг тодорхой хариулт өгөөч. Энэ хэдүүлээ одоо энэ хууль хэлэлцэж байгаа үед бол яг тодорхой л юмаа ярьсан нь дээр.

Хоёрдугаарт нь энэ нэрийн дансны одоо мөнгөжүүлэх, нэрийн дансыг мөнгөжүүлэх гээд 24 их наядын хий бичилттэй явж байгаа. Тэгэхээр энийг ойролцоогоор нэг ажил олгогчоос НДШ төлөгчөөс нэг, нэг хувиар аваад явахаар жилдээ нэг 300 орчим тэрбумын одоо юу төлөлт орох нь л дээ. Тэгээд 24 их наяд чинь цаашаа үргэлжлээд явахаар энэ чинь 300 их наяд 300 тэрбумаар бодохоор чинь нэг 80 жил орчим. Тэгэхээр бол энэ

бүтэхгүй. Тэгэхээр энийг тэр түрүүн төрийн нарийны үгэнд гарч байсан. Тэр 1995 оноос өмнө НДШ-ээ улсууд төлж л байсан шүү дээ. Тэр мөнгийг одоо ер нь хэн төлөх ёстой юм бэ? Энэ дээр энэ Сангийн яамтайгаа ойлголцсон, Засагтайгаа одоо ойлголцсон бусад эх үүсвэр энэ тэр гээд ярьсан юм байна уу. Энэ хуулийн чинь концепцыг харахаар энэ хуримтлалын тогтолцоонд орох буюу энэ нэрийн дансыг мөнгөжүүлж байж л нэлээн олон асуудал шийдэгдэхээр харагдаад байна шүү дээ. Яг энэ дээр бол ямар одоо бодлоготой энэ хуулийн төсөлд туссан бэ?

Энэ малчдын тэтгэвэр, ногоочдын тэтгэвэр гээд одоо ингээд энэ ХАА-н салбарт ажиллагсад дээр энэ тэтгэврийн асуудал маш хүнд байгаа. Эд нар маань одоо олон жил ажилтай, ажилгүй явж ирсэн. НДШ төлөлт маш бага, хамрагдалт маш багатай ийм хүмүүс дээр одоо тэр малчид дээр НДШ дээр бас нэг бодлого явуулна гээд ингээд ярьж байна. Бусад энэ ХАА-н салбарт ажиллагсад дээр ямар бодлого баримталж байгаа вэ? Энэ хуульд орсон зүйл заалт байна уу?

Дараагийн асуулт нь байна. Энэ тэтгэврийн зээлийнхээ журмыг нэг хэлээдхээч бас нэг журам байна уу үгүй юу? Одоо хөдөө орон нутагт явж байхад Хаан банк, Төрийн банкнаас нэг 6 сараас илүү тэтгэвэр барьцаалсан зээл олгохгүй л явж байсан. Сүүл рүүгээ энэ тавиад туучих шиг болсон. Зээлийн чинь энэ бүртгэлийг харахаар нийт тэтгэвэр авагчийн бараг 40 хувь нь 500-гаад тэрбум төгрөгийн зээлтэй харагдаад байна. Энэ дээр албан ёсоор одоо баримталж байгаа яг ийм журам байна уу? Дараа нь нэг юм энэ нийгэм юу хөдөлмөрийн дэвтэр гэж ярьдаг байсан одоо нийгмийн даатгалын дэвтэр. Энийг бид нар одоо цахимжисан гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ цахимжилт чинь одоо яг хэдэн хувь байна вэ? 100 хувь цахимжсан уу гэдэг нэг асуулт байгаа юм. Тэгээд иргэдтэй уулзаад явж байхад нэг газар харьяалагдаад ажиллаж байгаад тэтгэврээ тогтоолгогчоод өөр газар шилжиж очоод тэтгэврээ ингээд

шилжүүлэх тэтгэвэртэй холбоотой асуудал ярихаар нөгөө өмнөх газар руугаа оч гээд. Одоо нэг аймгаас хот руу аймгаас аймаг хооронд ингээд шилжчихсэн хүмүүс энэ асуудлыг хэрэв тэр цахимжилт чинь үнэн юм бол энэ хүмүүсийг чирэгдүүлж байх хэрэггүй л баймаар санагдаад байгаа юм. Тэгэхээр энийг нэг хариулж өгөөч.

Тэгээд энэ би нэг хуулийн төсөл өргөн барьсан Их Хурлын даргад. Энэ нас барсан НДШ төлөгчийн зээлийг зээл юу зээлээс чөлөөлөх тухай гээд. Энэ талаар ер нь боломж байна уу? Насаараа НДШ 30 жил, 40 жил төлж төлчхөөд одоо нас барчхаж байгаа юм. Тэтгэвэр одоо жил ч авч чадахгүй нас барчхаж байгаа ийм хүмүүс дээр ер нь энэ зээлийг нь чөлөөлчих, барих ийм асуудал.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Би түрүүн таны бас асуусан асуултыг тэмдэглээд байж байсан юм. Зарим асуултууд бас үлдсэн байна. Тухайлбал тэтгэвэр хууль батлагдсанаар нэмэгдэх үү. Энэ дотор сайн дураар одоо шимтгэл төлсөн хүмүүсийн тэтгэвэр нэмэгдэх үү гээд. Сайн дураар болон албан журмаар одоо даатгалд хамрагсдын бүгдэнгийнх нь тэтгэвэр нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Энэ яаж бүрдэх вэ гэхээр хамгийн гол зүйл бол үнийн одоо өсөлттэй уялдуулан жил болгон бүр хугацааг нь заачихсан байгаа. Нэгдүгээр улиралдаа багтаагаад сайн дурын, албан журмын бүх одоо шимтгэл төлөгчдийн хувьд тэтгэвэрийн хэмжээ нь бол нэмэгдэнэ нэгдүгээрт.

Хоёрдугаарт сүүлийн 2019 оноос эхлээд 6 жилээр, 7 жилээр тэтгэвэрийн одоо дунджийг тооцон энэ хүмүүс маань сайн дурын болон албан журмаар даатгуулж байгаа хүмүүс бүгдээрээ байгаа. 19-өөс 22 оны хугацаанд бол одоо яг энэ багаар илүү багаар тодорхой хэмжээнд багаар тогтоогдсон зайлиггүй залруулах шаардлагатай 48000 орчим хүмүүс дээр 60.4 тэрбум төгрөгийг одоо

нөхөж олгохоор бид нар тооцоо хийсэн. 23 онд хорь орчим тэрбум төгрөгийг бас мөн одоо нэмж санхүүжүүлэхээр тооцоо хийсэн. Эдгээр 6 болон 7 жилээр тогтоолгосон сайн дураар даатгуулсан болон албан журмаар даатгуулсан энэ одоо тэтгэвэр авагчдын маань тэтгэвэрийн хэмжээ бол бас шууд одоо нэмэгдэх ийм үр дүнтэй.

Нэрийн дансны асуудлыг мөнгөжүүлэх бол маш чухал. Бид нар үе шаттайгаар хэрэгжүүлье. Их олон жил энэ бол хийсвэрээр одоо 24 их наядын хэмжээнд одоо хийсвэр бичилт хий бичигдсэн байгаа, хүү хийсвэрээр тооцогдож байгаа. Энэ яагаад хийгдсэн гэх юм бол Нэрийн дансны хуулиараа энэ 1979 болон түүнээс хойш төрсөн хүмүүс 29 оноос эхлээд одоо анхны хүмүүс нь тэтгэвэрт гарна. Ингээд нэрийн дансны аргаар энэ хүмүүс маань тэтгэвэртээ гарах зохицуулалттай. 60 оноос 79 оны хооронд төрсөн хүмүүс бол ингээд сонголттойгоор тэтгэврээ тооцуулна. Тэгэхээр бид нар энэ нэрийн дансыг заавал мөнгөжүүлэх ёстой. Тэгэхийн тулд энэ 2 хувь бол зөвхөн одоо эхний үе шатны 2 хувь бол. Жилийн та хэллээ 300 тэрбум төгрөг энэ бол тооцоо мөн байна. Үүний зэрэгцээгээр хамгийн гол орж ирэх мөнгө нь бол энэ бид нар энэ хуримтлалын нэгдсэн сан бий болгож байгалийн баялгийнхаа энэ үр ашгаар энэ одоо нэрийн дансыг мөнгөжүүлэх энэ асуудлыг бол үр дүнтэйгээр хийнэ гэсэн ийм тооцооллыг хийсэн.

Одоогийн байдлаар Ирээдүйн өв сангийн тухай хүчин төгөлдөр хуультай уншсан байгаа. Удахгүй Баялгийн сангийн хууль батлагдахаар Баялгийн сангийн хуультайгаа уяна. Ингээд бодит тоотой бодитой хуримтлалууд бол бий болгох ийм боломжтой. Бүрэн тэтгэврээ бүрэн хуримтлалаа бид нар 2044 онд бүх одоо нэрийн дансыг гүйцэд мөнгөжүүлнэ гэж ингэж тооцож байгаа. Одоо хууль батлагдангуутаа одоо хагас хуримтлалын тогтолцоонд шилжиж байгаа.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүний асуултад ажлын хэсэг нэмж хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Сайдынхаа ярьсан дээр нэмээд. Сайн дураар НДШ төлж байгаа хүмүүсийн тэтгэвэр бол ерөөсөө бодолт дээр буурахгүй, цаашидаа харин ч нэмэгдэнэ. Ялангуяа энэ тэтгэврийг индексжүүлэх, инфляцын түвшинтэй уялдуулаад бүх хүмүүсийн тэтгэвэр бол одоо ингээд нэмэгдээд явах боломжууд нь нээгдэнэ. Дээр нь нэмээд сайн дураар даатгуулж байгаа ч гэсэн олон жил одоо шимтгэл төлсөн энэ хүмүүсийг урамшуулах бодолтын хэмжээнүүдийг нь бид нар бас нэмж өгсөн. Тийм учраас өөрөөр хэлбэл нэмэгдэнэ гэдгийг бас хэлье.

Туваан гишүүн бас сая чухал асуудал хөндлөө. 95 оноос өмнө НДШ харилцаа үүсээгүй байх улс хариуцаж байсан үед ажиллаж байсан олон хүний асуудал байгаа. 95 оноос өмнө нийгмийн даатгал юу улсад ажиллаж байсан хүмүүсийн тэтгэврийг бол өнөөдөр бид нарын шимтгэлээр буюу шимтгэл төлж байгаа хүмүүсийн шимтгэлээр тэтгэврийг нь өгөөд явж байгаа. манай яам бол юу гэж үзэж байгаа вэ гэхээр 95 оноос өмнө ажилласан бүх жилүүдийн одоо шимтгэл дүйцэх мөнгийг бол улсаас бол өгөх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа. Бид нар бол өөрсдийнхөө түвшинд бол тодорхой хэмжээний тооцоонуудыг хийсэн. Түрүүн би хэлсэн 8, 9 орчим их наяд төгрөгийг бол одоо бас энэ нийгмийн даатгалын санд бол 95 оноос өмнө ажилласан жилд нь бол ноогдох ийм тэтгэвэр бол бас байгаа гэдгийг бол мөнгөн дүн байгаа гэдгийг хэлье.

Та бас малчдын НДШ-ийн хамрагдалтыг нэмэгдүүлэх, ноос ноолуур, сүүний урамшууллыг одоо бас урамшууллаас нь суутгах ийм хуулийн төсөл бол өргөн барьсан. Бид нарын бас санаачилсан энэ хуулийн төслийн 21.8 дээр бол ялангуяа энэ ХАА-н салбарт ажиллаж байгаа хүмүүсийн ноос, сүү, арьс ширний

улаан буудайн урамшууллаас нь одоо суутгах агуулгатай ийм зохицуулалт бол одоо бас байгаа гэдгийг хэлье. Тэтгэврийн зээл бол нийгмийн даатгалын байгууллага болон төрийн байгууллагын ямар нэгэн оролцоогүйгээр банк тэтгэвэр авагч хоёрын хооронд одоо гэрээгээр явдаг ийм банкны одоо бүтээгдэхүүн. Бид нар бол энэ үйл ажиллагаанд бол одоо ямар нэгэн байдлаар бол бас оролцож байгаагүй, оролцдоггүй бас ийм бүтээгдэхүүн гэдгийг хэлье.

Цахимжилттай холбоотой асуудлыг ярилаа. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол нийгмийн даатгалын бүх үйлчилгээнүүдийг ихэнхийг нь цахимжуулсан. Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 24 үйлчилгээг цахимжуулсан. 24 үйлчилгээг цахимжуулахад бол жилд бол бид нар нийтдээ нэг 12 тэрбум төгрөгийн одоо хэмнэлт бол үүсэж байгаа. Цаашид бүх үйлчилгээг цахимжуулна. 95 оноос өмнөх архивын бүх бичиг баримтуудыг бол цахимжуулсан. Үүний үр дүнд бол иргэн бол Монгол Улсын аль ч өнцгөөс дэлхийн хаанаас ч одоо өөрөөр хэлбэл тэтгэврээ цахимаар бодуулаад тооцооллоо хийх энэ бүрэн боломж бололцоонуудыг бол бид нар бас нээж өгсөн гэдгийг бол хэлье.

Л.Мөнхбаатар: Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Тэр тэтгэвэртэй холбоотой асуудлаар энэ шилжилт хийгдсэн дээр нэмэлт хариулт авъя. Хоёрдугаарт тэр миний өргөн барьсан Нас барсан өндөр настны тэтгэврийн зээл авагчийн тэтгэврийн зээлийг чөлөөлөх тухай хуулийн талаар та бүхэн мэдэж байгаа юу? Энэ талаар бас энэ олон жил төлчхөөд үр ашгийг нь хүртэж чадаагүй нас барсан иргэдтэй холбоотой асуудал яг энэ хууль дээр чинь яг яаж орж ирсэн юм бэ?

Дараагийн асуулт нь энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өсөөд 550000 болсон шүү дээ. Энэтэй холбоотойгоор НДШ төлөлт, сайн

дурынхан маань бол төлөлт нэмэгдэж байх ёстой. Тэгээд одоо энэ жил I сарын I-нээс 550 болсонтой холбогдуулаад сайн дураар төлж байгаа хүмүүсийн сарын, жилийн НДШ төлж яг хэдэн төгрөг байгаа вэ? Энийг нэг иргэдэд маань нэг мэдээлэл өгөөдхөөч.

Л.Мөнхбаатар: Нэмэлт тодруулга асуултад ажлын хэсэг хариулъя. Өнөрбаяр дарга хариулъя.

Г.Өнөрбаяр: Хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтрийг бол бид нар бүрэн цахимжуулсан. Ингэснээр бол өөрөөр хэлбэл хөдөлмөрийн нийгмийн даатгалын дэвтэр дээр бичилт хийх зайлиггүй юу шаардлага бол байхгүй болсон. Бүх үйл ажиллагаа цахимаар явсан. Цахимаар бий болсон учраас нийгмийн даатгалын ийм шимтгэл төлөлгөөтэй холбоотой асуудлыг бол бүгдээрэнг нь ингээд цахимаар зохицуулаад явж байгаа учраас иргэдэд бол ямар нэгэн хүндрэл чирэгдэл байхгүй. Харин тэтгэврийн зээлийг тэглэхдээ бол нэг 637 орчим тэрбум төгрөгийн тэтгэврийн зээлийг бол одоо бас тэглээд явсан. Одоо бол, тэр нь юу юм.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд ажлын хэсэг үү? 85 дугаар микрофоныг өгье ажлын хэсгийн. Нэмээд хариулъя.

А.Хишигбаяр: Туваан гишүүний асуултад хариулъя. Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Хишигбаяр. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ энэ жил I сарын I-нээс эхлээд 550000 болсон байгаа. Тэгэхээр сайн дурын даатгуулагч сардаа 74250 төгрөг хамгийн бага хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцоод төлөхөд төлнө. Жилдээ 891000 төгрөг төлөхөөр байгаа.

Л.Мөнхбаатар: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ тэтгэврийн одоо энэ хуучин тогтолцоотой холбоотой бас нэлээд олон гомдлууд асуудлууд бас байдаг байсан. Тэгээд энэ шинэчилсэн найруулгаар бас нэлээн олон зүйлүүд

шинэчлэгдэж орж ирж байгаа байх гэж одоо бодож байна. Иргэдтэй бас уулзаад явж байхад бас энэ тэтгэвэртэй холбоотой нэлээд одоо олон асуудлууд ярьдаг. Тэднийг одоо яаж энэ шинэ хуулиар шийдэж байгаа вэ? Тухайлбал одоо нэг өнгөрсөн жил тэтгэврийн доод хэмжээ гэж 500000 төгрөг болсон. Тэгээд энэ дээр өнөө 500000 авдаг байсан тэр хавьцаа авдаг байсан эмч багш нарын хувьд одоо их зөрүү бий болчихлоо. Бид нар шалтай өссөнгүй гэдэг асуудлууд байгаа. Үүнийг цаашидаа яаж засах юм гэдэг дээр бас иргэд их асуудаг.

Мөн тэр нөгөө дараалсан 7 жилийг одоо 5 жил болгох ёстой гэдэг асуудлыг бас уулзалт болгон дээр одоо иргэд маань бас ярьдаг. Мөн улсад нийгмийн даатгал насаараа төлчхөөд 60 хүрээд тэтгэвэрт гараад 61-тэй нас барчихдаг ингээд тэтгэврийнхээ авч чаддаггүй үр шимийг нь авч чаддаггүй. Үүнийг тодорхой хэмжээгээр бас энэ хуулийн төсөл дээр эхнэр болон үлдэж байгаа хүн хүнд нь одоо өвлүүлдэг болох юм шиг байна. Энийгээ нэг тодруулаадхаач. Хүмүүс бол их асуудаг шүү дээ энийг. Өвлүүлээд одоо ар гэрт нь эхнэр, нөхөрт нь өвлүүлээд явах ямар боломж байдаг юм гэж одоо асуудаг.

Тэгээд тэтгэвэр маань одоо цалин хөлс нэмэгдээд байдаг, инфляц өсөөд байдаг тэтгэвэр ганцаараа үлдээд ингээд байдаг гээд ярьдаг. Үүнийг цаашидаа яаж одоо юмны үнийн өсөлттэй, инфляцтай уялдуулж цаашаа жил болгон нэмж явах юм бэ гэсэн нэг ийм асуудлууд байна. Тэгээд цаашилах юм бол энэ шинэ хууль батлагдсанаараа тэтгэврийн одоо сан маань өөрөө өөрийгөө ер нь цаашид аваад явах боломж байгаа юу? Аль эсвэл дандаа одоо улсын төсвөөс татаас аваад л ингээд одоо цоорхойгоо нөхөөд цаашидаа яваад байх юм уу? Цаашидаа тэтгэврийн одоо энэ санг ингээд өсгөөд байх ийм боломж өөрийг нь одоо ямар нэгэн байдлаар арилжаанд оруулаад өсгөх ийм одоо бас боломж бүрдэх үү гэсэн ийм зүйлүүд дээр бас тодруулга авъя. Тэгээд ер нь товчхон, товчхон бас энэ хуулийнхаа гол

онцлогуудыг бас хэлээд өгчихвөл сайн байна.

Л.Мөнхбаатар: 18 цаг болсон байна. Өнөөдөр Нийгмийн даатгалын багц хуулийг өнөөдөр хэлэлцэх шаардлагатай байгаа учраас цаг сунган хуралдана гэдгийг та бүгдэд хэлье. Наранбаатар гишүүний асуултад Аюурсайхан сайд хариулъя.

С.Аюурсайхан: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Үндсэндээ тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн шийдвэрийг бас гаргасан байгаа. Тийм ээ. Улсын Их Хурал төсөв тодотгол хийгээд Засгийн газраас авч хэрэгжүүлсэн 2022 оны 2 дугаар сард хийсэн тодотголоор хийсэн. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 500, хувь тэнцүүлсэн 400 мянган төгрөг болсон байгаа. Энэ үед бол бас тодорхой доод хэмжээнээс дээгүүр тэтгэвэр авч байгаа багш, эмч, дунд шатны тэр битгий хэл удирдах албан хаагчаар ажиллаж байсан хүмүүсийн маань тэтгэвэр бол доод хэмжээнд хүрсэн ийм гомдол саналууд бол ихээр ирж байгаа. Энэ хүмүүсийнхээ бид нар тооцоо хийгээд, энэ хүмүүсийн одоо тэтгэврийн зөрүүг гаргаж цэгцлэхэд одоо 55 орчим тэрбум төгрөг хэрэгтэй гээд сая төсвийн хэлэлцүүлгээрээ бас Төсвийн байнгын хороон дээр бид нар ярьсан. Хэрэгжиж чадаагүй. Энийг хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэ зөрүү юунаас бий болоод байсан бэ, яаж засах вэ гэж та асууж байна. Зөрүүг бол юунаас үүссэн бэ гэхээр энэ ижил ажил мэргэжил хашиж байгаа хүмүүс өөр цаг хугацаанд тэтгэвэрт гарахаараа тэтгэвэр нь зөрүүтэйгээр өөр байдлаар тогтоогдоод байгаа юм. Тухайлбал 2000 онд багшаар ажиллаж байсан хүний тэтгэвэр 2020 онд багшаар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан 2 хүний тэтгэвэр бол өөр, өөр байгаад байгаа юм. Юунаас болсон гэх юм бол тэтгэврээ тогтоох итгэлцүүрийг жил болгон тогтоож байх ёстой, хэрэглэж байх ёстой энэ тэтгэврийг тооцоход. Гэтэл хамгийн сүүлд тэтгэвэр итгэлцүүрийг 2014 онд итгэлцүүрийг

тогтоогоод, тэр итгэлцүүрээрээ өөрөөр хэлбэл 7, 8 жилийн тэтгэврийг тооцоолоод явчихсан. Энэнээс болоод зөрүү ихэссэн ийм асуудал байгаа.

Тийм учраас энэнээс яаж гарах вэ гэхээр энэ багц хуулийнхаа шинэчлэл дээрээ тэтгэврийг тооцоолох энэ итгэлцүүрийг жил болгон тогтооно. Жил болгон хэрэглэнэ гээд. Тэгэхээр энэ бол цаашидаа үнийн одоо өөрчлөлтөөс болон цаг хугацааны өөрчлөлтөөс үүдсэн тэтгэврийн зөрүү үүсгэхгүй байх эрх зүйн юу нь ингээд шаардлага нь хангагдаад явчих юм. 7 жилийг 5 жил болгох энэ асуудлыг бол хуульдаа оруулсан байгаа. Энэ бол үнэхээр одоо тэтгэвэр авах гэж байгаа хүмүүс дээр бодитоор дунджаар 60000 төгрөгөөр дутуу тогтоогдож байгаа. нэ бол тэтгэвэр даатгуулагчдын эрх ашигийн асуудал байгаа учраас бид нар энийг залруулна. Өмнө нь 2019-өөс 22 онд одоо 6-7 жил тогтоогдсон хүмүүс нөхөж нөхөн олговор олгоход 60.4 тэрбум төгрөгийг бид нар олгоно гээд тооцоолсон. 23 онд энэ чиглэлээр хорин тэрбум төгрөг нэмж одоо улсын төсөвт оруулна.

Нас барсан иргэд тэтгэврийнхээ шимтгэлийнхээ үр шимийг авч чаддаггүй. Энэ энийг бол бид нар тодорхой хувиар өвлүүлдэг болгож байгаа. Мөн түүнчлэн нас барсан гэр бүл нь тэтгэвэр нь 20 хувиар бас нэмэгдэж байхаар эрх зүйн орчныг нь бүрдүүлж байгаа. Энэ бол бид нарын хагас хуримтлалын тогтолцоонд шилжүүлэхийн хамгийн том бас одоо үр шимүүдийн нэг нь гэж бодож байгаа.

Л.Мөнхбаатар: Аюурсайхан сайд гүйцээгээд харуулчихъя.

С.Аюурсайхан: Баярлалаа. 4 дэх асуултад тэтгэврийг инфляцтай яаж уялдах вэ. Энэ тэтгэвэр бол үндсэндээ манай ахмадууд үргэлж үнэ яаж өсөж байгаа билээ. Гэтэл тэтгэвэр нь тэр хэмжээгээр өсдөггүй. Хаа нэг өсдөг. Тэр нь одоо үнийн өсөлтөө гүйцдэггүй учраас бид нар хуулиар тогтоочихъя. Жил болгон инфляцын түвшинтэй уялдуулаад

нэгдүгээр улиралдаа багтаагаад шууд хуулиараа нэмэгддэг Засгийн газрыг үүрэгжүүлдэг ийм болгоод өгсөн байгаа гэдгийг бас танд хэлье.

Тэтгэврийн сан бол өөрийгөө авч явах боломжтой. Тэтгэврийн санд хийсэн мөнгөн хуримтлалыг нэгдүгээрт эрсдэлээс хамгаалах, хоёрдугаарт өсгөж арвижуулах энэ асуудлуудыг хууль дээр бас тодорхой тусгасан байгаа гэдгийг танд хэлье.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр асуулт асууна.

Б.Энхбаяр: Баярлалаа. Бид Монгол Улсын бүх хүнд хамаатай маш чухал ийм суурь шинэтгэлийг ярьж байна. Энэ шинэтгэлийг одоо харж байгаа маш олон хүн байгаа. Тэгэхээр би нэг 2 чиглэлийн асуулт байгаа юм. Нэгдүгээрт одоо тэтгэвэр авч байгаа тэтгэврийн насны ахмадууд маань яг одоо шууд үйлчлэх, тэдэнд хамаатай үйлчлэх ямар асуудал энэ тэтгэврийн тухай хуульд байгаа вэ?

Хоёр дахь асуулт нь одоо НДШ-ийг яг төлж байгаа идэр насны дөч хүртэлх насны залуучууд 20 жилийн дараа тэтгэвэртээ гарах одоо идэр насны залуучуудад 20 жилийн дараа одоо таны нийгмийн баталгаа тэтгэвэр тэтгэмж бол одоо лав энэ өнөөдрийнх шиг байхгүй ээ, ийм өгөөжтэй гэсэн бас ямар зүйл байгаа вэ?

Гурав дахь асуудал нь бол яах вэ, миний хувьд сонгогчидтойгоо уулзаж байхад бас нэлээн их ярьж байгаа. Ялангуяа өнгөрсөн онд зарим ахмадуудын тэтгэврийн доод хэмжээг одоо нэмсэн. Энд бол ахмадууд маань бас талархалтай тухайн үед хүлээж авч байсан. Одоо энэ бол мэдээж алга болсон. Тэр нэмсэн зөрүүг тэрнээс хойш энэ юмны үнийн өсөлт аль хэдийн давсан. Тэгэхээр тэр үед уулзалт хийж байхад бол одоо манай бас олон ахмадууд ярьж байсан. Энэ тэтгэвэр ялангуяа энэ төр засаг маань жоохон шударга байгаач бидэндээ. Одоо миний хувьд одоо 30 жил тодорхой хэмжээгээр

ингээд сургуульд хичээл эрхлэгчээр ажилласан, багшаар ажилласан. Одоо би тэтгэвэр авч байгаа нь одоо бас тухайн үед одоо үйлчлэгчтэйгээ би одоо адилхан тэтгэвэр авдаг болчихлоо. Залуу халуун насан дээрээ одоо арай илүү ачаалал авч байсан, арай илүү ур чадвар шаардаж байсан, арай илүү хүнд хүчир хөдөлмөр хийж байсан тэр утгаараа арай илүү хариуцлага үүрч цалин авч байсан энэ хүмүүсийн одоо энэ ялгаа зааг гэж байхгүй юм уу? Уг нь энэ шударга ёс гэдэг чинь бол бүх юмыг адилтгах гэсэн үг биш шүү дээ. Хэн илүү ур чадвартай, хэн илүү хөдөлмөрлөсөн, хэн илүү ачаа үүрч, хариуцлага үүрч тэр тухайн үед тухайн үедээ тэтгэврийн санд илүү их хэмжээгээр энэ сангийн орлогыг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулсан нь тэр хэр хэмжээгээрээ илүү авдаг байхгүй юм уу. Энэ чинь л одоо шударга ёс гэж энийг чинь ойлгоод байгаа шүү дээ гэж жишээлбэл надаас аягүй их асуусан. Өөрөө одоо их шударга ёс их ярьдаг хүн. Энэ тэтгэвэр чинь өөрөө шударга ёс байх ёстой шүү дээ гэдэг асуултыг маш олон хүмүүс надад хандаж тавьж байсан. Тэгэхээр би тэр надаас одоо нэхэл хатуутай асууж байсан иргэд сонгогчдынхоо надад хандаж тавьж байсан тэр асуултыг бас сайдад ханд тавья. Энэ дээр одоо ямар бодлого барьж орж ирсэн бэ гэсэн ийм асуулт байна.

Г.Занданшатар: Төмөрбаатарын Аюурсайхан сайд хариулъя.

Т.Аюурсайхан: Энхбаяр гишүүний асуултад хариулъя. Үнэхээр таны хэлж байгаа энэ одоо нийгмийн даатгалын багц хуулийн асуудал бол одоо нэг орчим сая даатгуулагчид хагас сая одоо тэтгэвэр авагчдын бас анхааралтай харж байгаа, шууд одоо тулгамдсан асуудал нь мөн. Энэ хууль батлагдсанаар ахмадуудад бол шууд үйлчилнэ. Яаж үйлчлэх вэ гэх юм бол тэтгэвэр нь одоо бодитойгоор шууд нэмэгдэх нөхцөл боломж нь хуулиар бий болно. Яаж уу нэгдүгээрт хамгийн түрүүнд та хэллээ. Үнийн өсөлтийг одоо гүйцдэггүй гэж. Үнийн өсөлттэй уялдуулаад жил бүр нэгдүгээр улиралдаа

багтаагаад Засгийн газар ингээд тэтгэврээ нэмэгдүүлж байх үүргийг хуулиараа хүлээж байгаа.

Хоёрдугаарт тэтгэвэр тогтооход энэ итгэлцүүрийг жил болгон тооцож шинэчилж байгаагүйгээс болоод тэтгэврийн зөрүү үүсээд байгаа юм. Урьд өмнө нь өөр хугацаанд ижил ажил мэргэжил хашиж байсан хүмүүс тэтгэвэрт гарахаар өөр, өөр тэтгэвэртэй байгаа нь зүй бус. Тийм учраас энийг нь одоо зөрүү гаргахгүйн тулд жил бүр итгэлцүүрээ шинэчилж, хэрэглэж байхыг бас хуулиар Засгийн газарт үүрэг болгосон байгаа.

Гуравдугаарт тэтгэвэр тооцох дундаж 7 жилээс 5 жил болсон болох энэ асуудлыг тусгасан байгаа. 19 оноос эхлээд 6, 7 жил гээд үе шаттайгаар явсан. Энд бол одоо 48 орчим мянган ахмадын тэтгэвэр дунджаар 60000 төгрөгөөр бага тогтоогдсон байгаа. Энийг нь бол бид нар одоо ахмадуудынхаа шимтгэл төлөгчдийнхөө даатгуулагчдынхаа байр байдлыг нь дордуулсан байна гэж үзээд засаж залруулаад мөн одоо нөхөн олговор олгох асуудлыг одоо хэрэгжүүлэхээр тооцоолсон байгаа.

Үүний зэрэгцээгээр ахмадууд, мөн түүнчлэн одоо ид одоо шимтгэл төлж байгаа залуучуудын хувьд нэрийн данс мөнгөжнө гэдэг асуудал болбол маш чухал. Нэрийн хийсвэр дансыг мөнгөжүүлнэ гэдэг бол олон төрлийн эдийн засгийн ач холбогдолтой. Мөн түүнчлэн энэ нийгмийн даатгалдаа итгэх итгэлийг сэргээнэ. Ирээдүйдээ одоо хүн хэчнээн төгрөгийг ямар хэмжээгээр, ямар хугацаанд төлсөн тэрэнтэйгээ нийцсэн бодит нэрийн дансныхаа нөхцөл байдлаас шалтгаалж, тэтгэврээ тогтоолгох ийм шударга ёсны зарчим бол үйлчлэх юм. Үүний зэрэгцээгээр нэрийн данс мөнгөжихөөр мөн одоо энэ олон эх үүсвэрийг хууль дээр заасан байгаа. Байгалийн баялгаас оруулах мөн одоо төсвөөс хариуцах, сангаасаа хариуцах гээд. Тэгээд энэ эх үүсвэрээсээ нэрийн данс мөнгөжих юм бол энэ дээрээ хуримтлал

бий болгоод, энэ хуримтлалын сангаасаа залуучууд маань ирээдүйд одоо энэ орон сууцынхаа урьдчилгааг авах, орон сууцынхаа одоо ипотект хамрагдах, сургууль соёлынхоо төлбөрийг төлөх, эрүүл мэндийнхээ одоо үйлчилгээ ихээхэн зардал гарах жишээлбэл одоо маш одоо хүнд хагалгаанд ороход их мөнгө хэрэг болдог. Энэ одоо нөөц сангаасаа авах энэ бүх боломжуудыг нь бид нар бүрдүүлсэн.

Тийм учраас энэ энийг хийхийн тулд энэ хууль батлагдах юм бол бодитоор нэрийн данс маань мөнгөжсөөд эхлэх юм. Ахмадуудын хувьд энэ тэтгэврээ хамтын тэтгэврийн зарчим буюу одоо хань ижил нь одоо нас барах юм бол үлдсэн хань ижлийнх нь тэтгэвэр нь одоо нэмэгдэж байх. Тухайлбал шууд 20 хувиар нэмэгдэж байх бол хууль батлагдаад шууд хэрэгжих юм. Мөн түүнчлэн энэ нэрийн дансыг мөнгөжүүлсний үндсэн дээр бид нар энэ тэтгэвэр бол өвлөгддөг байх энэ хууль, эрх зүйн орчныг нь одоо бүрдүүлсэн байгаа гэдгийг танд хэлье.

Үнийн өсөлтийг 2022 оны 2 дугаар сард Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурал төсвийн тодотгол хийсний үр дүнд тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлсэн, нийт тэтгэврийг нэмэгдүүлсэн байгаа. Энэ бол үнийн өсөлтөөс хоцорч байгаа. Тийм учраас энэ үнийн өсөлттэй уяаж нэмэгдүүлэхийг энэ хууль батлагдсанаар хэрэгжих боломж нь гарна. Энэний өмнө энэ тэтгэврийн зөрүүг гаргах шаардлагатай энэ арга хэмжээг.../минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн. МАН-ын бүлгийн дэд дарга.

Ж.Батжаргал: Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль өргөн баригдаад ороод ирчихсэн байна. Дэмжиж байгаа. Бид нар нэрийн данс буюу тэр нийгмийн даатгалын сангаа мөнгөжүүлэх тухай их ярьцааж байгаа. Энүүнийг хийх ёстой. Тэгээд хэлэлцүүлгийн явцад энэ дээр тодорхой

байр суурь, саналуудаа илэрхийлж, илүү нарийн зөв зохицуулалтууд хийх ёстой байх. Тэгж байж энэ сангийн гэдэг юм уу, нэрийн дансны хуримтлал өөрөө бодитой бий болгох бололцоо боломж нь бүрдэх ёстой. Энэ дээр хаана хаанаа анхаарах ёстой болов уу гэсэн ийм бодол байна.

Олон шатлалт тэтгэврийн тухай бид нар ярьцгаагаад байгаа юм. Үгүй ээ үнэхээрийн энэ харилцааг нээх гээд байгаа бол суурь тэтгэвэр гэдэг нэг юм яригдах гээд байна. Тэр тэтгэврийг авдаг эрхийг тодорхой насны босго алхсан хүн бүр хүртдэг л байх ёстой. Тэрнээс хувь тэнцүүлсэн гэдэг юм уу халамжийн тэтгэвэр энэ тэрийн тухай ойлголт биш. Тэгэхийн тулд энэ албан бус секторт ажиллаж байгаа улсуудаа яаж заавал даатгалд хамруулах ёстой вэ гэдэг асуудал гарч ирнэ. Энүүнийг энэ хуульд ер нь яаж зохицуулсан бэ? Тэрийг ер нь ямар хэмжээний тэтгэврийн асуудал байна гэж ойлгоцгоогоод байна вэ? Энэ дээр нэг тов тодорхой хариулт авмаар байх юм.

Гурав дахь миний хэлмээр байгаа зүйл. Баялгийн үр өгөөж бол хүүхэд байна уу, залуу байна уу, хөгшин байна уу үл хамаараад иргэн бүр хүртэх ёстой зүйл. Энэ нийгмийн даатгалын сан буюу нэрийн данс гэдэг бол өтөл насныхаа нийгмийн баталгааг хангах гэж хүн урьдчилж төлсөн хуримтал нь. Энэ 2-ыг тусад нь ойлгож, тусад нь яримаар байна. Тэгэхдээ тэрийг би дан ганц байгалийн баялгийн өгөөжөөс нэрийн дансны мөнгөжүүлэлтийг хийчихнэ гэж би бас ойлгохгүй байна шүү. Тодорхой цаг хугацаануудад бид энэ эв санааны тэтгэврийнхээ зарчмыг баримтлаад, хүмүүсийн төлсөн энэ шимтгэлийг тодорхой хүмүүсийн тэтгэвэр болгоод олгочихсон явдал бий. Тэрнийгээ арилгахын тулд төр өөрийнхөө эх үүсвэрээс гаргаж энэ асуудлаа шийдэх ёстой. Тийм учраас энэ хуулиар бол би ойлгож байгаа зүйл бол хууль ер нь бараг батлагдсан жилээсээ эхлээд тухайн цаг үед шимтгэл төлж байгаа улсуудын тэр шимтгэл нэрийн данс руугаа шууд мөнгөжиж бичигддэг

хэлбэрээрээ яваад тэр хуримтлалын нэгдсэн дүнгээс нь одоо тэтгэвэр авч байгаа улсууддаа тодорхой хүүтэйгээр мөнгө авч тэтгэвэрээ тавьдаг энэ зарчмаар нэг тодорхой шилжилтийн үе явах ёстой байх л гэж ингэж л хараад байгаа юм. Ингэж байж энэ нийгмийн даатгалын сан, нэрийн дансны чинь хуримтлалын асуудал өөрөө эрүүлжиг зөв болох бодитой болох үйл явц харагдах болов уу гэж ингэж ойлгоод байна. Энэ дээр та бүгд ер нь ямар ойлголттой байна вэ гэж.

Түүрүүн би энийг хөндсөн. Энэ хамтын тэтгэвэр гэдэг юмыг мэдэхгүй ер нь яаж хэдүүлээ ойлгоцгоох ёстой юм. Тодорхой шилжилтийн цаг хугацаанд ашиглаж магадгүй. Нэг одоо юу гэдэг юм нэг 10 жил ч гэдэг юм уу ашиглаж магадгүй. Тэрнээс хойших үйл явц дээр бол дандаа нэрийн дансны үлдэгдлийг харин яаж өвлөгдөх вэ, яаж улсуудад нь хуваарилах вэ гэдэг л асуудал байгаа. Тэрнээс авч байгаа тэтгэврийн тодорхой хувийг үлдсэн улсуудад нь өгөх тухай ойлголт биш. Энэ шилжилтийн нэг цөөхөн жилд ашиглагдаж магадгүй. Одоо шимтгэл төлж байгаа улсууд тэтгэвэрээ тогтоолгосон байна уу, тогтоолгоогүй байна уу эрсдэл үүсчихсэн бол тэр улсуудын нэрийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Төмөрбаатарын Аюурсайхан Улсын Их Хурлын гишүүн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд асуултад хариулна.

С.Аюурсайхан: Энэ тэтгэврийн шинэчлэлийн суурь нь бол одоо одоо хэрэгжиж байгаа энэ хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоо руу шилжих. Ингэхдээ одоо нэн тэргүүнд хагас хуримтлалын тогтолцоо руу шилжих, цаашидаа бүрэн хуримтлалын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг нь одоо хуулиар тогтоох энэ байгаа юм.

Хоёрдугаарт нь бол энэ олон давхаргад одоо тогтолцоо руу энэ эрх зүйн шинэчлэлээрээ шилжиж байгаа юм. Нэгдүгээр давхарга нь бол одоо нийгмийн

халамжийн сангаас авч байгаа тэтгэвэр. Хоёрдугаарт нь нийгмийн даатгалын сангаас авч байгаа тэтгэвэр. Гуравдугаарт нь бол хувийн нэмэлт тэтгэврийн ийм сангийн тогтолцоо байгаа юм. Таны хэлдэг суурь тэтгэврийг бол хүн болгон авна. Энэ бол тодорхой тэтгэврийн насанд хүрсэн хүн бол одоо бүрэн бус тэтгэврийг авч байгаа. Энэ албан бус салбараар ажиллаж байгаа хүн хүмүүсийг албан салбар руу шилжүүлэх энэ дотор бол тэргүүн ээлжид одоо эмэгтэйчүүдийн асуудал байдаг, залуучуудын асуудал байдаг. Энэ бол манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр Нэгдсэн Үндэстний Байгууллагаас болон Дэлхийн банкнаас олон улсын төсөл хөтөлбөрөөр бид нар одоо ирээдүйн ойрын бас 5 жилийнхээ төлөвлөгөөг баталсан. Өнгөрсөн 5 жилийнхээ төлөвлөгөөг дүгнэсэн. Энэний хүрээнд энэ албан салбараас албан бус салбар руу шилжүүлэх энэ бодлогын арга хэмжээнүүдийг үе шаттайгаар авч байгаа. Үр дүнд хүрнэ гэж итгэж байгаа. Энэ дотор бол олон төрлийн хөшүүрэг байна.

Тухайлбал нэг жишээ хэлэхэд малчид 305000 малчин байхад 43 орчим мянга нь одоо сайн дурын даатгалд хамрагдсан байна. Энэ бол нэг 14 орчим хувь нь маш бага тоо. Тийм учраас эд нарыг бид нар одоо малчид дээр гэхэд хөшүүрэг хэрэглээд, энэ сайн дурын даатгалынх нь 50 хувийг нь 5 жилийн хугацаанд төрөөс хариуцъя. Ингэж байж одоо хамрагдалт бол нэмэгдэнэ гэж бол тооцож байгаа. Мөн бусад салбарт ажиллаж байгаа албан бус салбарт ажиллаж байгааг одоо албан салбар руу шилжүүлэхэд ажил олгогч нартаа бас энэ төсөл хөтөлбөрийн хүрээнд бид нар ажиллаж байгаа. Мөн ажиллагсад дээр бид нар ажиллаж байгаа. Энэ бол бас нэлээн томоохон одоо эдийн засгийн бас багц асуудлууд явж байгаа.

Энэ мөнгөжүүлэх асуудал дээр бол одоо зөвхөн байгалийн баялаг биш. Шимтгэлээсээ байх ёстой гэдэг зарчим бол уул нь гол зарчим нь. Гэхдээ энийг бид нар үе шаттайгаар хууль батлагдаад 2 хувийн

шимтгэлийг нь одоо нэрийн дансан руу нь хийнэ. Цаашилаад үе шаттайгаар мэдээж энэ цааш нь хийж байгаа шимтгэлийн хувь хэмжээ нь бол нэмэгдэнэ. Нийт шимтгэл нь нэмэгдэхгүйгээр. Гол мөнгө хаанаас орох вэ гэвэл мэдээж одоо энэ байгалийн баялгаас хүн болгон хүртэх эрхтэй учраас энэ бол даатгуулагчид ч хамаарна. Энийг бол бид нар маш тодорхой байдлаар тусгаж байгаа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд, Их Хурлын гишүүн.

Х.Булгантуяа: Бид нар саяхан Төсвийн байнгын хороон дээр сүүлийн 15 жилийн төсвийн дүн шинжилгээ үзүүлэлтүүдийг хийж харсан юм. Тэгэхэд 15 жилийн дотор ажиллагсдын тоо 2005 онд 960 хөдөлмөрийн насны хүний тоо нэг 1.6 сая байсан бол одоо 2.2 сая болсон. Тэгсэн мөртөө ажиллагсдын тоо гээд ингээд яг НДШ төлөөд явж байгаа хүмүүсийг харахаар 150000 орчмоор л нэмэгдсэн байна. Өөрөөр хэлбэл 650000 орчмоор хөдөлмөрийн насны хүмүүсийн тоо нэмэгдсэн мөртөө НДШ төлдөг, ХХОАТ төлдөг, ажил хөдөлмөрлөдөг эрхэлдэг энэ хүмүүсийн тоо бол энэ тоотойгоо ингээд харьцуулах юм бол хамаагүй бага байна.

Өнөөдөр бид нар сая нэг зуу, сая хоёр зуу орчим мянга хүмүүс өнөөдөр НДШ төлөөд, тэгээд нэг 300 хэдэн мянга, 400 орчим мянган тэтгэврийнхээ хүмүүсийн тэтгэврийг тавьж чадахгүй улсын төсвөөсөө бид нар дандаа дэмжлэг үзүүлж явж байгаа юм. Тун удахгүй одоо 10, 20 жилийн дараагаар байдаг юм уу, бид нарыг тэтгэвэрт гарахад энэ тэтгэврийн сан чинь хэчнээн төгрөгийн та бүхэн нэмж татаас олгохоос аргагүй нөхцөл байдал байна вэ гэж харж байна вэ? 10 жилийн дараа, 20 жилийн дараа. Тэгээд энэ олон НДШ төлөхгүй байгаа хүмүүсээ та бүхэн маань яая гэж бодож байгаа юм бэ? Бид нар нэгэнт нийгмийн даатгалын сандаа итгэлгүй болчихсон. Дээрээс нь нэмээд төлсөн ч, төлөөгүй ч тэртэй тэргүй нэг улсаас ямар нэгэн байдлаар тэтгэвэр

тэтгэмж өгчих юм чинь дээ гээд байх юм бол хүмүүст төлөх сонирхол байхгүй шүү дээ. Тэгээд албан журмаар одоо цалин дээрээсээ шууд суутгаад авчхаж байгаа хэдэн хүмүүс дуртай, дургүй л өгч байгаа байх. Тэгэхээр энэ нийгмийн даатгалд хамрагдалтыг та бүхэн маань энэ хуулийнхаа дагуу ер нь яаж нэмэгдүүлнэ гэдэг ийм арга аргачлал одоо ямар байгаа юм бэ?

Дээрээс нь одоо сүүлийн 15 жилийн дотор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх шийдвэр 8 удаа гарчээ. Харин 7 удаа гарч байна. Харин тэтгэвэр нэмэгдүүлэх шийдвэр 11 удаа нийтдээ ерөнхийдөө бол гарсан байгаа. Тэгэхээр тэгсэн мөртөө манай өнөөдөр ахмадуудын тэтгэвэр бас л хаанаа ч хүрэхгүй байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар одоо энэ, энэ том урсгалтай та бүхэн маань яаж тэмцье гэж бодож байгаа юм бэ? 2006 онд тэтгэвэр, тэтгэмжийн нийт зардал 195.1 тэрбум төгрөг байсан юм байна лээ. Одоо 2021 онд гэхэд 5.5 их наяд төгрөг болсон байгаа. Тэгэхээр энэ бүр юун эдийн засгийн өсөлт юун бараг төсөвтэйгөөө ингээд одоо өнөөдөр харьцуулиггүй их тоо болчихсон байгаад байдаг. Тэгэхээр миний одоо гол асуух гэж байгаа асуулт нь та бүхэн энэ бүгдэд энэ НДШ төлөлтийг яаж нэмэгдүүлье гэж бодож байгаа юм бэ? Эцэс сүүлд нь бас одоо адилхан л залуучуудтайгаа адилхан хөдөлмөр эрхлэж байгаа хүмүүстэйгээ адилхан бид нар нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүс. Сая жишээлбэл тэтгэврийг тэглэхэд надаас аягүй олон залуучууд тэгж асууж байсан. Үгүй ээ одоо ахмадуудын маань тэтгэвэр бага, тэтгэврийн өр зээлийг нь тэглэлээ. Одоо ойлгож байна.

Тэгвэл яг энэ шиг аргаар та бүхэн маань бид нарын нэрийн дансыг нэг удаа зузаатгах боломж бололцоо байдаггүй юм уу? Энийг ер нь одоо яваандаа ингээд нэг юм зузаатгаад явна гэдэг биш. Эсхүл энэ байгалийн баялгаас орж ирж байгаа орлогоосоо байдаг юм уу одоо эсхүл энэ томоохон компаниудын ногдол ашгаасаа ч байдаг юм уу бид нар яг одоо жишээлбэл

олон улсын шүүх дээр шүүхдэлцээд олсон орлогыг, эсхүл энэ авлигаас өнөөдөр одоо нөгөө арван тэрбум төгрөгийг авч байна гээд тэгвэл тэрүүнийг шууд ерөөсөө энэ нийгмийн даатгалын санг зузаатгахад бид нар шууд чиглүүлнэ гэдэг ийм давхар хууль эрх зүйн орчин байж болох уу? Бид нар нэг, одоо Х.Булгантуяа гээд би өөрөө өөрийнхөө нэрийн дансыг ингээд шалгахад миний төлсөн татвар бол гараад байгаа юм. Гэтэл миний төлсөн өнөөдөр НДШ өнөөдөр болтол би тэдэн төгрөг төлчихсөн юм байна. Би нэг тэтгэвэртээ гарахад тэдэн төгрөг авахаар юм байна гэдэг тийм мэдээлэлтэй хувь хүмүүсийн дансны энэ мэдээллүүдийг энэ хуулиар харж болох уу? Зарим нь одоо гадаадын улс орнууд.../минут дуусав/

Г.Занданшатар: Төмөрбаатарын Аюурсайхан сайд хариулна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боомтын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас асууж байна.

С.Амарсайхан: Булгантуяа гишүүний асуултад хариулъя. Тэтгэврийн сан маань бол одоо ингээд муудаад хүндэрчихсэн ийм асуудал бол нэгдүгээрт байхгүй. Улсаас одоо ямар асуудлыг нь хариуцаж байна вэ гэх юм бол зөвхөн одоо 1995 онд хууль хэрэгжээд эхэлсэн энэнээс өмнө тэтгэвэр тогтоолгосон хүмүүсийн тэтгэврийг нь хариуцаж байгаа. Хоёрдугаарт цэргийн албан хаагчдын тэтгэврийг улсаас хариуцаж байгаа. Бусдаар бол энэ сан бол өөрөө өөрийгөө авч явж байгаа. Улсаас энэ хариуцаж байгаа энэ дүн нь бол бас төсвийн дэмжлэгээр энэ бол бас Дэлхийн банкны хийсэн судалгаа байна. 2000 та Сангийн сайд байсан, 2019 онд 9.2 хувь төсвийн орлогын байсан бол 2050 онд 37 хувь болох нь байна шүү гээд ингээд анхааруулж тэтгэврийн тодорхой арга хэмжээнүүд авсан. 5 жилийг 7 жил болгосон. Одоо насыг нэмсэн энэ тэр гээд.

Бид нарын одоогийн одоо 2023 оны жишээлбэл төсвөөс олгож байгаа энэ хариуцаж байгаа энэ хүмүүсийн олговор нь бол 2022 онд 950 орчим тэрбум байсан бол

2023 онд 55 тэрбум болоод буурч байгаа. Өөрөөр хэлбэл төсвийн орлогын улам ачаалал нэмэгдээд буураад байна биш, 19 онд 9.2 хувь байна, 50 онд 37 хувь бол болно гээд тооцоолоод байсан нь 23 онд 2.7 хувь болж буурч байгаа. Энэ бол бас сангийн одоо менежментээ зөв хийснээр сангаа одоо зохистой, баталгаатай эх үүсвэрт арвижуулснаар энэ арга хэмжээнүүдийг улам одоо сайжруулах боломжтой гэж бас хуулийн үзэл баримтлал нь байгаа.

Нийгмийн даатгалын сангийн маань 2022 оны төсөв бол хоёр зуун сая төгрөгийн хоёр зуун тэрбум төгрөгийн алдагдалтайгаар ингэж батлагдаж байсан. Тэгвэл одоо гүйцэтгэх оны эцсийн гүйцэтгэлээрээ 3.5 их наядын орлоготой, 3.4 их наядын зарлагатай буюу нэг зуун тэрбум орчим төгрөгийн бас ашигтайгаар ингэж гарч байгаа. Тэгэхээр энэ менежментээ сайн хийх хэрэгтэй. Хоёрдугаарт яаж шимтгэл төлөхийг урамшуулах вэ гэх юм бол Нэрийн дансыг мөнгөжүүлэх. Нэрийн данс бодитоор мөнгөжөөд байгааг иргэд харах ёстой, даатгуулагчид. Ингээд байгалийн баялгаас бас хажуугаар орж ирэх ёстой. Энийгээ хуримтлалын сан бий болгоод орон сууцанд ашиглах эрүүл мэнд, боловсролд ашиглах бодитой эх үүсвэр мөн одоо энийг нь өвлөгддөг байх, хамтын тэтгэврээр хань ижил нь авдаг байх энэ нь одоо хэрэгжээд эхлэх юм бол хамрагдаагүй, шимтгэл төлөөгүй хүмүүст тодорхой хэмжээгээр өөрсдөө хамрагдах юм бол илүү их хэмжээгээр энэ үр ашиг нь ирэх юм байна гэдэг бодит эдийн засгийн одоо энэ тооцооллыг нь харуулах ийм боломжтой болох юм. Тэгээд энэ маш чухал суурийг нь бид нар энэ хуулиараа бас тогтоож өгч байгаа учраас нэрийн данс мөнгөжих энэ суурь нь тавигдаад, иргэдийн нийгмийн даатгалын тогтолцоонд итгэх итгэл нь нэмэгдэж, хамрагдалт нь нэмэгдэх өөрсдөө дагаад үр шимээ авах ийм бодитой ийм одоо реформ байгаа юм.

Г.Занданшатар:

Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн асуулт асууна. Хаслаа, алга байна. Гишүүд

дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх хүн байна уу? Дэмжсэн, дэмжээгүй үгийн талаар санал хураалттай гишүүд чуулганы танхимд цуглана уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Энэ хуулийг дэмжиж байгаа юм. Үнэнийг хэлэхэд иргэд олон нийтийн зүгээс ялангуяа хэд хэдэн багц хуулиуд дээр реформуудыг хийгээсэй гэдгийн нэг нь нийгмийн даатгалын багц хууль. Тэгээд хүмүүс бүр ингээд л одоо иргэд олон нийттэй уулзаж байхад энэ яагаад чи санаачлаад өргөн барихгүй байгаа юм бэ? Энэ бараг юу хийгээд байгаа юм бэ гишүүний хувьд гэж их шүүмжилж байсан. Тэгээд нийгмийн даатгалын багц зүйлийг бол хуулиараа хувь гишүүн энүүнийг өргөн барих боломжгүй. Заавал салбарын яам одоо үнэнийг хэлэхэд энэ бол бас хамаагүй поппер ч байдаг юм уу, улс төржиж байдаг юм уу, аль нэг салбарт тал засаж байдаг юм уу, эсхүл өөрийнхөө тойргийн хэдхэн хүмүүст таалагдах гэж энэ хуулийг хийх ёсгүй юм байна лээ. Үр дагавар ихтэй. Тэгээд улсын эдийн засагт, нийгэмд ингээд хувь үр дагавар ихтэй учраас заавал салбарын яам өргөн барих ёстой. Тэгээд хүлээлт ихтэй байсан энэ хуулийг бас өргөн барьж байна.

Тэгээд бид одоо энүүнийг Нийгмийн бодлогын байнгын хороон дээрээс нэлээн олон ийм талт хэлэлцүүлгүүдийг бас давхар иргэд, олон нийтийн дунд энэ чуулганы ялангуяа завсарласан цаг үед одоо хийж батлуулаасай гэж хүсэж байна. Дээрээс нь нэмээд иргэд, олон нийтийн зүгээс бас нийгмийн даатгалын тухай бид бас ойлголт бас төдийлөн бас байдаггүй. Тэгэхээр энэ үүнийг далимдуулаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бас оролцоод энэ иргэд, олон нийтэд энэ одоо мэдлэг мэдээллийг түгээх дээр бас та бүхэн маань давхар ажиллаач. Бид нар бас ингээд аягүй олон олон хуулиуд баталчхаад иргэдэд ерөөсөө энүүнийг хүргэж чаддаггүй юм байна лээ. Тэгэхээр энүүний үр дагавар нь юу юм, НДШ төлөхөөр та яах юм, таны амьдралд ямар одоо үр

нөлөөтэй юм гэдэг энэ тухай бид нар бас их танилцуулах ёстой шүү. Тэрнээс биш хуульд нэг хэдхэн ийм үг үсгийн бараг өөрчлөлт орлоо гээд тэгэх юм бол энэ бол үнэнийг хэлэхэд хэрэгжээд явахад бас их амаргүй. Та 2 яг хажууд зэрэгцээд ярьчихаар би бүр.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн үг хэлнэ.

М.Оюунчимэг: Нийгмийн даатгалын энэ багц хууль дагалдаж орж ирж байгаа хуулиудыг дэмжиж байгаа. Ер нь бол бид нар энийг цаг алдалгүй батлах ёстой гэсэн байр суурийг одоо 2020 оноос хойш л илэрхийлж байгаа. Тэгээд хамгийн гол нь нөгөө өмнө нь орж ирээд буцсан шалтгаан нь түрүүн би ч бас хэлсэн. Санхүүгийн тогтолцоогоо тодорхой болгоогүйгээс болоод энэ хуулийн хэрэгжих эсэх нь тодорхойгүй байсан учраас тухайн үед одоо Засгийн газар буцаж татаж авсан. Одоо ингээд буцаад орж ирж байна. Тэгээд түрүүн ч одоо олон асуултууд ярьж байна. Бас өмнөх асуудал буцсан учраас энэ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яам 2 маань санхүүгийн механизм, ялангуяа энэ нөгөө тэтгэврийн нөөц сангийн эх үүсвэрийг хаанаасаа яаж санхүүжүүлэх вэ, тэр одоо мөнгөжүүлэх гэдэг чинь өөрөө асар чухал байгаа. Тэгэхээр энэ энэ тэр дээрээ маш тодорхой ажиллах хэрэгтэй. Тийм учраас Нийгмийн бодлогын байнгын хороо мэдээж том ажлын хэсэг гарах байх. Тэгээд өнөөдөр хүн бүхэн хүлээж байгаа. Одоо шимтгэл төлж байгаа залуучууд маань би хэдийг төлж байна, хэдийг төлж байгаагаа шилэн болоод ороод харчихдаг байх. Энэ өөрөө өнөөдөр маш чухал.

Бид нар яг энэ тэтгэврийн сангийн шинэчлэлийн асуудлаар Унгар улсад туршлага судлаад яваад ирж байсан. Тэгэхэд бол одоо өнөөдөр би хэдийг төлж байна, миний нэрийн дансанд хэд байна гэдгээ шууд онлайнгаар ороод ингээд харчихдаг. Тэрийгээ үзээд ингээд явж байсан. Тэгэхээр бид нарт өнөөдөр энэ өрөө яг чухал байгаа юм. Тэгэхгүйгээр

төлөөд л байдаг, төлөөд л байдаг хэдийг төлөөд байгаа нь мэдэгдэхгүй. Дараа нь тэгээд тэтгэвэртээ гарахад юм уу, тухайн хүн нас барахад нэг сая төгрөг аваад дуусдаг энэ өөрөө маш олон хүн нийгэмд бухимдал үүсэж байгаа учраас энэ хуулийн шинэчлэлээр энэ зүйлүүд өөрчлөгдөнө гэж ингэж хүсэж хүлээж байгаа. Тийм учраас тогтолцоогоор нь өөрчлөх асуудал бол нэг номерт маш чухал. Нэгдүгээрт одоо тэр шилэн байх ёстой, хэдийг төлж байгаа нь тодорхой байх ёстой. Хоёрт нь тэтгэврийн зөрүү арилгах ёстой, гуравд нь инфляцтай уялдаж тэтгэвэр хөдөлдөг байх ёстой, индексжүүлдэг байх ёстой гэж энэ асуудлуудыг өнөөдөр энэ Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд бол энийг шийдэх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Тийм ч учраас энэ дээр бид нар бол ажиллаж байгаа.

Нөгөө талаасаа энэ нийгмийн даатгалын сан ашигтай ажиллаж байна уу, үгүй байна уу, энэ зөв юмандаа зарцуулж байна уу, үгүй байна уу гэдэгт хяналт тавих ёстой. Нийгмийн даатгалын сангийн үндэсний зөвлөл энэ менежментийн багийг илүү сайжруулах, энийг олон улсын стандартад нийцүүлж өөрчлөх асуудлууд бол маш чухал байгаа. Одоо энэ дээр орж ирж байгаагаар бол бас жоохон ерөнхий тусгагдсан. Тиймээс ажлын хэсгийн хүрээнд бид нар энэ давхар менежментийн бүтэц зохион байгуулалтын асуудал дээр маш тодорхой схемүүдийг нь зурж, хуулийн хүрээнд зааж өгөх ёстой гэсэн байр суурьтай байгаа. Өнөөдөр бид нар бас хэлээд, энэ Сангийн яамны энэ байр суурийг сонсож байна. Нийгмийн даатгалын сангийн шимтгэл 22 онд одоо 280-ад тэрбум төгрөгийн ашигтай гарсан гээд. Гэхдээ энэ нь өөрөө яг ашигтай биш, бас зарцуулалт нь өөр юмандаа ингээд явчхаж байгаа. Дээрээс нь энэ сангийн мөнгийг яаж эргэлдүүлэх юм, яаж найдвартай байлгах юм, яаж ашигтай ажиллуулах вэ гэдэг асуудлууд хүртэл урт хугацаандаа маш сайн шийдэгдэх ёстой асуудлууд.

Тэгэхээр ажлын хэсгийн хүрээнд энэ, энэ зүйлүүдээ бол давхар шийдээд явчих нь бол чухал байгаа. Энэтэй уяж бас нөгөө хувийн тэтгэврийн бас тогтолцоог бий болгох хууль давхар орж ирж байгаа. Тэгэхдээ өнөөдөр манай төсөв ямар байгаа билээ. Тэгэхээр төсөвт дарамт учруулахгүйгээр төр төсөвт ачаалал үүсгэхгүйгээр энийг шийднэ гэж байгаа. Тэгэхээр Баялгийн сангийн хуулийг Засгийн газар бас маш яаралтай өргөн бариад, Нийгмийн даатгалын багц хуультайгаа уялдаж шийдэхгүйгээр энэ хууль гараад бас амьдрал дээр амилахгүй. Хамгийн гол нь мөнгө, бүх юмны цаана санхүүжилтийн асуудал байгаа. Тэгэхээр энэ, энэ тэрээ бид нар хэлэлцүүлгийн явцад бол маш сайн ажиллах ёстой. Тэгээд энэ ажлын хэсэг бол том ажлын хэсэг гараад, нухацтай сууж салбарын яам, Засгийн газартайгаа ингээд хамтарч ажиллах нь чухал байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданиатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ Нийгмийн даатгалын багц хууль дагасан хуулиуд орж ирж байна. Тэгээд маш чухал асуудал. Юу вэ гэхээр хүн яг эд одоо залуу хүчтэй, тэнхээтэй байгаа үе дээрээ бас хөдөлмөрлөөд, тэгээд одоо чадалгүй тамир тэнхээ муудсан өндөр насныхаа насалсан тэр үедээ бас энэ тэр залуудаа хийсэн хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэж ингэж амьдрах ийм л тогтолцооны асуудлыг ярьж байгаа юм. Тэгэхээр одоо бид нар мэдэж байгаа Японд ард иргэд НДШ төлдөг, тэгээд тэтгэвэрт гарлаа л бол тэр хүмүүсийн амьдралын баталгаа бүр маш илүү сайнаар хангагдаад явдаг. Тэгэхээр энэ тогтолцоо маань өөрсдөө одоо зөвхөн нэг амь зогоох, өнөөдрийн амь зуулгын мөнгө өгөх биш иргэд маань тэтгэвэрт гараад одоо амьдрал нь чанартай, орлого нь хүрэлцэхүйц хэмжээтэй байх энэ асуудлыг л бас бид нар өнөөдөр ярьж байгаа. Тэгэхээр энэ дээр нэлээн одоо бас серёзны ач холбогдол өгч хандах ёстой.

Засгийн газар, Сангийн яам энэ тэр тэр нэрийн дансны өнөөдрийн одоо үлдэгдлийн 24 их наядын бас 8, 9 их наядыг нь бас төлөхөөр.ингээд тооцоо гарч байна. Тэгэхээр энэ асуудлыг ч гэсэн ер нь ярих ёстой. Яагаад гэхлээр энэ ганцхан энэ одоо хуримтлалын Баялгийн сангийн тухай хууль энэ тэр батлагдсаны дараагаар энэ нэрийн дансыг мөнгөжүүлнэ гэдэг бол бас л өрөөсгөл. Түрүүн бас Батжаргал гишүүн хэлж л байна. Дээрээс нь энэ ажил олгогч болон төлөгчөөс нэг нэг хувийг аваад одоо харганы ноос түүнэ гэдэг шиг энэ мөнгийг цуглуулаад нэрийн дансыг мөнгөжүүлнэ гэвэл бас л өрөөсгөл. Тэгэхээр энэ дээр бол бас бид нар нэлээн одоо сайн бодлого ярих ёстой тал талаасаа. Тэр ирээдүйн өв сангаас бид нар хуримтлалтай хүүхэд энэ тэр гээд л асуудлаа ярьсан. Тэгээд л мөн удалгүй л тэрийгээ бид нар сольсон шүү дээ. Тэгэхээр бас тэрэн шиг тийм одоо дутуу дулимаг юм болчих вий гэдэг ийм асуудлуудыг бас тал талаас нь ярих ёстой.

Энэ маш олон төрлийн одоо тэтгэврүүд байгаа. Нийгмийн даатгалын сангаас авах тэтгэврүүдийн тоо одоо цэргийнхэн гээд байна, хүчний байгууллагынхан гээд байна. Мөн хилийн цэргийнхэн гээд ингээд маш олон төрлийн одоо байгууллагууд энэ харилцаагаар одоо хуулиуд нь тэтгэвэр нь бодогдоод ингээд явж байгаа. Тэгтэл энэ дээр янз янзын одоо маш олон төрлийн хүмүүс ойлгомжгүй ийм олон харилцаанууд байгаа учраас энийг хүнд ойлгомжтой ийм одоо байдлаар хуульчилж өгөх ёстой гэсэн ийм одоо зүйл байгаа. Дээрээс нь энэ олон давхаргат буюу хуримтлалын, хагас хуримтлалын тогтолцоо, хувийн тэтгэврийн тогтолцоо гээд ингээд маш олон зүйлүүд гарч байгаа. Бид нар өмнө нь бас энэ Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг бас нэлээн олон жил одоо зохицуулалт хийх гэж банканд хадгалуулах гэж ингээд явсан. Маш их эрсдэлүүд үүсэж байгаа. Тэгэхээр энийг энэ хуулийнхаа хүрээнд бид нар бас маш сайн тооцоолж гарахгүй бол тодорхой ахиц үр дүн бас гарах нь эргэлзээтэй. Дээрээс нь ард иргэд маань энэ өөрсдөө НДШ-ээ төлөх ийм одоо

эрмэлзэлтэй, ажил олгогч маань төлөх эрмэлзэлтэй байж байж энэ одоо хууль маань бас үр дүнд хүрнэ гэсэн ийм зүйлийг хэлье.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Яах вэ. Энэ Нийгмийн даатгалын хуулийн шинэчилсэн найруулгыг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Өөрөө ч одоо бас энэ салбарт олон жил ажиллаж байсан сайдаар ажиллаж байхдаа нийгмийн даатгалын хууль тогтоомжуудыг бас шинэчилсэн найруулгыг хийж ажиллаж бас нэлээн нөхөн болгож байсан хүний хувьд бол дэмжиж байна. Хэд хэдэн зүйл бас ер нь цаашидаа ажлын хэсэг гаргаад ажиллах байх. Бас одоо бид бас анхаарах юманд бол байгаа юм. Нэг дэх асуудал. Юуны өмнө энэ нийгмийн даатгалын засаглалыг одоо сайжруулах асуудлыг бид нэлээн сайн бодох хэрэгтэй байгаа юм. Одоо бол Нийгмийн даатгал, нийгмийн даатгалын үндэсний зөвлөл байна Их Хурлаас байгуулагддаг, НДЕГ байна. Одоогийн энэ засаглалыг нэлээд сайжруулж боловсронгуй болгохгүйгээр бид нийгмийн даатгалын шинэчлэлийг хийж хийнэ, ялангуяа энэ нийгмийн даатгалын хөрөнгийг хуримтлал үүсгэх гэдэг асуудал бол нэлээн жаахан эргэлзээтэй. Тийм учраас анхны хэлэлцүүлэг дээр нь нийгмийн даатгалын засаглалыг хэрхэн яаж одоо сайжруулах вэ гэдгээ нэлээн сайн нухсан ярих ёстой гэж асуудал.

Хоёр дахь асуудал нь нийгмийн даатгалын хөрөнгийг хуримтлал үүсгэх, арвижуулах асуудал бол онцгой чухал анхаарах ёстой. Яах вэ, одоо орж ирснээр нь бол шинэлэг юм гэхэд болбол багавтар байгаа. Яах вэ, тэр 2 хувийг нь хуримтлал үүсгэнэ гээд байгаа юм. Гэхдээ ер нь бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг нийтэд нь хуримтлал үүсгэх, арвижуулах тухай асуудлыг л бид нэлээн сайн ярих хэрэгтэй. Зөвхөн хоёрхон шимтгэлийн хоёрхон хувиар нь хуримтлал үүсгэнэ гэдэг асуудал бол бас нэлээн бас учир

дутагдалтай болов уу гэж. Тийм учраас бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг нийтэд нь чөлөөт үлдэгдлийг яаж одоо бас менежмент хийх үү, хуримтлал бий болгох уу гэдгийг нэлээд сайн бас нухацтай ярих асуудал байгаа юм.

Хоёр дахь асуудал нь 3 дахь асуудал манай гишүүд бас нэлээн анхаарах ёстой болов уу гэж. Төр өөрөө санхүүжилтийг нь хариуцаж байгаа 2 субъект бол байгаа юм. Цэргийнхэн 95 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэвэр санхүүжилт гэж. Тэгэхээр энэ 95 оноос өмнө тэтгэвэрт гарсан иргэдийн тэтгэврийн санхүүжилтийг төр хариуцаж байгаа гээд одоо бол тэгж бид яваад байгаа хуулийн тогтолцоо нь ч тийм л байгаа юм. Гэхдээ нэг зарчмын асуудал нь 95 оноос өмнө энэ нийгмийн даатгалын салбарын багц хууль хэрэгжиж эхлэхээс өмнө ажил алба хөдөлмөр эрхлээд нийгмийн даатгалын санд тэтгэвэр авах эрх нь үүсээгүй ч гэсэн 95 оноос өмнө ажил хөдөлмөр эрхлээд нийгмийн даатгалд шимтгэл төлж байсан иргэдийн тэтгэврийн санхүүжилтийг төр хариуцах ёстой гэдэг ийм одоо өргөн утгаар нь энэ ажлын хэсэг дээр анхны хэлэлцүүлэгт бэлдэхдээ бид нэлээн сайн ярих бол хэрэгтэй. Тэгэхгүй бол зөвхөн 95 оноос өмнө тэтгэвэр авч байгаа иргэдийн одоогийн тэтгэвэр авч иргэдийн санхүүжилтийг төр хариуцна гэдэг ийм явцуу утгаар бас авчирч авч үзэж бол болохгүй байгаа юм гэж.

Дөрөв дэх асуудал нь бидний онцгой анхаарах ёстой бол энэ Нэрийн дансны хуулийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг асуудал байгаа юм. Хамгийн гол нь энэ нэрийн дансны дансыг хэрхэн яаж одоо мөнгөжүүлэх вэ, хэдэн оноос мөнгөжүүлэх вэ? Тэгээд тэр нөгөө Баялгийн сан, Ирээдүйн өв сангийн хуулиуд нь хуулиудтайгаа хэрхэн одоо хууль уялдуулах вэ гэдэг асуудал нэлээн сайн ярих ёстой. Харамсалтай нь нөгөө Баялгийн сангийн хууль нэгдсэн хуримтлалын сангийн тухай асуудлууд нь орж ирээгүй учраас энэ нэрийн дансыг мөнгөжүүлэх, нэрийн дансны хөрөнгийг хуримтлал үүсгэх

асуудал бас жаахан бүрхэгдүү байгаа болов уу гэж л бодож байна. Ийм одоо 4 асуудал дээр цаашидаа энэ хуулийг хэрэгжүүлэхдээ боловсруулахдаа анхны хэлэлцүүлэгтээ бас бэлдэхдээ бас анхаарах ёстой.

Тав дахь асуудал нь энэ тэтгэвэр бодож байгаа аргачлалтай холбоотой юмыг бид бас нэлээн сайн яримаар байгаа юм. Одоо хөдөлмөрийн гэрээ байгуулаад заавал даатгалд хамрагдаж байгаа иргэд шимтгэл төлж байгаа бол төлсөн шимтгэлээ тэтгэвэр болгож авахдаа 2.5-аас 4 дахин нэмэгдүүлээд тэтгэвэр болгоод авчхаж байгаа юм. Гэтэл сайн дурын даатгалд хамрагдаад шимтгэл төлж байгаа иргэд төлсөн шимтгэлийг нь 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр тэтгэвэр болгож аваад байгаа юм. Энэ тэтгэвэр бодож байгаа аргачлалаас нь одоо болоод бас энэ тэтгэврийн зөрүү бас нэмэгдэх, бага цалингаас бага хэмжээний шимтгэл төлж байсан иргэд бас одоо өндөр тэтгэвэр авах, энэнээс үүсээд тэр тэтгэврийн зөрүү одоо үүсэх нөхцөл одоо бас нэг нөхцөл нь болчихоод байгаа ийм асуудлууд байгаа юм. Тийм учраас ажлын хэсэг байгуулагдаад ажиллавал миний яриад байгаа энэ 5 одоо асуудал дээр нэлээн одоо голлож анхаарал хандуулж ажиллах болов уу гэж бол бодож байна.

Бид одоо хөрөнгө хуваарилалтын тогтолцоотой явж байгаа. Хэзээ одоо бид хагас хуримтлалын тогтолцоонд шилжих үү? Хэдэн оноос бүрэн одоо хуримталж шилжих вэ гэдгийг бас энэ нэлээн сайн ярьж тооцоо судалгаа хийж энийгээ бас цэгцлэх асуудлууд байгаа юм. Тэгээд ийм бас 5 асуудал дээр цаашидаа ажлын хэсэг Их Хурлын байгуулагдах ажлын хэсэг нэлээн анхаарлаа хандуулж ажиллах ёстой болов уу гэж бол бодож байна. Би ч гэсэн одоо бас салбарын хүний хувьд бас энэ ажлын хэсэгт нь одоо ороод ингээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан. Нийгмийн даатгалын багц

хууль бол одоо эрс шинэчлэлийн хууль. Ерөнхий хуулийг нь баталчихсан. Одоо энэ, санал хураалт бэлэн байна уу? Санал хураалт. 59.5 хувийн саналаар дэмжигдлээ. Ингээд Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Прокурорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын шүүхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрөөс төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ахмад цолтон ахмад настан төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Адьшаа гишүүнээ, Тогтохсүрэн даргаа санал хураалт. Энэ дагалдах хуулиуд Тэтгэврийн тухай хууль. 61.4 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хангалттай дэмжигдэж байна.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр нийгмийн, Нийгмийн бодлогын байнгын хороонд ишлэжүүлээ. Нийгмийн бодлогын байнгын хороо ажлын хэсгээ байгуулаад, нягт нямбай ажиллах эрхтэй. Хэлэлцэх эсэхийг Нийгмийн бодлогын байнгын хороо бол их сайн хэлэлцсэн гэж сонссон, яригдсан. Ингээд Нийгмийн бодлогын байнгын хорооноос ажлын хэсгүүд байгуулж багц хуулиа хэлэлцэх хэрэгтэй.

18.48 цаг

Арав.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Дараагийн асуудалд оръё. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын

Аюурсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүдээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай болон Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулж байна. Дээрх хуулиудыг мөрдөж эхэлснээс хойш нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн төрөл, тэтгэмж авах эрх нөхцөл тэтгэмж бодох хувь хэмжээг өөрчлөх зэрэг хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Тухайлбал, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг даатгуулсан хэлбэрээс үл хамааран адил хувь хэмжээгээр тооцох, хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацаанд дахин хүүхэд төрүүлсэн эхийн зөвхөн 2 удаагийн төрөлтөд тэтгэмж олгож байсныг төрөлт болгонд тэтгэмж олгохоор, ажлаас халагдсан шалтгаанаас хамаарахгүйгээр ажилгүйдлийн тэтгэмжийг олгохоор, хүндэтгэх шалтгаантай бол тэтгэвэр авах өргөдлийг 3-6 сарын дотор гаргах зэрэг даатгуулагчийн эрх ашигт нийцсэн хуулийн зохицуулалтыг тусгаж байсан.

Тэтгэмжтэй холбоотой тулгамдсан асуудлыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тухай бүр шийдвэрлэсэн боловч нийгмийн даатгалын сангийн тогтвортой бие даасан байдлыг урт хугацаанд хангах тэтгэмж болон ажилгүйдлийн даатгалын сангаас олгож буй тэтгэмжийн хэмжээ, хугацааг өөрчлөх, нөхцөл, шалгуурыг даатгуулагчид ээлтэй байхаар байдлаар уян хатан болгох зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлага байна. Мөн одоогоор хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмжийн харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар, ажилгүйдлийн тэтгэмжийн харилцааг Нийгмийн даатгалын сангаас

олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулж байна.

Эдгээр богино хугацааны тэтгэмжийн харилцааг 2 өөр хуулиар мөн даатгуулагчийн урт хугацааны тэтгэврийн харилцааг тэтгэмжийн харилцаатай нэгтгэн нэг хуулиар зохицуулж байгаа нь иргэд, даатгуулагч, ажил олгогчид ойлгомжгүй байдлыг үүсгэж ирсэн. Иймд тэтгэмжийн даатгалын харилцааг зөвхөн нэг хуулиар зохицуулахаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөлд тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгохоор, харин Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэхээр тусгасан.

Мөн бөөрний хүнд хэлбэрийн дутагдал, эрхтэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор болсон даатгуулагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар ажлын 66 хоног байсныг 132 өдрөөс хэтрэхгүй байхаар нэмэгдүүлсэн. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас баталсан нийгмийн хамгааллын доод хэм хэмжээний тухай 1952 оны 102 дугаар конвенцод иргэнд олгох тэтгэмжийн доод хэмжээ нь түүний авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас багагүй байхаар заасан Конвенцын шаардлага зөвлөмжид нийцүүлэн ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжийг бодох хувь хэмжээг нэмэгдүүлсэн. Даатгуулагчийг ажилгүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байранд нь тогтвор суурьшилтай урт хугацаанд ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэхээр тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагчийн авах тэтгэмжийн хэмжээ нэмэгдэж даатгуулах хүсэл сонирхол

нэмэгдэж, даатгуулагчийн нийгмийн баталгааг хангахад эерэг нөлөө үзүүлэх, хуулиудын уялдаа холбоо сайжрах, иргэд, даатгуулагчид, ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллага хууль тогтоомжийг нэг мөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх юм. Энэхүү хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон төрийн байгууллага, даатгуулагчид нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд харин нийгмийн даатгалын сангаас 744.8 сая төгрөгийг даатгуулагч болон ажил олгогчийн тэтгэмж, хөнгөлөлтөд нэмж олгох урьдчилсан тооцоог хийлээ. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн төсөлтэй уялдуулан 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх нийгмийн, Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Бейсен: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ.

Монгол Улсын Засгийн газраас 21 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 23 оны 1 сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ. Хууль санаачлагч тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд тэтгэмж олгохоор. Харин ажилгүйдлийн даатгалын сангаас даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж, ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт

үзүүлэхээр, мөн бөөрний хүнд хэлбэрийн дутагдал эрхтэнд шилжүүлэн шилжүүлэх мэс засал хийлгэсэн болон эрхтний донор болсон татгалзагчид хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацааны нэг удаагийн дээд хязгаар ажлын 66 хоног байсныг 132 өдрөөс хэтрэхгүй байхаар нэмэгдүүлэн тоочиж хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагчийн авах тэтгэмжийн хэмжээ даатгуулах хүсэл сонирхол нэмэгдэж, даатгуулагч нь нийгмийн баталгааг хангахад эерэг нөлөө үзүүлэх, хуулиудын уялдаа холбоо сайжирч, иргэд даатгуулагч, ажил олгогч болон нийгмийн даатгалын байгууллага хууль тогтоомжийн нэг мөрөөр хэрэгжүүлэх нөхцөл бүрдэх бөгөөд хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хуулийн этгээд болон төрийн байгууллага, даатгуулагчид нэмэлт зардал үүсэхгүй. Харин нийгмийн даатгалын сангаас 744.8 сая төгрөгийг даатгуулагч болон ажил олгогчийн тэтгэмж, хөнгөлөлтөд нэмж олгох урьдчилсан тооцоо гарсан бөгөөд хуулийн төслийг Днрламент.мн цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Туваан нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн хэмжээ болон хуулийн төсөл батлагдсанаар тэтгэмжийн хэмжээ хэдэн төгрөгөөр нэмэгдэх талаар, НДШ-д төлсөн иргэдийн нийгмийн даатгалын сангаас авч болох тэтгэмжүүдийн эрх нээгддэг ойлголтыг урамшуулах, сурталчлах, зохицуулах хуулийн төсөлд туссан эсэх талаар асуулт асууж хариулт авлаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлээгүй бөгөөд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу жаран хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн доод хэмжээг тогтоолгох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг нэр овог, ажил албан тушаал өмнөх хуулиудтай нэг адил. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайханаар ахлуулсан ажлын хэсэг байна. ТНБД Гомбосүрэнгийн Өнөрбаяр байгаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Байхгүй байна. Санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх хүн байна уу? Алга байна. Санал хураалтад бэлтгэе гишүүд. МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн, дэд дарга Жигжидийн Батжаргал, дэд дарга Мөнхөөгийн Оюунчимэг ирцээ бүрдүүлье.

Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нь хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 57.1 хувийн

саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

19.00 цаг

Арван нэг.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийг 1994 онд баталснаас хойш 28 жилийн хугацаанд шимтгэл төлөх зардал гаргах, урьдчилан сэргийлэх асуудлаар уг хуульд 4 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон. Үйлдвэрлэлийн ослыг бүртгэх, хяналт тавих, осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх замаар хөдөлмөрийн чадварыг сэргээж, хөдөлмөрийн зах зээлд эргүүлэн оруулах, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох,

мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зэрэг асуудлуудыг шийдвэрлэх шаардлага тавигдаж байна.

Хуулийн төсөлд үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацаанд болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаа тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэхээр тусгасан. Мөн даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлбөрийг нэмэгдүүлж, даатгалын сангийн тухай тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас илүүгүй байхаар тусгасан. Хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авагчид протез, ортопедын жишиг үнийг баримтлан эхний удаа зуун хувиар, дараагийн удаа 50 хувиар тооцон Даатгалын сангаас хариуцаж байсныг 3 жил тутам зуун хувиар хариуцаж байхаар хуулийн төсөлд тусгасан. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулсан ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлтийг 3 жилд 10 хувиар тооцож үзүүлдэг байсныг 15 хувь болгон нэмэгдүүлсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан 3 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын

гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч үйлдвэрлэлийн ослын улмаас учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацаанд болон хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон ажилтнаа тохирсон ажлын байраар хангасан тохиолдолд шимтгэлийн чөлөөлөлт үзүүлэхээр тусгасан. Мөн даатгуулагчийг үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээний зарлалтын төлбөрийг нэмэгдүүлж Даатгалын сангийн тухай сангийн тухайн жилийн шимтгэлийн орлогын 2 хувиас ихгүй байхаар, хөдөлмөрийн чадвараа алдсан тэтгэвэр авагчид протез, ортопедын жишиг үнийг баримтлан эхний удаа зуун хувиар дараагийн удаа 50 хувиар тооцон даатгалын сангаас хариуцаж байсныг 3 жил тутамд зуун хувиар хариуцаж байхаар хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт нэмэлт ачаалал үүсэхгүй, үйлдвэрлэлийн осолд өртсөн болон мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, хөгжлийн бэрхшээлтэй болсон даатгуулагчид эрүүл мэндийн нөхөн сэргээлтийн үйлчилгээ үзүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд бэлтгэх, тэдний нийгмийн баталгааг

хангах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн ажил олгогчид шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх шалгуур үзүүлэлт тодорхой болж үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэх, хяналт тавих, ослоос урьдчилан сэргийлэх мэдээллийн нэгдсэн сан бүрдэнэ гэж хууль санаачлагчид үзсэн бөгөөд хуулийн төслийг D-парламент.мн сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч эхэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Жаргалмаа Монгол Улсад протез, ортопедын үйлдвэрийн өнөөгийн нөхцөл байдал ямар хэмжээнд байгаа, хүний нөөцийн талаарх асуултыг асууж, хариултыг авлаа. Улсын Их Хурлын гишүүн Бейсен хүнд хортой нөхцөлд ажиллаж байгаа хувийн уурхайн ажилчдын НДШ-ийг ажил олгогчид нь төлөхгүй байгааг анхаарах, орон нутаг дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхдүүдийн сургалтын байрны орчин нөхцөлийг сайжруулах, төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх талаар саналаа хэлсэн болно.

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь буюу 60 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд ажил, албан тушаал, овог нэр өмнөх хуулийн төсөл дээр унхсан ажлын хэсэг нэг адил. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Содномын Чинзориг гишүүн үг хэлэх юм уу, хэлэхгүй юм уу? За. Одоо Байнгын хорооны саналаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмжийн төлбөрийн тухай хууль, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 58.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд ишилжүүлж байна.

19.08 цаг

Арван хоёр.Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар

2021.10.15-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Төмөрбаатарын Аюурсайхан танилцуулна.

Т.Аюурсайхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөр.../үг тасрав/

Г.Занданшатар: Тогтохсүрэн дарга.

Т.Аюурсайхан: Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогод заасан зорилтыг хэрэгжүүлэх, иргэд олон эх үүсвэрээс тэтгэвэр авах боломжийг бий болгох зорилгоор Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төслийг 11 бүлэг 60 зүйлтэйгээр боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, дагалдах 13 хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэхүү хуулийн зорилт нь хувийн нэмэлт тэтгэврийн хөтөлбөр хэрэгжүүлэх, хувийн нэмэлт тэтгэврийн хуримтлал үүсгэх, тэтгэврийн хуримтлалаас хөрөнгө оруулалт хийх, хувийн нэмэлт тэтгэвэр олгох, тэтгэвэр өвлүүлэх мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, талуудын эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулна. Хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаанд сайн дурын шимтгэлд суурилсан бүрэн хуримтлалын байх, үйл ажиллагаа засаглал ил тод байх, санхүүгийн тогтвортой, бие даасан, найдвартай байх, өвлөгддөг байх зарчмыг баримтлан ажиллахаар хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд олон улсын зөвлөх баг байгуулсан ажлын хэсэг 10 удаа хуралдаж, Хөдөлмөр,

нийгмийн хамгааллын яам, Санхүүгийн зохицуулах хороо дээр удаа дараагийн хамтарсан хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөлд Засгийн газрын яамд, Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг тусгасан. Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль батлагдсанаар Монгол Улсад хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, эрх зүйн орчин бүрдэх, тогтвортой ажил хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, өөрийн хуримтлалаас тодорхой хувийг эрүүл мэнд, боловсрол, ипотека зориулах, санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг дэмжих, ахмад настан олон эх үүсвэрээс тэтгэвэр авах, тэтгэвэр өвлөгдөх боломж бүрдэх зэрэг эерэг дүн гарах юм.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 01 сарын 10-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Хуулийн төсөлд Монгол Улсад тэтгэврийн олон давхаргат тогтолцоог нэвтрүүлэх, даатгуулагч олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор төрийн бус өмчид тулгуурласан сайн дурын хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагаа

явуулах эрх зүйн үндсийг тогтоож, хувийн нэмэлт тэтгэврийн санг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахаар мөн хувийн нэмэлт тэтгэврийн харилцаанд даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгагчийн болон төрийн захиргааны байгууллагын эрх чиг үүргийг тодорхойлох, тэтгэврийн сангийн хөрөнгө оруулалтын удирдлагыг тогтоох, тэтгэвэр олгох, маргаан шийдвэрлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах хамгаалах зэрэг бусад харилцааг зохицуулахаар хуулийн төслийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар Хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо бий болгох хууль, эрх зүйн орчин бүрдэх, иргэдийн эрх ашгийг хамгаалах, хувийн тэтгэврийн сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төлбөрийн чадварыг хангах нөхцөл бүрдэх, ирээдүйд ахмад настнууд олон эх үүсвэрээс тэтгэврээ авах, санхүү, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх урт хугацааны сан бий болгох, тогтвортой ажил хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, ажил олгогчоос ажилтныхаа хувийн нэмэлт тэтгэвэрт төлсөн шимтгэлийн хэмжээнд татварын чөлөөлөлт үзүүлснээр ажилчдынхаа нийгмийн баталгааг хангах зорилгоор хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоонд хамрагдах сонирхлыг нэмэгдүүлэх зэрэг олон эерэг өөрчлөлтийг бий болгох чухал ач холбогдолтой гэж үзсэн.

Төсөл батлагдсанаар улсын төсөвт 9.9 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай талаар урьдчилсан тооцоолол хийгдсэн бөгөөд хуулийн төслийг D-парламент.мн цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно. Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Оюунчимэг хувийн нэмэлт тэтгэврийн үйл ажиллагааны найдвартай байдал хэрхэн хангагдах талаар асуулт асууж харцулт авлаа. Хуулийн төсөлтэй холбогдуулан

Байнгын хорооны гишүүд үг хэлээгүй бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 70 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил хянан шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүд өмнө нь нэр дурдсан гишүүд дээр нэмэгдэж Санхүүгийн зохицуулах хорооны дарга Дэмбэрэлдашийн Баярсайхан, СЗХ-ны Даатгалын газрын даргын үүргийг түр олон гүйцэтгэгч Зоригтын Батболд, СЗХ-ны Үнэт цаасны газрын ахлах мэргэжилтэн Алтанбулагийн Нинжсин нар нэмэгдсэн байна. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Тогтохсүрэн дарга нааш ир. Цэвэгдоржийн

Туваан гишүүнээр тасаллаа. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуултаа асууна. Тогтохсүрэн даргаа та энэ.

Ш.Адьяа: Хувийн тэтгэврийн даатгалын сангийн тухай хууль өргөн мэдүүлсэнтэй холбогдуулж бас зарим нэгэн зүйлийг тодруулах ийм шаардлагатай байна гэж бодож байна. Хувийн тэтгэврийн даатгалын сан, төрийн тэтгэврийн даатгалын сан гээд энэ 2 байгууллага энэ зах зээлийн нийгмийн үед оршин тогтнох нөхцөл бүрдэж, энэ хуулийг өргөн мэдүүлж байгаа юм байна гэсэн ийм ойлголттой байна. Гэхдээ энд миний зүгээс бас энд их болгоомжтой бас асуудал байгаа учраас ганц нэг зүйлийг тодруулж асууя. Энэ хувийн тэтгэврийн даатгалын санг бүрдүүлээд маш их хэмжээний мөнгийг ингээд төвлөрүүлээд, цаашидаа энэ үйл ажиллагаа хэвийн явах, энэ эрсдэлээс хамгаалах талаар ямар зохицуулалт байна вэ? Ямар баталгаа байна вэ? Одоо ингээд бид нар энэ ББСБ гээд л нэг асуудал яригдаж байсан. Сүүлд нь энэ blockchain крипто валют гээд л ийм одоо олон асуудлууд гарч ирсэн.

Тэгээд энд одоо хувийн даатгалын энэ тэтгэврийн сангийн ямар баталгаа гаргах юм бэ? Энэ их хэмжээний мөнгө төгрөг төвлөрүүлээд энэ хувийн тэтгэврийн даатгалын сангийн мөнгийг тэр хувийн тэтгэврийн санг бүрдүүлж байгаа тэр компани ААН-үүд өөр зүйлд зарцуулаад, энэ ашиглаж үрэгдүүлээд ийм одоо ноцтой асуудал гаргавал хэн хариуцах юм бэ? Төрд энд ямар баталгаа зохицуулалтаар энд оролцож байгаа вэ? Энэ төвлөрсөн хөрөнгө мөнгийг давхар даатгуулах ямар одоо ийм хууль, эрх зүйн орчин байна вэ? Энэ бас нэлээн олон талаас нь хэдийгээр шинэлэг зүйл, зөв зүйтэй зах зээлийн нийгмийн үед байгаа ч гэсэн ийм эрсдэл энд байгаа. Энэ их хэмжээний мөнгө төгрөгийг төвлөрүүлээд, тэрнийг өөр зүйлд зарцуулаад тэр ирээдүйд тэтгэвэр төлөгчдөд тэтгэвэр авагчдад үүсэх эрсдэл үүсвэл энэ хууль болон бусад хуулиар ямар зохицуулалт хийж энэнээс урьдчилан сэргийлж байгаа

талаар тодорхой хариулт авах шаардлагатай байна.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Ажлын хэсэг 80, Дэмбэрэлдашийн Баярсайхан СЗХ-ны дарга хариулна.

Д.Баярсайхан: Адъяаа гишүүний асуултад хариулъя. Их зөв зүйтэй асуулт байна. Тэгээд мэдээж аль болох эрсдэлийг хаах талаар бол хуульд болон холбогдож гарах зохицуулалтуудыг бол тухайн бүрд шаардлагуудыг нь гаргаад маш тодорхой байдлаар зохион байгуулъя гэж бодож байгаа. Хууль одоо хэрэв батлагдах юм бол хорооны зүгээс нэг 18 орчим журам баталж гаргана. Мэдээж энд бол мэргэжлийн болон засаглалын, санхүүгийн, байгууллагын бүтэц зохион байгуулалттай холбоотой бүхий л журмууд бол энэ дээр бол гарна. Холбогдож гарна. Мэдээж энэ одоо бол даатгалын үйл ажиллагааг бол даатгалын ердийн болон урт хугацааны компаниуд бол хэвийн байдлаар үйл ажиллагаа аваад явуулж байгаа.

Дээрээс нь сангийн хувьд гэх юм бол одоогоор Монгол Улсад бол 4 хамтын сангууд байгаа. 2 нь нээлттэй, 2 нь хаалттай. Эдгээрт бол одоо компанийн засаглал, холбогдох этгээдэд тавигдах шаардлага гээд дүрэм журмууд нь маш тодорхой байгаа. Дээрээс нь энэ салбарт бас нэг 38 хөрөнгө оруулалт, менежментийн компани 23 сан үүсгэн байгуулчихсан байж байгаа. Одоогоор бол эдгээр сангууд бол яг зориулалтынхаа дагуу үйл ажиллагаагаа хэвийн явж байгаа. Ингэхээр даатгалын болон энэ хөрөнгийн зах зээлийн энэ сангуудад тавигдах бүхий л шаардлагуудыг бол хорооноос бол хэрэгжүүлээд явахад бол ямарваа нэгэн асуудал гарахгүй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адъяаа гишүүн тодруулъя 1 минут.

Ш.Адъяаа: Энэ мэдээж энэ эрсдэлийг баталгаажуулах асуудал энэ их чухал байна. Өнөөдөр ингээд бид нар тэр ХЗХ, сүүлд нь энэ blockchain крипто валют

гээд л энэ олон асуудал үүсээд одоо хүртэл зарим асуудал нь их анхаарал татсан хэвээр байгаа шүү дээ. Тэгээд энэ ерөөсөө энэ одоо тэнд Тусгай зөвшөөрлийн тухай хууль гэж орж ирж байгаа юм. Энэ олон журам одоо зохицуулна гэдэг энэ юмыг энэ дараагийн хэлэлцүүлгийн үед онцгой анхаараарай. Бид нар чинь аливаа асуудлыг журмаар зохицуулна гэдэг юмыг л таслан зогсооё гэж өнөөдөр хууль тогтоох байгууллага чинь зарчмаа болгочоод байгаа шүү дээ. Энэ нэг журам гаргаад, тэр журам чинь хуулийн хэмжээнд авагдах яригдахгүй бол журмаар зохицуулсан асуудал чинь тэгээд олон эрсдэлийг үүрч, энэ одоо хамтын сангийн хөрөнгө мөнгө одоо ашиглагдах үрэгдэх ийм нөхцөл бүрдэх вий гэж бодож байна. Энэнийг одоо энэ хэлэлцүүлгийн явцад цаашидаа анхаарч энэ дээр бас онцгой анхаарахыг би одоо хууль санаачлагчаас хүсэж байна.

Г.Занданшатар: Журмаар зохицуулдаг тухай ер нь тодруулж хариулсан нь зөв байх. Журмаар зохицуулахаас аргагүй юмнууд байна л даа. Хуульчилж болдоггүй. Санхүүгийн зохицуулах хороо 80.

Д.Баярсайхан: Хууль батлагдсантай хэрэв батлагдах юм бол СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд бол бас нэмэлт, өөрчлөлт орох байх. Энэ нь шинээр зохицуулалт хийгдэж байгаа учраас хороо бас тодорхой үйл ажиллагаануудыг бол яалт ч үгүй л журмын хүрээнд зохицуулаад явахаар ийм зохицуулалттай байгаа. Тусгай зөвшөөрлийн тухай хууль бол энэ хууль өргөн баригдахаас өмнө батлагдчихсан учраас бид нар мэдээж бас энэ Тусгай зөвшөөрлийн тухай хуульд холбогдох журмуудаа бол бас дахиж зөвшөөрөл авахаар тийм ээ, өөрчлөлт оруулна гэсэн ийм төсөөлөлтэй явж байгаа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Энэ олон давхаргат тэтгэврийн тогтолцооны нэг хэсэг л дээ.

Тэгээд энэ дээр энэ Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хууль гээд ингээд хууль оруулж ирж байгаа. Тэгээд энэ дээр бол нэг тодорхой хэдэн асуулт асууя. Эрсдэл бол одоо бид нар чинь хаширсан улсууд шүү дээ. Одоо сүүлийн үед ер нь тэгээд л дандаа л нэг хулгай ярьдаг болчихлоо. Тэгэхээр энэ санд хүмүүс ирээдүйдээ хэрэглэнэ гээд ингээд хуримтлал үүсгээд явж байсан нөгөөдхийг нь алдчихвал яах вэ? Энэ эрсдэл тэр ганцхан СЗХ биш бас энэ хууль өргөн барьж байгаа энэ яамнаас яамныхан яг энэ дээр ямар энэ хамгаалах бодлогуудаа нэг тодорхой хэлж өгөөч.

Хоёрдугаарт нь энэ юугаа ямар одоо хэмжээний байх юм. Одоо цалингаас нь хувиар бодох юм уу, эсхүл одоо доод хязгаар тавих юм уу, дээд хязгаар тавихгүй юу гээд энэ нэг хэдий хэмжээний мөнгөний асуудал одоо цалингийн хувьтай бодох ийм асуудал байна уу байхгүй юу? Эсхүл одоо сайн дураараа гэдэг дээр ямар нэгэн хэмжээ тавьж бодож байгаа юм байна уу? Энэ эрсдэл тал дээр нь түрүүн бас хэлсэн. Тэр энэ олон улсад ер нь манайхтай ижил төстэй ийм улс орнуудад олон улс дээр энэ хувийн нэмэлт тэтгэврийн энэ асуудал ер нь яаж явдаг юм бэ? Ийм судалгаа авчихаар ийм сайн туршилага юм байна уу?

Дараагаар нь энэ Учрал гишүүн яриад бас энэ асуудлыг яриад тавиад байсан. Тэгэхээр энэ хууль 2 адилхан уу? Энэ одоо Учрал гишүүний өргөн барьсан гэж би ойлгож байгаа. Тэр хууль ингээд ороод ирж байна уу, эсхүл одоо яаж байна. Энэ талаар бас нэг энэ ажлын хэсгээс нэг хэлж өгөөч. Одоо бид нар чинь бас энэ хадгаламж зээлийн хоршооноосоо эхсүүлээд л хамгийн сүүлд одоо юу энэ койн гээд л ингээд энэ нэг иргэдийнхээ итгээж хадгалуулсан итгээж өсгөөд авчихна гэсэн энэ одоо мөнгө төгрөгүүдийг л алга болгочоод байдаг нэг ийм асуудал үүсчхээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр бол би бас адилхан иргэдтэйгээ адилхан санаа зовж байна. Хуулиуд дээр ингээд харсан энэ 9.9 тэрбум төгрөг, 10 тэрбум төгрөг зарцуулна гээд ингээд хуулийн

төсөл дээр танилцуулга дээр ороод ирж байна. Энэ бас юун 10 тэрбум төгрөг болоод явчхав? Энийг юунд зарцуулах юм бэ гэдэг талаар мэдээлэл авъя.

Г.Занданшатар: Сайд хариулах уу, хэн хариулах вэ? Ажлын хэсэг 80.

Д.Баярсайхан: Туваан гишүүний асуултад хариулъя. Ялангуяа энэ татан төвлөрүүлэх хөрөнгийн эрсдэлд орчих вий гэдэг дээр их онцгой анхаарч байх шиг байна. Зайлигүй л бас чухал асуудал. Зүгээр хуулиараа бол хөрөнгө оруулалтын ангиллыг тусгайлаад заагаад өгчихсөн байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол тэтгэврийн сан байгуулагдвал бол нэмэлт тэтгэврийн хөрөнгө нь кастодиан дээр хадгалагдаж бүртгэгдэнэ. Дээрээс нь энэ санг бол хөрөнгө оруулалт, менежментийн компани удирдана. Өөрөөр хэлбэл яг мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, дээрээс нь тусгай зөвшөөрөлтэй ийм одоо менежментийн баг удирдана. Олон улсад бол яг л энэ жишээгээр явж байгаа гэдгийг хэлье. Тэгээд хуульдаа бусад асуудлуудыг эндээс нэмье гэж байх шиг байна.

Г.Занданшатар: 81.

Б.Батжаргал: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Батжаргал, Туваан гишүүний асуултад хариулъя. Ямар хэмжээний байх вэ гэдгийг хууль дээр хуулийн төслийн 10.4 дээр заагаад өгсөн байгаа. Энэ дээр бол шимтгэлийн дээд хэмжээ сарын үндсэн цалингийн 20 хувиас хэтрэхгүй байна гээд заагаад өгсөн, хязгаарлалтыг нь зааж өгсөн байгаа. Олон улсын туршилага ямар байна вэ гэж асуулаа. Энэ дээр нийтдээ одоогийн байдлаар 33 улс хувийн нэмэлт тэтгэврийн тогтолцоо нэвтрүүлсэн байгаа. Манай улсын хувьд бол сайн дурын хэлбэртэйгээр орж ирж нэвтрүүлж байгаа ийм сонголтыг сонгосон. Энэ талаар бас Дэлхийн банкнаас ажилласан зөвлөх бас энэ талын зөвлөгөөг өгсөн байгаа.

Учрал гишүүн нарын өргөн барьсан хуулийн төсөлтэй бол манай хуулийн төсөл

нийтдээ 37 зүйл заалтаараа нэлээн төстэй бараг адилхан хууль байгаа. Энэ дээр бол шимтгэл авах уу, авахгүй юу гэдэг асуудал дээр 2, 3 төрлийн үндсэн ялгаатай асуудал. Бусдаараа бол адилхан байгаа. 10 тэрбумын зардал дээрээ тодруулга өгөхөд энэ дээр бол татварын хойшлуулалт буюу татварын хөнгөлөлт дээр 1.4 тэрбум, СЗХ-н дээр бас орон тооны одоо хүний нөөцийн зардал хэрэгтэй. Энд 0.1 тэрбум гээд шууд гарах зардал бол улсын төсөв дээр 1.5 тэрбумын л зардал гарна. Үлдэх 8.4 тэрбум бол улсын төсөвт хамааралгүй. Энэ бол хуулийн этгээд болон иргэн 2-оос төлж байгаа шимтгэл буюу хуримтлалыг бол сая бас зардал гээд уншчих шиг боллоо. Энэ бол ирээдүйд цуглуулж байгаа хуримтлал юм байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Буланы Бейсен гишүүнээр тасаллаа. Буланы Бейсен гишүүн үг хэлсний дараа санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд ирнэ үү, асуулт хариултын цаг дуусаж байна.

Б.Бейсен: Энэ Хувийн тэтгэврийн сан дээр нэг анхаарах асуудал байгаа юм. Та бүгд мэдэж байгаа. Энэ ХЗХ гээд олон хүн мөнгөө хадгалуулж байгаад дампуураад сүүлдээ мөнгөө олж чадахаа байсан. Энэний эрсдэл нь тэндээ л байгаа. Нөгөө талаар одоо улсын нийгмийн даатгалын тэтгэврийн санд бас нөлөөлж ч магадгүй. Тэр талаар анхаарч ажиллах нь зөв байх гэсэн саналыг хэлье.

Г.Занданшатар: Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууслаа. Байнгын хорооны саналаар Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Компанийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, СЗХ-ны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Даатгалын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 60 хувь дэмжиж, төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцсон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлж байна.

Нийгмийн бодлогын байнгын хороо багц хуулиудаар ажлын хэсгүүд байгуулах нь байна, тийм ээ. Байнгын хороогоор оруулна. Туваан гишүүн ажлын хэсэгт орох санал дэвшүүллээ, Бадарчийн Жаргалмаа гишүүн ажлын хэсэгт оруулах түрүүн хэллээ, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ажлын хэсэгт оруулах, Буланы Бейсен гишүүн орох санал дэвшүүллээ. Ингээд ажлын хэсгийг Байнгын хорооны дарга ахлаад байгууллаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан үүгээр өндөрлөж байна. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ Д.УЯНГА